

Малын эмгэг эмчлэх уламжлалт арга ухаан

(эх сурвалж www.monevm.muls.mn)

АДУУ

Багтрах - Хурдан морины уяа сойлго тохируулаагүй, буруу дутуу хөлсөлж үсэргэн уралдуулснаас шалтгаалан морь бахардаж багтрах явдал олонтаа тохиолдоно. Их өлөн, эсвэл цатгалдсанаас болж морь багтарна. Намар цагийн тарган цатгалан адууг хол газар зогсолтгүй давхиулах, ширүүн хүчтэй хөөж туух үед зарим нь багтрах явдал тохиолдоно.

Шинж тэмдэг: Уралдаан болон унааны морины хүч суларч хар хөлс асгаруулан багтран унана. Багтарсан морины хамар амнаас хөөс сахарч, амаа ангайлган гэнэт унаж хөдөлгөөнгүй хэвтэх бөгөөд булчин мах нь чичирч, хамрын самсаа нь дотогшоо хумигдаж амьсгаа гүнзгий цөөн болно. Нүдний салст бүрхүүл улайж, хамраас цус гоожно. Зарим үед ам нь зуурна.

Эмчилгээ: Багтарч унасан моринд дараах засалын аль нэгийг хэрэглэнэ. Юуны өмнө толгой, цээжин биеийг өндөрлөж, салхи сөргүүлэн тавьж, урд хөлийг татаж хөдөлгөн цээжин биеийг сэвж, хүйтэн усаар шавшина. Ам зуурсан бол завжаар нь давс чихэж болно. Өвчүүний бүдэрхий тушаа, үсний эргүүлэг (цуслах цэгт)-ийн арьсыг татаж зүсэж сэргийлнэ. Зарим малчид дээрх хэсгийн арьсыг гурван хуруугаар чимхэж татаад угаар нь огтлон авч алгаараа алгадаж сэвдэг байна. Чих рүү нь ус хийж уураг тархины цусан хангамжийг сайжруулдаг.

Багтарсан даруйд нь хааны судас, хамрын сиймхийг хатгана. Хэрэв хааны судсыг хатгаагүй бол 1-2 хоногийн дараа ороо харыг ханаж болно. Багтарч унасан морийг сэхээхийн тулд түүний ам хамрыг битүү барихад бүтэж сандран тийчлэх бөгөөд энэ үед бага багаар амьсгаа авахуулна. Ийм засал хийхэд багтарсан морины хөхөрч цийлсэннүд аажимдаа тунгалаг болж, хөшсөн хөл нь суларч эхэлбэл тэнхэрч байгаагийн шинж тэр юм. Харин гэнэт их амьсгаа авахуулбал осолтой гэдэг.

Мөн багтарсан морины хоёр борвины нимгэн сиймхийг нэвт хатгаж сэхээх бас нэг сайн арга байдаг. (С.Самба, Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум).

Буйлны судас ханах (хамрын хоёр талын судас дайруулан буйллах маягаар хатгана), зүрх рүүнь хэд өшиглөх, эсвэл хойдхоёр хас (онгоныг) ханах, ташуураараа хамар руу нь гударч зүрх рүү өшиглөх зэргээр засал хийнэ. Багтраад уначихсан, эсвэл салганаж унах гэж байгаа үед нь бүс даавуу шатааж утах арга айдаг. Багтарч унасан морийг сэхээхийн тулд дараах аргуудыг дэс дараалан (Увс аймгийн Өлгий сум малчин Б.Чимид) хийдэг байна. Үүнд: Эхлээд хоёр хамрыг гарын алгаараа таглаж өвчүү рүүнь хэд өшиглөөд гэнэт гараа авна.

Сэхэхгүй бол тагнайн гурав дахь үе дээр нь голд нь ханах буюу буйллаж цус гаргана. Ингээд сэхэхгүй бол хамрын судас (цуур)-ыг мөгөөрсний үзүүр дээр хатгана. Хэрэв босохгүй бол сүүлний голыг хатгана.

Багтарч унасан морь явж чадахгүй, хойд борвиороо нугарч доголж эхэлнэ. Энэ үед хэнхдэг, цээж, сугыг хүйтэн усаар шавшиж (15-20 удаа) хоёр товчлуурыг хатгана. Хөл дээрээ зогсож чадахгүй, салганаж багтарч унах гэж байгаа морины сүүлнээс татаж дугтрах, хөл нь хөшсөн бол хөдөлгөх, хөлийг илэх, дарах, цохих зэргээр хошилтийг тайлах арга хэрэглэнэ. Багтарч унасан морины хамар шамшийж амьсгаа авах нь бэрхшээлтэй байвал хамрын шөвгөрсөн мөгөөрсний үзүүрийг огтолж авна. Мөн багтарч унасан морины магнайг сөхнө. Энэ нь морины хөхлийн доод талын үсний эргүүлэг дээр 3 хуруу хиртэй арьсыг босоо зүсэхийг хэлдэг

Дэлүүтэх - Тэжээл, эрдэс дутагдсанаас болж шавар, шороо долоох, шорвог ус уух, уналга эдэлгээ тохироогүй зэрэг олон зүйл адуу дэлүүтэхийн шалтгаан болдог.

Шинж тэмдэг: Адууны умсанд элс, шороо хуралдаж тэжээл боловсруулах эрхгний үйл ажиллагаа хямарсны улмаас гэдэс дүүрч тогтворгүй болно. Дэлүүтсэн адуу хэвтэж хөрвөөх, гэдсээ үнэрлэх, нүдээ анивчих, гэдсээ хайрах, биеэ маажих. хазах, нохой шиг оцойж суух зэрэг шинж тэмдэг үзүүлнэ. Зарим адуу дөрвөн хөлөө дээш гарган хумиж нуруугаараа хэвтэнэ.

Эмчилгээ: Зөв талын сүвээний сүүлчийн хавирганаас урагш гурав дахь хавирганы урьд завсраар, харцаганы нугалмаас доош мухар соом, эсчэл мөн нугаламд тулгаж алгаа тэнийлгэн тавьж доош нь эргүүлээд эрхий хуруу, долоовор хуруу хоёрын завсарг долоовор хурууны уг, эрхий хурууны урд үе харалдаа шөвгөөр 3-4 хуруу (адууны том жижгийг харгалзах) хиртэй гүн хатгана. Оносон бол шөвгөний бариул чичрэнэ. Шовгийг 20-30 минут байлгасны дараа авахад адууны амьсгаа намдаж бие нь тайвширна. Морийг ийнхүү хатгасны дараа эмээллэж хөлөртөл пичшуулна. Дэлүүтсэн адууг хатгасныхаа дараа нэг хоног услахгүй. Дэлүүтсэн адууны пүдэнд нэг чимх улаан тамхи хийж сайн хөдөлгөж явуулахад сайн.

Гаригсаа -Энэ эмгэг гусганадууны нэг талын чих унжина. Уруул нь хажуу тийшээ мурийна. Усанд хошуугаа завжаа хүртэл дүрж усаа шимж ууна.

Эмчилгээ:Ийм эмгэг туссан адууг газрын үс өвс, хөсрийдаавуу, өмхий хүрниймахны аль нэгээр утаж эмчилдэг байсан. Чих нь босоо байгаа эрүүл талын чамархай (түүшин) судсыг ханана. Ингэхдээ морио чөдөрлөөд чөдрийн хоёр хааны доогуур хазаарын цулбуурыг оруулж чанга татаж адууныхаа толгойг тонгойлгоно. Энэ үед чамархайн судас гүрийн гарч ирнэ. Уг судсыг ханахад цус олгойдон гарах бөгөөд 300-400 мл хиртэй цус гарсны дараа цулбуурыг суллаж, толгойг өндийлгөхөд цус тогтоно. Арваад хоноод доошоо дэлдийн унжиж байсан чих босож, уруулын мурий арилж хэвдээ орно. (П.Гатав)

Гүен - Адууны хамрын дотор доод талд 1-2 см хиртэй хатуу (мөгөөрс мэт) мах ургахыг гүентэхгэнэ. Хаврын улиралд уналга эдэлгээг хэтрүүлсэн туранхай морь, урьд өмнө нь таарах (суртах) гэдэг эмгэгт нэрвэгдэж байсан морь гүентэхталтай. Намар тарган морийг уяж хоноод ширүүн давхивал гүентэнэ.

Шинж тэмдэг:Гүентэй адуу сүүлээ шарваж, хэвтэж босох, хөлбөрч хөрвөөх, толгойгоороо савж унах, амьсгаадан тийчлэх зэрэг шинж тэмдэг үзүүлнэ. Хамраараа газар шөргөөж, хамар нь янтайж сарвайна. Заримдаа гүентэй адууны амьсгаа ихдэж, хамар нь сартайсхийх, хамрын нүх хавчин зууван болох, голоо цохих, түгших, сүүлээ их шарвагануулан доороо эргэх, хэвтэх, босох, амьсгаадах зэрэг шинж тэмдэг ажиглагдана. Өвсөнд хушуугаа тулгаж идэхгүй зогсоно. Уруул хөдлөхгүй байна.

Эмчилгээ:Гүентсэнадууг бэхлэжтолгойг нар өөд харуулж хамар дотор ургасан мөгөөрсийг хугалах, огтлон авч хаяхад засал авна.

ГҮҮ СҮҮНДЭЭ ХОРДОХ

Энэ эмгэгийг заримдаа сүүний жилбэн ч гэж нэрлэнэ. Их сүүтэй гүүг ширгээхгүйгээр хэт унаж эдлэх үед сүүндээ хордож өвчилнө. Сүүндээ хордсон гүү бөгсөө даахгүй болж, бөгсөөрөө суун хойд хөл нь мэдээгүй болно. Дэлэн хавдана. Их сүүтэй гүүг унаж эдлэх шаардлага гарвал хоср хаснаас бага зэрэг цус авч сар хиртэй тавьж байгаад зөөлөн эдэлбэл сүүндээ хордохгүй.

Эмчилгээ: Сүүндээ хордсон гүүний эхлээд хасыг, түүнээс хойш 2-8 хоноод шагайны ороолтыг хатгана.

(Д.Базарсүрэн) Чонын цөсийг хэлэнд нь түрхэнэ. Дэлэнг хүйтэн усаар 1-2 удаа шавшина, бага зэрэг сааж, эсвэл унагыг нь хөхүүлж, дэлэнг дундална.

НАЛИХ

Адууны нүдний дотор талын өнцгөөс мөгөөрсөн хальс (хар захтай) гарч нүдийг халхлахыг адуу налихтагэдэг. Энэ нь мэдрэлийн системийн хямралаас болж нүдний гурав дахь зовхи түрэн гарч ирж байгаа хэрэг юм. Мөн урьд өмнө нь таарах (суртах) эмгэгт нэрвэгдэж байсан адуу налихтах нь илүүтэй.

Шинж тэмдэг:Эцэж турсан морь хаврын цагт харангадаж хялалзан гэнэт үсрэн унаж, шилээ татна. Хамраас шар ус гоожно. Амьсгаадан тийчилнэ. Бүх биенийхөлс дааварлана.

Эмчилгээ:Хамрын тамхи нүдэнд нь цацан, хиншүүнэртүүлнэ. Тус болохгүй бол нүдний зовхины дээхнэарьсыг гурвалжин хэлбэртэйгээр огтолно. Үүнийг "цохтох" гэдэг. Нүд бүрхсэн мөгөөрслөг хальсыг болгоомжтойгоор сүвлэн татаж гаргаж ирээд хурц хутгаар өнгөц огтолж болно. Дээрх засал тус болбол адуу тэр дороо засарч босоод хэд хөрвөөнө. Бас хамрын сиймхий, буюу хасыг ханадаг тал бий.

ТЭВШ (ТЭВШИН) ХАВДАР

Адууны гэдэсний арьсан доогуур хаван гүйхийг тэвш хавдар гэдэг. Энэхүү эмгэг адуунд тохиолддог тухай А.Цэрэв, С.Чадраабал, Ч.Идэр, Т.Ривади, Л.Тэхэш, Ч.Туулайхүү зэрэг малчид мэдээлжээ.

Шинж тэмдэг: Морины цавинаас урагш, гүүний дэлэнгээс урагш өвчүүний аймхай мөгөөрс хүртэл тэвшлэг хатуу халуун хавдар үүснэ. Зарим тохиолдолд суга, толгой, дал хүртэл хаван үүсдэг.

Эмчилгээ: Өвчилсөн адуунд исгэлэн тараг, ганга өвс буцалгаж өгнө. Хавдрыг тойруулан улайсгасан төмөр, галын хайчаар үсийг хайрна. Арьсанд хүргэж болохгүй. Ийнхүү хавдрыг

тойруулж үсийг хайрсны дараа хайрсан талбайн дунд нь чагт хэлбэртэй (+) үсийг бас хайрна. Мөн хавдрын үзүүрийг улайсгасан шөвгөөр хөндлөн буюу тонолжлон цоргих буюу шивж хэд хэд хатгана. Модон тэвшний нэг өнцгийг хавдарт болон газарт ээлжлэн хүргэж дөмнөнө.

САГАЛДАРГАН ХАВДАР

Адууны хоолойн арьсан дор хаван гүйхийг сагалдарганхавдар гэж нэрлэдэг. Д.Лувсанцэрэн, Ч.Төөрүүл, Д.Балдорж, Т.Ривади, Д.Балтуу, С.Самбазэрэг малчид адуунд энэхүү эмгэг тохиолддог тухай мэдээлжээ. Сагалдарганхавдар адуунд нас хамрахгүй тусах бөгөөд маш их халуурна. Ихэвчлэн багалзуур орчим хавдана. Багалзуур, хоолойн булчирхай цочно. Ухаан балартаж, мэдээгүй юм шиг болж зогсоно, эмчлэхгүй бол хоногтоо л үхнэ.

Шинж тэмдэг:Эхлээд хамраас шар ус гоожно. Эрүүнээс хүзүүний тэхийдунд хүртэл хавдана. Булчирхай цочно, хоногт хэд хэдээр өвчилж үхэх явдал ч тохиолдоно.

Эмчилгээ:Хавдар эрүүнээс доош 4 хуруу (алга дарам) болоогүй бол хоёр гүрээг хатгаж, цавь, сугыг хөлөртөл цус гаргана. Мөн хавдрын доод хэсгийн судас, булчирхайгүй хэсэгт халуун зэс шөвгөөр цоргино. Хавдар үүссэн талын чамархайг, харин түүнийг хатгах боломжгүй байвал сүүлний гол судсыг хатгана. Мөн ганга өвс хандалж өгөх, хавдрыг шавших, исгэлэн цагаа буюу цагааны шар ус өгнө.

ЦАГААН МАХ (ХОШНОГО) УРВАХ

Олон унагалсан гүү, мөн хэт эцэж турсан болон янз бүрийн өвчний урхагбүхий адуунд цагаан мах урвах эмгэг тохиолдоно.

Шинж тэмдэг:Өвчний эхний үед шээх нь олширч, хойдхөлөө алцайж зогсох зэрэг шинж үзүүлэх ба улмаар цагаан мах дотор талаасаа бага багаар урваж гарч ирнэ.

Эмчилгээ:Архины шилэнд халуун бүлээн ус хийж хошноого руушургуулж жин тавихад адуу хөлөрч, урвасан хошноого эргэж орно. Мөн олон ясны уулзуурдээр халуун элсээр жин тавих, халуун төмрөөр төөнөх арга хэрэглэнэ. Сүүлний гол судсыг ханана.

МОРЬ ЗУУРАХ

Адуу ялангуяа олон хоног ус уугаагүйгээс цангаж ам нь зуурах явдал дулааны улиралд тохиолдоно. Их цангаснаас ам нь зуурах явдал бусад малд ч тохиолдоно. Малын ам зуурахыг зарим нутагт шазайх гэж нэрлэнэ.

Шинж тэмдэг:Ам нь зуурч байгаа адуу эвшээх, салхи залгих, хазаарын амгайгаа зажлах, гүн санаа алдах, хамрын нүхнийх нь сөртгөр хойш эргэж нугаран шантайж шазайх, самсаа нь шамшийх зэрэг шинж ажиглагдана. Байн байн газар үнэрлэх, цавчлах ба нүднээс нуух нулимс гоожно. Хэт их цангасан бол ам зуурч амаа ангайлгаж ус ууж, өвс идэж чадахгүй болно. Голоо цохиж, хамаг бие нь хөлөрнө. Зуурсан морь ус шимэх боловч залгиж чадахгүй хамрынхаа нүхээр буцааж гоожуулна.

Эмчилгээ: Зуурсан адууг их хөлөргөлгүй явуулсаар усны амьсгал дээр салхи сөргөөн зогсоож, усны анирт дасгана. Хөх мах өөд нь хүйтэн ус цацаж шавшина. Зоо нуруу зулай руу нь ус асгана. Үүний дараа үүдэн шүд арааны завсраар ташуур буюу мод хийж

аажим аажмаар гөнжин шүдний зуурааг гаргана. Хэлний доор байдаг хүрэн судас, тагнай судсыг ханаж цусыг залгиулбал сайн. Тараг, цагаа, хужир өгч болно. Чих рүү нь ус хийх, хошног, хамрын нүх рүү гаансны соруулаар тамхины утаа үлээх, араанд нь давс хавчуулах зэргээр амны зуурааг гаргахад тустай аргууд байдаг ажээ. Амных нь зуурааг гаргасны дараа усална. Зуурсан адуу нэг их ус ууж цангаагаа гаргаж чадахгүй учир хонуут өнжүүт ус бараадуулан байлгах нь чухал.

ӨЛӨН ТААРГА (ӨЛӨН ХЭЛБЭЭ)

Уяа сойлт таараагүй уралдааны моринд элбэг тохиолдоно. Хурдан морийг уяхад арьс, булчин агшиж чангарахаас гадна умснь агшиж хур баас гүйцэд гарч түүний оронд бий болсон шинэ баас нь бэхжиж, умсан дотор нэг эгнээгээр байрласан байдаг. Ийнхүү байршсан шинэ баас бэхжиж хагаралгүй, хуурайшсан умсанд хий хуралдуулахгүй учраас морь хурдлан давхиж байгаа үед хөдөлгөөн багатай, тогтвортой байна. Харин уяж байх үед арьс булчин агшиж чангарсан боловч умсгүйцэд агшаагүй, хуучин баас гүйцэд гараагүй, шинээр үүссэн баас сэвсгэр, нягт хомоол болж чадаагүй бүдүүн ширхэгтэй, исэлт ихтэй байдгаас шалтгаалан умсанд хий хуримталснаас давхих үед умсбайршлаа өөрчилж, түүний мухар үзүүр аарцагнаяс руутүрж орохыг өлөн тааргагэж нэрлэнэ. Уралдааны морь өлалдуулах, хол унаж яваа морийг удаан услахгүй ширүүн явснаас шалтгаалж моринд өлөн тааргатусдаг талтай.

Шинж тэмдэг:Өлөн тааргатуссан морь амаа ангайлган унана. Шилээ татаж, зүрх нь дэлсэнэ. Гэдсээ хатгалга туссан мэт хайрах, биеэ хазах, гэдсээ чагнах, хөрвөөх зэрэг шинж үзүүлнэ. Мөн хөх мах чичирнэ. Баас нь сэвсгэр, хийтэй, хэлтэрхий хомоол гаргана. Өлөн адууны умсхоорондоо хавирч шархалсны улмаас хэвлийн хөндийн цус хурах, умсбусад гэдэстэй орооцолдох явдал тохиолдож болох аюултай.

Эмчилгээ:Өлөн тааргатуссан морины нуруу руухүйтэн ус цацаж, хошногод нь тамхи хийж, адууны хар хомоолыг өрөм, шар тостой хольж шатаагаад утахад сайн. Өлзалгуулахын тулд үхрийн баасыг шингэн зуурч өгнө. Мөн тагнайг хатгаж, цусыг залгиулж болно. Үхрийн түүхий сүүг дангаар нь буюу үхрийн баастай хольж ногоон болтол зуурч өгөхөд сайн. Өлөн тааргатуссан морийг хэвтүүлэхгүй байхыг хичээнэ. Муужирч унасан моринд дээрх засал хийхэд сэхэж өгөхгүй бол бөгсөөр нь тамхи татуулна. Хэрэв тамхийг унтартал татвал урагшаа чихэлдсэн гэж үзнэ. Хойшоо чихэлдсэн бол хошноогоор нь гараа оруулж дотор эрхтнийг нь урагш түлхэнэ. Урагшаа чихэлдсэн тохиолдолд дотуур нь чихэртэй өтгөн хар цай данх данхаар цутгаж өгнө.

ХАРШАА

Уналга эдэлгээний морь эцэж ядрах, алсаараа туйлдахыг харшаа гэж нэрлэдэг. Ус, идэш тэжээлээр дутагдах, олон хоногоор уяа сойлго, өлхоолны дэг алдагдах, ширүүн унаж эдэлснээс туйлдаж ядрах нь эдэлгээний морь харшиж ядрахын үндсэн шалтгаан юм. Харшааг хавар, намрын гэж хоёр зааглана.

Шинж тэмдэг:Унаж явахад хар хөлс цутгаж, хоёр чихээ унжуулан явдлын эрч суларсан тэмдэг илт мэдэгдэнэ. Нүд нь гөлөрч хөхөвтөр туяатай болж мах булчин чичирнэ. Ухархай хонхойж зовхи цааш хумигдаж хамар амнаас ус гоожно. Ийнхүү өвчилсөн адуу хөөврөө эрт гэж гуужихгүй удна. Зохих засал эмчилгээг тэр дор нь хийхгүй бол унахад амархан харшина. Харшсан адууны явдал хатуу болно.

Эмчилгээ:Хаврын харшааг гаргахад хялбар, намрын харшааг гаргахад хэцүү байдаг. Харшсан адуунд дараах засал хийнэ. Үүнд: аль болох сайн чанарын өвс тэжээл өгнө. Шиврээ бороонд уях, гүүний саам (500-800 мл) өгч хөлөргөөд 5-6 цаг сойсны дараа тавьж идээшлүүлнэ. Эсвэл нойтон шивхтэйхашаанд бороотой шөнө уяж хоноод өглөө эрт хөлөргөөд тавина.

Харшсан адууг дараах байдлаар тордвол сайн байдаг. Үүнд: Цай нунтаглаж шар тостой хольж нухаад архиар зуурч үрэл хийж 6-7 удаа хазаарын амгайд уяж өгөх, 1-2 өндөг өгөх, хонины хэрчим сүүлийг хазаарын амгайд уяж зүүх, эсвэл хошноогоор нь шургуулж утсаар морины сүүлтэй хамт уях зэрэг тордлого хийнэ. Хавар цагт хол газар унаж явах морийг сэргийлэхийн тулд монголчууд сойж хоол тэжээлийг тохируулахын зэрэгцээ үхрийн сэмж, хонины нэг үе сүүлийг хазаарын амгайд нь боож уяж явдаг уламжлал байжээ.

Харшсан адууг ес эхлэхээс өмнө хөлөргөөд аль их жавартай, хатуу газар уяж хоноход өглөө нь гишгэж чадахгүй шахам даарч бээрсэн, цагаан цан болсон байдаг. Ийм засал хийсэн адуу хавартаа сайн таргалдаг. Мал таргалах үед үс ноосоо гээхгүй, өнгө зүс нь засрахгүй, тарга хүч авахгүй хөхөрч байгаа моринд үнээ, хонины дөнгөж саасан сүүг 2 аяга өгөөд нэмнэж, хөлөргөсний дараа уяж сойх, дулаан салхигүй өдөр хөлөргөсний дараа дөрөөлөх, гүрээг ханаж засал хийнэ. Хатиартайтарга хүч авахгүй адуунд төлгөн хонины сүүг жижиг тагш буюу тахилгын том цөгцөөр эхний өдөр 1, хоёр дахь өдөр 2, гурав дахь өдөр 3, дөрөв дэх өдөр 2, тав дахь өдөр нэг өгдөг байжээ. Хонины сүүг адуунд их өгдөггүй. Мөн дотуур гэм сууж харшсаны улмаас таргалахгүй

болсон (цагаан хорхойдсон гэж үздэг) адууг хавар лууль өвс ургасан газарт аргамжиж чацгаалдуулж гэдсийг цэвэрлэхэд тарга хүчээ сайн авдаг байна (Б.Гомбо). Хусрангүүний сүү өгөөд хөлөргөх сайн.

ХАНИАД

Адууны ханиад өвчнийг монголчууд голоороо туссан, уушгиар туссан гэж ялгаварлан үздэг. Голоороо туссан ханиадны үед гол судасны дагуу шар усан шалхаг гүйж ирдэг. Өвчилсөн адуу гөлийн, цаанаас бөгшиж голоороо гүдэс гүдэсхийж ханиана. Идээшлэхгүй бөхийж зогсоно. Ижлээ гүйцэхгүй, булчирхай томрохгүй, гэдсээ татаж, бөгсөн бие нь орооцолдон тагнай хавдаж хоёр хөлөө солбиж гишгэнэ. Хүндэрсэн үедээ оцойж "нохой суудал" сууна. Хэл нь хув хуурай байна. Хэрэв өвчин даамжирвал 2-3 жил тарга хүч авахгүй, уналга эдэлгээнд хэрэглэх боломжгүй болно. Халуунтай бол адууны (мөн тэмээнд өөрцгүй) хар нүдэнд нь хүний нүүрний тал нь үзэгдэнэ. (Ц.Бадарчин, Дорноговь)

Эмчилгээ:Гол барьж туссан адууг эмчлэхдээ ихэнх малчид эхлээд тагнайг хатгаад, сайжрахгүй бол гүрээг ханах, эсвэл хэлийг нэг барим хиртэй атгаж татаж гаргаад гарын цаад талаар хэлний судас дайруулан дөрлөх маягаар нэвт хатгана. Заримдаа эхлээд тагнайг

хатгаж, дараа нь сүүлийн гол судсыг (сүүлний угаас 4 хуруу хиртэй газар бооход уг судас гүрийнэ) ханана. Ингэхэд засал авахгүй бол 3-4 хоногийн дараа хаа болон хасыг зэрэг хатгана (Д.Лхам). Адуу ханиахгүй, их халуунтай байвал ханаж хэрхэвч болохгүй, харин нэг том халбага арц хандалж хөргөөд 0.5 литр өгнө (Д.Гунгаа).

Баавгайн хатаасан доньдоос шар будааны талын хиртэйг авч хэлэн дээр түрхэнэ. Хэрэв шингэн доньд бол түүнд чүдэнзний мод дүрж аваад хэлэн дээр зурна. Бөгсөө ороосон, тагнайрсан адууны хааны судсыг хатгаад шар модыг 1:10 харьцаатай буцалгаж хандлаад өдөрт 0.5-1 литрийг 5-7 хоног өгөхөд улам сайн.

Адууны ханиад уушиг барьж туссан бол адуу ханиаж, хахаж цацаж, идээшлэхгүй бөгөөд хамар нармай хүйтэн байна. Хий гөлийж зогсоно. Өнгө зүс алдана, унахад учиргүй амьсгаадна, эрүүн доорх булчирхай томорно. Хамрын нүхээр хуруугаа хийхэд хүйтэн хий үлээж, хамрын мөгөөрс цэв хүйтэн байна. Эмчлэхдээ хамрын доторх мөгөөрсийг огтолно. Эсвэл эхлээд нэг талын гүрээг засрахгүй бол хэд хоноод нөгөө талын гүрээг хатгана. 2-3 сарын дотор сайжирмаар бол хамрыг буйллан, хатгана. Утаатай шар эсгийг усанд базаж утаатай усыг хар дарьтай хамт өдөрт нэг удаа цутгаж өгнө. Зарим адуу хяхтнаж ханиах тал" бий. Энэ нь унаган насандаа уяа зэлэндээ ороогдож боосноос, уурга, бугуйлын нөлөөгөөр цагаан мөгөөрсөндөө гэмтэл олсон малд илэрдэг. Ийм адууны уналгыг тохируулбал төдий л гэм болохгүй. Харин адууны уушгины наалданги үүссэний улмаас хяхтнаж ханиавал гэмтэй. Ийм адууны багалзуур, хөх мах хавьцаа хөөнгөтөн, гүрийж ирвэл бүр ч аюултай. Энэ тохиолдолд хоёр хааг хатгаж 21 хонуулаад гүрээг ханана. Ерөнхийдөө манай хатгаачид адууны ханиад эмчлэхдээ дараах дарааллаар засал хийнэ. Үүнд: Өвчний эхний үед тагнайг хатгаж 2-3 хонуулаад самсаадна.

Хэрэв. засал авахгүй бол хоёр гүрээнээс цус авах, чамархай хатгах, хэлийг дөрөлж хатгах ажлыг дэс дараалан хийнэ. Ханиад хүндэрч гэдсээ татах, хамраас цус, нүднээс нулимс гоожиж турах, хойшоо доголохыг нарийслага, гөлзөнөг, байрга гэх мэтээр нэрлэдэг тал бий. Эхлээд урагш нь татаж (тагнай, чамархай, гүрээ хатгах, хэлийг дөрлөх зэрэг) зэрэг дараа нь адуу зүгээр болж тарга хүчээ авч өнгө зүс өроод ирэхээр нь хойш нь татаж өөрөөр хэлбэл хас хатгана.

Өвлийн улиралд ханиасан адууны хэлний доод талд байгаа хоёр судасны уулзуур дээр ханахад сайн гэдэг (Б.Цэрэндорж). Ханиасан адуунд дараах эмийн эмчилгээний аль нэгийг хийж болно. Үүнд: YII сард түүж сүүдэр газар хатаасан цөс өвс нэг атгыг литр усанд буцалгаж хар цай шиг болтол буцалгаж нэг лонх (0.5 л) хиртэй өдөрт 3 удаа өдөр дараалан эдгэрэх хүртэл өгнө.

Чихэр өвс нэг шил усанд нэг аяга хийж буцалгаж хандлаад өдөрт 500 мл орчмоор 3-4 өдөр дараалан өгөхөд сайн үр дүнтэй байдаг.

Дэрсний үндэс (нэг шаазан)-ийг 5-6 литр усанд буцалгаж бүгдийг 1 хоногийн зайтай 2-3 удаа өгнө.

Цээж нь хүндэрсэн янзгүй, идэж уух нь бага болж гэдсээ татаж ханиалгавал цайны жижиг халбага хар дарь буюу шалзны хиртэй доньд усанд найруулж өгнө.

Хэрэв адуу цацаж ханиаж бөглөрөх нүд бүлтийж хоолой хавдаж байгаа бол ,эрүүний ороолтыг ханана (С.Дашзэвэг), цацалга ханиад туссан үед тагнайд. тамхи бохь түрхэх сайн (Ц.Пүрэвзав).

Мөн царван, чихэр өвс, цөс өвс адил хэмжээтэй авч хандалж өгнө.

Өвөл, хавар тэжээж байсан морь гэм сууж бөгшүүлэн, тонгойж ханиах, амьсгаадах, нүд нь аниастай, чих нь дэлдийсэн нэг зовууртай мэт сэргэлэн биш болдог. Малчид иймэрхүү ханиадыг тэжээлийн хордлогоос үүссэн гэж үздэг бөгөөд ингэсэн адууны хоёр самсааг нэг зэрэг, хэрэв адуу тарга хүч муутай бол самсааг нь 10 хоногийн завсартай ээлжлэн хатгаад засал авахгүй бол сүүлний гол судсыг хатгадаг юм.

МОРЬ ТҮГШИХ (ГОЛОО ДЭЛСЭХ)

Өлхоолгүй ширүүн унаж эдлэх, тарган болон анх сургаж байгаа морийг сойж зүгшрүүлэхгүйгээр гэнэт хол газар хэт ширүүн давхиулах, хүнд ажилд хэт зүтгүүлснээс морь түгшинэ. Уралдааны морь уяа сойлго нь таараагүйгээс түгших явдал тохиолдоно. Өлөн морийг услалгүй давхиулснаас түгшиж болно.

Шинж тэмдэг:Түгшсэн морины бүх биенээс хөлс бурзайж зүрхний нь цохилт холоос сонсогдоно. Иймд зарим нутагт голоо дэлсэх гэж нэрлэдэг. Зүрхний цохилтоос бие доргиж, эмээлийн гөлөм, дөрөө чичирхийлнэ. Хамраас цус гарч бие нь салганаж, хөх мах нь чичирч, дөрвөн хөл дээрээ зогсож чадахгүй багтрах шинж үзүүлнэ. Нимгэн цавь нь гадагш бүртэлзэнэ. Түгшсэн морь багтарвал дөрвөн хөл дээрээ зогсож чадахгүй. Хамар нь бөглөрч байгаа мэт чимээтэй, тасалдалтай амьсгална.

Эмчилгээ:Түгшсэн морийг хөтөлж зөөлөн холхиулж биеийг нь хөшихөөс сэргийлнэ. Өтгөн хар цай, үхрийн түүхий сүү өгч хүйтэн усаар цээж бүдэрхийг шавшиж цохино. Хөх мах өөд нь хүчтэй өшиглөж өгдөг ч арга бий.

Бүдэрхий орчимд ташуураар хүчтэй ёврох, нэг литр исгэлэн айрагт нэг аяга архи хийж уулгах буюу хошноогоор нь дүнсэн тамхи татуулах аргын аль нэгийг хэрэглэнэ.

Яг түгшиж байгаа үед өтгөн хар цайг цутгаж өгөөд дөрөөлөхийн хоёр талын судас ханана. Түгшиж байх үед дөрөөлөхийн судас нарийссан байх учир олоход түвэгтэй байна. Нэг түгшсэн морь дахин түгшимтхий болж урхаг суудаг учраас дараах арга заслын аль нэгийг хийдэг байна.

Хаврын эхэн сарын эхээр шуудайд цас хийж 2-3 өдөр ганзагалж унахын хамт нюнө зоон дээр нь цас шуудайлж тохоод уяж хоноход урхаг арилдаг. Мөн өвлийн улиралд хошноогоор нь мөс хийдэг (Ц.Цэрэндорж).

Дэлсэж голоо цохидог байсан морины хоёр чамархайг хатгаж, тэнхүүлснийдараа сүүлийн гол судсыг хатгана. Морийг зогсоогоод байвал цус гараад байна. Харин явуулбал цус нь тогтоно. Хар хүрэн цус гарч байснаа ягаан цус гарах үед цусыг тогтооно. 6-12 сар эдлэхгүй байвал зохино. Түгшсэн морийг уяж хоноод маргааш нь дахин хөлөргөж хүйтэн усаар угаахад зүгээр болдог тал бий. Мөн 8 зархайбуюу дэлсгэл судас хатгана. Энэ судас нь умдаг руу олон салаалан орсон судас бөгөөд тэдгээрийн аль нэгийг умдагт ойролцоо хатгана (С.Ишдорж). Дэлсэх зуршилтай бол задархийн дээд талын судас ханахад засарна (Б.Раднаабазар).

Хаврын шар тарваганы нэг цөсийг 3 тасалж өгөх мөн нялх унаганы зуулт буюу 3 өндгийг чадвал 3 удаа өгөхөд урхаг арилгана. Архаг түгшээтэй болсон моринд 7 буюу 14 хоногийн турш нэг гүүний өглөө, өдөр, оройн саамыг өдөр бүр өгнө. Ийм засал хийхэд унаган төрх байдалдаа орно гэж үздэг. Хазаарын амгайд шинэ зууван булигаар ороож шөрмөсөөр уяж бэхлээд морио хазаарлаж шөнө үүр цайтал сойх, өдөр нь амгайтай нь өвс идүүлж 3 шөнө сойход түгшиж гол цохихоо больдог.

Дэлсдэг зуршилтай болсон морийг уяж хоноод маргааш өглөө ньмордож давхихад дэлсэх бөгөөд энэ үед нь өлөн царцаа (дөрөөлөхийн судас хоёр салж умдаг уу очсон) судсыг ханах нь дэлсгээг засах найдвартай арга гэж үздэг (С.Чойжил).

СОЁНГОТОХ

Үрээ морийг агталсны дараа бохирдол, хүндрэлээс үүсдэг малын салтаа хавдах, бөгсөн биеэ чирсхийждоголох, хойд хөлөө ээлжлэн сойхижлээ гүйцэхгүй, ус бараадах идээшлэхгүй зогсоход хүрдэг эмгэгийг соёнготох гэнэ.

Эмчилгээ:Өвчний шинж илэрч, хөнгөн байх үед соёнготсонадуунд бүлээн тохомтой эмээл тохож биеийг халтал унаад махны шөлөгнө. Эсвэл хар модны давирхайгаар утаж шөнөжин уяад тавихад засарна.

Мөн соёнготсон адууны бөгсөн талыг битүү хучаад аргалын цог дээр хар модны давирхай хийж засааны шарахыг утахад хавдар харьж эдгэрнэ. Цус алдахад тарваганы хатаасан цөс буюу төлөгч өвс хандалж өгнө. Соёнготсон малын салтаа хавдаж хойд хөлөө чирч явж чадахгүй болсон үед өөр адууны буюу өөрийнх нь засааг буцалгаж, шөлийг нь өгнө, мөн гүүний айраг, хүний сүүг 100 мг хэртэй өгөхөд сайн гэдэг.

Цус тогтоохын тулд соёнготсонадууныхоёр чихийг угаар нь чанга боож нэг цаг хиртэй байлгавал цус тогтож болно. Цус тогтоохын тулд буурны бохийг усанд найруулж соёнготсон адууны хамрын нүхээр цутган өгч 2-3 залгиулдаг (Э.Бумцэнд). Суман. мод (буурал бут), хар модны агил (нэг хоолны халбага) 1.5 л усанд хандалж өгнө (Д.Балдорж). Хар архи өчүүхэн өгвөл сайн. (Өчүүхэн хар домын сургаал)

АРАНГАТАХ

Адууны арааны урд захад буюу хааяа хажуу талд нь илүү шүд ургахыг арангатахгэнэ. Өсвөр насны адуунд илүү тохиолдоно.

Шинж тэмдэг:Арангатсанадуу идээшлэхгүй өнгө алдаж гэдсээ татна. Мөн хавар, зуны ирж буй цаг улиралд таргалахгүй үсээ хаяхгүй, эцэнхий хэвээр байна. Тарга хүч авахгүй, турж эцэж байгаа адууны амыг ангайлгаж үзэхэд хэрэв арангатсанбол илүү шүд ургасан байна.

Эмчилгээ:Илүү ургасан шүдэнд нарийн төмөр тулгаж сайн бариад уг төмрийнхөө араас алхаар огцом цохиж илүү шүдийг булгална. Эсвэл илүү шүдийг хуга цохихгүйн тулд эхлээд илүү шүдийг хажуу талаас нь цохиж ганхуулсны дараа бахиар мушгиж дээш нь татаж авна. Илүү шүдний ором дээр хонины өөхөн сүүл тавих буюу бүлээн шар тос хийж жин тавина.

ЦУС ХЭЛБЭХ

Энэ эмгэгийг цус авах, цус идэх, цус ихдэх гэх зэргээр газар газар өөр өөрөөр нэрлэнэ. Адууны цус хэлбэхнь элбэг тохиолддог, их ч тодорхой шинжтэй, гэхдээ бие даасан өвчин, тодорхой эмгэг, өвчний сонгомол шинжийн аль нь болох талаар тодорхой нэгдсэн ойлголтгүй байна.

Шинж тэмдэг:Адууны сүүлний угныүс унаж шингэрэн сүүл нь шодойно. Биенийүс энд тэндээ халцарч улаан сэвхтэй болж, арзайж босно. Таргалахгүй хатингартана.

Эмчилгээ:Цус хэлбэсэнатууг намар цагаан хяруу унах үед арваад хоногийн турш үдэш, орой бүр булаг, худгийн хүйтэн усаар цээжин биеийг нь шавшиж шөнө идээшлүүлж өдорнь сойж уяна. Ийм засал хийсний дараа зөөлөн хөтөлж сүрэгт нь нийлүүлэхэд засарна. Мөн цус хэлбэсэнатууны сүүлний голын судаснаас цус авна. Ар-үр, гачгүргэмөгөх, эсхүл суман модны хандыг цус шингэрүүлэх зорилгоор өгнө (Л.Алтангэрэл).

ЖИДҮҮ

х

Өвөл, хаврын улиралд уналгын морийг хөлстэй байхад нь услах, хөлс хатаагүй байхад эмээлийг авч нурууг салхинд цохиулах, хавар цасны шар ус уулгах, халуун ногоо идүүлэх болон тохиромжгүй эмээл тохох зэргээр нурууг олон дахин авснаас үүссэн нурууны архаг өвчнийг жидүүгэнэ.

Шинж тэмдэг:Жидүүрсэнатууны хур дэлнийурд талд эхний үе д зөөлөн, цаашдаа хатуу хавдар үүснэ. Энэхүү хавдар дээр дарахад ихээхэн эмзэглэх бөгөөд хагарахгүй удна, хагарвал идээ бээр гоожно. Өвчтэй адуу тонгойж идэж, ууж чадахгүй болно. Гэдсээ татна, хүндэрсэн үед адуу хөдөлж явж чадахгүй зогсоно. Зуны цагт шарх өтөж, өвөл хөлдөж улам сэдэрдэг. Эдгэрсний дараа адууны хур дэлнийурдуур шил нь сэтэрхий, хотгор болно. Уналгын морь өвчилбөл уналгын жидүү, эмнэг адуунд гарвал зэрлэг жидүүгэж нэрлэдэг.

Эмчилгээ:Жидүүгтөөнөх, ханах аргын аль нэгийг хэрэглэж эмчилнэ. Өвчний эхний үед овойж хавдсан сэрвээ, мундааны хавдар дээр халуун шар тос нэвчүүлсэн эсгий тавьж дээрээс нь тамга буюу халуун төмрөөр халууныг мэдэрч байж ядтал 3-4 удаа төөнөнө. Мөн хавдрын доод талаас нь үзүүртэй улайсгасан зэсээр цоргиж, гарсан нүхээр хялгас сүвлэж өгнө. Хавдар дээрээс чагт хэлбэртэйгээр халуун төмрөөр төөнөх арга байдаг. Жидүүтүссэн үед далны дээгүүр гүрийсэн судас томорч (мундааны хар судас гэнэ) ирэх бөгөөд судсыг мундааны хоёр талаар зэрэг хатгаж жидүүгэмчилнэ.

Далан түрүүний үндсийг чүдэнзний модны талын хиртэйгээр арьсан доогуур шургуулж оёж тогтооход идээ бээр гоожиж жидүүэдгэрэх талтай (С.Самба). Жидүүхүндэрч адуу хүзүүгээ доош хөдөлгөж чадахгүй болсон үед сээр хүзүүний сиймхийг (онжрого) нэвт хатгаж болно. Ингэхдээ хүзүүний сиймхийннөгөө талаас ташуур (мод)-аар тулж наанаас нь ташуурын үзүүр тушаа нэвт хатгана. Хэрэв эдгэрэхгүй бол сүүлний хоёр талаар явсан судсыг (хар хошногын судас) хатгана (Н.Оросоо). Морины нурууны элдэв шарханд аранжинзэсийг Хуурайдаж гаргасан үртэсбуюу гишүүний үндэс нунтаглаж хийхэд сайн гэдэг.

Мөнжидуусугалахэмчилгээ гэж байдаг. Өвчтэй адуугаа хүлж бэхэлсний дараа хамрын хоер нүхний хоорондох зөөлөн арьсан дээр арьсыг 3 см хиртэй дээрээс доош ярж үзэхэд чүдэнзний хоёр модны хиртэй шөрмөс тааралдана. Уг шөрмөсийг соёогоор

өлгөж сүлбэн авч гурав эргүүлээд дээд талаас ирсэн шөрмөсийг огтолно. Мөн эргүүлсэн шөрмөсний үзүүрийг огголж авна. Үүний дараа адууныхаа чихнээс барьж толгойг доош нь хэдэн удаа дарж биеийг тэгшлэх засал хийнэ. Зарим малчид энэ засал хийсний дараа ороо харыг хатгадаг. Жидүү хагарсан үе д идээ бээрийг угааж цэвэрлэнэ. Зарим малчид эдгэрдэггүй жидүү туссан морины нурууг тарваганы түүхий махаар хөхүүлэхээс өөр сайн арга байдаггүй гэж үздэг. Түүний тулд тарваганы түүхий махыг жидүүтэй хэсэг дээр тохож бэхэлж татна. Тарваганы мах үнэр ортол байлгана. Жидүүрсэн газрын мах хоёр дахь удаа хөхүүлэхэд өвчилсөн мах ягаан болно. Гурав дахь удаа хөхүүлэхэд өвчилсөн хэсэгт хар хөрс ургаж эхэлнэ.

ЖИЛБЭН

Морийг гамгүй унаж эдлэх, мал арчлах, тэжээх, услах дэг журам алдагдуулснаас шалтгаалан бие махбодийн үйл ажиллагаа хямарч эмгэгшихийг жилбэнтэх гэнэ. Жилбэнтсэн морь гэдсээ татаж, өнгө зүсээ алдаж, мундаа, ташаан толгой, бөөр, хондлой, хонго сугаар хавдаж нэвчин идээ бээр гоожно. Өвчтэй адуу өвс тэжээл идэх, идээшлэх дургүй, тамир тэнхээгүй болж эцэж турах зэрэг шинж тэмдэг үзүүлнэ.

Монголчууд адууны жилбэнг шалтгаан, цаг улирал болон эдэлгээ, арчилгааны нөхцөлтэй холбон хаврын усан жилбэн, намрын тосон жилбэн, зуны наран жилбэн, ташуурын жилбэн гэж ангилдаг.

С.Бариад, Ж.Дамиран, Д.Гунгаа, Н.Бадарчин, Б.Раднаабазар, М.Нарангэрэл, Ц.Пүрэвзав, Т.Норов, Т.Ривади, Ө.Бүрүү, Д.Балтуу зэрэг олон малчид болон хэвлэл мэдээллийг үндэслэн энэ өвчний шинж, эмчилгээг дурьдвал:

Усан жилбэн: Хаврын улиралд тохиолдох бөгөөд түүний үндсэн шалтгаан нь малын тарга хүчинд тохируулан унаж эдлээгүй, эсвэл амраалгүй халуун биен дээр нь ялангуяа хөлс нь хатаагүй байхад услах, эмээлийг авч салхинд цохиулах, цас идүүлэх зэргээс жилбэн тусна. Хавар уналгаа эдэлгээний морийг амраахгүйгээр услах, адуун сүргийг усны зүг ширүүн хөөж хөлөргөхийг цээрлэж ирсэн монгол уламжлал нь жилбэнгээс сэргийлэх арга юм.

Шинж тэмдэг: Усан жилбэн туссан адуу өнгө алдах, явахдаа амьсгаадах, нүд нь гөлрөх (онцлох шинж гэж үздэг) хамраас нь ус гоожих, толгойгоо унжуулан гөлийж зогсох зэрэг шинж үзүүлэх бөгөөд хүндэрсэн үедээ нуруу үе мөч нь хавдаж, хагарч, нэвчинэ. Явахдаа хойд хөлөө чирнэ.

Эмчилгээ: Усан жилбэн туссан адууны толгойг эсгий, хөвөнтэй туургаар битүү хучиж эрүүн доор нь хувинтай цогонд үхрийн өөх, шар тос, яс, адууны цагаан хомоолын аль нэгийг хийж хиншүү гарган адууны хамраас ус гоожтол сайтар утна. Ингэхэд бие нь хөлрөх бөгөөд хөлөрсөн даруйд адуугаа нэмнэнэ. Тарваганы хатаасан цөс, баавгайн доньд өгөх, хошноогоор нь дүнсэн тамхины утааг үлээх, татуулах, яс махны шөлөнд шар будаа чанаж өгөх, дөнгөж төхөөрсөн хонины халуун гүзээг зоон дээр нь тавьж жигнэх, олон ясны уулзварт төөнөх буюу халуун жин тавих, буцалсан усанд булхсан тохмоор жин тавих зэргээр хорыг гадагш татуулах арга хэрэглэнэ.

Усан жилбэнтэй адууны борвины сиймхийг нэвт хатгаж хурууны хиртэй хялгас томож гарсан нүхэнд сүвлэн хоёр үзүүрийг зангидна. Энэ нь мах ,арьс доор хуримталсан шар усыг гадагш нэвчүүлэх зорилготой (Б.Юнрэн).

Усан жилбэнтэй морийг дөнгөя- нядалсан хонины нэхийгээр нэмнэж нэвчүүлдэг. Нэмнээд 2-3 хоноход нэхий ногоорч, үс халцарч, үнэр орно. Хэд хоногийн дараа нуруу. сэрвээ, мундаа. ташаан толгой орчмоор хавдаж хагарч нэвчинэ. Ийнхүү нэхийгээр хөхүүлэх эмчилгээг намар хийж евчтэй морио адуунд тавиад хойдон хавар эрт ногооноор барьж цочир унадаг.

Усан жилбэнтэй адууг тэнхрүүлэн эмчлэх- зорилгоор шилмүүст зулзаган модны шилмүүс, үрийг хандалж 2-3 литрийг өдөрт нэг удаа, гурван өдөр дараалан өгөх буюу үхэр, хонины сүүг бүлээнээр нь хагас литр өгөөд унаж хөлөргөнө. Мөн усан жилбэнтсэн адууны хошноогоор 7 мөс хийж, сүүлний гол судсыг хатгана. Цавгийн утаатай шар эсгий тохож хөлөргөнө. Хэрэв бололцоотой бол Малын хээлийн уснаас бүлээнээр нь хоёр өдөр дараалан литр хагасыг өгч" нэмнэхэд тус болно.

Жилбэн тусахаас сэргийлэхийн тулд малгайнхаа хөлсийг үнэртүүлсний дараа эмээл авах, эсвэл хөлсийг хатааж эмээл авдаг ёс уламжлал бий.

Тосон жилбэн: Гол төлөв намар IX, X сард тарган цатгалан морийг уяж сойхгүйгээр ширүүн унаж эдлэхээс шалтгаалан үүсэх эмгэг юм. Эдэлгээний морийг гамгүй унаж, халуун бие дээр нь өвс идүүлэх, амрааж хөлсийг хатаахгүйгээр хүйтэн усаар услах, оройн шүүдэр бууж байхад хөлсийг хатаалгүй эмээл авах, халуун нартай өдөр эмээлийг гэнэт авах зэргээс үүснэ.

Шинж тэмдэг:Тосон жилбэн урхаг ихтэй хүнд өвчин бөгөөд туссан даруй бүх шинж илрэхгүй байж болно. Өвөл болсон хойно цавь, суганы үс халцрах, нүдний гал буурах, хавар ногооноор тарга хүч авахгүй, үс бөөгнөрч өнгө өөрчлөгдөнө, гуужихгүй байх, хамраас шар ногоон шингэн гоождог. Архагшихдаа хаа, гуя зэрэг нимгэн арьстай газарт хавдар ,уүсч хагарч нэвчинэ. Тэнхээ тамиргүй болж удаан хэвтдэг.

Эмчилгээ:Эмгэгийн хорыг гадагш татахын тулд аяга шар будааг битүү төмөр саванд хийж шатаан нүүрсийг нунтаглаад нэг шанага өтгөн хар цайтай хольж цутгаж өгнө. Бор гөрөөсний савыг хатааж нүдээд түүнээс зулын цөгц хиртэй авч хагас литр усанд буцалгаж хөргөөд өгөхөд сайн үр дүн өгдөг. Сая гаргасан хонины халуун нэхийгээр нэмнэж, халуун сэвсээр нь олон ясны уулзвар, зооны орчим жин тавина.

Тосон жилбэнтэйморинд хотны шавхайг чанаж өгөх арга байдаг. Хүрэн суман модны зоргодос нэг цайны халбага хиртэйг хоёр шанага хиртэй усанд буцалгаж сайн ширгээж хөргөөд цутгаж өгнө.

Эмчилгээ тохирч байгаа бол морины сүвээний хавирга, ташааны шонтгор зэрэгт битүү хавдар үүсчудалгүй цоорч нэвчинэ. Хэрэв хавдар аяндаа цоорохгүй бол өмхий шавар, хонины нойтон год, малын уушигзэргээр хөхүүлэх, хутгаар хавдрыг яржцоолох аргыг хэрэглэдэг. Эмгэгийн хор үе мөч рүүбуувал хөл хавдана. Хөлнийхавдрыг өөрөө өрхөлжхагарах хүртэл халуун жин тавьдаг. Шөрмөсний сиймхий, хаа, хаснысудсыг ханаж хорыг авдаг. Зарим малчид морины тагнай, сүүлний гол судсыг, хэрэв засрахгүй бол товчлуурыг хатгадаг байна.

Адууны чалхыгсайжруулах тэнхрүүлэх зорилгоор тосон жилбэн туссан, адуунд 7 хоногийн зайтайгаар 2-3 удаа хиншүүгээрутах, тарваганы цөс1-2 ширхэг, чонын бүтэн цөсний хагасыг

усанд хандлан өгөх, баавгайн доньдхэлэнд түрхэх, 7 хоногийн зайтай 2 удаа дотуур сүү өгөөд хөлөргөх засалхийнэ. Ийнхүү эмчилсэн адууг намар цагаан хяруу унах хүртэл унаж эдэлдэггүй. Цагаан хяруу унах үед эмчилсэн морийг барьж цочирхон, ширүүн унаж хөлөргөөд сайн уяж сойгоод тавихад урхаггүйэдгэрнэ.

Наран жилбэн: Зун, намрын халуун нартай өдөр уяа сойлгоныдэг алдсанаас үүснэ, Их нартайд хөлс хатаагүй байхад тохмоо сэвж, ус цацахгүйгээр эмээл хуулах, ширүүн эдэлгээний дараа амьсгааг нь даралгүй эмээл хуулах, усалснаас болж нуруу хавдах байдлаар илэрнэ.

Шинж тэмдэг:Наран жилбэнгийнонцлог гэвэл үсний үзүүр хуйхалсан мэт болж сайн ажиглавал үс нь мушгирсан, үсийг илэхэд их хэмжээгээр сугарч унана. Морины нуруу хавдах, цоорох, нэвчих, зэрэг урхагилэрнэ. Нүд, амны салст улаавтар өнгөтэй болно. Үе мөч хавдах, гэдсээ гатах, хажуугаар эвхэрч хэвтэх зэрэг шинж үзүүлнэ.

Эмчилгээ:Наран жилбэнтсэндуунд шар модны шүүс, ясны шөл, мөн гурван үе ургасан халгайг сүүдэрт хатааж хандлаад өдөрт 1 удаа өгч 3-4 хоног эмчилнэ. Гүрээнээс цус авч болно. Цавгийн шар эсгийг хүйтэн усаар нэвт норгоод адууны нуруу бэлхүүсээр ороож эсгий дээрээ хүйтэн ус ахин дахин асгаж эмчлэхийг сайн арга гэж үздэг (З.Пунцаг).

Ташуурын жилбэн: Унааны морины өлхоолыг тохируулахгүй хэт ширүүн эдэлж тамирдуулах, халуун хөлстэй байхад эмээл авч нурууг салхинд цохиулах, хөлстэй үед нь будаа идүүлэх зэргээс үүсдэг байна. Ташуурын жилбэн туссан адуунд хөх дарь, баавгайн доньд, түлсэн шар будаа, шар тос, малын цөс, тарваганы цөс, цагаан мөөг өгч эмчилнэ. Дээр дурьдсантөрөл бүрийн жилбэнгоношлох, эмчлэх түгээмэл арга байдаг. Жилбэн мөн эсэхийг оношлохын тулд гаансанд тамхи асаагаад морины хошногтхийхэд хэрэв тамхийг унтартал татаж байвал жилбэн гуссангэж үзнэ. Жилбэнгийн шинж тэмдэг тэр даруйдаа илэрч, мундаа, далны хавтсаар хавдаж хагарч нэвчих боловч зарим тохиолдолд хэзээ хойно дараа жилдээ илэрдэг тал бий.

Тосон жилбэн туссан адуу дараа жилийн нялх ногоо идэх үед гэнэт сульдаж, гэдсээ татаж, үс гуужилгүй шар үстэйгээ хатаж эцэж турах бөгөөд хаа, гуя, хонго мундаагаараа нэвчих, хамар амнаас цус идээ, бээр гоожих зэрэг шинж тэмдэг үзүүлнэ.

Усан жилбэнтсэн морь намар эмгэгшижбие нь сульдах, хавдах, цоорох, нэвчих, туран хатах явдал ч тохиолдоно. Аль ч жилбэнгийнхорыг авч анагаах түгээмэл арга туршлага бий. Жилбэнгийнхорыг авахын тулд юуны өмнө жилбэнтсэнморийг нэмнэж үхрийн түүхий сүү, хонины ясны шөл, тарваганы шаз, тууплин, улаан өвс, шар модны ханд, гөлөглөж буй бургасны нялх дол, хар модны нялх боргоцойн чанамал зэргийг бүлээнээр цутгаж өгсний дараа унаж хөлөргөдөг. Түүнчлэн аливаа жилбэн туссан моринд ясны шөлөнд шар будаа чанаж 2-3 өдөр, өдөрт 2-3 удаа өгч байгаад хас, сүүлний гол судсыг цувуулан (нэг зэрэг биш) ханаж засал хийдэг. Аль ч жилбэнд цагаан зээр, хар сүүлтийнхээлнийүс үнэхээрийн сайн (С.Бариад).

Тосон болон усан жилбэнтэй адуунд үнээний түүхий сүү нэг аяга, мөн хүний сүүг хагас цөгц, төлгөн хонины сүүг нэг цөгц өгөхөд хорыг гадагшлуулах, задлах нөлөөтэй гэдэг. Ямар ч жилбэнд монгол тууплин буюу цахилдагны үндсийг чанаж өгнө. Таван литр усанд нэг аяга

үндэс хийж хандлаад 7 хоногийн зайтай 3 удаа өгнө. Аль ч улиралд тохиолдох жилбэнтэй адууны гуяны дотор талын гурван судасны уулзуур дээр ханахад эдгэрнэ (Ч.Идэр).

ХЭТҮҮ

х

Даага шүдлэн зэрэг бага насны адуунд элбэг, нас гүйцсэн адуунд ховор тохиолдоно. Хэтүүгээрөвчилсэн адууны дал мөрнышонтгор, цээжний хөх мах, хүзүүний уг, дал бугалганыюрчимд аяга хөмөрсөн мэт бондгор халуун, хатуу их өвчинтэй хавдар үүснэ. Хавдар хагарахгүй удна. Хатгахад шүүс гарна. Өвчин туссан адуу гүлдийнзогсож, халуурвал удахгүй үхнэ.

Эмчилгээ: Улайсгасан зэс буюу төмөр илүүрээр хавдрыгтойруулан үсийг, мөн хавдрын дунд хэсэгт тонолжин хайрч эмчилнэ. Мөн хавдрын зөөлөрсөн хэсэгт цоо хатгаж болно. Хавдар өрхлөөгүйхатуу байх үед цоо хатгаж хэрэггүй гэж үздэг.

ХОРХОЙДОХ(ЗЭЭГТЭХ)

Өвөл гол нь хөрсөн, зун цангаж наршсан тарган морийг хол газар ширүүн эдэлснээс хорхойдох гэгч эмгэг тусдаг гэж үздэг. Хорхойдсон адуу бөгсөөрөө элдэв зүйлийг шөргөөнө. Гэдсээ 2-3 хоног татна. Эмгэг хууч хүндэрвэл босож чадахгүй, сүүлийн хялгас унаж шодон болно. Сүүлдээ бөгсөн бие, хавирганы үс унаж эхэлнэ.

Эмчилгээ:Хорхойдсонадууны сүүлийн гол судсыг ханана. Сүүлний угаас дөрвөн хуруу зайд сүүлийн доод талд судсаа тэмтэрч олоод хатгана. Нэг литр орчим цус гарах үед буюу хөөстэй цус гарч эхэлмэгц хатгасан газарт бөөрөнхий юм тавьж боогоод цусыг тогтооно. Гол судсыг бүдүүн зүүгээр хатгавал сайн. Морийг ус уугаагүй үед ханана. Зарим малчид хоёр хасыг ханаад 4-5 хоногийн дараа сүүлингол судас ханадаг. Сүүлийг давстай цагааны шар усаар хэд хэд угаахад өвөлдөө сүүлний хялгас бүрэн ургана.Хорхойдсонадууг мөн өөр аргаар эмчилдэг. Хошногониымгэн арьсыг зүсэж бага зэрэг хөндийлөөд түүн дотор зэсийн цэнхрийг шатааж үхүүлэн цайвар өнгөтэй болгож, түүнээс хурганы хорголын хиртэй хийж эмчилнэ (Ж.Хавдалдай). Бйгйнозэс утас хошногониарьсан доогуур шургуулж 7 хоног байлгаад авахад өвчин эдгэрдэг тал бий гэдэг.

УНАЛГЫН ХОР СУУХ

Хамраас ногоон нус, нүднээс нуух гоожих, турах, өнгө алдаж бүрзийх, амьсгаадах шинж тэмдгээр илэрнэ. Уналгын хорыг хүйтэн, халуун гэж ялгаж үзнэ. Найлзуулбулчирхай хавдахгүй (Д.Сумъяа). Хүйтэн хор үүссэн бол хойд хөлөөрөө гэнэт доголно, хамарт нь хуруу хийж үзэхэд хүйтэн байна. Ийм моринд 250 грамм хиртэй шээс өдөрт 3 удаа өгнө, 3-4 хоносны дараа доголох нь гайгүй болох үед хоёр хасыг зэрэг хатгана.

Намар цагаар тарган морийг болгоомжгүй унаж эдэлснээс халуун хор үүсэх бөгөөд амьсгаа ихдэж, идээшлэх дургүй болно. Хамарт нь хуруу хийхэд халуун байна. Ийм адуунд гараа хүйтэн усанд угаагаад угаадсыг өгнө. Ийм засал хийхээс гадна өвчин намдаж ирмэгц нь хоёр дөрөөлөхийг зэрэг хатгана. Эмгэгийн хор суусан адууны эхлээд хоёр самсааг, 7 хоногийн

дараа хоёр чамархайг, 10 хоногийн дараа сүүлний гол судсыг ханана, үхрийн баас усанд зуурч өгнө.

УСАН АЛЬБИН

х

Энэ эмгэгийг зарим нутагт сур цохино гэж нэрлэдэг. Адууг дулааны улиралд олон хоног услахгүй, цангаасны дараа гэнэт усалсанаас усан альбин тусна. Усан альбин туссан адуу усалсны дараа унаж, хөрвөөн тийчилнэ. Мөн өлдсөн цангаснаас болж салганана, хар хөлс асгарч, хөх мах чичирнэ, хүнээс айхгүй, ижлээс тасарч тэнэнэ.

Эмчилгээ: Шар хомоол, үхрийн халтар аргалын утаагаар утахад сэхэх боловч бүрэн эдгэрэхгүй. Бүрэн сэргээж тэнхрүүлэхийн тулд нүднээс хамар руу явсан судсыг ханана. Усан альбин тусахаас сэргийлж олон хоногоор услаагүй адууг бага багаар дасгаж усална.

Өвчтэй адууны нүдэнд хоергоний халбагаар хамрын тамхи хийхэд хөлөрнө, дараа нь хойд хоёр онгон (хас)-ыг зэрэг ханахад сэхдэг. Үүнээс сайн арга байхгүй (У.Ёндон).

ТААРАХ

х

Тачир хагд өвстэй, цас багатай бэлчээрт хариулж байгаа адуу, элс шороотой цас, ялзарч хөгцөрсөн хөлдүү ногоон өвс, хөлдүү хужир идсэнээс таарах эмгэг тусна. Зарим нутагт суртах гэж нэрлэдэг тал бий.

Шинж тэмдэг: Энэ эмгэг туссан адууны гэдэс умс хийгээр дүүрч хатгааны шинж үзүүлнэ. Таарсан адуу гэдсээ байн байн чагнаж, гэдсээ хайрах, цавчих, харах оролдлого хийнэ. Хоёр сугаараа болон өвчин хүндэрвэл бүх биеийн хөлс асгарна. Гэдсийг чагнахад хужигнаж, бөөрний хоёр хонхор, гэдэс хийгээр дүүрч цэндийнэ.

Эмчилгээ: Таарсан адууг эмээллэн мордож уруу, өөдгүй ядартал давхихад бүх бие нь хөлөрч, чацга алдвал зүгээр болно. Сайтар хөөн тууж унгуулах, чацга алдуулахад мөн засал авна.

Адууны гэдэсний дүүрэлтийг намжаахын тулд цайны жижиг халбага хиртэй хөх дарь, хүчтэй исгэлэн цагаа, гурилын зутан өгөх, ногоон хомоолоор утах арга бий. Хэрэв өвчин хүндэрсэн бол хаа болон сүүлний гол судсыг хатгана. Эсвэл цорводож байгаад уруулын голд 1 см орчим гүн хатгана. Бас дэлүүг шөвгөөр хатгаж болно (Н.Орсоо). Биеийн тэнхээ тамирыг засахын зорилгоор дугуй булантай цайны талыг хандалж өгч болно.

МОРЬ НУРУУГАА АВАХ

х

Нуруугаавсан морийг удаан хугацаагаарунаж эдлэх аргагүйболох учир морь нуруугаа авахаас сэргийлэх явдал тун чухал. Унаж байгаа морины тохон нимгэн, дайртай, олом жирэм

сул явснаас эмээл холхиж нурууг үрж холгох, эмээлийн хавтасны хоорондох зай хэт нарийхан буюу өргөн байвал эмээл нь морины нурууг дарж холгосоор морь нуруугаа авна.

Хийц тохироо муутай эмээл хэрэглэх, эмээлээ хэт урдуур буюу хойгуур тохох, морийг буруу эмээллэх (эмээлийг тохохдоо үсийг урдаас нь хойш нь илэх янзтай тохвол үс хугарч дарагдахгүй) моринд хэтэрхий дүүжилж мордох, хоёр хөлөөрөө хэт давирах, биеэ урагш займчуулах, гуйвах, найгах зэргээр морийг буруу эдэлж унаснаас морь нуруугаа авч болно. Унаж хөлөргөсөн морины хөлс хатаагүй байхад эмээлийг гэнэт авч нар, салхи, хар чийгт цохиулах, хурц нар харвуулах, амьсгааг нь дарахгүйгээр услах, унаж ядраасан моринд цас идүүлэх, цасны ус уулгах зэргээр морь буруу унаж эдэлснээс нуруугаа авах бас нэг шалтгаан болно. Энэ тухай жилбэнгийн тухай өгүүлсэн хэсэгт дурдсан.

Морины нуруу автахаас сэргийлэх уламжлалт арга олон бий. Хөлстэй морины эмээл авах хэрэг гарвал зуны халуун нартайд ус цацах, намар, өвлийн сэрүүн цагт хуурай үнс цацах, тохом тохох арга байдаг. Ер нь морины тохом зузаан, дайргүй байх нь чухал юм.

Шинж тэмдэг:Мордоход хотолзож эмээглэх, нурууны арьс улайх, халуун болох, хүндэрвэл шархалж идээлэх, арьс нэлэнхийдээ хавдаж хөндийрөн улмаар сэдэрч идээ бээр гоожно.

Эмчилгээ:Нуруу халцарч, арьс нь зүлгэгдэж хөрсгүй болсон байвал тостой хөө, тарваганы тос, түүхийцөцгийн тос, шар тосны аль нэгийг түрхэн эмчлэх бөгөөд хөрс сууж, үс ургатал эмээллэхгүй байхыг хичээнэ. Нуруу үрэвсэн битүү хавдсан байвал хүйтэн жин тавих, давстай хүйтэн усаар шавшина. Олон дахин нуруугаа авсан ,морь үхмэл нуруутай болно. Үхмэл нуруутай морийг эмээллэж унахад нуруу, сээрээрээ шалбарч хавдах бөгөөд заримдаа овойж хавдан цоорч нэвчинэ.

Үхмэл нуруутай морины нурууг задалж эмчлэх арга бий. Үүнд: нуруун дээр хонины халуун уушиг буюу сая төхөөрсөн хонины хойдон год, эсвэл өмхий шавар тавьж өдөржин, шөнөжин хөхүүлэхэд нурууны мах ягаарч ирнэ. Үүний дараа хар хүрэн өнгөтэй үхмэл махыг өвчин авч улаан ягаан өнгөтэй эм махыг үлдээнэ. Ийнхүү гарсан шархыг цагаан мөөгний шөл, модны агилын ханд зэргээр шавжтостойхөө түрхэнэ.

Эсвэл лууль өвсний хатаасаннунтаг түрхэнэ. Нуруу ньидээлсэн болтүүнийг цэвэрлэж исгэлэн тараг түрхэх, хатаасан яргуйг нунтаглан шархалсан хэсэг дээр тавьж бооход сайн. Үхмэл нуруутай морины сүүлний гол, зооны бүдүүп судас, цорвоны аль нэгийг ханаж болно.

Мөнмундааны хоёр талаар хойшоо явсан (эмээлийн хавтсан тушаа) судсыгханах маш сайн(А.Намсрай).

Нурууавсан адуундтэмээний, тэмээнд адууны шир түлжнүүрсийг нунтаглаад гэмтсэн нуруунд түрхэдэд гойд сайн. Хоёроос илүү/ түрхэлтгүй (Ш.Дамиран).

Адууны мундааны аль нэг талд нь хавдар үүсч хагарч нэвчих, идээ бээрт сэрвээний яс идэгдэх тал бий. Үүнийг онгон дайр гэж нэрлэдэг. Энэ тохиолдолд улаан шоргоолжны үүрнээс нэг атга авч литр усанд хар хүрэн болтол буцалгаж түүгээр мундааны хавдар, шархыг 2-3 удаа угаана. Хэрэв жидүү байсан бол ингэж угаахад эдгэрэхгүй. Мөн сохор цох 1-3-ыг бүтнээр нь дотуур өгч эмчилнэ. Чихийг урагш хэвтүүлж, чихний үзүүр хүрэх цэг дээрх чамархайн

судсыг ханаж эмчилдэг. Ийнхүү засал хийсэн морийг жилээс доошгүй хугацаагаар унаж эдлэхгүй.

Нуруу өвчилсөн үед далны ар талаар мундаа руу орсон судас гүрийж гарч ирнэ. (нуруу өвчлөөгүй бол мэдэгдэхгүй). Тэр судсыг ханана. Адууг 4-5 сард ханах нь зүйтэй (Ц.Пүрэвзав).

ЗООГОО АВАХ

х

Энэ эмгэгийг зоо авах, үгцүүрэг, цүгцүүрэг гэх зэргээр нэрлэнэ. Морь унаж яваад огцом хазгай суух, цочмог огло үсэргэж давхиснаас зоо нурууны урт булчингийн хойд талын холбоо хуурах, сунах, арьс булчингийн хооронд зай гарч хөндийрөх, нурууны мах булчин агших, нурууны загасан булчин (зураа) гол мах нь яснаасаа хуурч хөндийрснөөс зоогоо авах эмгэг үүснэ.

Шинж тэмдэг: Илрэх шинж тэмдгийг үндэслэн зоогоо гадагшаа, дотогшоо авсан гэж ялгаварлана. Зоогоо гадагшаа авсан морь толгойгоо гэдийлгэн хондлойгоо намсхийлгэн хойшоо сууж доголно. Зооны мах нурууны хоёр талаар овойно. Мөн хойд хөлийнхөө туурайн урьд ирмэгээр хумсалж дутуу гишгэж огцом эгц доголно. Бөгсөн бие мурийна. Зоогоо дотогш авсан морины толгойгоо тонгоруулж бөгсөн бие дээш оодогнуулж доголно. Хойд хөлөөрөө гишгэхээс эмзэглэх учир тэр хөлөө сойж, биеийн бүх хүчийг цээжин биедээ хурааж биеэ чирсэн байдалтай, хүзүүгээ сунгаж, толгойгоо доош тонгойлгон цээжээрээ түрэх янзтай явна. Дотогшоо зоогоо авсан морь хөлөө гадагш чирч доголно. Хоёр хасын доторх судсууд зангирсан байна.

Зоогоо авсан морины чихэнд ус хийхэд бүх биеэрээ тэгш шилгээж чадахгүй байдгаараа бусад өвчнөөс ялгаварлах арга болдог. Зоо авсан талын чихэнд ус хийхэд сэгсрэхгүй, зоо аваагүй бол сэгсэрнэ (Хар домын судар). Зоогоо авсан морины ар талаас харахад хоёр талын ташаа тэгш бус, хэлтгий харагдана. Зоо авсан талын хөлийг зовууртай сойж зогсоно. Удах тусмаа гуя ташаан толгойн булчин шуугдаж хатаж эхэлнэ.

Эмчилгээ: Хөндийрч хуурсан булчин ясыг барьцалдуулахын тулд зоогоо гадагшаа авсан бол эмээлийн хойд хавтсан доор ташуур буюу бөөрөнхий мод_ 4-5 хуруу хиртэй шургуулан оруулж ташуурын хойд үзүүрийг олон ясны уулзвар ташаан толгойн дундах хөндлөн булчин хүргэж тавиад эмээлээ тохиож уг морийг доголсон тийш нь гурав эргүүлж засал хийнэ. Өвөл зоогоо авсан даруйд бас хавтгай ташааны хонхорт хомоолын нарийн үзүүрийг хойш харуулан тавьж зургаагаас доошгүй удаа зангидсан гараараа шааж ташаан толгойн махыг доргиодог. Үүнийг хомоол цохих гэнэ. Мөн цай нүддэг модон уурыг ташааны зузаан махан дээр гавьж уураа огцом цохиж доргиоход засардаг. Зооны махан дээр хатуу аргамж цагираглуулан тавьж мунаар зөөлөн цохих арга

2 хэрэглэнэ. Мөн зоогоо авсан морины доголоогүй талын хөлийг борвиор нь чанга боож хөтлөн давхихад доголсон хөл дээрээ хүчлэн гишгэж зүгээр болдог, эсвэл тэр боодолтой нь хэд хонуулахад өвчтэй хөлөөрөө гишгэж засардаг тал бий. Морины сүүл, толгойг ойртуулан зоо авсан тал руу нь эргүүл гэж цагаан домын сударт заасан байдаг.

Дээрх засал хийхэд эдгэрэхгүй Бол бусад арга хэрэглэнэ. Үүнд: Зоогоо гадагш авсан бол сүвээний 3 хавирганы араар нурууны хөндлөн сэртэнг голлож, сэртэнгийн доод талаар яс булчингийн завсраар яс дагуулан 2 хуруу (3-4 см) хөндлөн гүн хатгана. Зоогоо дотогш авсан бол гараа угааж цэвэрлээд сайтар тосолж хошноогоор нь оруулан гол махыг дагуулан тэмтэрч үзэхэд хэрэв гол мах нь овойж товойсон байвал гарын

3 хурууны өндгөөр хэд дахин илэлт хийнэ. Үүний дараа гол махыг хатгана. Сүвээний гурван хавирганы араар нурууны хөндлөн сэртэнгийн доод талаар яс дагуула! хөндлөн хатгана. Зоогоо дотогшоо авсан тохиолдолд доголсон хөл талын цавиар оосорлож хойш нь татаад 3 дахин тонгочуулбал засарна. Бас гуяны хуянг хатгах ба эсвэл "зоо самнах" эмчилгээ хийнэ. Үүний тулд нурууны яснаас доош 4 хуруу тавьж сүвээний сүүлийн 3 хавирганы урдхануур хуруу хагас хиртэй эгц доош нь хатгана. Хатгасан нүхээр хий үлээж төмбийтөл хий оруулна. Энэ аргыг зоо самнах гэж нэрлэнэ. Дотор зоо авахад бас дараах засал хийдэг: - Морины хойд хөл хазайж байвал олон ясны уулзуур, ташаан толгой, өгзгөөс тус тус гурав, гурван хуруу тавьж үзэхэд тэдгээрийн уулзуур тушаа хонхор байх бөгөөд тэр тушаа мухар сөөм хатгаж засал хийнэ (С.Ишдорж). Адууны хомоол хатсанаас хошногт нь тогтоож түгжирснээс дотор зоо авч болох бөгөөд гараараа хатсан хомоолыг авах хэрэгтэй.

Зоогоо авсан морийг цорводож уруулын үзүүрийн үсний эргүүлэг дээр шөвгөөр 2 хуруу гүн 7 удаа хатгаж шивэхэд засал авна (Ц.Пүрэвзав, Д.Гунгаа, П.Гатав). Зоогоо авсан морийг тангаруулж болохгүй (тангаруулж засал авсан ч хэлтгий ташаатай болно), харин доголсон хөлийн хасын олон судасны уулзуур дээр ханах (их цус гарна) нь сайн гэж Д. Дайдаахүү үздэг.

Морь хойд хөлөө чирч хойшоо доголоход ар хонгоны хар зураасны адаг хонхорт сайн төө гурван хуруу хиртэй хутгаар хатгаж засал хийдэг (Д.Базарсүрэн, Д.Балдорж).

ХӨЛД ЦУС БУУХ

х

Буруу унаж эдэлсэн морины ихэвчлэн урд хойд хөлийн нарийн шилбэ, бэрэвхий орчмоор эмзэглэж доголохыг хөлд цус буух гэж нэрлэнэ. Уналгыг хэхрүүлэх, алс хол амраалгүй давхисан, унаж эдэлсэн морийг гэнэт зогсоох, ялангуяа халуун бууцан дээр уях, удаан хугацаагаар чөдөртэй байлгах зэргээс хөлд цус буух гэгч гэгийг олно.

Шинж тэмдэг:Хөлд нь цус буусан морь толгойгоороо доош дохиж доголох, хатуу газар гишгэхдээ эмзэглэнэ. Зогсож байхдаа хөлөө ээлжлэн сойно, удаан зогсож чадахгүй тул байн байн хэвтэж босно. Биеийг халтал унаж эдлэхэд доголох нь намдаж байвал хөлд цус буусны онцлог шинж байдаг. Хойд хөлд цус буух нь тун ховор, хэрэв цус буусан бол бэрэвхий хавдаж барьж үзэхэд халуун байна. Хэрэв хоёр хөлд цус зэрэг буусан бол бөгсөө чирнэ. Адуу дагаж чөдөртэй морь их дэвхцвэл зөв талын хойд хөлд цус буух тал бий.

Морины хөлд цус буухад тэр хавийн сагагнаас доош халуун, бүдүүрч хавагнасан, барьж үзэхэд эвэр, туурайн гярх дагаж их халуун, бамбалзуур, эмзэглэх онцлогтой.

Эмчилгээ:Цус буусан хөлийг давстай хүйтэн хар цайгаар шавшиж жин тавьж бооно. Хонины халуун сэвс, хужир, давстай шорвог шавраар хэд хэдэн удаа шавахад цус буусан хөлийн хаван татарна. Цус бууснаас болоод ихээхэн доголж явж чадахгүй байвал нэг талын туургыг, эсвэл урд хоёр хөлийн туургыг гадна дотроос нь хатгана. Онгон сиймхий (бэрэвхий сиймхий)-г хатгаад эрхий болон гурван хуруугаараа чөдөрлөхийн сиймхийн хоёр хажуунаас хавчин барьж доош нь илж шувтарна. Голхио самарснаас чөдөрлөхийн орчимд цус буусан бол чөдөрлөхийн сиймхийг ханаж цус авна.

ХӨЛД ЦУС БУУХ

х

Буруу унаж эдэлсэн морины ихэвчлэн урд хойд хөлийн нарийн шилбэ, бэрэвхий орчмоор эмзэглэж доголохыг хөлд цус буух гэж нэрлэнэ. Уналгыг хэхрүүлэх, алс хол амраалгүй давхисан, унаж эдэлсэн морийг гэнэт зогсоох, ялангуяа халуун бууцан дээр уях, удаан хугацаагаар чөдөртэй байлгах зэргээс хөлд цус буух гэгч гэгийг олно.

Шинж тэмдэг:Хөлд нь цус буусан морь толгойгоороо доош дохиж доголох, хатуу газар гишгэхдээ эмзэглэнэ. Зогсож байхдаа хөлөө ээлжлэн сойно, удаан зогсож чадахгүй тул байн байн хэвтэж босно. Биеийг халтал унаж эдлэхэд доголох нь намдаж байвал хөлд цус буусны онцлог шинж байдаг. Хойд хөлд цус буух нь тун ховор, хэрэв цус буусан бол бэрэвхий хавдаж барьж үзэхэд халуун байна. Хэрэв хоёр хөлд цус зэрэг буусан бол бөгсөө чирнэ. Адуу дагаж чөдөртэй морь их дэвхцвэл зөв талын хойд хөлд цус буух тал бий.

Морины хөлд цус буухад тэр хавийн сагагнаас доош халуун, бүдүүрч хавагнасан, барьж үзэхэд эвэр, туурайн гярх дагаж их халуун, бамбалзуур, эмзэглэх онцлогтой.

Эмчилгээ:Цус буусан хөлийг давстай хүйтэн хар цайгаар шавшиж жин тавьж бооно. Хонины халуун сэвс, хужир, давстай шорвог шавраар хэд хэдэн удаа шавахад цус буусан хөлийн хаван татарна. Цус бууснаас болоод ихээхэн доголж явж чадахгүй байвал нэг талын туургыг, эсвэл урд хоёр хөлийн туургыг гадна дотроос нь хатгана. Онгон сиймхий (бэрэвхий сиймхий)-г хатгаад эрхий болон гурван хуруугаараа чөдөрлөхийн сиймхийн хоёр хажуунаас хавчин барьж доош нь илж шувтарна. Голхио самарснаас чөдөрлөхийн орчимд цус буусан бол чөдөрлөхийн сиймхийг ханаж цус авна.

УЛДАХ

х

Доголох боловч бага зэрэг унасны дараа амархан зүгээр болно. Уяатай байхдаа хөлөө өргөнө. Удаан зогсож чадахгүй унаж явахад эхлээд эмзэглэнэ. Туурайн туурга хумина.

Эмчилгээ: Өсгийлдэх гэдэг арга бий. Туурайн ар талын хонхорт эвэр туурайнаас дээш нэг хуруу зайд байгаа ил судас хатгахыг өсгийлдэх гэдэг.

Улдахыг уланд цус буух гэж хэлдэг тал бий. Улдсан уланд нь цус буусан адуунд гахай сөхөх гэдэг засал хийнэ. Туурайн голд байдаг гахайг урьдаас нь сөхөж модоор тэвхдээд хануурын нарийн хутга буюу зүүгээр сөхсөн чигтээ хахайг хатгаж цус гаргаад тэвхээ авч гахайг байранд нь оруулахыг гахай сөхөх гэдэг. Гахайг нь сөхсөн адууг тэр өдөртөө ус уулгахыг азнана.

МААХАЙЛАХ (БЭРЭВХИЙ БУЛГАРАХ)

×

Хөлийнхөө шөрмөсөнд гэмтэл олж морины хөл бэрэвхийгээрээ хойшоо суухыг маахайлах гэнэ. Гол шинж тэмдэг нь морь хөлөө өргөөд байдаг.

Эмчилгээ:Цахилдаг өвс даавуун дээр зэрэгцүүлэн тавьж утсаар бэхлэн тогтоож чиг бэлтгэнэ. Ийнхүү бэлтгэсэн чигийг хойшоо суусан бэрэвхийд барьж хэд . хэдэн давхарлан сайтар боож арваад хоног байлгана. Морины хөл бэрэвхийгээрээ булгарахад бас хөлөө өргөөд байдаг. Хэрэв бэрэвхий тулгарч мултарсан . бол хөлийг олс сураар оосорллож урагш татаад тэр оосор дээрээ хүнд модоор цохивол мултарсан бэрэвхий байранд ордог тал бий. Шөрмөсний гэмтэл, бэрэвхий булгарах хоёрыг ялгахад амаргүй.

ЭВЭР ТУУРАЙН СУНАЛТ

×

Адууны эвэр туурай урагшаа сунаж, уртасвал хөлийн гишгэлт эвгүй болж доголох, хөлөө гэмтээх, голихио самрах урхаг үүсгэнэ.

Засал: Туурайн сунасан хэсгийг самны шүд мэт болгож ойр ойрхон хөрөөднө. Ийнхүү хөрөөдсөн хэсэг нь аяндаа хугарч унаж туурай хэвийн байдалдаа орно. Уртассан эвэр туурайг туурайн хутгаар тайрч засаж болно.

СҮҮЖНИЙ ЦАГААН ХУЯН ХУРАХ

×

Өөд, уруу газар ширүүн давхиж явснаас морины сүүжний цагаан хуянд хий, цус хурна. Ингэсэн морь хөлөө чирч, явж чадахгүй зогсоно.

Эмчилгээ:Олон яс, ташаан толгой, өгзөгний шонтгор тус бүрээс төө төө хэмжээ авч гурван төөний уулзвар тушаа бага хонхор таарна. Энэхүү хонхор тушаа бүдүүн тарган моринд бол сайн төө гүн хатгана. Хутганы үзүүр ясанд тулах нь мэдэгдвэл зөв хатгалаа гэж үзнэ. Эмчилгээ оносон бол 6-7 хоноход засал авна (С.Бариад).

Бас ташааны хуудас хуурч, булчин нь хонхойж. хөлөө чирч доголоход хонхор дээр нь хоёр гарын эрхий, долоовор хуруугаараа гурвалжин үүсгэж, гурван өнцөгт тэмдэг тавьж, өнцөг бүр тушаа ясанд хүртэл нарийн хутга буюу шөвгөөр хатгаж засал хийдэг (Д.Балдорж).

Гуяны цагаан хуя бяцарсан бол морины хойд хөл нь хугарсан мэт чирч явна. Засал хийхийн тулд хонгоны хар зураасны доод хэсэгт эрхий хуруу ором хонхорт 4 хуруу (бүдүүн моринд мухар сөөм) хиртэй гүн хатгана (Ц.Пүрэвзав).

Ташаа хуудан авч морь оцогнсж хойшоо сууж доголбол ташааны булчин дээр 15-20 цэгт шөвөг буюу 24 номерийн зүүгээр ясанд нь хүрэл хатгаж, дараа нь модоор цохиж нухна (Ж.Цэрэнжаа).

ГОЛИХИО САМРАХ

×

Хойд хөлийн туурайгаар урд хөлийн ар өсгийг цохиж шөрмөсөн сиймхийд цус бууж туламласнаас халуун хавдар үүсэхийг шөрмөсөн бороо буюу голихио цохих, голихио самрах гэж нэрлэнэ.

Өвчний шинж: Сагагны орчим халуун хавдар үүсч, шилбэний сиймхийг барихад хөндүүрлэж эмзэглэнэ. Уяан дээр зогсож байхдаа шөрмөсөн бороотой хөлөө өргөх, хумсалах, сойх байдал ажиглагдана.

Эмчилгээ: Хатуу хавдрыг зөөлрүүлэхийн тулд хонины халуун сэвсийг цагаан агьтай хольж хавдар дээр тавьж бооно. Эсвэл хуучирч өтгөрсөн айрагны шавхрууг ялз чанасан шар будаатай хольж хавдрыг шавшина.

Хүхэртэй рашааны шавар буюу тарваганы махаар хавдрыг 4-5 хоног шавахад сайн нөлөөтэй. Энэчлэн хавдрыг зөөлрүүлсний дараа шөрмөсөн сиймхийг хоёр талаас нэвт хатгана. Зарим малчид нэвт хатгахыг хориглодог ажээ. Зовиурыг дээш татахын тулд 3 хоногийн дараа ягнаг (лагцгын сиймхийг) хатгах арга бий. Бэрэвхийг шавж боохын өмнө хааны судас хатгаад айргаар чийглэсэн шар эсгийгээр 2-3 хоног боож чөдөрлөхийн болон бэрэвхийн сиймхийг хатгавал зүгээр гэдэг. Зарим хатгаачид шөрмөсөн сиймхийг дээр дурьдсан зүйлээр боож хавдар бууж өвчингүй болох үед чөдөрлөхийн сиймхийг хатгана. Үүнээс хойш 3-4 хонуулаад хааг, бас 3-4 хонуулаад хоёр дөрөөлөхийг, дараа нь чамархайг тус тус хатгаж эмчилдэг.

ЦЭЭЖЭЭ АВАХ

х

Жинтэй лагс хүн жижигхэн биетэй морь унаж ширүүн давхих, хүнд ачаатай морийг газрын уруу ширүүн явуулах, явж байхад нь эвгүй эргүүлж гэнэт зогсоох, богино дөрөөтэй явснаас гутлаар хөх махыг байн байн хүчтэй давирч нидрэх зэргээс цээж авах гэм олно.

Шинж тэмдэг:Морины хөх мах нэг буюу хоёр талдаа бяцрах гэж бий. Хөх мах нэг талдаа бяцарсан бол тэр талынхаа сугыг бүрэн тэнийлгэхгүй цээжин бие хэлтгий болж, хөлөө чирэх маягтай доголно. Хөх мах хоёр талдаа бяцарсан бол тушаатай мэт урьд хоёр хөлөө дутуу тавьж тундчиж ойр ойрхон гишгэнэ. Биеэ дааж ядах байдалтай гишгэх ба бүдчинэ. Бяцарсан хөх мах овойсон мэт, дарж үзэхэд их эмзэглэнэ. Хөх мах нэг талдаа бяцарсан бол хоёр талын хөх махыг харьцуулан үзэхэд ялгаатай харагдана. Цээжээ хөдөлгөхдөө эмзэглэнэ. Уяж байгаад хөдлөхөд хөлөө өргөж хүчтэй доголно. Хэвтэж байгаад босохдоо бүр явж чадахгүй, балцаганаад байна.

Хөх мах бяцрахыг бусад ойролцоо гэмтлээс ялгах нь чухал. Далны цагаан хуянд гэмтэл олсон бол тэр тушаа мах хөндүүр байх бөгөөд сайн ажиглахад морь хүзүүнийхээ угаар мурийсан байдалтай ажиглагдана. Давхиж явах зуур гэнэт ойчих тал бий. Далны мөгөөрсөнд гэмтэл олсон бол тэр тушаа нь дарж үзэхэд эмзэглэх бөгөөд бага зэрэг доголж унаж байгаад тавихад зүгээр болно. Ийнхүү цээжээ хаагуураа авсныг тогтоохын тулд дээр дурдсан шинж тэмдгийг тогтоож үзэхийн зэрэгцээ хамгийн гол нь далны зузаан махан ташаа байдаг цувраа гурван хонхорт ээлжлэн дарж үзээд хаанаа гэмтэл олсныг тогтоож болдог. Дээд талын хонхорт далны хуудасных, дундахыг бүдүүн хөх махных (цагаан хуяных ч гэдэг), гуравдахыг нарийн хөх махных гэж нэрлэдэг бөгөөд доод талд орших хөх махны хонхорт долоовор хуруугаа тавьж долоовор, дунд хурууг алцайлган дээш нь хэмжих замаар дундах, энэ аргаар дээдэх

хонхорыг олж болдог. Эгмээс хойш мухар сөөм дал богтны үеэс дээш мөн мухар сөөм хиртэй тавьж үзэхэд эрхий хуруу ормоор хөх махны хонхор таарна.

Эмчилгээ:Цээжээ авсан моринд илэх, ханах, хийлэх, усан заслын аль нэгийгхийдэг байна: Юуны өмнө эмзэглэж байгаа хэсгийг 1 сайтар илж барьж өгвөл сайжрах тал бий. Бас эмзэглэж байгаа газрын Тушаа байгаа дээр дурьдоан хонхруудадхатгах аргыг өргөн хэрэглэнэ. (Б.Раднаабазар, Л.Нарангэрэл, Ц.Пүрэвжав зэрэг).

Далны хуудсыг 2-2.5 см, бүдүүн хөх махыг 4 хуруу, нарийн хөх махыг 3 хуруу хиртэй гүн хатгаж хийлнэ. Энэ үед усаар шавшиж болохгүй. Бас заримдаа ороо харыг хатгаж тэр даруй буюу хэд хоноод жаврыг нь гаргасан усаар дал хөх мах тушаа үсийг сөргүүлэн шавшаад уяж хоновол сайн. Мөн усан заслын аргуудыг хэрэглэнэ. Үүнд: Хөх махны үсийг хайчилж хавтгай хүйтэн чулуу тавьж боогоод морийг гурван шөнө дараалан уяхад хөнгөн өвчилсөн бол эдгэрнэ. Зуны улиралд хөх мах нь бяцарсан морийг хөлгүй гүн усанд урсгал сөргүүлэн шумбуулна.

Цээжээ авсан морийг сойж засал хийнэ. Ингэхдээ гурван ес эхэлсэн хойно нар шингэсний дараа бүлээн усаар дал, хэнхдэг, хөх махны үсийг сөргүүлэн сайн шавшаад морио уяна. Хэрэв хөх мах бяцарсан бол өглөө нь шавшсан ус дарайтлаа хөлдсөн байх бөгөөд энэ эмчилгээ өдөр бүр 3-7 хоног дараалан давтан хийнэ. Өглөө үзэхэд шавшсан ус хөлдөөгүй байвал эмчилгээ авсан гэж үзнэ.

Зарим малчин хөх мах нь бяцарсан адууг 11 сард газрын хөрс, задгай ус хөлдөх үед хөх махны хэсэгт жаврыг гаргасан усаар 2-3 өдөр шавшиж өдөр нь идүүлж орой нь уяж хононо. Ингээд дээрдэхгүй бол шонтгор мөр, хавирга хоёрын завсраар хойш нь эгц хавуулах байдлаар эсвэл дал, бугалганы үеийн ард далны хөх махны сиймхийд хатгаж цус гаргана. Цээжээ авсан моринд хийн засал (хуян сэвэх, хөх мах самнах) арга хэрэглэнэ. (Насан-Очир, Д.Базарсүрэн, Б.Цэрэндорж, Х.Цэрэндорж, Ц. Чойжилжав зэрэг).

Бүдүүн хөх мах, хуудас хуурсан тохиолдолд дал тушаа доохно нь) гурван хуруу хиртэй газар дарж үзэхэд ховил тааралдана. Тэр хувилд (арьсыг цоо хатгаж нүх гаргаад хий үлээж тэр хийгээ мундааны чигт (илж түрэх, хавтгай модоор зөөлөн цохих зэргээр хийг тараана. Энэ засалыг 8-аас дээш насны моринд хийх бөгөөд үүнээс бага насны моринд хийдэггүй. Далны хуян нухагдсан үед далны мөгөөрсний дээд үзүүрт тохиолдох хонхорт арьсыг цоо хатгаж хий төмбийтөл үлээнэ. Үүнийг цагаан хуян сэвэх гэнэ.

Д.Гунгаа цээжээ авч доголсон адуунд дараах засал хийдэг:Цээжээ авч тушаатай мэт хөлөө зэрэг гишгэж доголбол ороо харыг ханана. Их зовууртай доголбол хөөсөн хааг хатгана, үүний тулд дал бугалганы. үеийн дотор талаар хэрэв адуу том бол алганы өргөний хирээр, бага жижиг бол 4 хуруу хиртэй дал талыг барьж хатгана. Хатгах хүн сугаа хавчин цээжээрээ түлхэс хийж чиг хатгана.

Толгойгоо дохиж доголдог морины сээрэн сиймхийг хатгана. Далны булчирхайн өмнүүр дарж үзэхэд гурвалжин хэлбэртэй хонхор таарна. Тэр хонхорын цаад талд мод тулж тэр тушаа нэвт хатгана. Хэрэв алдмаар бол хоёр талаас нь хатгана. Их цус гардаг.

ДАЛНЫ ХУУДАС ХУУРАХ

х

Эрэг, суваг, шуудуу дээгүүр эвгүй харайлгахад урд хоёр хөл тэгш биш, дээр доор гишгэснээс далны хуудас хуурдаг гэдэг. Зарим нутагт энэ эмгэгийг дал хуудагнах гэж нэрлэнэ.

Шинж тэмдэг: Далны гадна талын хуудас тухайлбал их хотын булчин хуурсан бол хөлөө гадагш хаяж доголно, тэр тушаа дарж үзэхэд эмзэглэнэ. Их хуурсан бол далны дээд тал нимгэрч, доод тал нь овойсон байна. Далны дотор талын хуудас хуурсан бол гадна талаас хөндүүргүй, дээрх шинж байдал ажиглагдахгүй, бүдрэх, хөлөө чирэх байдалтай доголно. Дал сул болсон мэт дээшээ оволзож байна. Малын тарга хүч хэвээр байхад хуудас нь хуурсан далны булчин аажимдаа хавчийж хатингартана. Далны хамрын аль талд нь хуурсан болохыг мэдэхийн тулд дарж үзэхэд хуурсан талдаа эмзэглэнэ.

Эмчилгээ: Морины мундаанаас доош 4 хуруу хиртэй газраас арьсыг татаж үсний ширхгийн дагуу 1-1.5 см хэмжээтэй арьсыг ярна.

Арьсыг цааш нааш татахад хий орно, эсвэл арьсны нүхээр гуурсаар хий үлээж болно. Орсон хийг нь дал руу илж оруулна. Ийнхүү дал орчмын (арьсан доор хийг төмбийтөл оруулна. Эсвэл далны мөгөөрснөөс доош 4 хуруу тавьж далны хуурсан талын булчинг 2 хуруу гүн хатгана. Ингэхэд цус гарахгүй. Эмчилгээ оносон бол түүнээс хойш 10 гаруй хоноод сайжирна (А.Намсрай).

Сайн норгосон эсгийг далны дээр тавьж дээрээс нь улайсгасан төмөр гадсаар тэгш дөрвөн өнцөг гарган өнцөг бүр дээр нь хайрч төөнөдөг. Далны гадна талын хуудас хуурсан үед бүдүүвтэр шөвөг сайн үзүүрлэж хөвөнгөөр ороож дээрээс нь тос дусааж шатааж ариутгаад далны хуудас хуурсан тал руу ясанд нь хүртэл шааж шөвгөө нар зөв гурав эргүүлж 10 минут орчим болгоод, мөн нар буруу гурав эргүүлж шөвгөө авна. Бас далны хуудас дотор талдаа хуурсан бол далны ясыг нэвт цоолно. Үүний тулд далны их хотын талбайн тушаа хутгаар буюу үзүүртэй цоолтуураар ясанд хүртэл хатгаж, ясанд тулсны дараа цоолтуур дээрээ огцом цохиж далны ясыг цоолно. Ийнхүү далны яс ба дотор талын хуудасны завсарт цус гаргаж хооронд нь наалдуулж байгаа гэж үздэг. Шархаар нь бохир зүйл оруулахгүйн тулд илгэ, нэхий тавьж наана.

ҮЕ МӨЧ МУЛТРАХ

х

Мал эвгүй унах, гишгэх, бүдрэх, гулгаж унах зэргээс адууны үе мултардаг.

Шинж тэмдэг: Үе нь мултарсан адуу гэнэт доголж, мултардаг хөлөө гишгэж чадахгүй сойж зогсоно. Мултарсан хэсэг овойж хавдая, дарж үзэхэд хөндүүр байхын зэрэгцээ мултарсан үе мөчийг нөгөө үе мөчтэй харьцуулахад эмгэгтэй хэсгийн хөлийн хэлбэр байдал гажих, мурийх, урт, богино болох зэргээр өөрчлөгдсөн байна. Мөр гадагшаа мултарсан бол хөл дотогшоо, харин дотогшоо мултарсан бол гадагшаа туялзан доголно. Түнхний үе мултрахад толгойгоо гэлжийлгэж тонгойж зогсоно. Хүзүү мултрахад хүзүүний хажуу тал овойж харагдана. Хөл үеэрээ мултарвал тухайн хөл нөгөө талын хөлөөс урт болж үеэрээ ойвойно.

Эмчилгээ: Үе нь мултарсан малыг зөөлөн унагааж хэвтүүлээд хөлийг нь туурай тийш алгуур зөөлөн татаж мултарсан үеийг оруулах зүг рүү зугуухан дарах, барих, холхиулахад хэвийн байдалдаа ордог. Хэрэв мултарсан үе байрандаа орвол нурхийх чимээ сонсогдож, мултарсан хэсэг нөгөө талын ижил үе мөчтэй адилхан болж ажиглагдана. Мултарсан үе ийг ийнхүү оруулсаны дараа хавдсан хэсгийг давстай хар цайгаар шавшиж зөөлөн юмаар бооно. Боолт тогтохгүй бол цавуутай илэг, хөдөс наах буюу хар модны давирхайгаар шавах арга хэрэглэнэ. Адууны мөр мултрахад тэр талын хөлийг богочилж хөлөөрөө дөрөөлж доор нь гишгэхэд мөр нь орно. Үүний тулд богтос чөмөгний шонтонгийн дээхнүүр олс сураар дөрөөлөх боломжтойгоор гогцоо гаргана. Түүнд дөрөөлөн доош нь мөрийг хөдөлгөж оруулна. Эсвэл богчилсон хөлийг сураар оосорлож урагш нь татаад суран дээр хүнд юм (тэрэгний дугуйн хигээс хиртэй модоор) цохиход мөр хэвдээ орно. Мөр нь мултарсан талын хөлийг оосорлож оосроо мориныхоо салтаан доогуур гаргаад хойш татаж мөрийг оруулж болдог.

Адууны тойг мултрахад "гэдэс хайруулах" гэдэг уламжлалт арга хэрэглэнэ. Тойг нь мултарсан хөлийн туурайн хярах орчимд урд талаас нь зүүгээр гэнэт хүчтэй хатгахад мал цочиж хөлөөрөө гэдсээ огцом хайрах, тийрэх хөдөлгөөн хийхэд тойг нь эргэж байрандаа орно (Мө.Даш. 1965). Морь тэмээний тойг мултарвал эрүүл хөлийн борви дээгүүр хошлонгоор мэдээ алдтал боож явуул (хар домын судар).

Түнх хойшоо, урагшаа, дээш, доошоо мултарсан байж болно. Түнх хойшоо мултрахад хөлөө хойш жийсэн маягтай байдаг. Бас хөл нь урт болсон мэт харагдана. Үүнийг засахын тулд салтаанд нь 40 литрийн битон хавчуулж урт мэт харагдах хөлийг аргамжаар оосорлож урагш нь нэг хүн татна. Нөгөө хүн бүдүүн гуяны доогуур оосорлож дээш чангаана, гурав дахь хүн түнхний араас хүчтэй дарж өгөх үйлдэл хийхэд түрхийх чимээ сонсогдвол түнх байрандаа орсон байдаг. Ийм засал хийсэн морины хонгоны хуян, хас, зоог тус тус хатгана. Түнхний үе, сүүжний толгой мултарсан морь, малыг унагааж, эрүүл гурван хөлийг боож, мултарсан үеийг оосорлож эгц дээш татаж байгаад хүнд юмаар (модоор) оосор дээр нь доргиулан цохино.

Хүзүү мултарвал малыг унагааж хүлээд ногтноос нь хүчтэй татаж байгаад хүзүүний мултарсан хэсэгт мод тавьж оруулах тийш хүчтэй огцом дарна. Хүзүү нь бага зэрэг мултарсан тохиолдолд чих рүү нь ус хийхэд цочиж чихээ сэгсрэхэд нь мултарсан үе байрандаа орох тал бий.

ХӨЛ БОРООЛОХ

Хөлийн шөрмөс, нимгэн газрын булчин мах дагаж хатуу бэрсүү суухыг ясан бороо гэдэг. Хөлд цус буух, голихио самрах зэргээс ясан бороо үүснэ. Бороог ясан, шөрмөсөн бороо гэж ялгаварлана.

Эмчилгээ: Юуны өмнө шөрмөсөн бороог задалж зөөлрүүлэхийн тулд дараах аргуудыг хэрэглэнэ.

Бороог задлахын тулд айрагны өтгөрсөн шавхруу, шорвог шавраар 14 хоног шавна. Зарим нутагт бороо сайн задалдаг шавар бий. Хэнтий аймаг дахь Аварга тосонгийн шаврыг бороо задлахад онцгой сайн гэдэг. Бороотой адууг усанд 10 гаруй хоног уяхад бороо задрах тал бий. Хонины сэвс буюу нэг кг шар будаа, нэг аяга давс, хар цайнд чанаж, өтгөн лаг болтол буцалгаж 2-3 удаа шавахад бороо зөөлөрнө.

Бороог задалж зөөлрүүлсний дараа чөдөрлөхийн сиймхийг нэвт хатгана. Зарим хатгаач нэвт биш, хоёр талаас нь хатгадаг. Чөдөрлөхийн сиймхийг хатгасны . дараа дээш доош нь татлага хийнэ. Үүний тулд эхлээд хааг хатгаж дээш татна, 3-4 хоногийн дараа туурайн магнай буюу туурга хатгаж доош татна. Мөн судсыг доош нь илж цусыг шахна. Сүрэгт нь жил хүртэл тавьж амраасны дараа эдэлж болно. Хялгасыг харандааны хиртэй бүдүүн томж чөдөрлөхийн сиймхийгээр оруулж сүвлээд илүү гарсан хоёр үзүүрийг хайчилж авна. Ийнхүү сүвлүүлсэн адуу 3-4 хоног хэвтэж байгаад босож идээшлэнэ. IY, Y сард сүвлүүлсэн адуу X, XI сард барьж үзэхэд бороогүй болсон байдаг. Ясан бороог эмчлэх хэрэггүй.

ДЭНШИГ ЯС ХӨДЛӨХ

×

Эвэр туурайны ард байдаг завь ясны аль нэг нь тулгарах, булгарахыг дэншиг яс хөдлөх гэнэ. Хальтарн ойчих, хатуу юм өшиглөх, огцом гэнэт эргүүлэх, гэнэт зог тусч зогсох зэргээс дэншиг яс хөдөлнө.

Шинж тэмдэг: Дэншиг яс хөдөлсөн адуу урд хөлийн туурайн ирмэгээр газар хумсалж зогсох бөгөөд барьж үзэхэд туурай нь хүйтэн байна. Явуулж үзэхэд туурай савлаж, хэлбэр байдлыг нөгөө талтай харьцуулж үзэхэд өөр болсон байна. Далны хуудас хуурах, дэншиг яс хөдлөхийн шинж тэмдэг ойролцоо бөгөөд ялгаатай тал нь гэвэл дэншиг яс хөдлөхөд туурайгаараа хумсалсан, гүйцэд биш гишгэлттэй болсон байхаас гадна толгойгоо урагш сунгаж, тонголзох байдалтай хүчилж явдаг.

Эмчилгээ: Хөдөлсөн дэншиг ясыг дор дурьдсан аргаар зөөлөн цохиж доргиулан оруулна. Нэг төө өргөн, хоёр төө урт, гурван төө хуруу зузаан хавтгай модны дор бөөрөнхий модыг дэрлүүлэн тавина. Хавтгай модны нэг үзүүр газар тулсан байна. Ийнхүү хавтгай модыг байрлуулсны дараа дэншиг яс нь хөдөлсөн морины эрүүл хөлийг богчилж өвчтэй хөлөөр нь банзан дээр гүнцэд сайн тэгш хийгүй бүтэн гишгүүлээд хавтгай модны нөгөө талын хөндий үзүүрийг модон мунаар 2-3 удаа хүчтэй цохиж доргионо. Засал тохирсон бол адуу туурайгаараа гүйцэд гишгэнэ. Аажимдаа туурайн ул нь бүлээснэ. Эхний 2 хоног хөдөлгөөнгүй уяж, гурав дахь өдрөөс тавьж идээшлүүлнэ. (Б.Шаравдорж).

ГАХАЙ УРГАХ

×

Хатуу хөрстэй замаар удаан хугацаагаар аялах, тууварлахад эвэр туурай түргэн элэгдэх, усанд удаан хугацаагаар зогсорх, ус намагтай нутагт олон хоногоор бэлчээх зэргээс адууны туурай, гахай нь түрж ургах зэргээс болж адуу мэтэлзэж доголно. Үүнийг гахай хавчих, гахай ургах, морь улдах гэх мэтээр нэрлэнэ.

Шинж тэмдэг: Гахай ургах хоёр янзаар илэрнэ. Адууг хатуу хөрстэй замд удаан хугацаагаар унаж эдлэх, тууварлах үед туурайн ирмэг элэгдэж, гахайтайгаа чацуу тэгш болсноос гахайгаараа гишгэж доголно. Нөгөө талаар ус чийгтэй нойтон, усархаг бэлчээрт удаан хугацаагаар маллаж байснаас гахай зөөлөрч урган сунаснаас туурайн ирмэгтэй чацуу болж гахайгаараа гишгэх болсноос доголно. Өвлийн тэсгим хүйтэнд морийг хэт бариу чөдрөөр явж чадахгүй болтол чөдөрлөж удаан хугацаагаар зогссоноос болж туурай хөлдөх, гахай амархан ургах тал бас байдаг. Мөн элсэнцэр шаварлаг хөрстэй нутгийн адууны гахайн завсар салаанд элс шавар чихэгдэж хөлдөж гахайг хавчсанаас адуу улдсан мэт доголдог.

Эмчилгээ: Адууг уналга, эдэлгээнээс чөлөөлж гахайд тарваганы тос түрхэж аль болох зөөлөн хөрстэй бэлчээрт 7-000 дээшгүй хоног байлгана. Гахайн наашилж ургасан хэсгийг туурайн ирмэгээс цааш ортол өөлөн авч тарвага, адууны тос түрхэнэ. Эсвэл илүү ургасан хэсэгт (ямааны бөөрний өөх зэрэг) халуун өөх, тос давстай хольж бөөрөнхийлөөд уланд тавьж дээрээс нь халуун төмрөөр хайрна. Туурай тэгш бус элэгдсэн байвал өөлж тэгшилнэ. Гахайг сайтар цэвэрлэж түрж ургасан, сунасан хэсгийг өөлж авна.

УНАГА НАРШИХ

х

Унагыг халуун бөгчим салхигүй газарт удаан хугацаагаар уяж, эхэд нь хөхүүлэхгүй удааснаас ундаасан цангаж эмзэглэхийг нарших (нарны цохилт) гэдэг.

Шинж тэмдэг: Наршсан унага уухилан аяндаа үсэрч ойчно. Босохдоо гуйван салганах бөгөөд хүндэрсэн бол зогсож чадахгүй тарайж хэвтэнэ. Бүх бие хөлөрч, шүд зуурч, нүд улайна. Наршихаас сэргийлэхийн тулд сүүдэр барих, эхэд нь олон дахин хөхүүлэх, унаганы зэлийг голын эрэг, зүлэг, чийгтэй газар буюу салхитай өндөрлөг газар байрлуулдаг. Хэт халуун, салхигүй, бөгчим өдрүүдэд унаганы зулай, зоо нурууг усаар шавшиж зэл уяаны хавиар ус асгана.

Эмчилгээ: Наршсан унаганы биеийг халуун бүлээн усаар шавших, ус, хярам цутгаж өгөх, сүүдэр газар бараадуулах, эхэд нь тавьж өгөх бөгөөд хүндэрсэн байвал гүрээнээс бага зэрэг цус авна.

УНАГА НАРШИХ

х

Унагыг халуун бөгчим салхигүй газарт удаан хугацаагаар уяж, эхэд нь хөхүүлэхгүй удааснаас ундаасан цангаж эмзэглэхийг нарших (нарны цохилт) гэдэг.

Шинж тэмдэг: Наршсан унага уухилан аяндаа үсэрч ойчно. Босохдоо гуйван салганах бөгөөд хүндэрсэн бол зогсож чадахгүй тарайж хэвтэнэ. Бүх бие хөлөрч, шүд зуурч, нүд улайна.

Наршихаас сэргийлэхийн тулд сүүдэр барих, эхэд нь олон дахин хөхүүлэх, унаганы зэлийг голын эрэг, зүлэг, чийгтэй газар буюу салхитай өндөрлөг газар байрлуулдаг. Хэт халуун, салхигүй, бөгчим өдрүүдэд унаганы зулай, зоо нурууг усаар шавшиж зэл уяаны хавиар ус асгана.

Эмчилгээ: Наршсан унаганы биеийг халуун бүлээн усаар шавших, ус, хярам цутгаж өгөх, сүүдэр газар бараадуулах, эхэд нь тавьж өгөх бөгөөд хүндэрсэн байвал гүрээнээс бага зэрэг цус авна.

УНАГА БЭЭРЭХ

х

Бээрсэн унаганы бие хөшиж, чичирч хэвтэнэ. Явж чадахгүй, амнаас хөөс гарна. Бээрсэн унаганы чихнээс барьж гурван удаа зөөлөн сэгсрэхэд сэргэж босдог. Хучиж дулаацуулах нь чухал.

ЗОВСОН СҮҮНД УНАГА ХОРДОХ

х

Алс газар тууж ядраасан гүүг хөхсөн унага эмзэглэж оёглохыг зовсон сүүнд хордох гэнэ. Эдэлгээ, уналгыг хэтрүүлсэн даага, шүдлэнд эхээ хөхөж байгаа бол энэ эмгэг тусна.

Шинж тэмдэг: Унага алсаараа тарга хүч муутай, өсөлт торнилт удаан ноомой байхын зэрэгцээ зооныхоо үсийг гээхгүй ихээхэн уддаг. Сүүнд хордсон бага насны адууны үсний өнгө өөрчлөгдөж, толбо суун арьсан дээр шөвөг яр үүснэ. Унаж эдлэх үед хамраас цагаан шингэн гоожно.

Эмчилгээ: Зовсон сүүний хордлого болсон унаганд унаганы зуулт өгдөг. Унаганы зуулт шинэхэн байх үедээ шар туяатай байснаа хүрэн бор дэлүү мэт өнгөтэй болж хатаахад хар хүрэн болно. Хатсан зуултыг нүдэж усанд зуурч өгнө. Мөн цагааны шар усаар 3-4 удаа шавшихад засал авдаг (А.Намсрай).

САХУУ

х

Бага насны адуунд ялангуяа унаганд эхлээд ханиад хэлбэртэй тусаж эрүүний дор багалзуур чихалзуур хавиар нь хавдар үүсч идээлнэ. Унага эхээ хөхөхгүй, идээшлэхгүй байснаа турж бүрзийнэ. Хавдар өрхөлж гадагшаа буюу дотогшоо хагарч идээ бээр гоожно.

Эмчилгээ: Унага, даага сахуутыхын өмнөханиажэхлэхбөгөөд хоолойд хавдар үүсэх шинж тохиолдох үед тагнайг хатгахад засал авдаг (Ц.Пүрэвзав).

Хавдар нь гадагш өрхөлж байгаа бол хавдрыг хөхүүлж идээг гаргана. Хавдрыг гадна талаас нойтон нэхий буюу шар эсгийгээр хөхүүлдэг. Хэрэв хавдар гадагшаа цоороогүй бол унага, даагыг уургалж, огцом татаж хавдрыг хагална. Нэрмэл архи буюу дарь цутгаж өгвөл хавдар гадагшаа хагарахад дөхөм үзүүлнэ. Сахуурсан адуунд улаан сонгино нэг ширхгээр 3 өдөр дараалан өгнө. Мөн далан түрүү өвсийг хөх махны арьсан дотор хавчуулах (арьсыг зэргэлдээ хоёр ярж, ярсан арьсны дунд хэсэгт өвсөө шургуулах) арга байдаг. Сахуурсан унаганд хуц,

ухнын хөгийг угаасан угаадас буюу чив орчмын заартай үсийг хайчлан авч усанд хийж заарын ус бэлтгэн өгч байжээ. Унаганд заартай ус нэг лонх орчмыг өгөх бөгөөд ялангуяа дотуур сахуунд бүр сайн гэж үздэг. Сахуурсан унаганы хээлний доорх хоёр судсыг ханана. Мөн амь тэмцэж амьсгаадах нь бэрхшээлтэй болсон үед хоёр шанаанаас цус авах, хамрын сиймхийг хатгах арга байдаг (Ч.Төөрүүл).

Мөн унаганы хэлний үзүүрийг хуруу хиртэй тайрах, эсвэл хамрын нүх рүү мод шургуулан нидэрч цус их гаргах сайн (Ж.Цэрэнжаа).

Б.Цэгмид (Ховд, Манхан сум) гуай нас гүйцсэн адуунд - хавар, намар сахуу тусдаг тухай ярьсан. Сахуурсан адууны хамраас эхлээд цагаан сүүлдээ ногоон, өтгөн шар ногоон нус гоожно, ханиана, шуухнаатна. Халдвартай, эхлээд даага сарваа, дараа нь том адуу өвчилнө. Өвчтэй адууны хоолой, товчлууур, суга, цавь орчим хавдар гарч хагарч нэвчиж ирвэл адууны биеийн байдал сэхэж ирнэ. Гүү хээл хаяна. Үхэхгүй, эдгэрэхгүй удна. Хавраас эхлэн өвөл болтол үргэлжилнэ. Өвчин гарсан адууны унага 8-р еард бараг бүгд сахуурна. Хужир борзонтой гол газар байсан адуунд илүүтэй төх-иөлдоно. 1974 оноос эхлэн энэ өвчин тохиолдох болжээ.

Өвчтэй адууны хазаарын амгайд сармисны нэг хумс даавуунд боож хэд хэд уяахад өвчин хөнгөрч ханиах нь гайгүй болно.

Д.Балжууны мэдээлснээр адуунд ган сахуу тусахад таргалахгүй, үе, хялгасаа хаяхгүй, ханиана, амьсгаадна. Эмчлэхийн тулд адууг хөлөргөж ирээд шар будааны. шөл: 2 литр хиртэй өгч нэмээд хөлс хаттал уяна. Мөн сармис, сонгино хазаарын амгайд боож өгөх сайн гэж ярьсан.

СӨДРӨГ

х

Өвчин туссан адууны хөлийн гярх, сагаг орчмоор хавдаж, хэд хоногийн дараа жижиг цэврүү үүсч улмаар яр шарх нь тэлж газар

авч шархны захын арьс мах үхжиж эмчлэхэд хүндрэлтэй болох учир эмчилгээг өвчин гармагц бага дээр нь хийнэ.

Эмчилгээ: Сөдрөгийг янз бүрийн аргаар эмчилдэг байна.

Тухайлбал шархыг сайтар угааж цэвэрлэнэ. Шархны нимгэн үхмэл захыг огтолж авч зэсийн цэнхэр түрхэх буюу шархан дээр тарваганы өөх (болбол сэмж) тавьж халуун төмрөөр хайрч эмчилнэ.

Хөл нь их хавдаж шархалсан үед хорыг авч хавдрыг хариулахын тулд ялз чанасан шар будаагаар шавах буюу тарвага алж туламлаад хавдсан хөлд углаж хөхүүлэх арга хэрэглэнэ. Хавдар харьсны дараа бэрэвхийн сиймхий, туурайн магнай, туурганы аль нэгийг ханаж

эмчилнэ.

Сөдрөгийн шарханд зэсийн үртэс цацаж бооход түргэн эдгэрдэг гэдэг. Содрогийм шарханд бас хатсан ааруул, өрөмний хөгц түрхэнэ. Мөн шархыг цэвэрлэж, үүссэн хаванг эргэн тойруулан 5-6 удаа хануурын хутгаар шивж хатгаж цусыг сайн гаргана. Шарханд ус хүргэж болохгүй хуурай байлгана. Өвчин хүндэрч шархалсан үед туурайн ар талын өсгийний хоёр судсыг, харин шархлаагүй шар дугуй үүсч байгаа үед туурайн магнайг (гярх) хатгаж эмчилж болно.

Говийн аймгуудын малчид сөдрөгтэй адууны яр шарханд сохор цох (толгой, хуягийг авч) бүтнээр буюу нухаж тавьж боодог байжээ.

(Ц.Долхүү, У.Ёндон зэрэг). Бас шарханд зэсийн үртэс цацах сайн (Ч.Гүүш). Шархалсан хөлд эсгий бойтог углаад түүний дотор малын

хатсан хуучин сэвс хийж, шээсээр шавшиж шөнө уяж- өдөр нь идүүлж байвал эдгэрэх нь түргэн байна. Сөдрөг урд хөлд гарвал хаа буюу ороо хар (товчлуу, жолоо) судсыг, хойд хөлд гарвал хасыг хатгаж цус сайн гаргаад шарханд нь зэсийн цэнхэр түрхэнэ.

Дундговь аймгийн малчид С.Цагаан-Өвгөн, Ж.Дамиран, Ш.Хэнмэдэх, Т.Лувсаншарав нар адуу сөдрөгтөж гэнэт доголж, бэрэвхийн аль нэг хэсэгт маш халуун их өвчинтэй хавдар үүсэх үед сагагны бондгор (сагагны сондой гэж зарим малчид ярьдаг)-ын дундуур доороос дээш нь хурц хутгаар өлгөж хагалахад дотор нь дээлийн товчны хиртэй гэртэй уйланхай мэт зүйл (заримдаа бэлцгэнэсэн хөх болсон байна) байх бөгөөд түүнийг зүүнд сүвлэсэн утсаар оосорлож доош татаж огтолж авахад гойд сайн гэдэг. Дараа нь шарханд хүхэр, эсвэл сохор цох тавьж боодог ажээ. Бүр 1944 онд малчид, мэргэжилтний зөвлөгөөнд оролцсон Дундговь аймгийн Дэрэн сумын III багийн малчин М.Ширнэн сөдрөгтэй адууны өвчтэй хөлийн сагагны сондгойг хагалж уйланхай шиг гэртэй идээг авч хаявал эдгэрнэ гэж ярьснаас үзвэл уламжлалт ийм аргыг хэрэглэж ирсэн нь тодорхой байна.

ХУЛГАНА ЯР

х

Хулгана яр өвчин адуу, илжиг, лууст голдуу өвөл XI сараас Y сар хүртэл хүйтний улиралд тохиолддог халдвартай өвчин. Эхлээд хаа, хас, шилбэний судас дагуу булцруу үүсч хожимдоо хагаран яршиж, шар онгийн идээ гоожно. Хэрэв хаа дагаж яр гарвал эр хулгана яр, харин хойд хөлд гарч бүх биед түгэж гарвал эм хулгана яр гэнэ. Адуунд үзлэг ажиглалт хийж өвчтэй адууг аль болох эрт илрүүлэх нь чухал.

Шинжтэмдэг:Хулгана яр адууны дөрвөн хөлний аль нэгэнд эхлээд гарах боловч ихэвчлэн урд хөлийн аль нэгэнд гарна. Анх гарахдаа өвдөгний үеэс доош үүсч, хаа гуяны дотор талын судас дагаж дээш доошоо тархаж эхэлнэ. Хаашаа дамжин гарч байгааг тодорхойлох нь чухал. Эмчилгээг урд хөлд гарсан бол мөрөнд хүрэхээс өмнө, хойд хөлд гарвал цавинд хүрэхээс өмнө хийвэл үр дүн сайтай. Үүнээс дээш гарвал ярны үзүүр олдохгүй болж бүх биед тарж эмчлэхэд хэцүү болно.

Эмчилгээ:Цувран гарч байгаа хулгана ярны шарх булцруу өөр хоорондоо бараг ижил зайтай гардаг. Хаа гуяыг өгсөж цувран гарч байгаа хулгана ярны хамгийн тэргүүний үзүүрийг олж авна. Хулгана ярын овойж хавдсан буюу барзгар шархыг тойруулан дарж үзэхэд нэгэн хатуу

судас мэт зүйл тааралдана. Энэ нь хулгана ярын үзүүр байдаг учиртай. Бас түүнийг тойруулан тэмтрэн үзэж цаашаа үзүүр гарсан эсэхийг нягтлах хэрэгтэй.

Хулгана ярын үзүүр тушаа арьсыг огтлоход цэлцийсэн цагаан усархаг зүйл, гарч ирнэ. Тэр усархаг цэлцийсэн цагаан булдрууг огтлон авч оронд нь зэсийн цэнхэр, эсвэл чонын хатаасан цөс шар будааны хиртэйг хийнэ. Зэсийн цэнхэр байхгүй бол шархны ёроолд хар тугалга, улаан тамхи, ааруул, өрөмний хар хөгцний аль нэгийг хийж эмчилнэ. Хулгана ярын үзүүр (толгой)-ийг олж авч хаяхгүй бол эмчилгээ үр дүнгүй болдог. Хулгана ярын үзүүрийн идээлэх гэж байгаа хэсгийг нарийхан хар тугалган буюу зэс утсаар арьстай нь хамт сүлбээд хоёр үзүүрийг нь нугалж бөгжилдөг арга байдаг (Н.Оросоо, С.Чадраабал). Хулгана ярны шархыг хагалж суман модоор нарийн зомгол хавчуулж орхивол эдгэрэх нь түргэн байдаг (С.Ишдорж).

Хулгана ярын задарч идээлсэн шархны шар махыг огтолж хаяад цэвэрлэж, хүхэр, зэсийн цэнхэр түрхэх буюу ярыг улайсгасан зэс шөвгөөр цоргиж эмчилнэ. Хорыг авахын тулд эдгэрсний дараа өвчин гарсан талын хаа, хасыг хатгадаг. Хулгана яр бүх биеэр энд тэндгүй гарсан тохиолдолд (эм хулгана) яр гарсан талын чихэнд хоолны нэг халбага сайн нунтагласан бор давс сайтар шигшиж хийгээд чихний үзүүрийг сулавтар бооно. Чанга боовол чих тасарч унана (Ц.Чойжилжав, Г.Батмөнх). Хулганы ярын үзүүрийг олоогүй бол энэ арга сайн гэж зарим малчид үздэг.

Мөн хулгана яр бүх биеэр гарсан үед хар модны холтос, шар будаа (тус бүр нэг аягыг) усанд буцалгаж хөргөөд 2-3 өдрийн завсартайгаар 3 удаа дотуур өгнө. (Д.Базарсүрэгц, Н.Оросоо). Бас шар будааны нүүрс өгч болно.

Давс чихэнд нь хийхэд засал авахгүй бол 0.5 литр усанд жижиг халбага зэсийн цэнхэр уусгаж дотуур цутгаж өгөх сайн (Г.Батмөнх).

ЦУС БӨГЛӨРӨХ

х

Үүнийг бас дүүрээ дэлбэрэх гэж нэрлэдэг бололтой. Тарган морийг ширүүн унаж эдэлснээс үүсдэг. Хамраас нь цус гоожно, цацаж ханиана, багтарна, амьсгаадна, унаж тийчилнэ.

Эмчилгээ:Тэр даруйд нь тагнайдна. Хэрэв цус бөглөрөөд удсан бол (1-3 жил) зоо, нуруу дагаж хулсан өнгөтэй үс бий болж толбо үүснэ. Энэ нь өвөл мэдэгдэхгүй харин зуны улиралд ил тод үзэгдэнэ. Энэ үед сүүлний гол судас ханана.

Хэрэв өвчин хүндэрч хамраас идээ гоожих, найлзуур булчирхай томорч гэдсээ татаж ирвэл буйллана. Үүний тулд хамрын хамгийн хойд талын сахал үс тушаа хоёр талаас нь ээлжлэн хатгана (Ц.Пүрэвзав).

Мөн өвчүүний мөгөөрсний хурууг ар талаас нь тоолж 6 дахь хурууны араар хөндлөн 10 см хиртэй гүн хатгаад хатгасан хутгаа хэвээр үлдээхэд хутганы иш хөдлөнө. Цус цоргодон гарч байгаад өөрөө зогсоно. Алдаж хатгавал зүрх хатах аюултай учир болгоомжлох хэрэгтэй (А.Цээрэв).

ТААНАТАХ

х

Таанатсан адуу хордож хөрвөөнө, гулдайж зогсоно, нүд нь их улайна, хүндэрвэл уухилж явж чадахгүй болно.

Эмчилгээ:Сүүлний хоёр талаар явсан судас ханана (Г.Зэвэг). Хатаасан нэг атга тааныг литр усанд буцалгаж 0.5 литр болтол ширгээж өгнө, намар, өвлийн зааг үед хааг ханах засал хийдэг.

Таанатаж цусаар шээвэл хамрын самсааны судсыг сахалын хамгийн хойд талын хялгасны ар дээр нарийн хутгаар нилээд лавхан хатгаж цусалбал сайн (М.Ваанчиг 1944). Бас хойд хоёр онгоныг (хас) ханана (У.Ёндон).

ХАЧИГЫН ХОРДЛОГО

х

Хавар хачиг ид унаж байгаа үед (3-р сарын сүүлчээр) адуу хачигт баригдаж хордох явдал тохиолдоно. Хачигтсан адууны хоёр чих дэлдийж бууна, адуу удаан зогсоно, халуурна, идээшлэхгүй, гуйваж явна, чихэнд нь хуруугаа хийхэд мэдрэхгүй, гэдсээ татна.

Эмчилгээ:Буга буюу гөрөөсний хатаасан цуснаас 2 хуруу чимх авч бүлээн усанд найруулж өгөх буюу хуурайгаар нь даавуунд боож амгайд нь боож өгнө маш сэрүүн чанартай учир морь чичирч байдаг, мөн хамар, тагнай ханаж болно (Д.Хашдорж).

Бас гүрээнээс нь 2 л цус авах буюу моринд баруун хамраар нь амьд жараахай өгнө (П.Тэхээш).

Хачигтаж халуурсан адуунд гиван (хөнхийн рашааны ус) өгнө (Д.Балдорж). Хачигтсан адуунд сүү бол хагас литр, шар тос бол 100 мл хамраар нь цутгаж өгч болно (Т.Ривади). Мөн хойлогны махны шөл 1 литр орчим өгдөг байсан, бас хүүхдийн шээс өгнө (Д.Балтуу).

Ж.Хурамхаан, хачигтсан адууны хааны (уушигны) судас хутга буюу зүүгээр ханаж цус авна. Эсвэл шүдний арын бондгор дээр хатгаж тагнайдаж эмчилдэг байна. Халуунтай, хөлстэй байхад уславал үхэх аюултай.

Н.Бахат, хачигтаж болзошгүй туранхай адууны гүрээнээс 3-р сарын 15-ны үеэр 200-300 мл цус авбал бараг хачигтахгүй, хачигтсан ч хөнгөн тусна. Хэрэв хачигтвал тагнай гүрээнээс цус авдаг байна.

Хачигтсан адууны сүүлний гол судаснаас 7 литр хүртэл (адуу том бол) цус авч буцалсан усаар усална. Сүүдэр газар уях хэрэггүй (А.Содномчой).

Хордсон адууны тагнайн урьдаас нь 3 дахь үенээс эхлэн 6-8 см зайнд нарийн үзүүртэй хутга буюу үзүүрлэсэн хулсаар ясан тагнайд хүрэхгүйгээр хаваж хатгана. Мөн сүү, цагаа буюу шар тос цайны халбагаар өгнө (Н.Равжир).

СҮР (СҮРДЭХ) ӨВЧИН

х

Алтайн нурууны өндөр уулын тагт зун, намрын сард адуу, тэмээ гэнэт салганан унадаг өвчин бий. Ардууд түүнийг сүр (сүрдэх) өвчин гэнэ. Зун, намрын борооны дараа өндөр уулын оройг манан будан бүрхэхэд сүрдэх өвчин ихэвчлэн тохиолддог. Мөн тэнгэр бүрхсэн, салхи шуургатай, бороотой үед голдуу YII сард тохиолдоно. Уулын тагт бэлчээрлэж байгаа адуу, тэмээний дэргэд исгэрэх, чанга гууглах, гэнэт үргээж цочоох, ширүүн туух үед адуу, тэмээ

олноороо салганан унаж, зохих арга засал хэрэглэхгүй бол хэд хэдээрээ үхэх тохиолдол нэг биш гардаг.

Байгаль цаг уурын ямар нэгэн үзэгдэл юмстай холбоотой байж болох талтай ийм тохиолдолд сарлаг уулнаас сүүлээ өргөн давхилдан бууж ирдэг байна. Сарлагт сүр өвчин тусдаггүй онцлогтой. Бас ботгонд сүрдэх өвчин тусдаггүй. Хур бороо орох, уулын оройд манан будан суух, салхи шуурга тавих үед мал сүрдэнэ гээд малаа өндөр уулнаас буулгаж байсан заншил Алтай нутгийнхны тухайд бүр эртнээс уламжлалтай.

Эмчилгээ: Сүрдэж, Салганан унасан адуу, тэмээг хөх буюу тостой даавуу шатааж, хэрэв тийм даавуу байхгүй бол бөс цамцнаас авч шатааж утаагаар нь утаж сэхээнэ. Бас зов талын хамраар нь хүний шээс цутгаж өгвөл сэхдэг ажээ (Б.Шижээ).

ХАМРЫН ГУУР

х

Шинж тэмдэг: Гууртсан адууны нүд гөлөрч нулимс гоожино. Хамар дотор 3-4 хуруу хиртэй гүнд бяцхан битүү улаан голтой шаралсан дугираг идээтэй яр гарч, нус гоожино, ханиаж, цээж нь хэрчигнэнэ, цустай нус гоожино. Сүүлийн гол судасны цохилт тасарна.

Эмчилгээ: Хүхэр, зэсийн цэнхрийг лантаз өвсний буурцагтай хольж нүдээд адууны толгойг битүүлж дахин дахин утна. Эсвэл дээрх нунтагийг 6 хуруу хиртэй урт гуурсанд хийж хамар руу нь үлээнэ. Хэрэв эмчилгээ оносон бол нунтагийг 2-3 үлээсний дараа хар толгойтой өт хамраас унана гэжээ. Хэрэв хүхэр, зэсийн цэнхэр байхгүй бол хужир шүүг хуурч түлээд лантазны буурцагтай хольж нунтаглаж хэрэглэдэг байжээ.

Гууртай адууны тагнайн хоёр дахь үеийг хутгаар ясанд нь тултал огтолно. Ингэхэд гурван салаа судаснаас цус гоожно. Дараа нь беөрөнхийлж зассан модоор тагнайн цусыг урагш нь нитгэрэн авна. Хэд хоног уух, идэхгүй болоход хорхой нь унаж эдгэрнэ. Эсвэл хоёр соёоны дотор талыг хатгана.

ХАНИАД

х

Тэмээ ханиах нь тэжээллэг, арчилгаа маллагаа, уналга эдэлгээний горим дэг алдагдах, элдэв халдварт, халдваргүй өвчний улмаас үүсч байгаа урхаг юм. Голдуу намар ханиад тусна.

Тэмээний ханиадыг шинж байдаар нь гурван янзаар ялгаварлан үздэг: Үүнд:

а. хөнгөн цацлага буюу тарганы ханиад тусахад тэмээ өнгөц ханиах бөгөөд усаар гачигдах үед голчлон намар тохиолдоно.

б. бөгших ханиад туссан тэмээний өвчин хүндэрсэн үедээ тэмээ бөгшиж ханиах бөгөөд үе мөч нь өвдөж хэвтэх болно.

в. халуунтай ханиад намар өвлийн зааг 10-11 сард тохиолдоно. Ханиасан тэмээ гэдсээ татна, идэж уухгүй хэвтэнэ. Дөрвөн мөч нь халуун болно. Тэмээ олноороо ханиаж халуурах явдал өвөл намрын зааг үеэр тохиолдож эхлээд нэг тэмээ дараа нь дөрөв таваараа, сүүлдээ бүр сүргээрээ ханиана. Хээлтэй ингэ зулбах, олон хоногоор хэвтэх, сааль нь татарч ботгоо цатгахгүй, сул дорой ботго төрнө. Ам, суга, цавьнаас эвгүй үнэр ханхална. Арчлахгүй

бол турж хатсаар байгаад үхэж болзошгүй. Энэ нь тэмээний вируст томуу өвчин ч байж болзошгүй.

Эмчилгээ: Өөртөө байгаа бололцоог ашиглан дор дурдсан эмчилгээг хийнэ.

Хөнгөн цацлага болж амьсгаадан ханиасан тэмээг тост бут (хар бут), арцаар утна. Тост бут шатаахад хар тос гоожиж өмхий муухай үнэртэй утаа гарна.

Бөгшиж ханиаж байгаа үед чээрэн, морин шарилж, хар шаваг, татанхай шаваг (үндэс нь мушгирсан) 200 грамм хэртэйг усанд буцалгаж хандалж өгнө.

Тэмээ ханиаж дотуур халуунтай үед цагаан гурил усанд зуурч өгөх, зээрний ундааг хандалж өгөх, чулуун нүүрс нүдэж устай хольж өгөхөд үр дүн сайтай байдаг.

Халуурч ханиан хэвтсэн бүдүүн тэмээнд 3-4 литр, ботго тормонд 500-700 мл хүний шээс нэг удаа өгөхөд сэхэх тал байдаг.

Саахалт айлын тэмээнд ханиад өвчин гарвал усны онгоцонд ул дүүргэж алсан туулайн гулууз хийж тэмээгээ услахад ханиад дамжин халдварладаггүй гэдэг (Л.Ишдорж, Т.Өлзийт). Энэ аргыг одоо ч малчид хэрэглэж байна. Мөн алсан туулайныхаа цусыг тэмээнийхээ аманд түрхдэг байна.

Ханиаж халуурсан тэмээнд цагаан гоёо, гунжин өвс хандалж өгнө.

Суурийн тэмээ олноороо зэрэг ханиасан үед дараах засал хийдэг:

-Тэмээ олноороо ханиасан үед гүрээний нарийн үзүүрийг ханаж толгойг тонгойлгон хар хүрэн цус авах мөн толгойн овооноос доош ясан дээр байгаад судсыг ханахад арваад хоноод ханиах нь зогсдог тал бий (Г.Ишдорж). Гэвч энэ арга халдвар тараах аюултай учир болгоомжлох нь зүйтэй.

-Аргалын эврийг хотондоо шатааж утахад тэмээний ханиад зогсох буюу ханиасан ч хөнгөн тусна.

-Тэмээ ханиахад загасгал, хатир (чээрэн)-ын хамт тогоогоор дүүрэн чанаж хандлаад хөргөж өгөхөд сайн нөлөөтэй.

АМРУУ

х

Нас гүйцсэн болон өсвөр тэмээ амруутна. Гэхдээ эцэнхий тэмээнд хавар, жижиг тэмээнд хүйтний улиралд голдуу тохиолдох бөгөөд том тэмээнд хүйтний улиралд голдуу тохиолдох бөгөөд том тэмээ зун, намар ч хааяа амруутдаг.

Шинж тэмдэг: Амруутсан тэмээ сүргээсээ сүүлдэж босох, хоцорч явах, бэлчээрт гараад зогсох зэрэг шинж үзүүлэх бөгөөд цаашдаа ханиах, нүднээс нь нулимс гоожих, ам уруул нь хавдаж, цэврүүтэн яр шарх үүсч шүлсээ гоожуулна.

Ботго тором өвс идэхгүй, ус уухгүй болж, амнаас нь өмхий үнэртэнэ.

Амруутсан тэмээний сүүлний ясны үеүүд мэдэгдэх болж арьс, мах нь суларсан байна.

Эмчилгээ: Амрууны яр шархыг хуулан шалбалж хуурай давс нунтаглаж түрхэнэ. Эсвэл давстай бүлээн хар цайгаар угааж шавшсаны дараа хуурай нунтаг давс түрхэнэ. Мөн загийн нүүрсээр хавдарт жин тавих, түрхэх, улаан шавагны утаагаар утна. Хэрэв засал авахгүй бол лантаз ургамлыг ногоон байхад авч хатаагаад бага тэмээнд лантаз өвсний нэг боргоцойгоор, том тэмээнд хоёр боргоцойгоор тус тус утна. Мөн тарваганы давстай тосыг шархыг шалбалж цус гаргасны дараа түрхэж эмчилнэ. Буцалмал усан дээр бага зэрэг өвс дэвсгэрлэн хийж халуун уураар нь утаж болно.

Амруутсан тэмээнд үхрийн ясыг усанд дэвтээж, усыг асгаад дахин буцалгаж гарсан шөлийг хоёр удаа өгөхөд сайн.

ТЭМЭЭ ЗООСТОХ

×

Тэмээний хэлний уг, багалзуур хоолойн салст бүрхүүлд олон тооны дугараг хэлбэртэй зузаан хүрээ бүхий их хөндүүр улаан толбо туурч яр гарахыг зоостох гэнэ. Малчид энэ өвчнийг цусаар үндэслэн үүсдэг жилбэнтэй холбоотой халдвартай өвчин гэж үздэг.

Шинж тэмдэг: Зоостсон тэмээ шүлсээ гоожуулна, амнаасаа хөөс цахруулна. Идээшлэхгүй, тэжээлдээ дургүй болж богино хугацаанд турж өнгө зүсээ алдана. Хүндээр тусвал хэлний уг болон багалзуурын салст бүрхүүл дээр хорин мөнгө, эсвэл тавтын улаан мөнгөний хэртэй улаан хүрээтэй дугараг толбо шарх үүснэ. Хэрэв ийм толбо хэлний хоёр талаар гарвал хөнгөн хэлбэр гэж үздэг.

Эмчилгээ: Зоостсон тэмээний амыг бүлээн усаар сайтар угааж цэвэрлээд давс нунтаглаж шарх дээр цацна. Мөн зэсийн цэнхэрийг шарханд түрхэнэ.

Амны хөндийн салст бүрхүүлд гарсан улаан толбо, гүвдрүүг иртэй юмаар маажиж шалбалж цус гаргасны дараа давс буюу давсыг зэсний үртэстэй хольж цэнхэр ногоон болгон түрхэхэд түргэн эдгэрнэ (Н.Чойхор. А.Жүд). Байванг нунтаглаж шарханд цацаж болно. Хужир давс, үхрийн ясны шөл өгөхөд сайн нөлөөтэй.

Түүнчлэн шар мод, улаан овс хандалж өгөх нь зүйтэй.

Дулаахан өдөр сонгож нэг өдөр уяж байгаад хэлэн доорх хоёр хар судсыг хатгана. Хүйтний улиралд бол өрхний эсгий, хонины нэхийг бүлээсгэн тэмээний зоо нурууг нэмнэж дулаан хонуулаад маргааш нь хэлний доорх судсыг хатгана. Бас дугуй толбон дээр зоос тавьж нүхээр нь хэлийг шөвгөөр хатгаж цус гаргаж эмчилдэг ч арга бий., Буцалж байгаа тосонд хятад зоос дүрж халаагаад толбо дээр тавьж хайрч эмчилдэг байжээ.

ГУВРУУТАХ (ХАДМАРАХ)

х

Ихэвчлэн бага насны тэмээ гувруутна. Тэмээний хамрын салст бүрхүүл үрэвсэхийг гувруутах гэнэ.

Шинж тэмдэг: Эрүүл тэмээ амьсгалахад хамрыи самсаа цорволзож байдаг бол гувруутсан үед хамар самсаа цорволзохгүй, харин дотогшоо хумхийж байдаг. Нүдний зовхин доогуур хөлөрнө. Гувруутсан атан тэмээний нүдний дээрээс, ингэний нүдний доороос мах ургаж улайна. Нүднээс нулимс гоожино. Хамарт нь хуруу хийж үзэхэд цэв хүйтэн (онцлох тэмдэг) бөгөөд дотор нь хөх мөгөөрс (халис) ургаж гарсан байна. Ботготой ингэ буйлж, идэш тэжээлдээ дургүй болж гэлүүрнэ. Хойд хоёр гуяны дотуур илж үзэхэд зангирсан булдруунууд буюу нарийхан савх мэт гүвдрүүнүүд тэмтрэгдэнэ.

Эмчилгээ: Бүдүүн тэмээ гувруутсан бол түүний хамар дотор ургасан хөх мөгөөрсийг огтолж авна.

Гувруутсан бага тэмээний хамрын хөндийн мөгөөрсийг долоовор хурууны хэртэй бөөрөнхий хулс, хус модоор бургуйдаж мөгөөрсийг нухаж шалбалан цус гаргавал эдгэрнэ. Эсвэл буга, цагаан зээрний халуун цус буюу зээрний мах ялз чанаж шөлийг нь өгөөд нэмнэж хөлөргөвөл сайн нөлөөтэй.

Тэмээ таргалах цаг болсон үед чамархайг хатгаж урхагыг арилгана.

АРАНГА

х

Тэмээний дээд буюу доод талын арааны өмнө, эсвэл дотор талд нь ихэвчлэн илүү хар шүд ургахыг арангатах гэнэ.

Шинж тэмдэг: Тэмээ идээшлэх үед илүү шүд нь хэл, тагнай, буйл руу хатгаж өвчлүүлэх учир тэмээ идээшлэхгүй хивэхгүй болж гөлөрч зогсдог. Богино хугацаанд эцэж турж, өнгө зүсээ алдана. Ийм шинж тэмдэг үзүүлсэн тэмээний араа шүдийг шалгаж үзэхэд араа шүдний өмнөх үзүүр буюу дотор талд муухай хэлбэртэй илүү хар шүд ургасан байна.

Эмчилгээ: Арангатсан тэмээний амыг модоор (дүрээгээр) тэвхдэж илүү ургасан шүд тушаа тостой халуун давсаар жин тавьж байгаад илүү шүдийг адууны ранга шүд авахтай ижил арга хэрэглэн булга цохиж авдаг. Илүү шүдийг авахдаа эрүүг хуга цохихоос болгоомжилохын тулд эхлээд зөөлөн цохиж ганхуулаад дараа нь бахиар мушгиж авч болно. Ийнхүү авсан шүдний оронд хонины сүүл, шар тос буцалгаж халуунаар жин тавина.

БАГАЛУУРТАХ

х

Багалуур найм, есдүгээр сард тав, зургаан үетэй болж замбагалж цэцэглэх бөгөөд энэ үед их шимтэй, ямар ч мал дуртай идэж таргалдаг байна.

Харин зуны эхэн 5, 6-р саруудад багалуур 2-3 үе ургаж тачир, өлөн чийгтэй байхад их хэмжээгээр идсэн тэмээ (бусад хивэгч мал)-ний гүзээ дүүрч, хүндэрвэл тэргэн зуур үхэх явдал ч нилээд тохиолдоно.

Шаравтар будаг суусан, элс шороон шуурганд цохиулсан, цэнхэр ногоон өнгөтэй, чийг шүүс муутай багалуур тэмээний гэдсийг гойд их дүүргэдэг байна. Чээрэн бут нүдэлж замбалах үед (5 сарын дундуур) багалууртай хамт их идвэл гэдэс дүүрэх нь их байдаг.

Шинж тэмдэг: Багалууртсан тэмээний гэдэс дүүрч, чацга алдана. Сэвсээрээ бөөлжинө, хүчтэй янцаглана. Тогтворгүй болж налах, хэвтэх, босох нь олширч байж ядан тэнүүчилнэ. Нэг багалууртсан тэмээ ахин дахин багалууртах бөгөөд голдуу ботготой ингэнд илүү тохиолдоно. Зарим үед тав арваараа тэмээ бэлчээрээс ирэхдээ гэдэс нь дүүрсэн ирдэг. Тэмээ багалууртахаас сэргийлэхийн тулд багалууртах үед (зуны эхэн саруудад) тэмээг багалуур бага ургадаг бэлчээрт залах, бэлчээх, цагаан өвстэй бэлчээрт хариулах, бэлчээрт гарахын өмнө услах хэрэгтэй, салхи өөд ширүүн туухыг цээрлэх хэрэгтэй.

Эмчилгээ: Багалууртсан тэмээг эмчлэхэд дараах аргуудыг хэрэглэнэ.

-Багалууртсан тэмээг барьж уях буюу олноороо гэдэс нь дүүрсэн бол хурааж хэвтүүлнэ.

-Исгэлэн тараг, креолин, ихтиолын цийдмэг цутгаж өгнө.

-Салхины уруу ширүүхэн тууж чацга алдуулахад сайн, гэхдээ гэдэс нь хэт их дүүрсэн тэмээг хүчтэй туухаас болгоомжилбол зохино.

-Гэдэс нь дүүрсэн тэмээг унгуулах, хэхрүүлэхийг онцгой чухалчлах хэрэгтэй. Үүний тулд адууны шар хомоол, шар будаа, хонины зунгагтай ноос, утаатай шар эсгийг шатааж салхин дээр нь хиншүү тавьж утдаг.

-Гэдэс нь дүүрч, амь нь тэмцэж үхэхэд хүрвэл гүзээг шприцын бүдүүн зүү, гуурстай шөвгөөр хатгана. Нуруунаас 4 хуруу, сүвээний хавирганаас 4 хуруу тавьж уулзуур дээр хатгана. Амь тэмцэж байгаа тэмээний хоёр бөхний орой руу 4 хуруу гүн хутгаар хатгахад хөөстэй цус гарч засал авдаг (Д.Долгор).

ЖИЛБЭН

×

Тэмээг уяа сойлго хийхгүйгээр ширүүн унаж эдлэх, арчилгаа тэжээллэг, эдэлгээний дэг журам, гам алдагдсанаас үүсэх эмзэг гэж малчид үздэг бөгөөд олон хэлбэрээр илрэх энэ өвчнийг жилбэн гэнэ.

Тэмээний жилбэнг хавар тохиолдвол усан жилбэн, намар тохиолдвол тосон жилбэн гэж нэрлэнэ. Эдгээрээс гадна бас хийн жилбэн, цусан жилбэн гэж ялгаварлан үздэг ч бий.

Дээр дурдсан олон хэлбэрийн жилбэн туссан үед тохиолдох шинж тэмдэг, тэдгээрийг эмчлэх аргуудыг авч үзье.

Тосон жилбэн туссан тэмээний тагнай цагаан цайвар болж тагнайн гол нь хотойн хатуурч хавдана. Сүүлний дотор талыг имэрж үзэхэд ясны үеийг тэмтрэн тоолж болохуйцаар сүүлний арьс нимгэрч суларсан байна. Хоргол нь гялгар бүрээстэй болно.

Эмчилгээ:Тосон жилбэн туссан тэмээнд дарь буюу хаврын тарваганы цөс, адууны цөс, байвгайн доньт (хэлэнд түрхэж) өгнө.

Тарган том тэмээнд бол тарваганы цөсний талыг, ингэ, бага насны эцэнхий тэмээнд дөрөв хуваасны нэгийг өгнө. Дараа нь үхрийн борц, ясны буюу махны шөл өгөхийг чухалчилдаг. Мөн хонины сүүлний нэг үеийг нарийн зүсэж, дээрх аргыг хэрэглэсний дараагаар эмгэгтэй тэмээний хошногонд шургуулж голын хийг дарах засал хэрэглэнэ. Хавар ногооноор тэмээний гүрээнээс 1.5-2 литр цус авна (Ц.Адьяа).

Амьтан ургамлын гаралтай дараах эмийн зүйлийг өгч эмчлэх аргуудыг хэрэглэнэ.

Тосон жилбэн туссан тэмээнд адууны халуун цус 3-5 литрийг цутгаж өгөөд нэмнэж хөөж хөлөргөсний дараа уяна. Цагаан зээр, хар сүүлтийн 3 сартай хээлийг савтай нь хамт авч хатааж нунтаглаад 50 гр хиртэйг усанд дэвтээж хандлаад өдөрт 2 удаа 3 өдөр дараалан өгч эмчлэхэд үнэхээрийн сайн (С.Бариад). Эсвэл зээрний эхийн ус, ботгоны хальс, ингэний усыг 4 литр халуунаар нь өгвөл үнэнхүү тус болно. Суман модны нэг хоолны халбага зоргодос (үртэс) 2 шанага усанд ханд чанаж 1 литр болтол ширгээн өгч нэмнэж, хөлөргөнө. Зулзган модны ногоон шилмүүс, холтсыг 1:10 харьцаатайгаар усанд хандалж бүлээнээр нь 1,5-2 литрээр өдөрт нэг удаа 3 өдөр дараалан өгөхөд ашигтай. Ташаа, сүвээ зэрэг газарт хавдар үүсвэл дэлүү, уушгиар хөхүүлнэ.

Бургасны хальс 1:10 харьцаатайгаар усанд хандалж 500 мл-ээр өдөрт нэг удаа, цахилдагийн үндэс 1:10-аар хандалж 1,5-2 литрээр өдөрт нэг удаа 3 өдөр дараалан өгнө. Тууплин 1:10-аар усанд хандалж өдөрт 1 удаа 1 лигрээр 3 өдөр дараалан өгч нэмнэнэ. Нэмнээг 3-7 хоногийн дараа салхигүй дулаан өдөр авна. Халуун хар цайнд хуурсан шар будаа хийж уур гарахааргүй бөглөж бүрээд, хөрсөн хойно нь 5 литр орчмыг 2-3 хоногийн завсартай 3 удаа өгөхөд түргэн тэнхэрнэ. Тэмээг хонины намрын шар хорголоор (толгойг нь юмаар хучиж) утахад сайн.

Хийн жилбэн: туссан тэмээний ам өмхийрч тагнай нь хүрэн буюу хөхөрч суларсан (онцлох шинж) байна. Чийглэг салхитайд тохом хуулснаас үүснэ. Эцэж турж, өнгө зүсээ алдана. Тэмээний нүдэнд хүний хагас тал нь харагдана (С.Цагаанөвгөн). Үүнийг хийн жилбэний онцгой шинж гэж үздэг.

Эмчилгээ: Шар эсгий буюу зунгагтай эсгийг халуун усаар нэвт норгож хийн жилбэнтэй тэмээний нуруунд тохож хөхүүлнэ. Эсвэл нэг хормой хиртэй ногоон халгай түүж чанаж хандлаад бүгдийг нь өгч эмчилнэ. Мөн үхрийн удсан борц буюу богино хавирга буцалгасан

шөлийг тарган тэмээнд 5-6 литр, эцэнхий тэмээнд 4 литр орчим тус тус өгч тэнхрүүлнэ. Тосон болон хийн жилбэнтэй тэмээнд хурганы зуны хэвтэр шавхай жалавчин тогоонд буцалгаж ширгээгээд дундуур болгон нэг өдөр хоёр хувааж өгдөг. Хийн жилбэнгийн урхагаас буглаа үүсдэг гэж үздэг.

Ийм тэмээнд 2 кг шар будааг хуурч 10 литр халуун усанд бүрж хөргөөд бүгдийг нь өгөх засал хийнэ (Ц.Дальхүү).

Усан жилбэн туссан тэмээ хэхрэх, гэдэс нь нарийсах, нартай өдөр заримдаа хөх нус гоожуулах, усан дээр авчирч услахад гэдийсхийн зогсож хэхрүүлнэ. Усан жилбэнтэй тэмээг усалбал дороо үхэж мэдэх учир болгоомжлох хэрэгтэй.

Эмчилгээ: Усан жилбэн туссан тэмээнд шар будаа бүрж (ам хагалж) 4-5 литр хиртэйг, мөн энэ хиртэй үхрийн борцны шөл өгнө. Зусаг, төлөг хонины сүүг хоолны жижиг халбагаар хоёрыг өгнө. Элс халааж савлаад хондлой дээр нь тавьж жин тавина. Эсвэл баавгайн доньт буюу хаврын тарваганы цөс хэлэнд зурж түрхэж эмчилнэ. Усан болон хийн жилбэнд хонины хуучирсан сүүлний иэг үеийг нарийн зүсэж тэмээний хошногонд шургуулах буюу эсвэл дүнсэн тамхи гурав хуваасны нэгийг буцалгаж өгч тэнхрүүлэх засал хийнэ.

Цусан жилбэн туссан тэмээг эгц зогсоогоод урьдаас нь харахад нэг талын гэдэс нь татагдаж дээшээ сойгдсон байдалтай харагдана.

Эмчилгээ: Сойгдсон талын соёоны дотор талын тагнайг хатгана. Голд нь тогтсон цусыг авахын тулд хойд бөхний оройн гол руу төө сөөм буюу төө дөрвөн хуруу хэртэй хөндий шөвгөөр хатгаж цуслана. Зарим малчид хасны хоёр судасны уулзуур дээр ханадаг байжээ.

Наран жилбэн буюу гуйванга өвчин нь хурц нартай үед тохом авах, ноослох зэргээс тусах бөгөөд тэмээ өвс идэхгүй турж хатингар болно. Нүдээ шөргөөх, нүдний ухархай нь хонхойн нулимс асгаруулах, суниах салхи татаж явах буюу хэвтэнэ. Үс нь тачир хилэн мэт болох ба ажиглавал үсэн доор нь хэсэг хэсэг өөр өнгийн үс ургаж, цоохортож бүрзийсэн хорголын нэг тал шөвийсөн байна. Гуйванги туссан тэмээний ясны чөмөг хатаж тосоо барж цайсан байна.

Эмчилгээ: Худгийн усны хүйтэн хөх лайгаар эсгийг норгож тэмээг нэмнэж хөхүүлнэ (Ж.Балжинням). Зун бол тарваганы бүхэл мах шалз чанаж шөлийг цутган өгч хөлөртөл хөөвөл засал авна.

Өвөл бол хонины сүүтэй цай өгч нэмнэж дулаалаад хөөж хөлөргөнө. Мөн үхрийн гол махны дөрөвний нэгийг чанаж шөлийг нь өгнө. Таван литр халуун хар цайнд 1-2 шаазан шар будаа хийж халуунаар (шар будааны ам хагалж) өгөхөд хялбар тэнхэрнэ. Ер нь тэмээний ямар ч өвчинд лүүгийн мод, шаваас, цаас буцалгаж өгвөл заавал тус болдог байна. Наран жилбэнтэй тэмээнд хүний сүүг хавар ногооноор 25 мл хэртэй нэг удаа өгөхөд сайн (Т.Туулайхүү). Тэмээний жилбэнд шар будаатай хамт цулбуур өвсний 2-3 үндэс хамт чанаж өгөх, эсвэл дэрсний хөх дэмбүүлийн үндсийг тогоогоор дүүрэн чанаж хар цай мэт болгон хандалж 4-5 литрээр 1-2 өнжөөд өгөхөд тус болдог байна.

ХАЧГИЙН ХОРДЛОГО

х

Хачиг ид буух үед их хачигтсан тэмээ өнгө зүсээ алдаж, босож чадахгүй хэвтэнэ. Далны урд талын булчирхай томорсон байна. Халуурна.

Эмчилгээ: Тэмээнд өөрөөс нь 10 хувалз түүж цаасанд боож ам руу нь хийхэд захиалан ам нь улаан шүлс болно. Хэрэв эмчилгээ тохирсон бол хэд хоноод босож идээшлэнэ (Д.Дайдаахүү). Тэмээний хачиг, хувалзыг түүж авбал салхинд цохиулах гэм суух аюултай. Харин хачиг, хувалзыг хайчилж авах нь зүйтэй гэж үздэг.

Хачиг болон бусад шалтгаанаар тэмээ халуурахад дараах эмчилгээ хийдэг.

Боодол улаан тамхины талыг 5 литр усанд буцалгаж 3 литр хүртэл ширгээж тамхины бүдүүн ишийг түүж авсны дараа тэмээнд цутгаж өгч хоёр өдөр нэг шөнө уяна.

Хорыг авахын тулд хоёр хааг хатгана. Бөхний үзүүр лүү 10-15 см урт нарийн хутгаар хатгаж, хатгасан газар луугаа бага зэрэг зэсийн цэнхэр хийхэд зүгээр болдог байна. Мөн сойлго алдсан тэмээнд энэ заслыг хийж болно.

Халуурсан тэмээнд нойтон бургасны хальсыг хуулж усанд сайн буцалгаж хандыг нь өгвөл халуун бууна.

ЧҮНГЭРЭГ

х

Зуны халуунд халгай, халуун өвс идсэн буюу өвөлжөөнд хэвтэж хоносон тэмээг ширүүн тууж хөөснөөс энэ өвчин үүснэ. Ийнхүү 2-3 саахалт газар хөөвөл тэмээ амнаас нь цагаан хөөс цахарч, цээж нь хоржигноно.

Эмчилгээ: Нэрмэл буюу буцалгасан цагааны шар усыг 2-3 шанага өгөхөөс гадна шавших. Хүйтэн усаар норгосон эсгийгээр биеийг нь хучих, эсвэл усанд зогсоох эмчилгээ хийдэг байна. Эдгэрэхгүй бол хоёр дөрөдхийг суганаас хойш төө буюу дөрвөн хуруу тавьж хоёр салаа судасны нэгийг хатгадаг.

ХӨХ ӨРГӨСТӨХ

х

Тэмээний хэл, уруулын салст буурхүүл үрэвсэж, хөхөнцөрүүд нь томрохыг хөх өргөстөх гэж нэрлэнэ. Энэ эмгэг ихэвчлэн 2-3 насны тэмээнд хавар тохиолдоно.

Шинж тэмдэг: Хөх өргөстсөн тэмээний ам өмхийрч, өвс идэхгүй, ус уухгүй болдог. Эхлээд хэл бэржийж улайна. Харин 3 хоногоос өргөсүүд томорч тэдгээрийн завсраар 2-3 салаа үзүүртэй үс мэт өргөс ургасан байна.

Эмчилгээ: хэл уруулын гэмтсэн газарт нунтаг давс үрэх эсвэл өөхөн тостой хуурч халуунаар нь томорсон хөхөнцөрүүдэд түрхэх буюу чимхүүр, хямсаагаар өргөсийг зулгааж аваад хуурай нунтаг давс үрэх арга хэрэглэдэг ажээ.

БӨӨДИЙТЭХ (ШИВЭЭТЭХ)

х

Говийп зарим нутагт шивээний төрлийн ургамлыг говийн малчид бөөдий гэж нэрлэдэг. Намар бөөдий өвс хатаж бөөдийн шивээ тэмээний үс ноосонд наалдаж, улмаар арьсанд ярган орж үрэвсэл үүсгэнэ. Бөөдийтэх өвчин суурийн бараг бүх тэмээнд тусаж болно.

Шинж тэмдэг: Бөөдийтсэн тэмээний үс ноос нь бөөгнөрч, ихэвчлэн хөлийн шилбэний үс халцарч, биеийн зарим хэсэгт үрэвсэж эсэргэнэ туурч идээлнэ. Өвчилсөн тэмээ амархан турна. Хамуутай төстэй бөгөөд буглаа дотор шивээний зүү яргаж орсон байдгаар нь ялгаварлана. Тэмээ шөргөөнө. Эхлээд тэмээний хөл, дараа нь биеийн бусад хэсэгт үс нь налаж шивээнд орооцолдсон, тэр тушаа буглаж идээлсэн байна.

Эмчилгээ: Тэмээний биед ассан шивээг түүж, шалбарч идээлсэн арьсыг савантай усаар угааж үсний сорыг босгох, үрэвсэл буглаа, шархыг ариутгах уусмалаар угааж эмчилнэ.

Энэ өвчнөөс сэргийлэхийн тулд бөөдий их ургасан бэлчээрт тэмээг намар бэлчээхгүй байвал зохино.

ЧАЦГАРАХ

×

Энэ өвчин 7-10-р саруудад тохиолдох бөгөөд хөмүүл, таана, гашуун шаваг их идэх үед илүүтэй тохиолдоно. Бас сойлго алдах, жилбэнтэхэд гарна. Тэмээний толгой, хүзүү, бөхөнд товойсон хатуу хавдар гарна. Эхлээд шөргөөж арьс нь халцарч хогжруутан дараа нь хавдаж идээлнэ. Цус, идээ гоожно. Хавдар хагарахгүй удах ба хавдар хагарсан хойно шөргөөх нь улам ихсэнэ. Бусад тэмээг шөргөөж халдаана. Ус, тэжээлээс гарна. Эмчилгээ хийхгүй бол үхнэ.

Эмчилгээ: Бөхөнд хавдар гарч, үс нь унаж бөх нь шомбойсон үед бөхний орой руу хутгаар шааж, гарсан шарханд шалзны хэртэй зэсийн цэнхэр хийнэ. Хүзүү гуянд гарсан хавдарт мөн зэсийн цэнхэр хийдэг ажээ.

Үс халцарч, арьс овойж хавдах, шөргөөх үед хавдрыг хагалж, шарханд нь алсан, үхсэн могойн биеээс 1 см хиртэй буюу могойн хальсыг шарханд нь хавчуулж хийхэд, хурдан эдгэрдэг байна (Э.Бумцэнд, Д.Түдэв, С.Бариад).

Багалуурын үнсийг шатааж, гарсан үнсийг усаар зуурч шархыг шавахад (1-2 удаа) эдгэнэ (Д.Ролгор). Шарх хатаж тав үүсч унана. Шархан дээр хүүхдийн халуун өтгөнийг тавьж боогоод 3 цаг хэртэй байлгахад зүгээр болдог тал бий (Д.Батсүх).

УСАН СОЙЛГО

×

Тэмээг хавар ширүүн унаж эдэлж яваад гэнэт усалснаас усан сойлго тусна.

Шинж тэмдэг: Тэжээл унднаас гарч алс харж зогсоно. Нулимс асгаруулна. Гэдсээ амархан татна.

Эмчилгээ: 10 литр өтгөн халуун хар цайнд хүрэн хар болтол хуурсан хоёр аяга шар будаа хийж, уур гаргахгүйгээр бөглөж шар будааг хонуут бүрнэ. Уурыг гаргахгүйгээр хөргөж бүгдийг усан сойлго туссан тэмээнд нэг удаа өгч засал хийнэ.

ТОСОН СОЙЛГО

×

Энэ эмгэг ямар ч насны тэмээнд намар тохиолдоно. Тарган тэмээг уяа сойлгогүй эдэлснээс үүснэ.

Шинж тэмдэг: Тэмээний ноосны ёзоор нь тостой болж завааран (зунгагтай болсон), үсний үзүүр нь түжийсэн байна. Тарга хүчний байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт илрэхгүй.

Эмчилгээ: Тосон сойлго туссан тэмээг барьж уяж байгаад ингэ ботголох үед ингэний хээлийн уснаас 4 литр цутгаж өгөхөд эдгэрнэ.

Эсвэл хавар ногооноор тосон сойлго туссан тэмээний гүрээнээс 0.5 литр цус авч хоёр гуянд нь хувааж тарихад эдгэрдэг байна. Тэмээг сойж урд хоёр хөлний алган хумснаас хойш тавхайн хажуу талаас шивэж хатгах эмчилгээ хийдэг.

ДОТРЫН ЯР

х

Энэ өвчин ямар ч насны тэмээнд хавар тохиолдох бөгөөд ширүүн бут, заг идсэний улмаас доторын яр үүсдэг гэж үздэг.

Шинж тэмдэг: Өвчилсөн тэмээ налах, нүдний сормуусны үзүүр нь нугарч дотогшоо эргэж сормуус нь хуйхалсан мэт харагдана. Үзүүртэй, бүрхүүлтэй хэлхээтэй хоргол гаргана. Их халуурна. Гэдэс гүзээ дүүрэхгүй. Хүйтэн ус уувал дороо үхнэ. Аргалахгүй бол үхэж болно.

Эмчилгээ: Ирмэгтэй сохор хар цох (шинжин туулиу ч гэдэг) нэгийг бүтнээр нь усаар даруулж өгдөг байна. Мөн ердийн сохор хар цох ч өгч болно (Н.Чойнхор). Нэг аяга дүнсэн тамхи усаар зуурч 1-2 удаа өгнө. Засрахгүй бол сохор хар цох гурвыг бүтнээр өгнө (Г.Өлзийт). Бас хар дарь цайны халбагаар нэг өгч эмчилдэг байна.

ХАТИАР

х

Ямар ч өнгөй жилд тэмээ идээшлэх боловч таргалахгүй уруул нь шөвийж хатаж, шүд нь ярзайна. Нүдний ухархай хонхойно. Үс ноос тачир ургана.

Ус бага ууна. Сүүлний үзүүр 3-4 хуруу хиртэй заг мод мэт ян хатана.

Баас нь бүрхүүлтэй, хоргол нь гонзгой нэг тал нь шөвгөр, хоорондоо хальсаар хэлхээтэй байна. Аргалахгүй бол аяндаа үхнэ. 2-3 настай тэмээнд илүү тохиолдоно.

Эмчилгээ: Хатиарсан тэмээнд дараах аргуудын аль нэгээр эмчилгээ хийнэ.

-Хавар ногоонд мал цадах үед нядалсан ямааны гүзээний сэвсийг базаж авч хаяад үлдсэн шүүсэнд нэг аяга давс хийж (давсыг бага зэрэг халаана) бүгдийг нь хатиартсан тэмээнд цутгаж өгөхөд засал авдаг.

-Ногооны үед хатиартсан тэмээнд хонин гүрвэлийг 3 хоногийн зайтай 3 удаа

өгөхөд хүрэлцээтэй гэж үздэг. Гүрвэлийг амьдаар нь тэмээний ам руу шидэж өгч наанаас нь усаар даруулна. (Н.Чойнхор, А.Жүд)

-Хатиартсан тэмээний хатсан сүүлийг хавар ногооноор хатсан хэсэг, эрүүл хэсгийн дундуур огтолж цус гаргана. Сүүлний хоёр талаар явсан судсыг ханана. Сайн хөлөргөж тарваганы махны тостой шөл 3 литр орчим өгч нэг өдөр уяад тавихад засал авна (Б.Зонров).

-Мөн сүүлний үзүүрийн 1-2 дахь үед хатгаж, зээрний хээлийн ус буюу гүүний сүү өгч эмчилдэг.

-хатмал, тарга хүч авдаггүй тэмээнд будааны ам хагалж өгнө. Үүний тулд 5-аас доошгүй литр аагтай халуун хар цайнд 1-2 шанага шар будаа хийж савыг нь таглаж бүрхэнэ. Ийнхүү бүрсэн шар будаатай хар цайнаас нэг тэмээнд 5-аас доошгүй литрийг 1-2 удаа 7 хоногийн завсартай өгөхөд тэмээ тэнхэрч таргална.

-Зуны торомтой ингэний сүүг 500 мл-ээр өдөр бүр 2-3 удаа өгч эмчилгээ хийнэ (Э.Бумцэнд).

-Нэг аяга шар будааг нойтон цаасанд боож шатааж нүүрс болгоод нүдэж өтгөн хар цайнд самарч 2-3 литрээр 2-3 удаа өгч болно.

-Бөөрөлзгөний үндэс, ишийг нүдэж чанаж хандлаад 5-6 литрээр хэд хэд дахин өгч болно. Хэмжээ ихэдсэнээс хор болохгүй.

-Мөн монгол өвс, цахилдагны үндэс чанаж өдөрт нэг литрээр 2-3 өнжөөж өгнө.

Дээрх өвс ургамлын ханд тохирвол дороо гэдэслэж, өнгө зүс нь засарч эхэлнэ.

Их нууруудын хотгор газарт бас тэмээний хатиар гэж нэрлэгдэх су-ару өвчинтэй төстэй эмгэг тохиолдоно. Одоогоор онош нь бүрэн тогтоогдоогүй ч су-ару өвчин байх бүрэн үндэстэй. Энэ өвчин ус, намаг, гол, цөөрөмтэй нутагт олон жил маллах үед тохиолдоно. Малчдын үзэж байгаагаар ялаа, шумуул ихтэй гол газар тэмээг ногоолуулах үед тохиолддог гэж үзэж байна. Ялаа, шумуулгүй гашуун өвс ургамал ихтэй нутагт тэмээг ногоолуулж, зусах нь уг өвчнөөс сэргийлэх арга гэж үздэг. 50-60 жилийн өмнө 100 гаруй тэмээтэй айл дөнгөж ачаалах хэдэн тэмээтэй үлдэж байжээ. Зарим аж ахуй 80-аад оны үед тэмээгээ олноор үхүүлж байсан байна.

Шинж тэмдэг: Тэмээ гурна. Нус, нулимс гоожуулна. Өнгө зүсээ алдаж хувхай өгөр өнгөтэй болно. Мал таргалах үед бүр тодорхой болж, муу гэдэслэх бөгөөд идэж уухдаа дурамжхан байна. Бөх нь өөхөлж босохгүй, хэвтээ хэвээрээ байна. Сүүлний гурван үе нь хатна. Ийм тэмээ зун, намар бүрэн тарга хүчээ авахгүй бөгөөд өвөл, хавар нь үхэж хорогддог байна.

Эмчилгээнд дараах аргуудыг хэрэглэдэг ажээ. Үүнд: сүүлний гол, хоёр дөрөлхийг 7 хоногийн завсартайгаар ээлжлэн ханана. Дөрөлхийн хоёр салаа судасны уулзуур дээр ханана. Зарим нь сайжирч эдгэрэх боловч тэр болгон эдгэрдэггүй (Б.Юнрэн).

Өвчтэй тэмээнд арц буцалгаж өгнө. Мөн тэмээний хатиартсан үед өгдөг дээр дурдсан бэлдмэлүүдийг өгч болдог байна.

СУРТАХ

х

Голдуу хөгшин тэмээ их элс шороотой өвс идсэнээс суртана. Суртсан тэмээ хэвтэж, гэдэс нь томрон, нүднээс нь хужир дааварласан нулимс гоожно. Хоргол нь хатингартан, хорголыг таваг дотор хийж усаар шингэлэн угааж үзэхэд тавагний ёроолд их хэмжээний элс үлдэнэ. Үүгээр өвчний онош тогтооно.

Эмчилгээ: Хоолны давс буюу туулгах эмээр туулгана. Дундын нэг шаазангаар хоолны давсыг 3 литр усанд хийж суртсан тэмээнд өгөөд хөөж чацга алдуулбал зүгээр болно.

ХАМРЫН ГУУР

х

Тэмээний хамарт гуур үржсэнээс энэ эмгэг үүснэ.

Шинж тэмдэг: Гууртсан тэмээний эрүүн доор хавдар үүснэ, нүд нь цийж хөхрөх ба шүдээ хавирна. Бага зэрэг халуурна. Турж эцэх нь илүүтэй.

Эмчилгээ: Дарь буюу хүхрийг шүү хужиртай хольж өгөх буюу хоёр хамар өөд ээлжлэн үлээх замаар өгнө. Эдгэрэхгүй бол хамар луу нь марганц үлээж болно.

Мөн үхрийн мах, ясны шөлөнд бага зэрэг креолин хутган уулгавал заавал эдгэрнэ.

СОЙЛГЫН ГЭМ СУУХ

х

Намар тарга хүчээ авсан үед уяа, сойлгогүйгээр хүнд ачаа ачих, уналга эдэлгээнд хэрэглэх, хөлстэй тэмээг уяж холсийг хатаахгүй тавьж идээшлүүлэх зэргээс шалтгаалан гэм сууж хатингартаж, тарга хүч авахгүй шарлана. Сойлго алдсан тэмээний толгой, шанаа, хоншоор, сүүлний угны үс халцарч унана.

Эмчилгээ: Царван, дэгд, морин шарилжийг адил хэмжээгээр хольж дураар нь идүүлэхэд тарга тэвээргэ авах нь сайжирна.

-Хатингартсан тэмээнд хүж, шар мод, тууплинг буцалгаж өгөх, халуун элсэн дээр хэвтүүлэх, халуун элсээр булах зэргээр засал хийж болно.

-Тарга хүч авч эхлэх үеийг дагуулан дөрөөлөхийг ханаж литр орчим цус авахад тарга хүч сайжирна.

-Зарим нутагт чамархай, сүүлний гол судаснаас цус авч тарга тэвээрэг авалтыг сайжруулдаг байна.

-Эдэлгээг хэтрүүлж, шарласан тэмээнд зээр, тарваганы махыг шалзартал чанаж шөлийг хөргөөд цутгаж өгөхөд тамир орох нь дээрдэнэ.

ЖҮГЭН

х

Ихэвчлэн 2-3 настай тэмээнд голдуу тохиолдоно. Тэмээ турж, цээжин бие нь хавчийж биеийн энд тэнд хавдаж идээлнэ. Хавдар ихэвчлэн булчирхайд ойр газар гарна. Хавдар дотогшоо хагарвал тэмээ удахгүй үхдэг. Үүнийг зарим малчид буглаа ч гэж нэрлэдэг.

Эмчилгээ: Таана ихээр идүүлэх буюу тааны үндэс хандалж (5 литр усанд 4-5 таананы үндэс хийж буцалгана) өгнө (Т.Туулайхүү). Бугалааг хагалж идээг сайн шахаж гаргаад ариутгах бодис түрхэж эмчилнэ.

Марганцыг усанд шингэн найруулж (дөнгөж ягаан болгоод) буглаа руу шахаж угааж эмчилдэг.

Буглаа гардаг суурийн тэмээг жил бүр туулгаж, тарга хүч сайн авахуулбал буглаа гарахаа больдог байна.

2 кг шар будааг хүрэн хар болтол хуураад халуунаар нь 10 литр хар цайнд хийж таглаж бүрээд хөргөж өглөө нь бүгдийг цутгаж өгнө.

БӨӨР УНАХ

х

Тэмээг өл хоолгүй унаж ширүүн давхих, хэт хүнд ачаа ачих, ширүүн элдэж хөөх, хальтарч унах зэргээс шалтгаалан бөөр нь унах гэмтэл тохиолдоно.

Шинж тэмдэг: Бөөр нь унасан тэмээ налах, тарайн хэвтэх, хэвтэж босох нь олширно. Тийчлэх, дэвсэх, тийрэх зэрэг шинж тэмдэг үзүүлэхээс гадна цустай шээнэ. Бөөр унасан талаараа налж толгойгоо босгож хэвтэх, хоргол нь заавал цустай байх зэрэг нь бөөр унахын үндсэн шинж бөгөөд бөөр тушаа дарахад эмзэглэнэ. Бөөр тушаа үс нь халцарсан байна. Дүлэх, нуруугаа бөгтөр болгох зэрэг шинж бас үзүүлнэ.

Эмчилгээ: Бөөр нь унасан тэмээг урьдаар газар ухаж бэлтгэсэн нүхэнд хоёр бөхөөр нь газар шаалган хэвтүүлээд дөрвөн тавхай дээр нь хавтгай мод тулган тавьж уг модон дээрээс нь модон мунаар гурав гурав ээлжлэн доргиож засал хийнэ. Үүний дараа 2-3 цаг хөдөлгөөнгүй хэвтүүлж тун зөөлөн босгож хөдөлгөх хэрэгтэй. Засал авсан бол сүүлний гол судас ханадаг байна.

Мөн тэмээг унагаж хоничлон дөрвөн хөлийг боож дөрвөн тавхай руу нь 4-5 удаа модоор цохиж доргиож болно. Хойд хөлийн тавхай руу арай хүчтэй цохино (Д.Ролгор). Мөн бөөр тушаа модон уур тавьж, уурын модоор уурын ёроол руу 2-3 удаа цохиж доргио үүсгэж бөөрийг хэвийн байдалд оруулах засал хийдэг.

Олон ясны уулзуур дээр тогоо хөмрүүлэн тавьж тогоон дээр араас нь гурав алхаж ирээд нэг дэвсэнэ. Дараа нь зургаа алхаж ирээд бас нэг дэвсэнэ. Дараа нь 9 алхам газраас -гүйн шогшиж ирээд дэвсэх замаар бөөрийг хэвэнд нь оруулах засал хийдэг ажээ.

Энэ үйлдлийг тогоо тавихгүйгээр ташаан толгойн хоёр шонтгор ясны хооронд дэвсэх замаар ч хийж болдог гэнэ. Бөөр унаж, шээж чадахгүй болбол хоёр чихэнд нь ус хийж сэгсрүүлбэл засал авна (Хар дом).

ТЭМЭЭНИЙ ЦАГААН МАХ УРВАХ

х

Тарган тэмээг хэт хүнд ачиж эдлэх, ширүүн хөөснөөс цагаан мах нь урвах явдал тохиолдоно.

Эмчилгээ: Архины шилэнд халуун бүлээн ус дүүргэж шулуун гэдсэнд шургуулан хийж жигнэнэ. Энэ засал тохирвол тэмээ хөлөрнө. Эсвэл том тэмээний ууцан дээр сүүлний угаас урагш төө, богино сөөм, бага тэмээнд төө, хоёр хуруу хиртэй газарт халуун элсээр жин тавина. Эсвэл асга нурууны хоёр дахь үе дээр норгосон эсгий тавьж наанаас нь улайсгасан төмөр гадсаар төөнөж жин тавина, нимгэн цавиар бооно.

Эдгээр **эмчилгээний** эцэст сүүлний угаас барим хэмжээний газарт сүүлний судас ханана, эсвэл гуяны дотор талын бүдүүн хоёр судсыг ханана (Ж.Эвийхүү).

Цагаан мах нь урвасан тэмээнд нэг сохор цохыг тэмээний ам руу шидэж өгөөд усаар даруулдаг. Дахин цагаан мах ураввал дахин нэг цох өгнө (Э.Бумцэнд). Цагаан махыг угааж шивж бага зэрэг цус гаргасны дараа сохор цох өгнө.

Сохор цохгүй үед олон ясны уулзуур дээр халуун жин тавьдаг.

Мөн урвасан цагаан махыг худгийн хүйтэн усаар, угааж, сүүлний доод талын гол судсыг ханаж, 3 өдөр уяд тавихад засал авдаг. Цагаан мах нь урвадаг тэмээг өвөл сайн унаад тавихад цагаан мах урвах нь багасна.

ХУЯНТАХ

х

Тэмээний гуяны цагаан хуянд хий, цус хурвал тэмээний бөгсөн бие мурийж, хөлөө чирнэ. Хойд хөл нь хазгар болж, гүйцэд гишгэж чадахгүй болно.

Энэ тохиолдолд хоёр янзаар ханана.

Өгзөгний шонтгороос доош гарсан ховилд шонтгороос доош 4 хуруу тавьж 4 хуруу хиртэй гүн хатгана. Эсвэл дээрх ховилын адагт үений дзэгүүр тойгны яс чиглүүлэн сайн төө хатгаж засал хийнэ (С.Бариад).

Урд хөлний дотуур цагаан хуянд юм ороход хөлөө гадагш тавьж туялдаж гишгэнэ. Цээжин бие нь хэлтгий болно.

Энэ тохиолдолд хөлийг урагш татаж байгаад хавирга дал хоёрын завсраар суганаас нь хатгана. Эсвэл зүгээр зогсож байгаад урдаас нь дал хавирганы завсраар хатгана. Хутгыг дал дагуулан хатгах бөгөөд хавирга дагуулбал зүрх рүү орох аюултай.

АСГА СУУХ

х

Тарган тэмээг сойлгүй унаж эдэлснээс асга сууна. Мөн хэт таргалах, эдлэхгүй байснаас урагшаа доголно, алцаганаж явж чадахгүй болно. Асгатсан тэмээ урд хоёр хөлөө зэрэг гишгэж

хөлөө урд хойно тавьж гишгэж чадахгүй болно. Энэ нь далангийн булчин бяцарснаас үүсдэг гэж үздэг.

Эмчилгээ: -Асга суусан тэмээг хүйтэн газар уяж байгаад бага багаар унаж, зөөлөн эдэлнэ. Хүйтэн газар уяж сойно.

-Дал хавирганы завсраар далны хуянг урдаас төө илүү гүн хатгана.

-Мөн асга суусан тэмээний өвчтэй талын хаа буюу тавхайн салааны угны хонхорт 1.5 см хэртэй хатгана.

ХӨЛД ЦУС БУУХ

х

Алс замд хүнд ачаатай явж аянших, хатуу замд ширүүн явах, ачаа нь хүнддэх, хол явсны дараа амрааж идээшлүүлэхгүйгээр уяж удаан хэвтүүлснээс хөлийн тавагт цус тогтонги болохыг хөлд цус буух гэнэ.

Шинж тэмдэг: Тэмээний хөлд цус буухад тэмээ алцаганаж доголно. Хөлийн бэрэвхий ул хавдаж халуун болсон байна. Хөлийн тавхай, бэрэвхийг харьцуулан барьж үзэхэд цус буусан хөл илүү халуун хавантай байна.

Эмчилгээ: Хөлд нь цус буусан тэмээг ачилга, уналгаас чөлөөлж, цус буусан хөлийн тавгийг шорвог давстай хар цайгаар шавших буюу утаатай эсгийд давстай хар цай шингээж тавгийг нь бооно. Эдгээр **эмчилгээ** тус болохгүй бол тэмээг нэг хоног дулаан газар уясны дараа алтан хумснаас хойш гадна талд дөрвөн хуруу зайд эрхий хурууны өндгөвч таарч орохоор хонхорт мах өөхөн таваг хоёрын завсар зайгаар хөлөө дөнгөж өргөх үед нарийн хутга буюу шөвгөөр хатгана (Ж.Эвийхүү). Цус нь аяндаа тогтсоны дараа тэмээг хайрагтай дагжуур буюу хүйтэн газар уяж хонуулна. Эзэн хүн тэмээний цус буусан хөлд шээж байвал сайн. Бас цус буусан хөлийн салааны завсрын дээд мухарт ханаж цус авдаг ч арга бий.

УЛДАХ

х

Алсын аян жин хийх, удаан унаж эдэлснээс шалтгаалан тавхайн эвэрлэг бүрхүүл нь элэгдэж нимгэрснээс ул нь цоорч, элс чулуу хайрга, шороо мод орж сэдэрээснээс болж доголно.

Тавхайн эвэрлэг бүрхүүл нь голдуу алтан хумсныхаа орчмоор элэгдэх бөгөөд улдаж сэдэрвэл таваг нь ханзарч, хагарч ч болно.

Шинж тэмдэг: Улдаж байгаа тэмээ эхний үед мизилзэж эхлэх бөгөөд цаашдаа хазаганаж доголно. Зогсож байгаа үедээ улдсан хөлөө сойх, өргөх, тавих шинж үзүүлнэ. Ул нь цоорсон бол цус гарна.

Эмчилгээ: Тавхайн эвэрлэг бүрхүүл нь зүлгэгдэн нимгэрч гулгаж хальтрах, мизилзэн доголж байгаа бол хөлийн улыг хайрга, чулуу, шорооноос цэвэрлэж, нимгэрсэн хэсэгт адууны халуун тос хөөтэй хольж түрхэж бооно. Ул нь гөлийж нимгэрсэн, хальтардаг болбол тавхайг олсоор ногтолно.

Улдсан тэмээг хол явуулахгүй гэрийн гадуур байлгаж, хужиртай газар зогсоож байвал сайжрах нь түргэн байдаг.

Ул нь хагарч цоорсон, хавдаж бугласан бол тавхайг тахлана. Үүний тулд нойтон зузаан ширээр тэмээний тавхайг тунтарч тавгийг үмхүүлсхийж, ширний захыг хумиж үдэж оёно. Энэ аргаар тахлахыг "мэлхий тахлах арга" гэж нэрлэдэг (Мө. Даш).

Эсвэл улны цоорхойд үхрийн зузаан шир тавьж үзүүртээ сүвтэй шөвгөнд олс буюу нарийн суран үдээрээр сүвлэж, эвэрлэг тавагтай нь цойлдон оёно. Ширийг тэмээний тавганд барьж ийнхүү цойлдон оёхдоо шөвгийг өөхөн таваг руу хатгахаас болгоомжилж өөхөн таваг, эвэрлэг таваг хоёрын хоорондуур нь хавж хатгах хэрэгтэй.

Хэрэв таваг нь тасарч дээр дурдсан дагуу тах тогтоон оёх бололцоогүй болсон бол тэмээний зогдроор утас томж өөхөн тагийг дайруулсхийн сөлбөж тахыг оёж тогтооно. Ийм оёдол тавьсан тэмээний Ноосон утсыг авахгүй орхино. Үүнийг "зогдор сүвлэх" гэж нэрлэнэ (Мө.Даш).

Тэмээний таваг нэлэнхүйдээ жигд элэгдэж цус шүүрч байвал тарваганы халуун тос түрхэж үнс буюу хужир дээр хэвтүүлэх хэрэгтэй.

Таваг нь цоорсон тэмээний. улыг бог малын турууны дотор талын эврээр цоорсон нүхэнд тааруулан бөглөдөг бөгөөд эвэр аяндаа гадагш түлхэгдэж унадаг байна.

ОРООНГИ (ОРООХ)

х

Тэмээг өл хоолгүй буюу арчилгаа маллагааг тохируулахгүйгээр хол газар удаан хугацаагаар уналга, ачилганд хэрэглэх, тэмээний нуруу ачааг хойшдуулах, ачааг тэнцвэргүй ачих, бартаат замыг туулах зэргээс тэмээ ороонгитно. Тэмээ ороонгитох нь уул, хангай нутагт болон бороо чийгтэй үед тэмээ хальтарч явдгаас болно.

Шинж тэмдэг: Ороонгитсон тэмээг тэр даруй эмчлэхгүй бол үс ноосоо гээхгүй хатаж турна. Ороонгийг дотуур, гадуур гэж ялгадаг.

Дотуур ороонги тусвал гол маханд гэм сууж оцойж сууна. Бөгсөн бие мэдээгүй болсноос бөгсөн биеэ даахгүй, хоёр борвио тахийлгаж

чадахгүй учир яг хэвтэнэ.

Гадуур ороонги туссан бол ташаа хэлтгий болж хөлөө чирж доголно. Бэлчээртээ хүрч чадахгүй, бөгсөн бие нь орооцолдон мушгирч ойчдог болно.

Эмчилгээ: Ороонгитсон тэмээг хануур буюу төөнүүрийн аргаар эмчилнэ.

Төөнөж эмчлэхийн тулд халуун элс буюу эсгийг норгож чийглээд

олон ясны уулзуурт тавьж, норгосон эсгий дээрээ улайсгасан чулуу, халуун төмөр тавьж түүний хөртөл нь төөнөнө.

Эсгийг нэвт төөнөж байгаа бол тэмээ уруулаа цорволзуулж байж ядах байдал үзүүлнэ. Төөнүүр **эмчилгээг** 7 хоногийн зайтай 2-3 удаа хийнэ. Бас ороонгитсон тэмээний цээжин биеийн талд нь хүнд ачаа ачиж аяархан хөтөлж явуулах арга хэрэглэнэ. Борвины дотор талд зангирч овойсон (ороолт) судасны доод талд ханаж цус авах засал ч хийдэг.

Мөн хоёр модон шатаар тэмээний хойд хоёр хөлд нь цэхээр нь хойш хандуулан чиг барьж боогоод явуулж аргалдаг байна.

Хойд хөл нь мэдээгүй болж бөгсөн биеэ даахгүй болсон үед сүүлний доорх гурван судасны дундах судсыг ханана. Хэрэв нэг хатгаад засрахгүй бол хэд хоноод дахин хатгаж болно (Ж.Гончиг).

Дотуур ороонги болж бөгсөн биеэ даахгүй болсон тохиолдолд гол мах хатгах засал хийнэ. Үүний тулд бөөрнөөс урдуур сүвээний хавирганы араар нурууны хөндлөн сэртэнгийн доогуур сэртэнг дагуулан хусах маягаар сайн төө хэртэй хатгана. Дараа нь бөгсөн биеийг урагш нь татахын тулд хойд хоёр хөлийг бүдүүн гуяар нь холбож оосорлоод тэр оосрын хоёр хажуугаас уясан таталгыг урд бөхний урдуур давуулан урагш татуулна.

Энэхүү татлага нь агших сунах боломжтой байхын тулд татлагын хоёр талд резин зүсэж гогцоо оруулах хэрэгтэй (С.Бариад).

Гадуур ороонги болсон үед борвины сиймхийн дээд захад (махгүй газарт) шөрмөсний догуур, шаант чөмөгний булчингийн гадуур нэвт хатгана (С.Бариад). Эсвэл шаант чөмөг ороосон судас ханана (Ж.Эвийхүү).

Мөн өөх тосонд хуурсан шар будааг өтгөн халуун хар цайнд хонон бүрж хөргөөд 10 литрээр хэд хэд өгч тэнхрүүлнэ.

Чирч байгаа хөлийг оосорлож хойш нь татахад хонгоны зузаан махны дунд хэсэгт хөндлөн хонхор гарч ирнэ. Тэр хонхорт ташаан толгойн ар чиглүүлэн төө хиртэй гүн хатгах засал хийдэг (Ж.Хэнмэдэх).

ИНГЭ ХИЙТЭХ (СОЛИОРОХ)

х

Ингэ ботголж, ботгоо байнга сахиж байснаас идэш унднаас гарч өлссөнөөс энэ өвчин тохиолддог гэж үздэг. Хийтэх нь ботготой гунжин болон туранхай ингэнд илүүтэй тохиолдоно.

Шинж тэмдэг: Ингэ солиотой, мэдрэлгүй болж байгаа шинж үзүүлж, хаашаа ч хамаагүй газар үнэрлэн ботгоо орхиж, буйлж, цааш нааш тэшинэ. Хад бут хазах, өвс шороо хамж идэх, шавах, ботгоо хаана байгааг мэдэхгүй хөхүүлэхгүй болно. Хажуудаа байгаа тэмээг хазах, хүн рүү дайрч мэднэ. Заримдаа гөлөрч зогсоно, хөлөрнө, нулимс асгаруулна, нэг тийшээ эргэж татаж ойчно, нүд ам нь таталдана. Энэ өвчин сүүлийн үед тохиолдох нь олонтоо боллоо гэж зарим малчид мэдээлж байна. Зарим орон нутагт энэ өвчнийг "пээтнэ" гэж нэрлэнэ. Галзуу өвчин туссан гэж андуурах явдал ч байдаг.

Эмчилгээ: Салхин дээр нь яс, тосоор хиншүү тавих, хахаж цацтал одорт гурван удаа утна (С.Бямбасүрэн). Мөн шар будаа, малын ялангуяа хонины ясны шөл, хар цайг чанаж 4-5 литрийг өгөхөд тэнхээрэх нь түргэн байна.

2-3 хоолны халбага дүнсэн тамхи усанд найруулж 2 өдөр дараалан огч болно.

Зарим малчид хасыг хатгахад сайн гэж үздэг. Мөн ботголохгүй шилэрч гүйгээд байгаа ингийг хиншүүгээр утахад хялбар ботголдог (Д.Пүрэв, Л.Чимид).

ЗОВСОН СҮҮНИЙ ХОРДЛОГО

х

Богго торомтой ингийг алс туух, ширүүн хөөж хөлөргөж ядраасны дараа ботго, тормыг хөхүүлбэл "зовсон" сүүг хөхсөн ботго, тором хордож турж хатсаар байгаад үхдэг байна.

Зарим малчдын үзэж байгаагаар эхийнхээ хөлсийг их хэмжээгээр хөхсөнөөс иймхүү хордлого гэж үзэж байна. Их хөлөрсөн ингэний дэлэнг угаасны дараа хөхүүлбэл ботго хордох, эрвэйтэхээс сэргийлж чадна.

Эмчилгээ: Зовсон сүүний хорлого болсон торомд эхийн нь 2 литр сүүнд улайсгасан 7 цагаан чулуу хийж буцалгаад нэг литр болгон ширгээж тормонд нэг удаа өгөхөд тарга хүчээ авч, өнгө зүс засарна.

Эхийн нь сүүг буцалган ширгээхэд өтгөн саарал болох бөгөөд түүнээс тэмээний хоргол хэртэй үрэл бэлтгэнэ. Ийнхүү бэлтгэсэн үрлийг зовсон сүүг хөхөж хатаж байгаа ботгонд өдөрт нэгээр 2-3 өдөр дараалан өгч хордлогыг арилгана.

БОТГОНЫ ДАВХАР ХҮЙС

х

Хүйснээс элэг, давсаг руу орсон судас тасарч цус нь бүрэн асгараагүйгээс бүлэгнэж халдвар авч үрэвсэнэ. Хэвтрээс даарч хөрснөөс болж цус бүлэгнэж үрэвсэх нь илүүтэй тохиолдоно.

Давхар хүйстэй ботго эхээ хөхөхгүй, бөгтийж зогсох, халуурах зэрэг шинж үзүүлнэ.

Эмчилгээ: Давхар хүйстэй ботгыг эхэд нь тохож, гэрээ гурав тойруулна. Эсвэл урд хөлийг урагш нь (цээж татуурга), хойд хөлийг хойш нь (бөгс татуурга) хийнэ. Хүйс нь үрэвсэж хавдсан бол малын эмч нарт мэдэгдэж **ЭМЧИЛГЭЭ** хийвэл зохино.

БОТГО НАРШИХ

х

Ботгыг халуун наранд удаан хугацаагаар уяж хэт халаах, услах, хөхүүлэх зайг холдуулснаас ангаж цангаснаас болж ботго наришна.

Шинж тэмдэг: Наршсан ботго толгойгоороо газар саван унаж тарайн хэвтэх ба бүх бие нь чичирч хөлөрнө.

Сэргийлэх эмчлэх арга: Ботго наршихаас сэргийлэхийн тулд зуны халуун нартай үед ботготой ингийг алс хол бэлчээснээс эргэж ирэхгүй удсанаас ботго цангаж нарших нэг шалтгаан болдог учраас ботготой ингийг аль болох ойрын бэлчээрт идээшлүүлэх хэрэгтэй.

Ботгыг ойр ойр хөхүүлэх, ботгоны зулайд даавуу эсгий, арьсаар халхавч хийнэ.

Эмчилгээ: Наршиж унасан ботгоны бүх биеийг халуун бүлээн усаар шавших, мөн халуун бүлээн хярам цутгаж өгнө. Сүүдэр буюу чийггэй сэрүүн зүлэг бараадуулбал зохино. Наршсан ботгыг уях хэрэггүй, хэд хоног эхтэй нь хамт явуулна. Наршилт хүндэрч амь тэмцэх, ам нь зуурсан бол гүрээнээс хагас литр орчим цус авч болно.

Наршсан ботгонд цагаан гурилын зутан зээрний ундаа, зэрлэг гоёоны ханд өгөхөд амархан тэнхэрнэ.

БОТГО ЭРВЭЭХЭЙТЭХ

х

Зуны халуун 6, 7, 8-р саруудад ялангуяа зовсон сүү хөхсөн ботгонд илүүтэй тохиолдоно.

Шинж тэмдэг: Өвчилсөн ботго хоёр нүдээ тас аниж, нулимс гоожуулна. явахгүй, хөхөхгүй, идээшлэхгүй. Заримдаа чацга алдана. Халуурна.

Дээд доод зовхийг эргүүлэн үзэхэд 1.5 см хэртэй янз бүрийн бүдүүн нарийхан хар судас мэт зүйл салстын өнгөн дээр гарсан байна.

Эмчилгээ: Нүдний зовхины салст бүрхүүл дээр гарсан хар судсыг зүүнд сүвлэсэн улаан утсаар хар судасны цаагуур сүвлэн татаж хар судсыг огглон авахад дороо эдгэрнэ (Д.Пүрэв, Л.Чимид).

Мөн бор давс зажилан нүд рүү нь нулимхад сайжирч болно. Харин савж унан нүдээ гэмтээсэн байвал тус болохгүй (Я.Чулуун).

БОТГО НАХЛАЙТАХ

х

Ботгоны нүдний дээд талаас улаан хальс гарч нүдийг хучина.

Эмчилгээ: Нүдийг хучсан хальсыг зүүнд сүвлэсэн утсаар сүвлэн татаж хайчилж авна.

Мөн нүдний ухархайн дотор талаас доош гарсан судсыг ногт судас (голих судас) гэж нэрлэнэ. Хоёуланг нь ханана. Уг судас нүдний ухархайгаас гарч ясан дээр гарсан цэг дээр ханана (Г.Өлзийт).

БОТГО ТЭНЦЭХГҮЙ БАЙХ ҮЕД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ

х

Ханиаж турж эцсэн, хэт турж онд орсон ингэ сул дорой төл гаргах нь олонтоо тохиолдоно.

Ийнхүү сул дорой гарсан ботго тэнцэж босохгүй, үе мөч нь тэнийхгүй байдаг. Ийм эмгэгтэй гарсан ботгыг юуны өмнө нэмнэж дулаална. Тэнхэрч босож тэнцэхгүй бол ботго багтмаар

газар хонхойлон ухаж дотор нь гал түлж шороог халаасны дараа галын цог, үнсийг авч халуун бүлээн болсон нүхэн дотор босохгүй байгаа ботгыг хэвтүүлэн хучиж орхиход засал авсан бол хэдэн цагийн дараа тэнцэн босоод ирнэ.

БОТГО ЧАЦАРХАЙТАХ

х

Эхийн хэвлийд байх үед тогтсон зунгаага гаргахыг ботго чацархайтах гэнэ. Ботго зунгаага гаргахдаа гажиггүй бол өвчлөхгүй, харин гажигтай бол өвчилж чацга алдана.

Шинж тэмдэг: Ботго чацархайтах үедээ өнгө зүсээ алдаж, гэдсээ татна. Хэвтэх дуртай болно. Нүднээс нулимс, нуух гоожино. Байн байн дүлэх боловч баас гарахгүй, зарим нь чацга алдах зэрэг шинж үзүүлнэ. Эхээ хөхөхгүй, идээшлэхгүй, хэвийн хар зунгааг арван хоёр үеэс тогтсон хэлхээ хэлбэртэй байвал зунгааг бүрэн гарсан гэж малчид үздэг. Энэ хэмжээний зунгаагаас ямар нэг хэмжээгээр үлдвэл муу нөлөөтэй гэж үздэг учраас зунгааг бүрэн гарсан эсэхийг ажиглаж байхыг зөвлөдөг.

Өвчин хүндрэх буюу гэдэс, дотрын өөр өвчинтэй хавсарвал үхүүлэх аюултай учир түүнээс сэргийлэх зохих эмчилгээ, засал заавал хийх хэрэгтэй. Ботго чацга алдахгүй бол барагтайд өвчилдөггүй учраас чацга алдах явдлаас сэргийлэх ажлыг туйлын чухалчлан хийх хэрэгтэй.

Чацархайлахын хүндрэлээс сэргийлэхийн тулд дараах аргыг хэрэглэнэ. Үүнд:

-Ботго эхээс гарч тэнцсэний дараа зөв чацархайлуулахын тулд амруулахаас өмнө ботго бүрт 2 халбага шар тос, 2 ёотонтой ус(200 мл) эсвэл давстай ус, шорвог хар цай, сонгино, сармисны хандны аль нэгээр амлуулна.

-Эхийн усыг халуунаар (100-200 мл хиртэй) авч ботгонд цутган өгч амлуулах нь хар зунгааг хөөх, чацарахайлахын хүндрэлээс хамгаалах нэг арга болно.

-Дөнгөж гарсан ботгоны сүүлд хуруу хиртэй цагаан хальсан ууцыг устай нь хамт ботгоны аманд хийж залгиулна (Т.Дашням).

БОТГОНЫ ЧАЦГА

х

Ботго гарсны дараа чацархайлж, 21 хоногтойгоос өвс тэжээлд орж эхэлнэ. Энэ хугацаанд ботгоны арчилгаа маллагаа, тэжээллэгийн дэг журам алдагдсан болон нарших, даарч хөрөх зэргээс шалтгаалж тэжээл боловсруулах эрхтний үйл ажиллагаа хямарч чацга алдан турж эцэн хүндэрч үхэж үрэгдэх нь олонтаа тохиолддог байна. Ботго шинэ ногоо идэх үед

олноороо чацга алдах нь илүүтэй тохиолдоно. Чацга алдсан ботго халуунтай, халуунгүй байхаас гадна чацганы өнгө, үнэр ч янз бүр байдаг. Ботго, тором зун, намар чацга алдах нь олонтаа тохиолдох бөгөөд даамжирвал ботго хатингар болно. Өсөлт нь саатна. Ботго чацга алдахаас сэргийлэх, чацга алдсан ботго эмчлэх талаар олон арван арга туршлагыг малчид, тэмээчид үе уламжлан хэрэглэж иржээ.

Эмчилгээ: Ботго чацга алдах явдлаас сэргийлэхийн тулд дараах уламжлалт аргуудыг хэрэглэнэ: Үүнд:

-Ботго эхээс гармагцаа ботгоны сүүл дотроо устай хальсаар бүрэгдсэн байх бөгөөд тэрхүү уут хальсыг устай нь хамт ботгонд өгөхөд хялбар чацархайлж, чацга алдахаас сэргийлнэ.

-Өмнөговь аймгийн Ханхонгор сумын тэмээчин Монгол улсын аварга малчин Г. Өлзийт 31 жил тэмээ маллахдаа нэг ч ботго гарздаж яваагүй бөгөөд ботго чацга алдахаас сэргийлэхийн тулд ботго 21 хоногтой болж өвс тэжээлд орох үед нь ботго бүрд буурны бохьны ханд өгдөг байна.

Буурны бохь бүхий 2-3 туг үсийг литр усанд хийж байлгахад өтгөн хар цай мэт болох бөгөөд түүнээс нэг хоолны халбагаар нэг удаа ботго бүрт өгч ботго чацга алдахаас сэргийлдэг байна. Зарим ботго чацга алдавч хөнгөн өнгөрдөг.

Тэрээр ботгыг сүүгээр махлуулж, өвсөнд оруулж, чацга алдуулахгүй байлгаж чадвал том, эрүүл чийрэг тэмээ болгон өсгөж болох учир ботгыг чацга алдуулахгүй байлгахыг маш чухалчилдаг байна.

-Ботго олноороо чацга алдмаар болбол бор бударганатай бэлчээрт эхтэй нь хамт бэлчээх нь зүйтэй.

Дундговийн тэмээчид тухайлбал хөдөлмөрийн баатар Эс, улсын аварга Э.Бумцэнд, малчид Х.Шаазаг, Ц.Лувсандорж, С.Бямбасүрэн, Г.Гур, С.Бариад, С.Цагаан-Өвгөн, П.Логшир, Л.Ишдорж, Өмнөговь аймгийн малчид Ю.Даваа, Т.Туулайхүү, Д.Түдэв, Л.Чимид, Д.Батсүх, Д.Цолмон, Н.Гончиг, Д.Ролгор зэрэг олон тэмээчид ботгоны чацга өвчинг ардын уламжлалт аргаар анагаах дараах арга туршлагыг хэрэглэж байна. Үүнд:

дотуур халуунтай чацга алдаж байгаа ботгонд 2 шаазан цагаан гурилыг 2-3 литр усанд зуурч 2-3 удаа өгөхөд халууныг авч чацга тогтооход маш сайн үйлчилгээтэй гэж үздэг. Энэ зутанд 1-2 ширхэг биомицин хийж өгвөл бүр сайн.

Зээрний ундаа өвсийг нэг том шаазангаар авч 2 литр усанд хийж буцалгаад нэг литр болтол ширгээж өглөө, орой өгөхөд чацга бараг тогтооно. Мөн ийм маягаар чихэр өвс өгнө.

нүдэж нунтагласан чулуун нүүрсийг жижиг шаазан авч устай хольж өгнө.

дотуур халуунтай, цагаан хөөстэй чацга алдаж байгаа ботгонд хатаасан цагаан гоёо (загийн гоёо) нүдэж нэг шаазан аягыг нэг шанага усанд буцалгаж хандлаад өгнө. Улаан гоёо ч хэрэглэж болно. Тэр өдөрт хөхүүлэхгүй, харин тостой хар цай өгнө. Мөн цагаан будааны нүүрсийг хүйтэн усаар зуурч өгч болно.

хоолны нэг халбага лидэр, нэг аяга зэрлэг гоёог 2 литр усанд хандалж чацга алдсан халуунтай ботгонд 2-3 өдөр дараалан өдөрт 3 өгнө.

ботго уяандаа, бозлог нүхэндээ гэгчээр бэлчээрт яваад чацга алдвал барьж уяна, цагаан өвс (монгол өвс)-ний 2-3 үндсийг хандалж өгвөл бүр сайн.

чацга алдсан ботгонд чээрэн бут нүдэж 2-3 атгыг 5 литр усанд хандлаад өглөө, орой 2 л өгч эмчилнэ. Эсвэл нэг аяга үхрийн аргалын үнс зуурч өгөх сайн.

Эхийн сүүг түлж нүүрс болгоод сүүтэй хольж өгөх, шар будааны нүүрс хуурайгаар нь хоолны 2 халбагаар усаар даруулж, өдөрт 2-3 удаа өгнө. Мөн эхийн сүүнд 7 халуун цагаан чулуу хийж буцалгаж хөргөөд өгөх, эсвэл эхийн сүүг хусам болгож, түүнээс тэмээний хорголоос арай жижиг бөөрөнхий хийж 5-6 ийм бөөрөнхийг өдөрт нэг удаа, өнжөөд бас ийм хэмжээтэй 2-3 удаа өгнө. Зарим малчид өдөрт 1 бөөрөнхий өгдөг байна. Мөн ургахгүй болсон хөх дэрсний үндэс (дүмбүүл) 2 атга орчмыг шанага усанд чанаж хандлаад ботгонд 0.5 литрээр өдөрт 2-3 удаа чацга тогттол өгч эмчилнэ. Бас туулай буюу бор гөрөөсний махыг шалз чанаж нэг аяга хиртэй шөл өгөх сайн.

Ботго чацга алдаж халуунтай байгаа үед монгол өвс (цагаалж өвс)-ний 2-3 үндсийг усанд буцалгаж хандлаад өтгөн хар цай мэт болгон ботгонд өгнө.

БАЙВАРГА

х

Тэмээний тавхай, бэрэвхий шалбарч шархалж өвчлөхийг байварга гэх бөгөөд хар таваг, тавагтах ч гэж нэрлэдэг.

Өвчний шинж: Уг өвчин халдвартай бөгөөд хэд хэдээрээ өвчилнө. Өвчтэй тэмээ доголно, хэвтэнэ. Тавхайн, бэрэвхийн аль ч хэсэгт халуун хавдар үүсч аажмаар хагарч яр шарх болно. Яр нь тавхайн дээд талын арьсан дээр тойрсон маягтай шар ногоон толгойтой байна. Өвчин хүндэрвэл эвэр тавхай нь хавдаж, эвэр тавхай, арьсны завсар идээ бээрт идэгдэж, эвэр ул нь хуурч унаж цус нөж гоожно. Тэмээ халуурна. Эвэр тавхай ургахыг хүлээхгүйгээр тэмээ туйлдаж үхнэ. Зарим тэмээний хар ул хуурч гутлын ул ханзарсан мэт чирч явна. Тэмээний хөлийг боож, тавхайг нар өөд харуулж удаан хэвтүүлснээс таваг нь халж, цус хурснаас өвчин

үүсэх нөхцөл болдог гэж үздэг. Маш халдвартай учир тэр суурийн тэмээ бүгд ч байварга тусаж өвчлөх тохиолдол ч гардаг байжээ.

Эмчилгээ: доор заасан аргуудын аль нэгийг хэрэглэн өвчнийг анагаадаг.

Яр шархан дээр өөх тавьж өөхөн дээрээс нь улайсгасан төмрөөр хайрч төөнөх эмчилгээг хийнэ.

Ярны доод талаар арьс, махны завсраар хаваж хагалж идээ, шүүс нэвчиж гарах боломжтой болгоно.

Шархан дээр хэд хэд хатгаж цус гаргаж, хүний (хүүхдийн) шээсээр шавшина, тууплин хандалж өгнө, хүүхдийн шээсээр шавшина (Д.Батсүх).

Байварга туссан тэмээг хужир шүү ихтэй хуурай газар зэллэж уяхад аажмаар эвэр ул нь ургаж эдгэрнэ. Мөн стрептомицин, пенициллин, новорсенол, цусанд тарихад эдгэрэлт нь түргэснэ.

Алтан хумснаас хойгуур 2.5 см хэртэй зайнд тохиолдох хонхорт хар таваг, өөхөн тавагны завсраар 1.5 см гүн хатгана. Зарим хатгаач нар 4 хуруу хиртэй хатгахыг зөвлөдөг. Үүний тулд тэмээ тийрч болох учраас нүдийг нь боож, хөлийг модон дээр гишгүүлж дөнгөж өвчтэй хөлөө өргөх үед огцом хатгана.

Энэ хатгалгааг нарийн урт хутгаар хатгах бөгөөд өөхөн тавгийг хатгаж болохгүй. Дээрх хонхроос хойш 3 см хэртэй зайнд дарж үзэхэд бас нэг хонхор тохиолдох бөгөөд тэр тушаа 1.5 см гүн хатгана (С.Бариад).

Мөн байваргатсан тэмээний өвчтэй хөлний тавхайн салааны дээд талын хонхорт урдаас нь хойш нэвт хатгаж цус гаргана. Нэвт хатгах бололцоогүй бол урд хойд талаас хатгана. Ийнхүү хатгасны дараа хүнд ачаа ачиж явуулан цусыг сайн гаргах хэрэгтэй.

Тарваганы тосыг шорвог давсалж шарханд нь түрхэж болно.

Тэмээнд байварга өвчин тусахаас сэргийлэхийн тулд уналга, ачилганд хэрэглэх тэмээг сайтар уяж сойх, унаж эдэлсний дараа уяж амруулж, идүүлсний дараа услах хэрэгтэй.

ХАМУУ

х

Малчид тэмээний хамууг цусан, эвэр, тосон хамуу гэж (Т.Өлзийт) ялгаварлан үзэж тус тусыг эмчлэх уламжлалт арга хэрэглэж байжээ.

Цусан хамуутай тэмээний биеийн шөргөөсөн газарт язарч, цус гарч улаан болох бөгөөд ийм хамуутай тэмээг эмчлэхийн тулд цусан хамуутай тэмээний гүрээнээс 3 литр цус нэг удаа авч эмчилдэг байна.

Эвэр хамуутай тэмээний суга, хүзүүнээс эхлэн арьс нь хувхайран цагаан болох бөгөөд ийм хамуутай тэмээнд бог малын (ямааных бол сайн) хоёр бөөрний өөх буюу адууны махны шөл 4 литр эсвэл адууны цус 3 литрийг 2-3 удаа 7 хоногийн завсартайгаар өгч эмчилнэ.

Тосон хамуутай тэмээний биеийн шөргөөсөн хэсгийн үсний ёзоор нь тостой болох бөгөөд ийм хамуутай тэмээг эмчлэхийн тулд утаатай гэрийн цагаан догуур бүрээс буюу утаатай шар эсгийг усанд байлгаж хар цай мэт болгоод түүнд хөлстэй хиртэй цамцны угаадас хийж дээрх угаадаснаас 10 литрийг авч 3 удаа 7 хоногийн завсартайгаар өгч аргалдаг байжээ.

Дээрх аргыг Өмнөговь аймгийн Ханхонгор сумын тэмээчин Монгол улсын аварга малчин Г.Өлзийт 30 гаруй жил тэмээ маллаж ирэх хугацаандаа хэрэглэж тэмээгээ хамууруулахгүй маллаж байжээ.

Тэмээ хамуурч шөргөөж хогжруутахад ингэний хагны ус 3 литр өгөхөд буюу адууны махны шөл литр орчмыг 3 өдөр цутгаж өгөөд бага багаар идүүлж байгаад 2-3 хоног уяхад засал авна. Харин адууны тос, тостой шөл өгсний дараа тэмээг усалбал үхдэг гэнэ.

Хамуутай тэмээнд мөн адууны махаар (мах, өөх, уушиг, элэг, дэлүү, цус) шөл хийж ес эхэлж хүйтэрсэн хойно буюу жавартай газар уяж 5-10 литрээр 10 хоног өгч эмчилнэ. Ийнхүү адууны шөл өгсөн тэмээг 3-5 хоног усгүй бэлчээрт байлгаж байгаад авчирч өглөө орой бага багаар услаад тавьдаг байна.

Хамуутай тэмээг 3-5 хоног сойгоод тарвага, мануул, үнэгний махаар (баас, цөсийг авсан) шаз хийж өгч, 3-5 хоног уяад тавихад маш сайн эдгэрнэ.

Монгол улсын хөдөлмөрийн баатар Эс, улсын аварга малчин Э.Бумцэнд нар олон арван жил тэмээ маллах хугацаандаа тэмээ хамуурч эхлэх үед адууны цус 3-4 литр дотуур өгөх, адууны цусыг бага хамуурсан хэсэгт түрхэж эмчилдэг байжээ. Хэрэв их хамуурсан бол 3-5 хоногийн дараа адууны цус дахин дээрх хэмжээгээр өгч хөлөргөөд тавихад эдгэрдэг байна.

Хамуурсан тэмээнд дүнсэн тамхины талыг 10 литр усанд буцалгаж өгөхөд согтож дайвалзах бөгөөд хамуу нь арилна.

Их хөлтэй бууцыг ухаж үзэхэд гүнд нь хар өттэй хальс мэт болсон (хорхойдой бууц гэнэ) байдаг. Түүнээс хоёр том цагаан шанага авч 10 литр усанд буцалгаж хандлаад дотуур 1-2 удаа өгч тэмээний хамуу ч эмчилдэг (Ж.Дамиран).

Мөн хамуутай тэмээнд хөх дэрсний үндсийг нэг тогоогоор дүүрэн чанаж 1-2 удаа өгч хамуутай тэмээг тэнхрүүлнэ. .

Хамуутай тэмээнд чулуун нүүрсний өрөм хэмээх өнгөн талын хүхэр мэт ногоон үе судал бүхий хэсгийг авч хандлан буцалгаж тарган тэмээнд 3 саахуу, эцэнхий тэмээнд 2 саахуу өгч эмчилнэ.

Мөн тарваганы нэг шанага тосонд хоёр аяга давс хийж буцалгаад халуунаар нь тэмээний хамуурсан хэсэгт түрхэж эмчлээд халуун наранд 2 хоног уяж байгаад тавина. Зүгээр болохгүй бол дахин түрхэнэ.

Хамуурсан тэмээнд нэг ямааны цусанд бөөрний өөхийг базаж бүгдийг өгч нэмнэж 2-3 хоног уяж эмчилдэг байжээ.

Хамуутай тэмээг 2 хоног өвс, ус өгөхгүй уяж байгаад улаан тамхины талыг буцалган цутгаж өгөөд усан хулгана болтол хөөж, толгойг тонгойлгон гадаснаас уяна, Хоёр гүрээг хатгана. Том тэмээнээс 7 хүртэл литр цус авна, бага тэмээнээс үүнээс бага цус авна.

Түүнчлэн хамуутай тэмээнд адуу, зээрний халуун цус 5 литр нэг удаа өгч утаатай эсгийгээр нэмнээд хөөж хөлөргөх,

Халиар өвсийг цэцэг навчтай нь авч усанд хандлаад хамуутай Тэмээнд дотуур өгөх,

Хамуурсан тэмээнд чоно, адуу, тарваганы махыг ялз чанаж хөргөөд дотуур өгсний дараа хөлөртөл хөөж 2-3 хөнөг уяна,

Хамуутай тэмээг хүхэр ихтэй рашаанаар угаах буюу ийм рашаан цутган өгөх,

Хүхрийг үхэр тэрэгний тостой хольж нухаад бага зэрэг халааж, тэмээний хамуурсан хэсэгт түрхэх,

Мөн гэрийн унины утааг угааж аваад давсаар шорвоглож зуураад хамуутай тэмээг шавших зэргээр эмчлэх арга хэрэглэдэг байна.

ТЭВЭНТЭХ

х

Тэмээний хэлний доорх зураас хонхор дотор ширүүн цагаан юм бий болохыг тэвэнтэх гэнэ.

Голдуу өсвөр тэмээнд тохиолдох бөгөөд гэдсээ татна, амнаас нь хөөс гарна. Идэх, уух нь багасна. Нас гүйцсэн тэмээнд энэ эмгэг ховор тохиолдоно.

Эмчилгээ: Хэлэнд үүссэн цагаан зүйлийг хутгаар өлгөж аваад, хэлний доорх хоёр судсыг тэвнээр буюу шөвгөөр ханаж эмчилнэ (П.Тэхээш).

ҮХЭР ХОНЬ ЯМАА

ДЭЛҮҮТЭХ

х

Эрдэс тэжээлээр тогтмол хангаагүйгээс шавар шороо долоох элс, шавартай ус уух, нимгэн устай горхи булаг шандын усыг элс хайрга, шаврын хамт уух зэргээс тэжээл боловсруулах эрхтнүүдийн үйл ажиллагаа хямарснаас үүсдэг хатгалгаа хэлбэрийн өвчин болно.

Шинж тэмдэг: Өвчилсөн үхэр идээшлэхгүй зогсох бөгөөд өвчин даамжрахад үхэр тогтвор алдаж байн байн хэвтэж бөөрний хавь газрыг үнэрлэх, гэдсээ хайрах, газар дэвслэх, тийрэх хөрвөөхөөс гадна заримдаа чацга алдана. Гэдэс, гүзээ нь дүүрч цэндийнэ. Нимгэн цавьны дотуур талаар урагш нь имэрэхэд мушгиралдсан судсууд гүрийж гарна.

Эмчилгээ: Эмчлэх үндсэн арга бол дэлүү хатгах эмчилгээ болно. Үхрийн буруу талд нь дэлэнгээс урагш өвчүүний бүдэрхийг дагуу явсан бүдүүн судсыг дагуулан тэмтэрч үзэхэд хуруу ором хонхор тохиолдох бөгөөд тэр хонхорт эрхий хуруугаа чанга дарж, хурууныхаа хажуугаар шөвгөөр хоёр хуруу буюу 3-5 см гүн хатгаж, шөвгийг сул тавьж түр зуур орхино.

Хэрэв онож хатгасан бол шөвөгний бариул салганаж байдаг.

Дэлүүг нь хатгасан үхрийг эхний хоногт усалж болохгүй.

Дэлүүтсэн үхэрт 2 литр усанд адууны хомоолыг хийж, усаа ногоон болтол сайтар хутгаад дээр нь нэг шаазан хиртэй цагаан гурил хийж зутан болтол хольж цутгаж өгнө. Дэлүүтсэн үхэрт давс өгч туулгах, хөөж хөлөргөх, усаар цохиулах зэргээр эмчилж болно. Мөн нүдний доод зовхинд хамрын тамхи чимх хиртэй, хийж, шорвог давстай ус 1 литр орчим өгнө.

ТУГАЛ, ХУРГА, ИШИГНИЙ ЧАЦГА

х

Нялх тугал, хурга, ишгэнд хамгийн их тохиолддог өвчин бол чацга алдах овчин бөгөөд арчилгаа маллагааны дутагдал доголдлоос үүдэн ходоод гэдэсний үйл ажиллагаа хямарснаас шалтгаална. Чацга алдах нь элдэв халдварт өвчин туссанаас үүсч болно. Халдварт өвчний улмаас чацга алдаж байгаа бол төл 41-42 хэм халуурах, олноороо зэрэг өвчлөх бөгөөд, энэ нь халдваргүй өвчнөөс ялгах нэг үндсэн шинж болохыг анхаарах нь зүйтэй.

Арчилгаа, тэжээлийн горим алдагдсанаас халдваргүй чацга өвчин байснаа хүндэрч халдвартай болж хувирах явдал тохиолдож мэднэ. Иймд төл чацга алдвал тэр даруй эмчилж эдгэрүүлэхийг урьдал болговол зохино. Нөгөө талаар чацга алдсан төл шингэнээ алдаж хоол тэжээлээс гарч, тамир тэнхээ алдаж, өсөлт хөгжилт нь саатаж улмаар халдвартай чацга өвчин үүсэх, уушигны хатгалга, ханиад хүрч сэдрэх, сэнсрэх, давжаарах нэг шалтгаан болно. Чацга алдсанаас үүдэн элдэв хүндрэл, сөрөг үр дагавар үүсэхийг анхаарч төл чацга алдах шалтгааныг мэдэх, түүнээс сэргийлэх нь юу юунаас чухал болно. Хээлтэгч малыг хур таргатай төллүүлэх, угтуулан тэжээх зэргээр эх малыг хур тарга хүчтэй онд оруулж жилбэтэй төллүүлэх явдал өсөлт хөгжилт сайтай, чийрэг, биеийн эсэргүүцэл ихтэй төл хүлээн авах боломжийг хангах болно. Төлийг эхтэй нь хамт байлгаж тол дуртай цагтаа уураг сүүгээ бага багаар хөхөж байх нь ходоод гэдэсний ажиллагаа хямрахаас сэргийлэх гол арга болно. Төлийг халуун байр пүнзэнээс гэнэт хүйтэнд гаргаж хөхүүлэх, өлсгөж байгаад гэнэт ихээр хөхүүлэх, төлийн хэвтэр нойтон чийгтэй байснаас болж дороос чийгтэж даарах зэргээс шалтгаалж хөхсөн уураг сүүгээ боловсруулж чадахгүй чацга алдах, уураг нь зангирч болно. Төлийн байр хэвтрийг хуурай дулаан байлгах нь чацга алдахаас сэргийлэх үндсэн арга юм. Хурга ишигний байр нэн хүйтэн байснаас төл чацга алдах нь олонтаа тохиолдоно. Бог малын төлийг чацга алдахаас сэргийлэхийн тулд өвс ургамлын хавд шүүс өгдөг олон сайхан туршлага хуримталсан байна. Энэ талаар чацга алдсан төл эмчлэх тухай дараачийн хэсэгт тодорхой дурьдах болно.

ҮХЭР БОГ МАЛЫН ХАР ЧАЦГА

х

Үхэр, бог мал хавар ногооноор, хурга ишиг голдуу 4 дүгээр сард хар чацга алдах бөгөөд хэрэв удааширвал тарга хүчээ алдаж хатсаар үхэх аюултай. Бог малд өвөл хаврын улиралд муудсан тэжээл өгөх, өл хоол муутай хужир шүү дутагдалтай байснаас ядарч доройтон хар чацга алдах тал бий. Голдуу төлөг, борлон өвчлөх бөгөөд удаан хугацаагаар хар бараан өнгөтэй чацга алдаж тарга хүчээ алдана.

Төл, өсвөр мал хар чацга алдах нь цагаан хорхойгоос үүссэн бол чацга нүхтэй, хэрэв осгож даарснаас үүссэн бол чацга нь нүхгүй байна.

Эмчилгээ: Хар чацга алдсан малд дараах аргуудыг хэрэглэнэ.

Зуны улиралд чацга алдсан хонь, ямааг нэг өдөр барьж уяж сойгоод нэг сохор хар цох өгнө. Эмчилгээ тохирсон бол 2-3 удаа хар цох өгөхөд чацга тогтоно. (С.Бараадий, Д.Дайдаахүү)

Бог малд хоолны 2 халбагаар, хурга ишгэнд цайны халбагаар шар тос өдөрт 3 удаа өгөхөд сайн.

Мөн шар тосыг тарианы (арвайн) гурилтай хольж багсарч бөөрөнхийлөөд аманд нь хийж өгөхөд сайн. Эсхүүл хар цайг нунтаглаж шар тосоор багсарч хоолны халбагаар өдөрт 2-3 удаа 1-2 өгөхөд зүгээр болно.

Увс аймгийн Тэрэмийн улаан хар сэндрийг нунтаглаж бог малд хоолны 3 халбагыг өдөрт 3 удаа өгч өтгөн хар цайгаар даруулан өгнө. Энэхүү сэндрийг хүн, малын түлэнхийд түрхэхэд сайн гэж үздэг байна.

Хар чацга алдсан малд 2 литр усанд 2 жижиг атга жамц давс хийж 1.5 литр болтол буцалгаж ширгээгээд хоолны халбагаар өдөрт 3 удаа өгнө. Ийнхүү эмчлэхэд мал хорхойдсон бол 2-3 хоноод буюу заримдаа өдөртөө цагаан (хошлон туузан) хорхой гарч эхэлнэ. Дээрх аргаар найруулсан жамц давсыг хурганд 6 сард өгч цагаан хорхойг туулгадаг байна.

Мөн хар чацга алдсан сарлагын тугалд ийнхүү найруулсан жамц давсны уусмал 500 мл нэг удаа өгөхөд цагаан хорхой туугдана. (Ч.Төмөрбаатар).

Малын чацга алдахад хэлний доорх хоёр судасны аль нэгийг ханана.

Хавар хар чацга алдсан малд 1-р гурилын шингэн зутан (аяга хиртэйг) нэг атга шар цагаан будааны нүүрстэй хольж 2-3 удаа өгөхөд чацга тогтдог. Цагаан хорхойн гаралтай хар чацга алдаж байгаа бол үхэр бог малыг хар цайгаар 2-3 услаад зэсийн цэнхэр үхүүлж (шатааж өгнө). Бог малд цайны хагас халбага үхүүлсэн зэсийн цэнхрийг үхрийн түүхий сүүтэй хольж нэг удаа өгч 4 цаг уяна, үхэрт бол үүнээс нэг дахин их (цайны бүтэн халбага) өгнө.

Бог малын хар чацга өвчнийг улаан давс, зэсийн цэнхрээр эмчлэх арга байдаг (Хөдөлмөрийн баатар И.Сэрхбай.)

Хонь хавар ногоолох үед чацга алдвал хоолны том халбагаар улаан давсны уусмал (халбага усанд чимх давс хийж найруулна) өдөрт 3 өгнө. Хэрэв маргааш нь сайжирч нүд нь сэргэсэн байвал давсны уусмал 2 халбага өгнө. Хонь өвөл чацга алдвал өвс ургамлын биш харин цагаан хорхойноос ихэвчлэн үүсдэг. Үүнийг хоёр янзаар эмчилнэ.

а/ Улаан давсыг дээрх маягаар найруулж 3 хоног өдөрт нэг өгнө. Хэрэв засрахгүй бол өдөрт 3 удаа, нэг өгөхдөө 3 халбага өгнө. Маргааш засрах төлөвтэй болбол 3 халбагаар хоёр удаа, 3 дахь өдөр нь 3 халбагаар нэг удаа өгөх зэргээр багасгана. Ийнхүү давс өгөхөд 3 дахь өдөртөө нэг янз үзүүлнэ.

б/ Дээрх эмчилгээ үр дүн өгөхгүй бол зэсийн цэнхрийг нүдэж гурил мэт болгож хоолны халбага усанд багавтар чимх нунтагласан зэсийн цэнхэр хийж усыг цэнхэрдүү өнгөтэй болгож гурван өдөр дараалан өдөрт 1 халбага өгнө.

Хэрэв баас нь өөрчлөгдөхгүй бол арай илүү өтгөн найруулж нэг өгөхдөө 3 халбага өдөрт 3 удаа өгнө. Хар чацга алдсан хонинд нэг шаазан шимийн архинд биоветин зуурч өгдөг.

Ийнхүү эмчлэхэд засал авахгүй бол зэсийн цэнхрийг нэг дахин их хийж нэг удаа өгөхдөө 3 халбагаар өдөрт 3 удаа өгнө. Ингэхэд хонь эрүүлжих, эсвэл мал болохгүй.

Зун, намар болон өвлийн хар чацга алдсан малд хоолны халбага улаан зоос (шороон будат)-ийг усанд зуурч эдгэртэл чацга тогтох хүртэл өгнө.

Мөн хар чацга алдсан үхэрт тарваганы өөх, тос өгнө. Төл, өсвөр үхэр осгож даарснаас гэдэс нь сэрийж дүүрч чацга алдсан бол өөх тосны хиншүүгээр утна.

Үхэр нарийсч чацга алдаж, чацга нь хөөстэй хөлдсөн байвал хар модны холтосны ханд 2-3 литрийг 2-3 удаа цутгаж өгөхөд сайн.

-Нунтагласан цайг дангаар буюу эсвэл шар тостой хольж зуураад хэлний угт тавьж 2-3 удаа өгнө.

БОГ МАЛЫН ДОГОЛ

Хонь ямаанд догол өвчин олон хүчин зүйл шалтгаанаас үүдэн тохиолдоно. Ямар нэг шалтгаанаар малын жилбэ бэрэвхий шалбарч шархалсаны улмаас элдэв хортой нян орж сэдрээн идээ бээртэй шарх болж хүнд үрэвсэл үүссэний улмаас мал доголж, явж идээшлэх чадваргүй болж, тарга хүч алдах, заримдаа туурай мултарч унах хүртэл хүндрэл үүснэ. Бүх эрхтэнд идээ бээр буглана.

Өвөл, хаврын улиралд бог малыг их хөр цастай бэлчээрт идээшлүүлэх үед мал цас цавчиж бэрэвхийн үс халцарч шалбарч өвчилж хавдана. Туурайн гярахны үсэнд нойтон цас шавж бамбардан мөсөн молцог болж туурайг хайрах, үс холгож халцруулах, шалбалах, шархлах үрэвсэх нөхцлийг бүрэлдүүлэх учир бамбардсан мөсийг арилгах хэрэгтэй.

Зун, намар цагт хур бороо ихтэй үед малын хөлний арьс, ул, туурай дэвтэж зөөлөрсөний улмаас хөлийн арьс хад, мод, чулуу, өргөстэй өвс ургамалд өртөж хялбар шалбарч шархлан үрэвсэл үүсэж хавдсанаас мал олноор доголно. Хур бороотой үед малын хот хороог байнга солихгүй байх, их шавхайтай хороонд хонь хаших, намаг шавар ихтэй бэлчээрт тогтмол идээшлүүлэх, ургамлын шүүдэр, хар чийгээр мал бэлчээх зэргээс шалтгаалж хонь, ямааны туурай жилбэний арьс зөөлөрч, шалбарч шархлан сэдэрснээс догол үүснэ.

Шивээ хялгана ихтэй бэлчээрт бэлчээх, мөн царван их ургасан жил (хонины хөлийн ус шар будагтай болно) хонь догол өвчнөөр өвчлөх нь илүүтэй тохиолддог гэж малчид үздэг. Ийнхүү байгаль, цаг уурын нөхцөл, хариуцлага, маллагааны сөрөг нөлөөнөөс шалтгаалан үүссэн догол өвчин өвчлүүлэх, идээлүүлэх үйлчилгээ бүхий микробоор бохиртон сэдэрч хүндрэх нь элбэг тохиолдоно.

Түүнчлэн хөлийн үүсч сэдэрсэн шарханд халдвартай балцруу өвчин үүсгэгч нян орж халдвартай догол өвчин болж хүндрэх нь зуны улиралд тохиолдоно.

Халдвартай догол өвчин үүсэн гарсан тохиолдолд мал хэдэн арваараа зэрэг доголж, дотор эрхтэнд идээ бээр хурж, өвчилж үхдэг. Малчид халтдвартай догол өвчнийг хоньхыг "балцруу", адууныхыг "содрог" тэмээнд туссаныг "байварга" гэж нэрлэж иржээ.

Эмчилгээ: Догол өвчин хүндэрч, бүр халдвартай догол өвчин болж сэдрэх аюултайг анхаарч доголсон малыг сүргээсээ даруй тусгаарлаж, хотондоо байлгаж тэр даруй эмчилж эдгэрүүлэх нь чухал.

өвөл, хаврын улиралд цас малтаж идээшлэсний улмаас шилбэ, бэрэвхий, гярах нь шалбарч, хавдаж доголсон тухайд малын шарх, шалбархайд хөөтэй тос түрхэх шорвог давстай бүлээн усанд хөлийг дүрэх, шархыг гар доорх материалаар боох, дугтуй хийж хөлд нь өмсүүлэх арга хэрэглэн эмчилнэ. Хэд хоног гадна байлгаж тэжээх, цасгүй газар бэлчээх хэрэггүй.

хөлд балцруу тусаж шархалж хавдсан байвал шархыг цэвэрлэж давстай хар цайгаар шавшиж, шарханд нь нунтаг давс хийж боох, битүү хавдрыг айраг, ялз чанаж агшаасан шар будаа, зуурсан гурилын аль нэгээр нь хөхүүлж хавдар нь өрхөлсөний дараа хагалж дээрх эмчилгээг хийж болно. Битүү хавдар өрхөлж идээлсэн байвал шууд хагалж идээ бээрийг шахаж гаргаад шарханд тэнгэрийн дүлий нунтаг, аги гишүүний үндэсний хандаар угааж байн байн бор давсыг үхрийн баастай хольж өдөр бүр шархыг хөхүүлэхэд шарх нь түрж түргэн эдгэрэхэд тус болно. Шарх эдгэрэх явцыг түргэтгэхийн тулд дотуур нь агил, бугын зуулт өгөх, аргалын халуун үнсэн дээр зогсоох арга хэрэглэнэ.

Ийнхүү шархыг хөхүүлж хорыг авсны дараа доголсон хөлийн хоёр салааны завсрын дунд хирд дороос дээш нь чигтэй 1 см хйртэй гүнзгий хатгана. (Ч.Намсрай) 2-3 хоног хуурай газар уяж тэжээх нь чухал.

Балцруу туссан даруйд нь туурны туурга буюу магнай, ар жолооны судасны аль нэгийг ханаж цус авахад сайн. Хонь, ямааны балцрууны шарханд сохор цох тавьж бооход хатаж эдгэрэх нь түргэн байдаг. (С.Ищцорж).

Мал сүргийг догол өвчнөөс сэргийлэх зорилгоор цастай үед нимгэн, зөөлөн цастай бэлчээр дагуулж хариулах, зун, намар хур бороотой үед малын хашааны шавар шавхайг этэж овоолох, хашааг байн байн урилах, шүүдэр чийг их унасан үед уул толгодын хяр, намхан өвстэй бэлчээр дагуулан хариулах, намар шавартай газарт өдөр бүр идээшлүүлэхгүй байх зэргээр малын хөл, ул туурайг хэт норж дэвтэхээс болгоомжлох хэрэгтэй.

ЦОВХРОО

Нялх ногоонд цадах үед буюу намар ногоо хэнзэлж байгаа үед хонинд цовхроо өвчин тохиолдоно.

Уг өвчин 6, 7, 8 сард ихэвчэн гарна. Үд дунд хонь амрах, хотондоо хэвтэх үедээ гэнэт өвчилж түргэн зуур үхнэ.

Шинж тэмдэг: Гэнэт үхэхгүй бол хонь яг зогсоно. Хэвтэж тийчилнэ. Яг зогсож байгаад 1-2 цаг болсны дараа чацга алдаж хамар нь хатна.

Эмчилгээ: Гэнэт өвчилж, яг зогссон үед чацга алдахаас нь өмнө буюу чацга алдаад удаагүй байгаа үед хоолны нэг халбага креолоныг усанд найруулж дотуур өгөхөд зарим нь сэхдэг ажээ.

Айргийн шар ус, цагаан архи (50-100 гр) буюу шимийн архи (нэг аяга) өгнө.

Бас цовхроо туссан хонины хаа (уушигны судас) хатгаад зарим нь сэхнэ (Г.Цэвээн).

Цовхроотож эхэлбэл давс хужиртай бэлчээрт хонио бэлчээхийг зөвлөдөг.

ҮХЭР, ХОНЬ, ЯМААНЫ ГҮЗЭЭ ХИЙГЭЭР ДҮҮРЭХ (ЦЭНДЭЭГ)

×

Хивэгч малын гүзээ хийгээр дүүрч өрц рүү нь шахаж дарснаас болж зүрхний ажиллагаа, амьсгалд бэрхшээл учруулснаас мал түгшиж амьсгаадан амь тэмцэх бөгөөд засал даруй хийхгүй бол үхнэ.

Олон шалтгаанаас үүдэн гүзээ хийгээр дүүрнэ. Тухайлбал ялзарч хөгцөрсөн үр тариа, төмс байцааны навч, цантсан өвс, сүрэл их хэмжээгээр гэнэт идсэнээс гүзээнд хүчтэй исэлт явагдсанаас хий үүсгэнэ. Зун, намрын улиралд халгай их хэмжээгээр идсэнээс халгайн дүүрэлт болно. Гүзээ хийгээр дүүрэх нь ямар нэг өвчний урхаг дагавараас үүсч болно. Багалзууртах, таанатах, хар халгай, хорт ургамлаар хордох, хуурай хүчит тэжээл идүүлж байгаад гэнэт услах, нялх ногоо, шүүст тэжээл их идэх зэргээс үүдэн үүсдэг байна.

Шинж тэмдэг: Гүзээ нь дүүрсэн малын хоёр талын бөөрний хонхор тэгширч зүрхний лугшилт хурдасна.

Халгайн дүүрэлт болсон үхэр хэлээ унжуулж амаа ангайлгаж шүлс гоожуулна. Чацга алдвал өвчин хүндэрч үхүүлэх нь ховор. Харин чацга алдахгүй бол амьсгаа давхцаж багтарч үхэх аюултай.

Эмчилгээ: Хэлийг байн байн татах, аманд нь хөндлөн мод зуулгах зэргээр хэхрүүлэх, гүзээг илэх арга хийнэ. Мөн дотуур нь үнс, хөө, модны нүүрсийг нунтаглаж устай хольж өгнө. Үс, яс, тосны хиншүүгээр утаж хэхрүүлэх, унгуулах арга хэрэглэнэ.

Өвчилсөн малд махны тостой шөл өгөх, мушгисан өвс, сүрэл зэрэг ширүүн зүйлээр гүзээний ойр орчмыг сайтар үрнэ. Бод малд 300 мл хүртэл, богд 100 мл архийг 0.5 л усанд найруулж

цутгаж өгнө. Эдгээр засал тус болохгүй бол гүзээг шөвгөөр буюу шприцын бүдүүн зүүгээр хатгаж хийг гаргана. Гүзээг хатгах цэг бол зөв талын сүвээний хонхрын төв дунд ташаан толгой, харцаганы хавирга тус бүрээс дөрвөн хуруу хэмжиж энэ хоёр хэмжээний уулзвар дээр цэг хатгана. Хатгах хутга шөвөг, зүүний үзүүр нь нөгөө талын хөлийн толгойн чигт чиглэсэн байх ёстой. Хатгах хамгийн тохиромжтой хэрэглэл нь гуурстай шөвөг (троакар) бөгөөд аль аль нь байхгүй тохиолдолд нарийн хутгаар хатгаж, хутгаа эргүүлэх маягаар хийг бага багаар гаргаж, гэдэс хонхойж ирэх үед хутгаа авна. Хатгах газрын арьс болон хутгаа ариутгах хэрэгтэй.

Гэдэс нь дүүрсэн хонинд ямааны халуун сүү 200-300 гр өгөхөд сайн. (Ц.Намхайнямбуу). Мөн нэг атга аргалын үнсийг нэг аяга устай хольж өгнө. Үхэрт 8 литрийн хувин үнсийг 10 литр усаар найруулж өгнө.

Бод малд хонины нэг толгойг хуйхалж, хярвасыг нь бүлээн усаар зуурч өгч аргалдаг. Нүдийг татаж үзэхэд хар захтай цагаан хальс нүдийг бүрхээд ирвэл түүнийг утас сүвлэсэн зүүгээр сүвлэн татаад хайчлах буюу огтолж авч юман дээр хаянгаа сүүлийг шар хийтэл тат. (А.Цэрэв).

ҮХРИЙН ГЭДЭС ЧИХЭЛДЭХ

×

Үхрийн гэдэс буюу хошног чихэлдэж болно. Тэжээл боловсруулах эрхтний үйл ажиллагаа хямарч, түүнээс шалтгаалан гэдэсний хөдөлгөөн ихсэх буюу багассанаас гэдэсний аль нэг хэсэг нь нөгөө хэсэг рүүгээ чихэж орох, зангирах, орооцолдсоноос энэ эмгэг үүснэ.

Шинж тэмдэг: Гэдэс нь чихэлдсэн үхэр бөгсөөрөө ухрах, сүүлээ шарвах, урьд хоёр хөлөө цахалж толгойгоо гудайлган зогсдог болно. Мөн суниах, дүлэх боловч баас гардаггүй байна. Босоход нуруугаа хотойлгон суниадаг.

Эмчилгээ: Үхрийн гэдэсний чихэлдээг гаргахын тулд дараах аргуудыг хэрэглэнэ.

чихэлдсэн үхрийг газрын уруу хөлөрч тамирдал хөөж их хэмжээгээр чацга алдуулбал засарч болно.

гэдэс нь чихэлдсэн үхрийн нимгэн цавь доогуур 20 см голчтой мод хийж дээш өргөж, эсрэг талын өлөн хонхорт гэдсэн талаас нь доргилт үүсгэх маягаар хөдөлгөж гэдэсний орооцолдож түгжирсэн хэсгийг гаргах засал хийнэ.

мөн өлгийдөх арга хэрэглэж болно. Үүний тулд үхрийг өөд харуулан хэвтүүлээд хойд хоёр хөлийг нь холбож оосорлон цах модноос уяж, бөгсөн биеийг нь бага зэрэг өргөж байгаад тонгочуулж болно.

бас нимгэн цавиар нь сулавтар гүйдэггүй уяагаар оосорлоод модоор аль гижигтэй газарт нь хатгаж тонгочуулж болно.

хөөж хөлөргөөд нүдэнд нь улаан тамхи цацахад тус болдог тал бий.

гэдэс нь зангирсан бол үхрийг хэвтүүлж хойд хоёр хөлөөр нь дүүжилж 2-3 цаг байлгаж тавихад засардаг тал бий.

Чихэлдсэн үхрийн сартгар хамрын араар дээд, доод уруулыг хамт чанга бооход амьсгаа боогдон дэвхцэж, цовхорч чацга алдсанаас гэдэсний чихэлдээг гаргаж болдог. Амьсгаа боогдож үхэхээс өмнө амны боолтыг тайлж ав. (Д.Лхам).

Дээрх аргуудыг хэрэглээд эс эдгэрвэл хонхолцог бөөр харалдаа нурууны далбага ясны бөгсөн талын хоёр дахь үеэс дотогш 3 хуруу газарт татаг сөөм эхлээд хөндлөн арьсыг дараа нь махыг огтолж хоёр хуруу оруулан аарцаг ясыг дагуулан хуруугаар илэхэд 2-3 судас тааралдах бөгөөд түүнд гэдэс орооцолдсон байна.

Аарцагны ясны хажуугаар унжсан судсыг хоёр талаас нь сайн боож дундуур нь огтолно. Үүний дараа арьс махыг оёно.

Гэдэс зангирах гэм эр үхэрт тохиолдох нь олонтаа бөгөөд энэ нь үхрийг хөнгөлөх үед төмсөгийг авсан даруй хоёр цагаан судас үлдэх бөгөөд түүнийг сайтар татаж огтолж, аваагүй орхисон бол тэр судас нь аяндаа гэдсийг ороож зангираа үүсгэдэг гэж үздэг. (Б.Долгор 1944 он).

Мөн дараах аргаар гэдэсний чихэлдээг гаргаж болно, Банз дэвсгэртэй тэргэн дээр үхрээ гэдрэг нь харуулан унагааж хойд хоёр хөлийг цээж, толгойн хоёр тал руу татаж атийлган уяад нуруугаар нь гулгуулж толгойг доош унжуулан аарцаг орчимд гэдсийг хүүхдээр гишгүүлэх буюу гараар дарж өгвөл хойшоо шахагдсан гэдэс цээжний чөлөө рүү орж зангираа нь тайлагдсан бол хар чацга алдаж зүгээр болно.

Хошног нь чихэлдсэн үхэр бааж чадахгүй дүлээд байдаг. Ийм үхрийн хошног руу гараа сугаа хүртэл шургуулж чихэлдсэн хошногыг цааш нь түлхэж засал хийнэ.

ҮНЭЭНИЙ ХӨХ ДЭЛЭН ХАГАРАХ

х

Саалийн үед үнээний дэлэн айх, хөх шалбарах, хөхийг арчлахгүй байх, ялаа шумуулд хатгуулах, халдвартай өвчин тусах зэргээс үнээний хөх үрэвсэн хагарч сүү шим нь татрах явдал тохиолдоно. Үнээний дэлэн хөх үрэвсэхээс сэргийлэхийн тулд саахдаа хөхөнд цөцгийн тос түрхэж зөөлрүүлэн саадаг. Хөх нь хагарсан тохиолдолд 1-2 хоног тугалд нь хөхүүлэхгүй байх, тос цөцгийг саахын өмнө, хойно түрхэж эмчилдэг.

Хагарсан хөхөнд үхрийн түүхий цөцгийг шорвог давсалж халуунаар нь 2-3 удаа түрхэхэд түргэн эдгэрнэ. Цөцгий түрхэхийн өмнө хөхийг хуурай болтол арчина.

ҮХЭР, ХОНЬ, ЯМАА, ХУРГА, ИШИГНИЙ ХАНИАД МЭНГЭР

×

Нялх байх үедээ чацга алдсан, хатгалгаа туссан, мөн шар бууцан дээр удаан байснаас бог мал ханиаж мэнгэртэнэ. Ханиаж мэнгэртсэн хурга бөгшиж ханиах, уушгийг чагнахад хэржигнэх чимээ сонсогдоно.

Архаг ханиад мэнгэртэй хурга, ишиг өнгө зүс муутай өсөж торних нь удаан хамраас ногоон цус гоожно.

Эмчилгээ: Ханиад мэнгэртэй малыг дор дурдсан аргуудын аль нэгээр эмчилнэ. Үүнд:

архаг ханиад мэнгэртэй хурга, ишгэнд 1-3 царцааг усанд буцалган хандалж, хоолны халбагаар өдөрт гурван удаа, 2-3 өдөр дараалан өгнө. (Г.Гүр, С.Бариад, Ж.Дамиран).

Намар орой хүйтэрч эхлэх үед царцаа нь чулууны завсар хомоол доор хоргодож хүрэн хар болсон байх үед түүж авч хатааж хадгална.

Өвөл, хавар бол чулууны завсар хатсан царцааг түүж хэрэглэж болно.

Халуурч ханиасан хурганд худгийн хүйтэн ус бага багаар (100 мл) өгдөг байна. Ханиасан хонь, ямаанд гаансны бохь өгөх сайн гэдэг. Гаансны бохь шүдэнзний хоёр толгойн хиртэйг цаасанд боож хонь, ямааны аманд хийх буюу усанд найруулан 2-3 удаа цутгаж өгнө.

Мөн уухилсан түгшсэн таанадсан хонь ямаанд гаансны бохь өгч хамрыг буйлдан сэтэлнэ.

Цус гарахгүй бол толгойг доош нь тонгойлгоход цус гарна.

Гэнэт халуурсан бод, бог малд хөх дэрсний үндэс, бодод 500, богт 50-100 грамм хандалж өгөхөд сайн нөлөөтэй.

Бүх төрлийн малын амьсгалын дээд зам үрэвсэж хамраас ногоон нус гоожиж, амьсгаа авах нь бэрхшээлтэй болж шуухитнахад самсаа, эсвэл хаа, шамархайг ханана. Цус гарахгүй бол толгойг тонгойлгоно. (ДЛувсанцэрэн).

Хурга, ишиг хэржигнэж ханиалгах үед нямдүүжин өвс, улаан өвс хандалж (гурван хуруу чимх өвсийг 3 литр усанд) өгнө (Ж.Сүхбаатар).

бог малын ханиаданд хонгор зулын навчийг хандалж, дунд шаазан аяга өгч эмчилнэ.

мэнгэртэй хонинд хоолны халбага аарцыг литр усанд чанаж хандлаад хоолны халбагаар өдөрт 3 удаа эдгэртэл өгч эмчилнэ.

ханиад, шуухинаатай нус гоожуулах, голоо цохиж байгаа малд 10 литр усанд нэг атга чихэр өвс хийж буцалгаад том малд 500, төлд 200-300 мл-ээр өдөрт 2 удаа эдгэртэл өгч эмчилнэ.

ҮХРИЙН НАЛИХ (НАХАЛ)

х

Тамир тэнхээгүй байн байн хэвтэж босно. Нүдний дотор хар захтай цагаан мөгөөрс урган гарна. Нүд улаан өнгөтэй болж, нулимс гоожно.

Эмчилгээ: Нүдний цагаан мөгөөрсийг нарийн юмаар сүлбэн татаж огтолж авна. Сүүлнээс хэд сайн чангааж дугтарна.

ЦАХЛАЙ

х

Цахлайтах өвчин тугал, бяруунд элбэг тохиолддог бөгөөд малын тарга хүч, өсөлт торнилтонд муугаар нөлөөлнө. Цахлай малын зовхи, уруул болон толгойн бусад хэсэгт гарна.

Эмчилгээ: Малын биед гарсан цахлайг цус гартал хусаж, халуун тос түрхэх, түрхсэн тосон дээрээ халуун жин тавьж жигнэх арга хэрэглэнэ. Мөн цахлайд бензин түрхэж дэвтээгээд цахлайн хогжрууг хусаж арилгах замаар эмчилдэг ажээ.

Тарваганы тосонд бор давс хийж халаагаад түрхэх эсвэл цахлайтай хэсгийг цус гартал хусаад адуу, тарваганы тосыг хөөтэй хольж халуунаар түрхэхэд цахлай арилдаг байна. Бургасны хальс буюу хар модны гөлөгөн боргоцойг халуун тогоонд жигнэхэд ялгардаг шүүсийг халуунаар нь хусаж цэвэрлэсэн цахлайд түрхэж эмчилдэг байна.

ТУГАЛЫН ХЯЛУУ

х

Хэлний үзүүрт байгаа хялуу нь өөрийнх нь төрөлх хялуу болно. Харин түүнээс хойш хэсэгт байгаа хялуу (хөхөнцөрүүд) нь цусаар дүүрч бүдүүрэн үрэвсэл өвчин болно. Үүсэх шалтгаан нь тугал хужир шүүгээр дутагдах, олон хоногоор наранд уяж цангааснаас энэ өвчин тусна.

Шинжтэмдэг: Хялуутсан тугал бөрзийж зогсох, идээшлэхгүй байснаа эцэж турдаг. Тугалын амыг ангайлгаж үзэхэд хөхөнцөр улайж, жавьжны өргөснүүд нь хар буюу хар хөх өнгөтэй болж бүдүүрсэн байна. Хэлний, жавьжны өргөснүүд нь өрвөссөн учраас хэлээрээ өвс ороож зулгаахаас эмзэглэж идээшлэхгүй болж гэдсээ татна. Хялуутсан тугалын чацга нь хар ногоон өнгөтэй, анхилуун үнэртэй, амархан өрөмтөж, хусаж үзэхэд нүхтэй цоохор байдаг онцлогтой. Үүнийг уул өвчнийг таних онцлог шинж гэж үздэг.

Эмчилгээ: Тугалын хэлэн дээр гарсан аль томорсон хөхөнцөрөөс хэд хэдийг чимхүүрээр сугалан авч маажиж шалбалан цус сайн гаргаж, хэлэнд нь нунтаг давс үрж түрхэхэд амархан эдгэрнэ. Өвчин гарсан тохиолдолд тугалд хужир давс нэмүү өгнө.

ХОНЬ ЯМАА ТҮҮДЭГТЭХ

х

Бог мал ялангуяа хурга, ишиг, борлон өвлийн улиралд хоол тэжээл муутай, гэнэт даарч хөрөх, даарч яваад дулаан гэр байранд оруулах зэргээс гэдэс гүзээний үйл ажиллагаа хямарч гэнэт өвчилнө. Өл хоолгүй хурга, ишиг, төлөг гол төлөв өвлийн улиралд түүдэгтэх нь их байдаг.

Шинж тэмдэг: Түүдэгдсэн малын гэдэс гүзээ дүүрч, амь тэмцэн тийчлэх, хэвтэж босох, яраглах, бөгсөн биеэ мушгиж савж ойчих, тарайж хэвтэх, урьд хөлөө жийх, суниах, нуруугаа хөтөйлгөх, дүлэх байдлаар илэрнэ. Зохих тусламж үзүүлэхгүй бол богино хугацаанд үхэж мэднэ.

Түүдэгтсэн мал. түргэн, түргэн хэвтэж босохдоо баруун,. Зүүн талаараа ээлжлэн дутуу хэвтэж босох нь түүдэгдэхийн онцлог шинж болно. Түүдэгтсэн ишиг орилно, савж унана, хөрвөөнө.

Эмчилгээ: Түүдэгдэх үед тохиолдох шинж байдал нь мэдрэлийн ажиллагаатай холбоотой хүнд зовиур учраас мэдрэлийг сэдээхийн тулд цочоох, дугтрах, айлгаж тэвдүүлэх арга юуны өмнө хэрэглэнэ. Хар малгайгаар биеийг нь болон газар ээлжлэн цохиж дөмнөдог. Мөн сэдээх, цочоохын тулд сүүлний үзүүрийг хазах, хутгаар зүсэх, өөрийн имээр имнэх, имгүй бол чихийг сэтэлж цус гаргах арга хэрэглэхэд үнэхээр түүдэгдсэн бол тэр дороо зүгээр болно.

Ам хамрыг нэг гараа бүтүүлэн атгаж амь тэмцэхдээ шээс алдах үед амьсгааг тавьж, нөгөө гарын алгаар шээсийг нь тосон авч амаар цутгаж өгдөг. Аманд нь давс хийж барьж болно. Дараа нь хойд, баруун урьд хөлийг солбиулан урагш хойш татаад нөгөө хоёр хөлийг мөн ийнхүү татаж засал хийнэ. Мөн төмсгийг зөөлөн хэд хэд атган судсыг нь илж зөөлөн базна. Мөн нэг настай эмэгтэй хүүхдийн шээс өгдөг ажээ.

САРХИНАГ ХАТАХ

х

Өвөл, хавар, намрын улиралд ил булаг шанд гол горхи хөлдөж мал усаар гачигдах, олон хоногоор услахгүй байх, усалсан ч бүгд малыг жигд сайн ханатал услахгүй, ялангуяа ядуу дорой мал ус уухгүй өнгөрөх зэргээс усны өлсгөлөн болж малын сархинагны баас хатаж үхнэ.

Хар, цагаан зудын үед болон хуурай хүчит тэжээлээр тэжээж байгаа үед малыг хангалттай услаагүйгээс шалтгаалж сархинаг нь хатах явдал элбэг тохиолдоно.

Ийнхүү мал ус цасаар дутагдаж цангаснаас сархинагны баас хатаж, өвс тэжээлээс гарч, идээшлэхгүй зогсон өнгө зүсээ алдаж, гэдсээ татаж хоёр бөөрөөрөө хавчийж түргэн турах бөгөөд хэрэв усаар хангахгүй бол үхдэг байна.

Сархинаг нь хатсан хонийг гэнэт босгож өргөхөд явж байгаад байн

байн ойчиж, дөрвөн хөлөө дээш харуулан сарваганаж хэвтэх шинж үзүүлдэг. Сархинаг нь хатахаас сэргийлэхийн тулд малаа тогтмол сайн услах нь чухал. Сархинаг нь хатсан малыг услахаас өмнө давс өгөх, давстай усаар усалбал сайн нөлөөтэй.

Мал сүргийг усаар хангах явдал тарга хүч авахуулах, тогтоох төдийгүй өвчин эмгэгээс сэргийлэх үндсэн аргын нэг юм. Малчдын мал услах уламжлалт аргаас энд бас дурдах нь зүйтэй гэж үзлээ. Мал услах тоо, хугацаа нь байгаль, газар зүйн байдал, цас бороотой, гантай зудтай байх, малын хүйс, ашиг шимийн байдлаас шалтгаалан өөр өөр байж Үхэр, хонь, ямааны өвчин болох боловч мал услахад баримтлах уламжлалт үндсэн зарчимд дараах зүйлс ордог байна. Үүнд:

- хонь, ямааг зуны тэргүүн сард юүлх ногоотой үед өдөрт нэг удаа, бага үдийн алдад усална. Харин зуны аагим халуун үед өдөрт хоёр удаа буюу эхнийхийг нар баруун хананаас мултрах үед, оройнхыг нар зүүн хана өөд өгсөх үед усална. Намар, өвөл, хавар өдөр бүр услах ба бороотой, бүрхэг цастай бол өнжиж усална.

- үхрийг зун, намар өдөрт хоёр удаа өглөө оройд, харин өвөл, хавар өдөрт нэг удаа өглөө бэлчээж идээшлүүлэн бие нь дулаацсаны дараа усална.

- тэмээг зун намрын цагт өдөр бүр, бороотой бол өнжөөд, эр сувай тэмээг өнжөөд усална. Өвөл, хавар бол ингэ, өсвөр тэмээг өглөө идээшлүүлсний дараа өдөр бүр, цастай бол өнжөөд, эр сувай тэмээг 7 хоногт 2-3 удаа усална.

- адууг зуны улиралд өглөө хумин эргүүлж усанд оруулах ба саалийн гүүг нар баруунаа тонгойх үед намар бол өглөө, орой, хаварт бол харз уснаас 1-2 өнжөөгөөд, худгаас бол 2-3 өнжөөд усална. Адууг олон хоног өнжөөн усалснаас усны цанх, гэдэсний хатгалга, гэдэс чихэлдэх, хээл хаях эмгэг тохиолдох учир адууг услах тоо, цаг зэргийг тогтоож журамлах нь зүйтэй гэж үздэг.

Мал сүргийг аль ч улиралд дураар нь усалж байх, өвөл, хавар хуурай нэмэгдэл тэжээл өгч байгаа үедээ усан хангамжийг сайжруулах нь чухал байдаг.

Мал услах уламжлалт горим дэглэмийг нарийвчлан судалж малын төрөл, ашиг шим, нас хүйс, улирал, цаг агаарын байдал, өнтэй зудтай үе зэргийг харгалзан малын уух усны хэмжээ, услах ашигтай хугацааг бүс тус бүрээр судлан тогтоох нь цаашид манай эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, мэргэжилтэн, малчдын нэг зорилго юм.

Энд энэ асуудлыг судалсан эрдэм шинжилгээний нэг ажлын үр дүнг товч дурдвал дэд эрдэмтэн М.Содном тал хээрийн бүсийн бог малын өдөрт уух усны хэрэгцээ, услах хугацаа,

тоо, уух усны хэмжээ нь малын идээшлэлт, тарга хүчинд хэрхэн нөлөөлж байгааг судлан тогтоож сонирхолтой дүгнэлт хийсэн байна.

Тэнгэр бүрхэж, үүл хэдий чинээ өтгөрч нар халхлах, хур тунадас орох үед бог малын биеэс чийг уурших нь бага болж уух усны хэмжээ багасдаг болохыг тогтоожээ. Энэ дүгнэлт нь манай малчдын уламжлалт мал ажиллагаанд бүрхэг бороотой, хуртай үед малыг өнжөөж усалдаг дэг журмыг шинжлэх ухааны үндэстэйг харуулж байгаа юм. Бог малын уух усны хэмжээ агаарын халуун 15 хэмээс дээш гарах үед нэг хэм дутам уух усны хэмжээ 0,05 л, харьцангуй чийгшил нэг хувь болгонд 0,012-0,014 л ус нэмэгдэж хоногт уух усны хэмжээ 4-5 литрт хүрдэг байна. Харин хүйтний улиралд бог малын уух усны хэлбэлзэл цаг агаарын тогтвортой байдлаас шалтгаалан бага болдог байна.

Дээрх зүй тогтлыг үндэслэн ургамал шүүслэг боловч биеийн усны ууршилт их байх үед болон бэлчээрийн өвс хагдарч, цасгүй байх үед бог мал өдөрт 4 литр, бэлчээр цастай бол 1,4 литр, хурга. ишиг зуны улиралд 1,4 литр, бэлчээр хагдарсан үед 3 литр ус хэрэгтэй болохыг тогтоосон байна.

Бог малыг зун хур бороотой бол өдөрт нэг удаа, гантай бол хоёр удаа, нартай, цасгүй бол 2 удаа, бүрхэг цастай бол 1 удаа, зөөлөн цастай буюу цас орж байгаа өдрүүдэд 1-2 өнжөөж услахыг дээрх эрдэмтэн зөвлөсөн байна.

Мөн бог малыг хэдийг услах нь ашигтай болохыг судалж орой 20 цагт усалж байсан бог малын жин өглөөний 8 цагт усалж байсан

малынхаас 3,3 хувь, үдэд 13 цагт усалж байсныхаас 1.7 хувиар тус тус давуу байгааг тогтоосон байна.

Энэ бүгдийг дурдахдаа мал маллагааны уламжлалт аргад шинжлэх ухааны үндэслэл өгөх, түүнийг улам боловсронгуй болгоход санаа авахыг удирдлага болгосонд оршино.

ХУРГА ИШИГ ШИЛЭЭ ТАТАХ

х

Хурга ишиг нүдээ хялалзуулан гөлийлгөж, шилээ татан унана. Хүзүүний булчин агшсанаас мөгөөрсөн хоолой дарагдаж, боож бүтэж үхэх явдал гардаг гэж үздэг. Заримдаа дэмий тэнүүчилнэ, шүдээ хавиран. Ийнхүү шил нь татаж унасан хургыг дараах аргын аль нэгийг хэрэглэж сэхээнэ. (П.Лувсаншарав) Үүнд:

а) аман хүзүүний хоёр талын далавчны нүх чиглүүлэн ясанд нь хүртэл шөвгөөр хатгаж сэхээнэ. Ийнхүү хатгахдаа шилэн хүзүүнд хүрч болохгүй.

б) ууцны ясны хажуугийн олон нүх чиглүүлэн шөвгөөр хатгаж болно. Шөвгийг зөв гурав эргүүлж, 10 минут болсны дараа шөвгөө буруу гурав эргүүлэн авна.

в) хошногын дээд талын хонхорт хутганы үзүүрийг сүүлний яс чиглүүлэн хатгаж болно.

г) хонины махны шөл хоолны 2-3 халбага өгч чихний нүх рүү нь шар тос хийж аргалдаг.

д) шилээ татаж унасан хурга, ишгийг тостой даавуу буюу хөвөн шатааж утахад сэхэж болно.

ХУРГА, ИШИГНИЙ УУРАГ ЗАНГИРАХ

х

Хэт их уураг хөхсөний дараа даарах, нойтон чийгтэй хэвтэр дээр удаан хэвтэж доороосоо жигнэгдэх зэргээс хөхсөн уураг нь боловсролгүй ээдэж хатуурахыг уураг зангирах гэж нэрлэнэ.

Шинж тэмдэг: Уураг зангирсан үед төл эхээ хөхөхгүй, шаравтар өнгийн чацга алдана, бэгзийж. зогсох буюу хэвтэх, босох эсвэл байнга хэвтэж зовууртай яраглах болно. Амнаас шү хар шүлс гоожно, хошуу нь хөрч нэн нойтон болно, хошуугаа далан дээрээ тавьж үе үе яраглах зэрэг шинж үзүүлнэ. Урьд хоёр хөлөө жийж, хойшоо өнхөрч ойчих болно.

Ийнхүү өвчилсөн төлийн ходоодыг гадна талаас нь тэмтэрч үзэхэд ходоод дотор нь нэг буюу хэд хэдэн хатуу бөөн зүйл тэмтрэгдэнэ.

Эмчилгээ: Уураг зангирах явдал хүнд өвчин бөгөөд барагтайд засал авахгүй үхэх аюултай учир бог малын төлийн хөхсөн уураг зангирахаас сэргийлэх ажлыг байнга тогтмол зохиох хэрэгтэй. Уураг зангирахаас сэргийлэх гол арга бол төл гарсан даруйд халуун бие дээр нь дааруулалгүй- амлуулж байвал цаашдаа хөхсөн уураг нь бараг зангирч бөөгнөрдөггүй болно. Түүнчлэн төлд элгэвч нэмнээ уяж ходоод гэдсийг дулаан байлгах нь өвчнөөс сэргийлэх арга болно.

Төлийг удаанаар хэвтүүлэхгүй байх, тогтмол цагаар хөхүүлэх, байранд нар салхи оруулах зэрэг ажиллагаа нь энэ өвчнөөс сэргийлэхэд тустай юм. Зангирсан уургийг гадна талаас нь зөөлөн барьж задлах, бутлах, уураг сүүг сойх, архи, сармис, сонгины ханд ходоодны шүүс өгдөг, Уураг зангирсан тохиолдолд малын эмч нарт мэдэгдэж, зохих эм өгөх, ходоодонд хагалгаа хийж зангирсан уургыг авах арга хэмжээг авахуулбал ихэнхийг эдгэрүүлнэ.

ХУРГА, ИШИГ ХАРАНГАДАХ

х

Хөрвөжсөн хурга ишиг татаж ойчих, хэвтэж босох, ахин дахин татаж ойчно. Ийм хурга ишгэнд нэг аяга ус өгөхөд (цутгахад) зүгээр болно. Цаашдаа төлийн байранд давс, хужир, шүүгээр амталсан ус тавьж өгөх, эх нь жилбэтэй эсэхийг шалгаж саамшуулах хэрэгтэй.

ХУРГА, ИШИГ ХАТГАЛГА ТУСАХ

х

Дулаан байр, пүнзнээс төлийг гэнэт гадаа хүйтэн жавар салхинд гаргаж салхинд цохиулах, дааруулснаас хатгалгаа тусна. Мөн төлийн байр, пүнзний нүх сүвээр хүйтэн салхи сийгэснээс болж хатгаа авч уушиг нь үрэвсэнэ. Түүнчлэн шарлаж нунтгарсан бууцтай байранд удаан байснаас болж бог малын төл уушиг өвчлөх явдал тохиолдоно.

Шинж тэмдэг: Хатгалга туссан хурга, ишиг гэнэт халуурах, амьсгаа нь давхцаж гэдэс нь бүлхэлзэж байна. Уушгинд гэм суусан хурга, ишиг нь явах хөдлөх нь удаан эрүүгээ газар тавьж, хүзүү сунган хэвтэнэ. Эхээ хөхөхдөө дурамжхан болно. Эхэд нь хөхүүлэхэд сөхөрч чадахгүй эсвэл сөхөрч босоод байдаг.

Эмчилгээ: Уушгинд гэм суусан хурга, ишгэнд ганга өвс, царван, агь, шар мод, улаан өвс, нохойн хошуу, нарсны шилмүүс, аньс, чихэр өвс, хонхолцог өвс зэргийг хандалж цутгаж өгнө. Мөн арц, гангаар утаж болно.

Хурга, ишиг хатгалгаа авч амьсгал давхцаж байгаа үед хоёр хааг хатгаж эмчилнэ. 2-3 дусал цус гарна. Мөн хатгалгаа туссан даруйд хайрцагт халаасан элс хийж элсэн дээр нь даавуу тавьж дээр нь хурга ишгийг хэвтүүлж хучихад хурга, ишиг ихэд хөлрөх бөгөөд 2 цаг орчмын дараа босож ирнэ. Хатгалгаа туссан хурганы туулай хамрыг сэтлэх засал хийнэ.

ШӨВӨГ ЯР

х

Ямааны шөвөг яр, амрууг урьдаар аманд гарсан яр шархыг хусаж, цус гаргаад орой хэвтүүлсэн тэмээг өглөө шээхэд тосож аваад бүлээн дээр нь ямааны хошууг дүрж сойлдон 1-3 хоногийн завсартайгаар 2 удаа угаахад бүрэн эдгэрнэ.

Аль болох шорвог хар цайгаар шавшина. Давс нунтаглаж хөө, тостой (бараг ижил хэмжээтэй) хольж халуунаар нь түрхэж болно.

Амруутсан ишгийг хадны хагаар угаах сайн нөлөөтэй.

ОРОНГОТОХ

х

Энэ өвчний зарим нутагт горинго, оринго гэж нэрлэнэ. Гол газар зусаж ихэвчлэн гол газар төллүүлсэн бог малын хурга, ишиг хөрвөжиж, хурга сүүллэж эхлэх 7-8 сард хурга, ишгэнд оринготох өвчин тохиолдоно. Хар ус нуурын голд бараг жил тойрон байсан 5 суурийн мал зүгээр төллөсөн боловч 4, 5, 6 сард эдгээр суурийн хурганд оринготох өвчин тусаж ихэнх төлөө үхүүлж байсан удаатай.

Гол шинж тэмдэг нь хурга, ишигний хойд хөл мэдээгүй болсноос бөгсөө чирч урьд хөлөөрөө бөгсөн биеээ чирч, тойрч дугуйлах хөдөлгөөнтэй болно. Идэх уух нь хэвийн боловч бөгсөн бие нь хатингар болно. Зарим жил гарахгүй, суурь бүрд ч тохиолдохгүй. Ийм өвчтэй

хургыг нядалж идшинд хэрэглэдэг байжээ. Зарим малчдын ярианаас үзэхэд оринготовх өвчин туссан хурганы ууцны арьсыг ярж зэсийн цэнхэр хийдэг гэж өвгөд дээдэс ярьдаг байсан гэсэн мэдээ байна.

ХҮРД

х

Өвөл, хаврын улиралд хүрд шимэгчилсний улмаас бог мал тарга хүчээ алдаж, тураалын үхэлд нэрвэгдэх аюултай юм. Хүрд 10, 11 сард өтөг бууц бэлчээрээс бог малд асаж шимэгчилнэ. Хүрд ихтэй хот бууцанд бууж, урьдчилан сэргийлэх эмчлэх ажил хийгээгүйгээс хонио олноор тураалаар үхүүлж байсан тухай мэдээ бий.

Эмчилгээ: Малыг намар өтгөн бууцан дээр хэвтүүлэхгүй байх, өвөлжөөнд хүйтэрсэн үед буухад мал хүрдтэх нь бага байна. Хүрд ихтэй нутагт, өтөг бууцыг газарт нь хүртэл малтаж зайлуулна. Хүрд ихтэй өтөг бууцанд адуу оруулж, хэд хэдэн удаа гишгүүлж, бууцыг сэндийлэх үед хүрд бужигнан гарч ирдэг бөгөөд энэ үед дуст цацах, май тавьж утах зэргээр бууцны хүрдийг устгах, арилгах арга хэмжээ авна.

Хүрд малын биед асахаас сэргийлэх, нэгэнтээ ассан хүрдийг устгахын тулд халуун бүлээн аргалын үнсийг бог малын биед түрхэхэд хүрд асах нь бага бөгөөд ассан хүрд нь хатаж үхдэг байна. Мөн тарваганы халуун тосыг малын хоолой, цавь, суга, нурууны үсний ёроолд өнгөц түрхэж хүрдээс эмчлэн сэргийлдэг байна.

Дүстийг цэврээр нь малд түрхэхэд үс зунгаггүй, ноос хатаж, мал тэжээлдээ дургүй болж хордох шинжтэй болдог. Ийм учраас 3 кг дустыг 1 кг аргалын үнстэй хольж түрхэхэд Дээрх сөрөг үзэгдэл тохиолддоггүй байна.

Хотон дотроо болон хотны эргэн тойрон май тавих, хөрзөн шатаах, хөө тортог болсон дээврийг хотон дотуураа чирэх, сэгсрэх зэргээр хүрдийг арилгах арга хэрэглэдэг ажээ. Ховд аймгийн Мянгад сумын хоньчин Л.Нацагдорж тус сумын Зээрэн нуурын усанд хүрд баараггүй үхдэг гэж мэдээлж байна.

Хүрдийг атга атгаар түүж хонинд өөрт нь өгдөг байсан нь сэргийлэх нэг арга байжээ. Хотон дотроо түмпэн дотор аргал хөрзөн шатааж гал тавихад хүрд орж үхдэг. Мөн хотон дотроо цагаан даавуу дэлгэж тавихад түүн дээр хүрд олноороо цуглах үед хамж устгах арга хэрэглэдэг ажээ.

САРЛАГИЙН ТУГАЛ ХӨӨРГӨДӨХ

х

Ямар ч насны тугалд зун, намар тохиолдоно. Хөөргөдсөн тугал сул дорой болж тарга хүч, өнгө зүсээ алдаж зовууртай зогсдог. Байн байн өөг өөг гэж дуу алдана. Ийм эмгэг туссан тугалд шар тос хоолны халбагаар өдөрт 2 удаа тэнхэртэл өгөхөд сайн (Ш.Долгор).

ХУРГА, ИШИГНИЙ УУРАГ ЗАНГИРАХ

х

Хэт их уураг хөхсөний дараа даарах, нойтон чийгтэй хэвтэр дээр удаан хэвтэж доороосоо жигнэгдэх зэргээс хөхсөн уураг нь боловсролгүй ээдэж хатуурахыг уураг зангирах гэж нэрлэнэ.

Шинж тэмдэг: Уураг зангирсан үед төл эхээ хөхөхгүй, шаравтар өнгийн чацга алдана, бэгзийж. зогсох буюу хэвтэх, босох эсвэл байнга хэвтэж зовууртай яраглах болно. Амнаас шү> хар шүлс гоожно, хошуу нь хөрч нэн нойтон болно, хошуугаа далан дээрээ тавьж үе үе яраглах зэрэг шинж үзүүлнэ. Урьд хоёр хөлөө жийж, хойшоо өнхөрч ойчих болно.

Ийнхүү өвчилсөн төлийн ходоодыг гадна талаас нь тэмтэрч үзэхэд ходоод дотор нь нэг буюу хэд хэдэн хатуу бөөн зүйл тэмтрэгдэнэ.

Эмчилгээ: Уураг зангирах явдал хүнд өвчин бөгөөд барагтайд засал авахгүй үхэх аюултай учир бог малын төлийн хөхсөн уураг зангирахаас сэргийлэх ажлыг байнга тогтмол зохиох хэрэгтэй. Уураг зангирахаас сэргийлэх гол арга бол төл гарсан даруйд халуун бие дээр нь дааруулалгүй- амлуулж байвал цаашдаа хөхсөн уураг нь бараг зангирч бөөгнөрдөггүй болно. Түүнчлэн төлд элгэвч нэмнээ уяж ходоод гэдсийг дулаан байлгах нь өвчнөөс сэргийлэх арга болно.

Төлийг удаанаар хэвтүүлэхгүй байх, тогтмол цагаар хөхүүлэх, байранд нар салхи оруулах зэрэг ажиллагаа нь энэ өвчнөөс сэргийлэхэд тустай юм. Зангирсан уургийг гадна талаас нь зөөлөн барьж задлах, бутлах, уураг сүүг сойх, архи, сармис, сонгины ханд ходоодны шүүс өгдөг, Уураг зангирсан тохиолдолд малын эмч нарт мэдэгдэж, зохих эм өгөх, ходоодонд хагалгаа хийж зангирсан уургыг авах арга хэмжээг авахуулбал ихэнхийг эдгэрүүлнэ.

ХУРГА, ИШИГ ХАРАНГАДАХ

х

Хөрвөжсөн хурга ишиг татаж ойчих, хэвтэж босох, ахин дахин татаж ойчно. Ийм хурга ишгэнд нэг аяга ус өгөхөд (цутгахад) зүгээр болно. Цаашдаа төлийн байранд давс, хужир, шүүгээр амталсан ус тавьж өгөх, эх нь жилбэтэй эсэхийг шалгаж саамшуулах хэрэгтэй.

ХУРГА, ИШИГ ХАТГАЛГА ТУСАХ

х

Дулаан байр, пүнзнээс төлийг гэнэт гадаа хүйтэн жавар салхинд гаргаж салхинд цохиулах, дааруулснаас хатгалгаа тусна. Мөн төлийн байр, пүнзний нүх сүвээр хүйтэн салхи сийгэснээс болж хатгаа авч уушиг нь үрэвсэнэ. Түүнчлэн шарлаж нунтгарсан бууцтай байранд удаан байснаас болж бог малын төл уушиг өвчлөх явдал тохиолдоно.

Шинж тэмдэг: Хатгалга туссан хурга, ишиг гэнэт халуурах, амьсгаа нь давхцаж гэдэс нь бүлхэлзэж байна. Уушгинд гэм суусан хурга, ишиг нь явах хөдлөх нь удаан эрүүгээ газар тавьж, хүзүү сунган хэвтэнэ. Эхээ хөхөхдөө дурамжхан болно. Эхэд нь хөхүүлэхэд сөхөрч чадахгүй эсвэл сөхөрч босоод байдаг.

Эмчилгээ: Уушгинд гэм суусан хурга, ишгэнд ганга өвс, царван, агь, шар мод, улаан өвс, нохойн хошуу, нарсны шилмүүс, аньс, чихэр өвс, хонхолцог өвс зэргийг хандалж цутгаж өгнө. Мөн арц, гангаар утаж болно.

Хурга, ишиг хатгалгаа авч амьсгал давхцаж байгаа үед хоёр хааг хатгаж эмчилнэ. 2-3 дусал цус гарна. Мөн хатгалгаа туссан даруйд хайрцагт халаасан элс хийж элсэн дээр нь даавуу тавьж дээр нь хурга ишгийг хэвтүүлж хучихад хурга, ишиг ихэд хөлрөх бөгөөд 2 цаг орчмын дараа босож ирнэ. Хатгалгаа туссан хурганы туулай хамрыг сэтлэх засал хийнэ.

ШӨВӨГ ЯР

х

Ямааны шөвөг яр, амрууг урьдаар аманд гарсан яр шархыг хусаж, цус гаргаад орой хэвтүүлсэн тэмээг өглөө шээхэд тосож аваад бүлээн дээр нь ямааны хошууг дүрж сойлдон 1-3 хоногийн завсартайгаар 2 удаа угаахад бүрэн эдгэрнэ.

Аль болох шорвог хар цайгаар шавшина. Давс нунтаглаж хөө, тостой (бараг ижил хэмжээтэй) хольж халуунаар нь түрхэж болно.

Амруутсан ишгийг хадны хагаар угаах сайн нөлөөтэй.

ОРОНГОТОХ

х

Энэ өвчний зарим нутагт горинго, оринго гэж нэрлэнэ. Гол газар зусаж ихэвчлэн гол газар төллүүлсэн бог малын хурга, ишиг хөрвөжиж, хурга сүүллэж эхлэх 7-8 сард хурга, ишгэнд оринготох өвчин тохиолдоно. Хар ус нуурын голд бараг жил тойрон байсан 5 суурийн мал зүгээр төллөсөн боловч 4, 5, 6 сард эдгээр суурийн хурганд оринготох өвчин тусаж ихэнх төлөө үхүүлж байсан удаатай.

Гол шинж тэмдэг нь хурга, ишигний хойд хөл мэдээгүй болсноос бөгсөө чирч урьд хөлөөрөө бөгсөн биеээ чирч, тойрч дугуйлах хөдөлгөөнтэй болно. Идэх уух нь хэвийн боловч бөгсөн бие нь хатингар болно. Зарим жил гарахгүй, суурь бүрд ч тохиолдохгүй. Ийм өвчтэй хургыг нядалж идшинд хэрэглэдэг байжээ. Зарим малчдын ярианаас үзэхэд оринготох өвчин туссан хурганы ууцны арьсыг ярж зэсийн цэнхэр хийдэг гэж өвгөд дээдэс ярьдаг байсан гэсэн мэдээ байна.

ХҮРД

х

Өвөл, хаврын улиралд хүрд шимэгчилсний улмаас бог мал тарга хүчээ алдаж, тураалын үхэлд нэрвэгдэх аюултай юм. Хүрд 10, 11 сард өтөг бууц бэлчээрээс бог малд асаж шимэгчилнэ. Хүрд ихтэй хот бууцанд бууж, урьдчилан сэргийлэх эмчлэх ажил хийгээгүйгээс хонио олноор тураалаар үхүүлж байсан тухай мэдээ бий.

Эмчилгээ: Малыг намар өтгөн бууцан дээр хэвтүүлэхгүй байх, өвөлжөөнд хүйтэрсэн үед буухад мал хүрдтэх нь бага байна. Хүрд ихтэй нутагт, өтөг бууцыг газарт нь хүртэл малтаж зайлуулна. Хүрд ихтэй өтөг бууцанд адуу оруулж, хэд хэдэн удаа гишгүүлж, бууцыг сэндийлэх үед хүрд бужигнан гарч ирдэг бөгөөд энэ үед дуст цацах, май тавьж утах зэргээр бууцны хүрдийг устгах, арилгах арга хэмжээ авна.

Хүрд малын биед асахаас сэргийлэх, нэгэнтээ ассан хүрдийг устгахын тулд халуун бүлээн аргалын үнсийг бог малын биед түрхэхэд хүрд асах нь бага бөгөөд ассан хүрд нь хатаж үхдэг байна. Мөн тарваганы халуун тосыг малын хоолой, цавь, суга, нурууны үсний ёроолд өнгөц түрхэж хүрдээс эмчлэн сэргийлдэг байна.

Дүстийг цэврээр нь малд түрхэхэд үс зунгаггүй, ноос хатаж, мал тэжээлдээ дургүй болж хордох шинжтэй болдог. Ийм учраас 3 кг дустыг 1 кг аргалын үнстэй хольж түрхэхэд Дээрх сөрөг үзэгдэл тохиолддоггүй байна.

Хотон дотроо болон хотны эргэн тойрон май тавих, хөрзөн шатаах, хөө тортог болсон дээврийг хотон дотуураа чирэх, сэгсрэх зэргээр хүрдийг арилгах арга хэрэглэдэг ажээ. Ховд аймгийн Мянгад сумын хоньчин Л.Нацагдорж тус сумын Зээрэн нуурын усанд хүрд баараггүй үхдэг гэж мэдээлж байна.

Хүрдийг атга атгаар түүж хонинд өөрт нь өгдөг байсан нь сэргийлэх нэг арга байжээ. Хотон дотроо түмпэн дотор аргал хөрзөн шатааж гал тавихад хүрд орж үхдэг. Мөн хотон дотроо цагаан даавуу дэлгэж тавихад түүн дээр хүрд олноороо цуглах үед хамж устгах арга хэрэглэдэг ажээ.

САРЛАГИЙН ТУГАЛ ХӨӨРГӨДӨХ

х

Ямар ч насны тугалд зун, намар тохиолдоно. Хөөргөдсөн тугал сул дорой болж тарга хүч, өнгө зүсээ алдаж зовууртай зогсдог. Байн байн өөг өөг гэж дуу алдана. Ийм эмгэг туссан тугалд шар тос хоолны халбагаар өдөрт 2 удаа тэнхэртэл өгөхөд сайн (Ш.Долгор).

ХУРГА, ИШИГ БОГОРГОНТОХ (БОХИРОГДОХ)

х

Зарим газар мунжирах гэж нэрлэнэ. Хурга, ишгэнд эхээс гарснаас хойш нэг сарын дотор буюу өвсөнд орох үед илэрч голдуу өвдөг нь хавдана. Хөлөө тэнийлгэхгүй босож чадахгүй мөлхөж явж идээшилнэ. Хэвтэх нь их болно.

Хавдар нь хагарахгүй, аяндаа татарч алга болно. Чийгтэй, хүйтэн хэвтэрт байснаас үүсдэг гэж үздэг.

Эмчилгээ: Хөлийн хавдрын дээгүүр улаан утсаар хэт чацга бишээр уяж засал хийдэг. Малын яс шатааж нунтаглаад бага зэрэг хужиртай хольж зоодой хийж долоолгох буюу усаар зуурч амны халбагаар өдөрт 3 удаа өгч эмчилгээ хийнэ. Мөн нохойн үс, хялгас томж зүүнд сүвлээд хавдсан өвдгийн арьсан доогуур сүвлэж орхиход зүгээр болдог гэнэ. Мөн давхар шүдтэй хүн хавдрыг хазаж домнодог байжээ. (Б.Загаржав).

ЯМААНЫ ХАЧГИЙН ХАЛУУН

х

Ховд аймгийн Зэрэг сумын ямаачин, Монгол улсын аварга малчин Түдэвийн Бэгз 24 жил ямаа дагнан маллаж ирэхдээ ямаанд хачгийн халуун өвчин тохиолддогийг анзаарсан байна. Ямар ч насны ямаа хачиг бууж буй үед 3-4 сар халуурч тэжээлдээ дургүй болж, хоёр чих нь бууна. Нүд нь нуухдана, ам нь халуун байна. Биеийн халуун 39-40 байдаг. 3 дугаар сард хүндээр халуурах бөгөөд 4 сард арай бага халуурна.

Эмчилгээ: Газар үс өвсийг хайчилж нунтаглаад чүдэнзний хайрцаг хиртэй 500 мл усанд буцалгаж хар цай мэт болгоно. Үүнээс 100-200 мл-ыг өдөрт 2 удаа өгнө. Ямаанд цагаан өвс өгдөг. Тэжээлийг бага багаар өгч тэнхрүүлнэ. Ногоон өвс малын халуунд муу гэж үздэг байна.

Хэрэв сайжрахгүй бол шар тос цайны жижиг халбагаар өдөрт 1-2 удаа өвчний байдлыг харгалзан 2-3 өдөр дараалан өгнө. Их халуунтай ямаанд хэвтэрт нь нэг жижиг сонгино (том бол хоёр хувааж) өгнө. Ямаа дуртай иднэ.

Хонины хачиг түүж иддэг учраас ямаа бараг хачигдаггүй гэж Л.Ишдорж үздэг.

ТУГАЛ ДЭЛҮҮТЭХ

х

Энэ өвчнийг зарим нутагт тугал булчирхайтах гэж нэрлэнэ. Тугал гэнэт өвчилнө.

Шинж тэмдэг: Тугал зарим үед бяруу аль ч улиралд өвчлөх бөгөөд өвчилсөн тугал хойд хөлөөрөө ээлжлэн тийрэх, түргэн түргэн хэвтэж босох, их тогтворгүй болж их зовууртай болно. Сүүлээ ихэд хөдөлгөн эргэж харна.

Зарим малчид булчирхайтсан тугал удаан хугацаагаар чацга алдаж арьс, яс болж нүд ширгэх шинж үзүүлдэг гэж мэдээлж байна.

Эмчилгээ: Тугалын цавины нимгэн арьсан дотор хонины шагайн хиртэй булчирхай тааралдана. Түүнийг бахиар (урьд шүдээрээ) бяц татна. Эрүүл тугалын цавины энэ булчирхай цавины нимгэнээс нилээд дээгүүр хонины хорголын хиртэй байдаг.

Бяруу тугал дэлүүтвэл сүвээний гурван хавирга оруулан нуруунаас нь доош нэг алга дарам газарт дээрээс нь шөвгөөр 2 хуруу гүн хатгана.

ҮХРИЙН ХОРХИРОО

х

Үхрийн төвөнх, эрүү, багалзуур хавдана. Амаа ангайлгаж хихнаж, амьсгаадаж ядна. Хамар нь хатна. Тэжээл идэхгүй болж ямар ч улиралд ямар ч насны үхэр өвчилдөг. Заримдаа хэд хэдээрээ зэрэг буюу цуварч өвчилнө. Чацга алдана. Урьд бол өвчилсөн үхрийн гол нь хөлдсөн гэж үздэг байв.

Эмчилгээ: Хоолны нэг халбага бор давсыг 1 шил усанд найруулж, өдөрт нэг удаа эдгэртэл нь цутгаж өгнө. Хэлний доод талын ил судсыг хатгана (Ж.Дугаржав). Мөн .хавдар тушаа 3 см гүн нарийн хутгаар хатгахад эхлээд ягаан шүүс, дараа нь тунгалаг ус мэт зүйл нэвшин гоожно. (Ж.Бараадий)

ДУУТ ХАВДАР

х

Дуут хавдар туссан үхрийг шагтав өвсний хандаар эмчилдэг. Шагтав өвсний үндсийг хатааж нунтаглаад түүнээс цайны нэг халбагыг 250 мл усанд хандалж, хандыг үхэрт дотуур өгч шаараар нь хавдрыг шавшина. Өдөрт 2 удаа 5-6 өгөхөд эдгэрнэ. Эмчилсэн үхэр (бяруу) орой нь зүгээр болсон байдаг.

Энэ аргаар Увс аймгийн Өндөрхангай сумын малын их эмч Д.Цэрэнжаа, С.Батдорж, бага эмч Ж.Мундагар нар хоёр литр усанд нэг атга шагтав хийж паалантай саванд буцалгаж хандлаад дуут хавдар туссан үхэрт 500 гр-ыг өдөрт 2 удаа дотуур өгч эмчилж байжээ.

Шагтавын хандыг битүү буглаатай малд өгөхөд уг хавдар нь түргэн эдгэрдэг байна.

ҮХЭР ХӨРӨВСӨГДӨХ

х

Толгой нь хавдана, нүд нь бүлтийнэ, хошног нь хавдана. Ийм өвчтэй үхрийн толгойг юмаар битүү хучиж нөмрөөд түмпэн дотор цог хийж түүн дээр тос өөх тавьж хиншүүгээр нь үхрийн хамрын толь хөлөртөл нус шүлс гоожтол утна. 1-2 өдөр услахгүй байлгасны дараа бүлээн усаар усална. (С.Дашзэвэг)

ШИДРЭХ

х

Энэ эмгэг туссан үхрийн үс халцарч арьс нь битүү улайна. Тохиолдсон юм бүхэнд биеэ шөргөөнө.

Эмчилгээ: Лантанз өвсний хандаар гаднаас нь 3-аас доошгүй шавшина. Үхрийн яс, махны шөлөнд лантанзын бүтэн хагас буурцаг буцалгаж дотуур өгнө.

ХОНИНЫ ХАМРЫН ГУУР

х

Хонины хамар, дух, эврийн хөндийд гуурын авгалдай орж шимэгчилснээс энэ эмгэг үүснэ. Заримдаа уураг тархийг гэмтээх явдал ч тохиолдоно.

Шинж тэмдэг: Хамрын хөндийгөөс идээ бээр гоожих, ханиах, амьсгал нь бэрхшээлтэй болж шуухитнана. Хамрын салст бүрхүүл үрэвсэж улайж хавдана. Хонь эцэж турна.

Эмчлэх, сэргийлэх: Хонь хамар гууртахаас сэргийлэхийн тулд хавар яргуй хөөлгөх, хужир мараатай газар салхины уруу тууж хонь найтаалгаж хамрын гуурыг унагаах арга хэрэглэж иржээ. 19-р зууны сүүлийн хагаст То вангийн бичсэн сургаалд "... халуун болох хирд хужиртай газар хонийг салхи уруу хөлөртөл хөө. Хамрын хорхой унаж хурдан таргална ..." гэсэн байдаг. (Ш.Нацагдорж).

НҮДНИЙ ӨВЧИН

х

Малын нүд улайж өвчлөн нулимс гоожиж нуухтана. Хүндэрвэл нүд цэхэртэж, хараа муудан зарим тохиолдолд үүл сууж сохордог.

Эмчилгээ: Нүд өвчлөхөд дараах уламжлалт аргуудын аль нэгийг хэрэглэн эмчилдэг байна. Үүнд:

-Нүд нь өвчлөн үүл тогтсон, юм харахгүй болсон малыг унагааж амыг ангайлгаад, тагнайн голын үеийн хажуугийн хоёр суваг нүхэнд төө хиртэй адууны цагаан хялгас, зөөлөн дэрс, хялгана өвсийг сүвлэж 5-7 хоног байлгана. Хэлэнд торж гаргаж хаяулахгүйн тулд өвсний илүү гарсан үзүүрийг хайчилж авна. (А.Цээрэг)

- Хонины зүүн нүд өвчилбөл зүүн хаанаас ноос авч, зүүн чихийг сүвлэнэ. Энэ тухай домын сударт ч заасан байдаг.

- Ямар ч малын нүд үрэвсэж эвэрлэг бүрхүүлд үүл сууж, дайсан байвал ранжин (цэвэр) зэсийг нарийн хуурайгаар үрж гарсан нарийн үрдэснээс нэг чимх авч нүдэнд нь хийхэд үүл аяндаа

арилна. (Домын судар . Н.Даш). Засрахгүй бол нүдний- ухархайд лугшиж байгаа судас ханана. (С.Цагаанөвгөн).

Үүл суусан нүдэнд исгэлэн тараг буюу ёотон давс нунтаглаж, нүдэнд хуурай глюкоз, ёотонг маш сайн нунтаглаж өдөрт нэг удаа 3-5 өдөр

дараалан цацаж эмчилнэ.

- Архангайн Цэцэрлэг сумын Дөрвөн нуурын хужрыг малын нүдний үрэвсэл, цайсан нүдэнд хийхэд түргэн хугацаанд эдгэдэг ажээ.

- Нүд өвчилж цайх үед хар модны нүүрс, сахар хоёрыг адил хэмжээгээр бага багаар өдөр өнжиж хийхэд 7 хоногт засал бүрэн авна.

- Малын нүд өвчилж эвэрлэг бүрхүүл нь бүрэн цайсан үед буцалгасан бүлээн усанд мохоор тамхи дэвтээж, шүүсийг нь нүдэнд дусааж болно.

- Өвдсөн нүдэнд тарваганы тос хийхэд сайн.

- Өвчилсөн нүдэнд тогооны хөө, хус, хар модны нүүрсийг сахартай хольж хийж эмчилдэг.

- Улайж эвэрлэг бүрхүүл цайж юм харахгүй болсон тохиолдолд нүд рүү нь тамхины утаа үлээх, хүн шүдээ чигчилж цус гаргаад цустай шүлсийг малын өвчтэй нүд рүү 2-3 тургихад эдгэрэх тал бий. (Д.Балтуу)

Хонь, ямааны өвчилсөн нүдэнд нарс модны нүүрсийг шунхтай хольж хийхэд тус болохгүй бол тагнайн нүхэнд адууны хялгас сүвлэнэ. Ямааны нүдэвд хонины, хонины нүдэнд ямааны сүү дусаахад сайн. (Н.Бямба 1944)

Дээрх эмчилгээ тус хүргэхгүй бол нүдний ухархайн хонхорт лугшиж байгаа судас, мөн тагнайн 3 дахь үеийг ханана.

-Хонь ямааны нүд өвчлөхөд хоёр чамархайг тэвнээр ханах засал хийнэ.

- Адууны нүд өвчлөхөд нүдний ар талын сэнж ясны гол дахь нүхэн тушаа судас (толгойг сайн тонгойлгоход гүрийж тод болно) ханана.

- Ботго, торомны нүд өвчлөхөд овооны ясан дээгүүр явсан хоёр судасны уулзуур дээр ханана. Толгойг тонгойлгоход тэдгээр судас гүрийх бөгөөд цус гаргахын тулд толгойг тонгойлгоно, толгойг өргөхөд цус тогтоно. (Эс.Бумцэнд)

ДЭЛЭН АЙХ

х

Малын дэлэн бүхэлдээ буюу -ихэвчлэн нэг талын хэсэг нь чинэрэн хавдаж, халуун болсон байна. Саалгахгүй, төлөө хөхүүлэхээс эмзэглэдэг.

Эмчилгээ: Дэлэн өвчилж эхэлж байгаа үед дэлэнгийн урьд талаас очсон хоёр судасны өвчилсөн талын судсыг дэлэнгээс 2-3 хуруу хиртэй зайд ханаж 100-200 мл цус авахад зүгээр болно. Хэрэв 24 цаг болсон бол тус болохгүй. (Ц.Чойжилжав)

Зарим малчид дэлэнгийн ар талын ховил дотор байгаа судсыг дэлэнд ойролцоо хатгадаг. (Ц.Гэндэн)

Түүнчлэн малын дэлэн айхад хэлэхгүй авсан ихэр хүүхдийн ооймс, хувцсаар буюу гуулин шанага, сангийн бойпор, бууны ам, гартаам хөөрөп мөн ямар ч хамаагүй шанагыг ууранд халааж 2-3 илж дөмнөдог. Бас ямар ч малын дэлэн айхад сохор хар цох нэгийг өгөхөд зүгээр болдог гэдэг.

ТӨРӨЛТИЙН ХҮНДРЭЛТЭНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ

х

Хээлтэгч мал хэт эцэж туран тамирдах, том төл гаргах, анх төллөж байгаа мал, төлийн хэвийн байршил гажигтай болох, малын, аарцаг гэмтэж бэртсэн, эхийн дотор төл нь үхэх зэрэг шалтгаанаас хээлтэгч малын төрөлт хүндэрнэ.

Шинж тэмдэг: Хэвийн төллөж байгаа бол гүү хагас цагт, үнээ 1-3 цагт, хонь ямаа 1-2 цагт төллөх ёстой. Хэрэв дурдсан хугацаанд төллөж чадахгүй байвал төллөлтийг хүндрэлтэй гэж үздэг. Төллөлтийн хүндрэлтэй болсон мал удаанаар хэвтэж дүлнэ. Ус нь гарсан боловч төл нь гарахгүй буртаг гоожих зэрэг шинж үзүүлнэ. Төллөж байгаа малд дээрх хүндрэл тохиолдсон нөхцөлд тусламж үзүүлнэ.

Арга, засал: Төрөлт нь хүндэрсэн малд тамир оруулахын тулд чихэртэй өтгөн хар цай, шар тостой нэрмэл архи цутгаж өгвөл тамир орж дүлэлт нь сайжирна. Төлийн толгой, хөл нь гарсан боловч гаргаж чадахгүй байвал зөөлөн зугуухан дүлэх үеийг тааруулан татах хэрэгтэй.

Төлийн байршилт буруу байвал түүнийг засах арга хэрэглэнэ. Үүний тулд эх малын савны амсар, салтаа, сүүлийг савантай усаар угааж цэвэрлээд туслах хүн гараа угааж ариутгаад, төлийн буруу байршилтайг засахажиллагааг үйлдэнэ.

Хэрэв бод малын төлийн толгой хөл нь саван дотроо эргэж нугарсан байвал түүнийг засахын тулд сав руу нь гараа оруулж дүлэхгүй байх үед нь төлийг цааш нь түлхэхийж, төлийн толгойг нааш эргүүлэх хэрэгтэй.

Хэрэв ийнхүү бод малын төлийн буруу байршлыг засаж чадахгүй бол гурван шургааг модны үзүүрийг бат бэх холбож цах босгоод, төллөх- малынхаа бөгсөн биеийг оосорлож, бэлтгэсэн

цах модноосоо дүүжилж, өндийлгөсний дараа саванд нь гараа оруулж, дүлэлтийн хоорондох хугацаанд хээлийг цааш нь түлхэж, төлийн нугарсан толгой, хөлийг цааш нь харуулах засалыг зугуухан хийнэ.

ХАГ СААТАХ

х

Өвчин эмгэггүй, хэвийн байдлаар төллөсөн гүүний хаг 1 цаг, үнээний хаг 6-8 цаг, эм хонь, ямааны хаг 2-6 цагийн дотор унах ёстой. Хэрэв энэ хугацаанаас хэтэрвэл хаг саатлаа гэж үздэг. Хаг саатахыг хаг түдэх, хорогдох гэж нэрлэдэг. Хагыг үнээнийхийг хаг, гүүнийхийг судас, хонь, ямааныхыг оог гэж ялгаварлан нэрлэдэг ч тал бий.

Үнээ, хонь, ямааны хаг товчлууртай учир саатах нь харьцангуй элбэг. Харин гүүнийх товчлуургүй учир хаг саатах нь ховор тохиолдоно. Хаг саатахад ямаа, гүү маш эмзэг бөгөөд хялбар хүндрэл үүсч, өвчилж үхэх нь нилээд тохиолдоно. Мөн ихэр буюу хэт том төл гаргах, хэт хөгширснөөс болж савны агшилт удааширснаас хаг саатаж болно.

Өвөл хавар эцэж турж онд орсон, өлсөж ядарсан хээлтэгч малд хаг сааталт илүүтэй тохиолдоно. Хаг сааталт бурцеллез өвчний улмаас үүссэн байж болох учир хаг саатсан малд тусламж үзүүлэхдээ ариун цэврийн шаардлагыг сахих хэрэгтэйг байнга анхаарах шаардлагатай.

Шинж тэмдэг: Хаг саатсан үнээ нуруугаа хотойлгох, хойд хоёр хөлөө алцайж зогсох, биеэ хурааж бээцийх, байн байн дүлэх шинж үзүүлнэ. Гүүний хаг саатахад хэвтэж босох нь олширч, явахдаа алцганах бөгөөд их удвал босож чадахгүй болж, хөлбөрч тийчилнэ.

Ямааны хаг - саатвал их эмзэглэх бөгөөд хотолзох, алцганах, суниахаас гадна хэвтэж, дүлэх бүрдээ орилно. Хаг нь саатсан хонинд онцын шинж тохиолдохгүй бөгөөд хонины хаг унасан эсэхийг шалгаж байвал зохино.

Хаг саатахаас сэргийлэх, саатсан үед дараах аргуудын аль нэгийг буюу хослуулан хэрэглэж болно.Үүнд:

Хаг саатахаас сэргийлэхийн тулд мал төллөж байгаа үед үргээх, цочоохгүй байх нь чухал. Түүнчлэн төлийн үсийг хаттал удаан тайван эхэд нь сайтар долоолгох явдал эх малын хаг саатахаас сэргийлэх байгалийн нэг зохицолдоо болно.

Мал төллөхөд, эрүүл малын хээлийн усыг цэвэр саванд авч өөрт нь б&г малд 500-1000 мл, бод малд 1,3 литр уулгах хэрэгтэй. Хээлийн усыг сэрүүн газарт 1-2 хоногоос илүү хадгалж болохгүй. Харин нэг малын хээлийн усыг өөр малд уулгах нь бруцеллез зэрэг халдварт өвчин тараах учир аль болохоор цээрлэх нь чухал.

Саатсан хагыг унжиж байгаа хэсгийг борвины дээгүүр хайчлан цусыг гоожуулах нь хаг унахад дөхөмтэй болохоос гадна мал хагаа гишгэж татуулснаас болж саваа урж гэмтээхээс сэргийлэх арга болдог.

Эх малд өөрийн гал уургыг усаар шингэлж цутгаж өгөх буюу 7,8 сард түүж хатаасан цагаан мөөгийг, бог малд 10-16 грамм, бод малд 30-50 граммыг нэг литр усанд хандалж өгөхөд хаг саатахаас сэргийлдэг.

Үнээний хаг саатахад хадны дүмбэрээ, согоон чих, халгайн үндэс хандалж өгөхөд сайн.

Хаг нь саатсан үнээнд туулай, чандаганы 60-100 гр хиртэй хорголыг 200-250 мл бүлээн усанд хандлаад үнээнд цутгаж өгөхөд хаг нь амархан унадаг гэдэг.

Үнээнд хөх дэрсний үндэс чанаж хандлаад нэг литр өгөхөд хаг унахыг түргэсгэнэ.

Хаг нь саатсан халуурсан малд могойн гуужиж унасан хальснаас бог малд хумсны нэг толины хиртэйг, бод малд хумсны хоёр толины хиртэйг 100 мл усанд буцалгаж өдөрт нэг удаа өгдөг.

Үнээ, бог малын хаг саатахад буруу талын чих рүү нь хүйтэн ус хийдэг. Дээр үед тахилын хүйтэн цай хийдэг байжээ.

Хагнаас сүүжний хувхай яс дүүжлэх буюу хоёр савх модоор унжсан хагыг хавчиж эрч эрчлээд тавьдаг бөгөөд ийнхүү эрчилсэн эрчилгээний эрчийг байн байн чангалж хагыг унагаах засал хийнэ.

Хаг нь саатсан үнээнд 2 литр усанд атга юмдүүжин (жавхаалаг башир) хийж, 1 литр болтол ширгээж, хөргөөд өгнө. Хаг унахгүй бол 2-3 удаа өгч болно. (О.Цэрэндэжид)

Хаг нь саатсан үнээ, бог малын олон ясны уулзвар дээр маш халуун (бараг буцалмал) шар тосыг дусааж хагыг унагаах арга ч хэрэглэдэг.

Үнээ, гүүний хаг саатахад хүзүүг нь бүсээр арай боож үхэхээргүй боож хаг унагаах засал хийдэг

Бод малын хаг саатахад жижиг аяга арцыг том шанага усанд буцалгаж, нэг жижиг аяга өгөх ба хаг унахгүй бол 2-3 өгдөг.

Дээрх аргуудыг хэрэглэхэд хаг унахгүй бол малын сав руу угааж цэвэрлэсэн гараа оруулж, наалдсан хэсгийг хуруугаараа их зөөлөн урж салгах арга хэрэглэнэ.

Хаг нь саатсан малд дээрх аргуудын аль нэгийг гар доор байгаа материалыг хэрэглэн дангаар буюу хэд хэдэн аргуудыг хослуулан хэрэглэхэд харшлахгүй бөгөөд мал хүндэрч халуурах, идээтэй буртаг гоожих зэргээр сэдэрч хүндэрвэл мал эмнэлгийн тусламж авах хэрэгтэй.

Хаг саатсан, савны үрэвсэлтэй, буртаглах, дотор халуунтай үнээнд юмдүүжин (жавхаалаг башир) 3 хуруу чимх хиртэй 200 гр усыг паалантай саванд хандалж өгнө. Мөн 3 хуруугаар, 2 чимх алтан гагнуурыг нэг литр усанд буцалгаж, бод малд 500 граммаар өдөрт нэг, бог малд 3 хоолны халбагаар өгч эмчилдэг.

Увс аймгийн Зүүнхангай суманд хаг саатсан халуунтай чацга алдсан, дотрын халдваргүй өвчтэй малд Хөнхийн рашаан "гиван" 0,5-2,0 литр хүртэл (өвчний хүнд хөнгөн малын том жижгийг харгалзан) өдөрт 3 удаа 2-3 хоног өгч эмчилгээ хийдэг байна.

Хаг саатсан тохиолдолд үзүүлэх эмчилгээ, сувилгааны дараах бололцоотой аргуудыг ашиглана. Үүнд:

Хаг нь саатсан малд тэнхээ тамир оруулах зорилгоор бод малд 200-500 гр, бог малд 25-50 гр сахар усаар найруулж, өдөрт 2 удаа 6 цагийн зайтай өгвөл сайн.

Төрөлтийн хүндрэл болж халуурсан малд 100 гр мөөгийг 1 литр усанд буцалгаж, бод малд нэг удаа, бог малд хоёр хувааж өгөхөд халуун буурч тэжээлд ордог.

БАЯН САВ УРВАХ

×

Хээлтэгч мал ихэр буюу хэт том төл гаргах, эцэж турах, төлийг хүчтэй татаж, гаргах зэрэг шалтгаанаас баян сав урвана. Ингэ, бог малын сав гарах нь илүүтэй тохиолдоно.

Эмчилгээ: Урвасан баян савыг марганцын шингэн уусмалаар сайн арчиж угааж цэвэрлээд дотогш нь аажим түлхэж оруулна.

Сав нь гарсан малын бөгсөн биеийг газрын өөд харуулан зогсоох буюу хэвтүүлнэ. Эсвэл малаа хэвтүүлж, бөгсөн бие доор нь юм тавьж өндөрлөнө. Ийнхүү савыг дотогш оруулсны дараа охин бөгсний амсар дээр малын хувхай аман хүзүүний яс тавьж бооно.

Хэрэв мал дүлж урвасан савыг буцааж оруулахад бэрхшээлтэй байвал 1-2 аяга монгол архи цутгаж өгвөл дүлэхээ больж савыг дотогш оруулахад хялбар болно.

Дотогш оруулсан сав дотор нь хурц ирмэг үзүүргүй бөөрөнхий жижиг мөс хийж хавдах үрэвсэхээс сэргийлнэ. Мөн шуудайд 10-15 кг орчим шороо хийж ууцан дээр нь тохож хүйтэн жин тавьж болно.

Дээрх арга хэрэглэхэд сав дахин урваж гараад байвал бог малын нойтон давсаг үнээний сав дотор хийж, хий үлээгээд савыг тэлж урваж гадагшлахаас хамгаална. Давсагны оронд гар бөмбөгний дотуур хамер урвасан саванд хийж хий үлээж дүүргээд орхиж болно. Ийнхүү хийгээр дүүргэсэн давсаг, хамерийг нэг хонуулаад хийг гаргаж татаж авна.

Савыг буцааж оруулан хувхай аман хүзүүний яс тавьж боохын зэрэгцээ малын цавиар нь бүслүүрдэж сайн бооход сав нь дахин гарахгүй болдог тал бий.

Сав нь урваж бохирдсоноос шалтгаалан мал халуурах сав нь үрэвсэх, идээ, буртаг гоожих Оуюу савыг нь эргүүлэн оруулж чадахгүйд хүрвэл малын эмч нарын тусламж яаралтай авах нь чухал.

ӨТӨХ

×

Малын арьс ямар нэг шалтгаанаар шархлах, шалбарах, хөлс, шээс баасанд нурах зэрэг нь мал өтөх шалтгаан болно. Ийм учраас зуны улиралд мал бүрийг ажиглаж өтөж байгаа эсэхийг шалгаж байвал зохино. Өтсөн мал дороо дэвхцэх, мод, хад, тэрэг шөргөөх, өтсөн газраа хазах, Маажих, цавчих, дэвсэх байдал үзүүлнэ. Өтсөн малыг даруйд нь илрүүлж эмчлэхгүй бол үхэж хорогдох төдийгүй малчдын ажлыг их хүндрүүлдэг өвчин юм. Ихэнх малын өтсөн шархыг юуны өмнө угааж цэвэрлээд өтийг бүрэн түүх хэрэгтэй. Хонины сүүл, адууны өтийг цэвэрлэхгүйгээр арилгах арга ч бий.

Өт малын биеийг хөндийлөн идэж, гүнзгий яргасан, түүхэд бэрхшээлтэй болсон байвал. шархыг хэсэг зуур нойтон хөвөн даавуугаар агаар хий орохгүйгээр бөглөхөд өт нь наашаа гарч ирдэг учраас түүхэд хялбар болно. Өтөх үед шархнаас цус гардаг учраас байн байн угааж өтийг түүнэ.

Ийнхүү өтийг бүрэн түүж хаясны дараа дахин өтөхөөс сэргийлэхийн тулд тогооны хөө, үнсийг тостой хольж шарх, түүний эргэн тойронд түрхэнэ. Давс хийж шархыг эгшээнэ. Мөн тосгүй хөө, дагш, арц, зээргэнийг нунтаг шарханд цацаж шархны эргэн тойронд тарваганы тос, креолин зэрэг өтний эсрэг үйлчилгээтэй уусмал түрхэж, ялаа сууж өт хаяхаас сэргийлнэ.

Өтөж шарх нь хүндэрсэн малд доогуур нь түлэгч өвс, тарнын ханд өгвөл шарх эдгэрэх нь түргэн байдаг.

Малын чив өтвөл чивний өтийг унагаахын тулд чив нь далд орохуйц гүн усанд зогсоох арга хэрэглэнэ. Өтсөн малд тэмдэг тавьж өдөр бүр үзэж өтийг цэвэрлэх, эмчлэх ажлыг эдгэртэл нь хийж байвал зохино.

-Бөгс нь өтдөг зуршилтай тэмээний сүүний судсыг 1,0-1,5 см гүн ханаж цус гаргахад өтөх нь бага болдог.

-Малын өтний шарханд хатаасан эвэр өвсийг нунтаглаж хийхэд амархан эдгэрнэ.

-Малын өтийг түүж, шархыг цагааны шар сүүгээр угааж, улаан тамхи нунтаглан хийхэд сайн.

-Адууны өтийг арилгадаггүй, харин адууны хомоолын цогтой нурмаар өтсөн газрыг 1 удаа жигнэхэд 5-6 хоноод эдгэрнэ. Дахин өтөхгүй. (С.Сүхээ)

Шарх эдгэрэхгүй бол шарх эмчлэх бусад аргуудыг хэрэглэж болно. Хонины сүүлийн өтийг арилгахгүйгээр өтөнд нь адууны шар хомоолын халуун нурмыг хийхэд гойд сайн эдгэрнэ. Харин хошног бусад газар нь өтсөн бол өтийг арилгасны дараа халуун нурам хийнэ. Нэг удаа нурам хийхэд үндсэндээ эдгэрнэ. (Л.Нацагдорж)

ШЭЭС ХААГДАХ

х

Тэмээ, хонь, ямаа, үхрийн шээс хаагдах нь нилээд элбэг тохиолдоно. Заримдаа адууны шээс хаагдах ч тохиолдоно. Голдуу эр малын шээс хаагдана.

Шинж тэмдэг: Шээс нь хаагдсан мал зовууртай байн байн сүүлээ өргөх, дүлэх, хэвтэх, босох, тогтворгүй болох, явахдаа сүүлээ оодойлгон өргөж, алцганах, шээсээ савируулан дуслуулах болно. Шээс хаагдаад удсан бол шалан, салтаа чив дагаж хавдах, босож чадахаа болих, халуурах болно.

Тэмээний шээс хаагдахад бөөр нь унасан үед тохиолдох зарим шинж

Тухайлбал бөөрөө чагнах, өвчний эхний үед налах, сүүл тийшээ хэвтээд босохгүй байх зэрэг шинж# үзүүлнэ. Ихэвчлэн ат буурны шээс хаагдана.

Хонины шээс нь хаагдсан бол бөгсөн биеэ даахгүй болж яраглан зовууртай хэвтэнэ.

Шээс нь хаагдсан ямаа сүүлээ өргөж дүлэх, орилох, майлах,

бөгсөөрөө савж унах зэрэг шинж үзүүлнэ. Малын шээс наана чивэндээ хаагдсан бол чив нь үзүүрээсээ эхлэн хавдах бөгөөд хэрэв цаана хаагдсан бол хавдар үүсэхгүй.

Эмчилгээ: Юуны өмнө шээс нь хаагдсан малын чивний сүвийг үзэж, хэрэв чивний үзүүрт нарийн хар бөглөө бий болсон байвал түүнийг авч хаяна. Хэрэв чивэнд бөглөө байхгүй бол чивийг илж, шувтрах шалан салтаа орчимд халуун жин тавина. Ийнхүү шээс нь гарахгүй бол барааны саванг усанд уусгаж, шингэн хярам мэт өнгөтэй болгож үхэрт 300-500 мл-ийг, тэмээнд 121,5 литр, бог малд 100-150 мл-ийг нэг удаа өгнө.

Олон ясны уулзвар дээр халуун жин тавихад шээс нь гарах тал бий. Мөн шээс нь хаагдсан малд тарваган шийр, цахилдаг, арц буцалгаж өгөх, арцаар утах, элсэн чихэр өгөхөд шээс тавигдаж болно.

Мал эцэж гүн тураалд орсноос шээс хаагдах явдал тохиолддог учир шээс нь хаагдсан малд өтгөн хар цай, мах ясны шөл өгч биеийг тэнхрүүлэх нь чухал.

Тэмээний шээс хаагдахыг шээс хадьнах гэж нэрлэдэг бөгөөд түүнийг усан хадьна, цусан хадьна гэж бас ялгаварлана. Цусан хадьна хүрсэн бол шээсний сүвний үзүүрт цус бултайсан байна. Усан хадьна хүрсэн бол дээрх шинж үзэгдэхгүй бөгөөд тэмээ ихэд дүлнэ.

Эмчилгээ: Дараах аргуудыг хэрэглэнэ.Үүнд:

-Цусан хадьна туссан бол тэмээг хэвтүүлж, олон ясны уулзвар дээр халуун жин удаан тавина.

-Усан хадьна туссан бол хоёр хасыг хатгана. (ДЛхам)

-Гар нүүрийн улаан саван байхгүй бол барааны саванг усанд хөөсрүүлж цайвар болгоод 1-1,5 литр цутгаж өгнө.

-Зээргэнэ, зэрлэг цахилдаг чанаж ногоон болгоод 1шил хиртэйг (500гр) өгнө.

-Эцэж ядарснаас болж шээс нь хаагдсан бол ясны шөл, шар будааны шүүс хэдэн литр өгнө. Мэдрэлийн системийн гажигнаас болж шээс нь хаагдсан бол ам хамрыг битүү барьж амьсгалыг боогдуулахад бие нь суларч шээс тавигдаж болно. (Д.Дашзэвэг)

Эсвэл сүүлийн үзүүрийг хазаж сэврээхэд шээс нь тавигдах тал бий. Мөн зөөлөн өвс нойтон зээргэнээр чивний сүвийг бургуйдаж болно.

-Хонины шивхийг усанд буцалгаж литр орчмыг өдөрт 1 удаа шээс нь гартал нь өгнө. Мөн гуяын хар судсыг хатгана. Уг судас гуяын ар талын дунд хирд байгаа хонхорт (эхний хуруу ормоор) 1-1,5 см гүя хатгана.

Хэрэв шээс нь гарахгүй хаалт хүндэрсэн бол чивний үзүүрээс хойш арьсыг нь 4 хуруу хиртэй хагалж, чивний цаад талаар нарийн Мод оруулан хөшиж байгаад чивийг урагш нь гараараа имэрч шумрахад шүдэнз буюу нарийн богинохон шар бүлхи гарвал шээс нь тавирдаг.

Адууны шээс хаагдвал шээс нь хаагдсан адууны насн-ы тоогоор замба цэцэг буцалгаж өгөхөд бүх биенийх нь хөлс цутгаж (хөлс .бөнжигнөж гарна) шээс тавигдана. (Ж.Даш) .

Бог мал ялангуяа төлөг, борлон, хурга, ишигний шээс хаагдахад хамар амыг барьж амь тэмцүүлэхэд. мөн сүүлний үзүүрийг хазахад шээс нь тавигдаж болно. Бог малын шулуун

гэдсээр гараа оруулах буюу гадна талаас нь давсгийг илж шээсийн хаалгыг тавиулах арга бас хэрэглэнэ.

Эр үхрийн шээс тавигдахгүй бол чивийг төмсөгнөөс урдуур тас огтолж болно. (С.Цээрэв).

ШЭЭС ХААГДАХ

х

Тэмээ, хонь, ямаа, үхрийн шээс хаагдах нь нилээд элбэг тохиолдоно. Заримдаа адууны шээс хаагдах ч тохиолдоно. Голдуу эр малын шээс хаагдана.

Шинж тэмдэг: Шээс нь хаагдсан мал зовууртай байн байн сүүлээ өргөх, дүлэх, хэвтэх, босох, тогтворгүй болох, явахдаа сүүлээ оодойлгон өргөж, алцганах, шээсээ савируулан дуслуулах болно. Шээс хаагдаад удсан бол шалан, салтаа чив дагаж хавдах, босож чадахаа болих, халуурах болно.

Тэмээний шээс хаагдахад бөөр нь унасан үед тохиолдох зарим шинж

Тухайлбал бөөрөө чагнах, өвчний эхний үед налах, сүүл тийшээ хэвтээд босохгүй байх зэрэг шинж# үзүүлнэ. Ихэвчлэн ат буурны шээс хаагдана.

Хонины шээс нь хаагдсан бол бөгсөн биеэ даахгүй болж яраглан зовууртай хэвтэнэ.

Шээс нь хаагдсан ямаа сүүлээ өргөж дүлэх, орилох, майлах,

бөгсөөрөө савж унах зэрэг шинж үзүүлнэ. Малын шээс наана чивэндээ хаагдсан бол чив нь үзүүрээсээ эхлэн хавдах бөгөөд хэрэв цаана хаагдсан бол хавдар үүсэхгүй.

Эмчилгээ: Юуны өмнө шээс нь хаагдсан малын чивний сүвийг үзэж, хэрэв чивний үзүүрт нарийн хар бөглөө бий болсон байвал түүнийг авч хаяна. Хэрэв чивэнд бөглөө байхгүй бол чивийг илж, шувтрах шалан салтаа орчимд халуун жин тавина. Ийнхүү шээс нь гарахгүй бол барааны саванг усанд уусгаж, шингэн хярам мэт өнгөтэй болгож үхэрт 300-500 мл-ийг, тэмээнд 121,5 литр, бог малд 100-150 мл-ийг нэг удаа өгнө.

Олон ясны уулзвар дээр халуун жин тавихад шээс нь гарах тал бий. Мөн шээс нь хаагдсан малд тарваган шийр, цахилдаг, арц буцалгаж өгөх, арцаар утах, элсэн чихэр өгөхөд шээс тавигдаж болно.

Мал эцэж гүн тураалд орсноос шээс хаагдах явдал тохиолддог учир шээс нь хаагдсан малд өтгөн хар цай, мах ясны шөл өгч биеийг тэнхрүүлэх нь чухал.

Тэмээний шээс хаагдахыг шээс хадьнах гэж нэрлэдэг бөгөөд түүнийг усан хадьна, цусан хадьна гэж бас ялгаварлана. Цусан хадьна хүрсэн бол шээсний сүвний үзүүрт цус бултайсан байна. Усан хадьна хүрсэн бол дээрх шинж үзэгдэхгүй бөгөөд тэмээ ихэд дүлнэ.

Эмчилгээ: Дараах аргуудыг хэрэглэнэ.Үүнд:

-Цусан хадьна туссан бол тэмээг хэвтүүлж, олон ясны уулзвар дээр халуун жин удаан тавина.

-Усан хадьна туссан бол хоёр хасыг хатгана. (ДЛхам)

-Гар нүүрийн улаан саван байхгүй бол барааны саванг усанд хөөсрүүлж цайвар болгоод 1-1,5 литр цутгаж өгнө.

-Зээргэнэ, зэрлэг цахилдаг чанаж ногоон болгоод 1шил хиртэйг (500гр) өгнө.

-Эцэж ядарснаас болж шээс нь хаагдсан бол ясны шөл, шар будааны шүүс хэдэн литр өгнө. Мэдрэлийн системийн гажигнаас болж шээс нь хаагдсан бол ам хамрыг битүү барьж амьсгалыг боогдуулахад бие нь суларч шээс тавигдаж болно. (Д.Дашзэвэг)

Эсвэл сүүлийн үзүүрийг хазаж сэврээхэд шээс нь тавигдах тал бий. Мөн зөөлөн өвс нойтон зээргэнээр чивний сүвийг бургуйдаж болно.

-Хонины шивхийг усанд буцалгаж литр орчмыг өдөрт 1 удаа шээс нь гартал нь өгнө. Мөн гуяын хар судсыг хатгана. Уг судас гуяын ар талын дунд хирд байгаа хонхорт (эхний хуруу ормоор) 1-1,5 см гүя хатгана.

Хэрэв шээс нь гарахгүй хаалт хүндэрсэн бол чивний үзүүрээс хойш арьсыг нь 4 хуруу хиртэй хагалж, чивний цаад талаар нарийн Мод оруулан хөшиж байгаад чивийг урагш нь гараараа имэрч шумрахад шүдэнз буюу нарийн богинохон шар бүлхи гарвал шээс нь тавирдаг.

Адууны шээс хаагдвал шээс нь хаагдсан адууны насн-ы тоогоор замба цэцэг буцалгаж өгөхөд бүх биенийх нь хөлс цутгаж (хөлс .бөнжигнөж гарна) шээс тавигдана. (Ж.Даш) .

Бог мал ялангуяа төлөг, борлон, хурга, ишигний шээс хаагдахад хамар амыг барьж амь тэмцүүлэхэд. мөн сүүлний үзүүрийг хазахад шээс нь тавигдаж болно. Бог малын шулуун гэдсээр гараа оруулах буюу гадна талаас нь давсгийг илж шээсийн хаалгыг тавиулах арга бас хэрэглэнэ.

Эр үхрийн шээс тавигдахгүй бол чивийг төмсөгнөөс урдуур тас огтолж болно. (С.Цээрэв).

АВХАР ХҮЙС

х

Хүйснээс элэг давсаг уруу орсон судас тасраагүйгээс давхар хүйс үүсдэг гэж үздэг. Хүйс бохирдож, халдвар орж, хүйсний судас хувилж үрэвссэнээс төл эмзэглэж бэгцийж зогсоно. Нялх төл 1-3 хоногийн дараа хүйс нь хавдаж, өмхий үнэртэй идээ бээр гоожно. Эхээ хөхөхгүй, хэвтэж амьсгал нь давхцана. Удалгүй үе мөч нь хавдана. Уушиг гэдэс өвчилж өмхий чацга алдах амьсгаадах ханиах болно. Давхар хүйстэй гарсан тугал нүд нь гөлөрсөн, сэргэлэн биш ноомой болно.

Эмчилгээ: Өвчний шинж мэдэгдмэгц давхар хүйстэй охин тугал, хургыг эхийн нуруун дээгүүр буюу хайс хорооны модон дээр шнрдэг тавьж дээгүүр нь өвчтэй тугал, хургыг 3 удаа хөрөөдөх маягаар нааш цааш татаж давхар хүйсийг тасална.

Мөн хүйс хавдаж идээлсэн бол тэр орчмын үсийг хайчилж, цайны нэг халбага хиртэй креолин буюу лизолыг нэг литр буцалгасан усанд найруулж, түүгээр хүйсийг угааж хавдсан хүйсэн дээр архи шингээсэн хөвөн даавуу тавьж, хулдаас буюу тосолсон цаас тавьж боон 30 минут орчим жигнэж эмчилгээ сувилал хийнэ.

Давхар хүйстэй гарсан эр тугал ногоон, шар усан чацга алдаад зогсохгүй эвхэрч зогсоод байх үед хөнгөлбөл зүгээр болдог.

Бог малын төлийг давхар хүйстэхээс сэргийлэхийн тулд гармагц урьд хоёр хөлөөс барьж өргөхөд давхар хүйс нь тасарч үрэвсэхгүй болдог гэдэг.

Давхар хүйстэй тугал, ботгоны өрний зүүн буюу баруун талд хүйсний урьд талд буюу авалхай мөгөөрснөөс хойш 3 хуруу зайнд арьс цорой чанга татаж, хурц хутгаар 2 хуруу урт зүсэн хагалж нэг хуруугаараа буюу махир төмрөөр судсыг татаж гаргаад хоёр талыг сайн боож дундуур нь огтолж тасалбал засал авч болно. Арьс, цоройг оёж ариутгах эм хийнэ. (ААмгаабазар 1944)

Давхар хүйсний шинж үзүүлсэн тугалын хүйсний судсуудыг сайтар ажиглаж үзвэл хүйсэн дотор хүрэн өнгөтэй нарийн судас байх бөгөөд

Хүйсийг шамлаж тэрхүү судсыг зөөлөн чангаан татаж сайтар гаргаж ирээд угаар нь огтолбол засал авна.

ТӨЛИЙН ЗУНГАГ ТҮГЖРЭХ

х

Ямарч малын төл эхээс гарахдаа гэдсэндээ зунгагтай байна. Зунгаг нь түгжирснээс хурга ишиг тугал унага, ботго алин ч анхны баасаа гаргаж Бүх чадахгүй өвчлөх, үхэх явдал тохиолдоно. Зунгаг түгжрэх ялангуяа унаганад харьцангуй илүү тохиолдог бөгөөд малчид "унага түгжрэх" гэж бие даасан өвчин болгон томьёолдог байжээ. Хөрвөжиж сар гаруй настай унаганы баас хатаж түгжирдэг тохиолдол ч бий.

Шинж тэмдэг: Зунгаг нь түгжирсэн төл эхээ хөхөхгүй, өнгө зүс алдах, хий дүлэх, хэвтэх босох нь олширно. Зунгаг нь түгжирсэн унага өнгө зүсээ алдах нүд нь ширгэх, нуухтах, сүүлээ өргөж нуруугаа бөгцийлгөж дүлэх шинж үзүүлнэ. Түгжрэл удааширвал босож чадахгүй болж, хошноогоо төмбийтөл дүлэх бөгөөд гэдэс нь дүүрч үхэхэд хүрнэ. Унагыг эхтэй нь бэлчээрт бойжуулж байгаа нөхцөлд унаганд байнга ажиглалт хийж байх нь чухал.

Эмчилгээ: Гараа сайн угааж хумсаа авч сайн цэвэрлэсний дараа хуруугаа төлийн хошноого уруу оруулж хатуурч түгжирсэн зунгагийг малтаж авах хэрэгтэй. Түгжирсэн зунгагийг бургуйдан гаргах арга хэрэглэнэ. Үүний тулд эхийн нь сүү, тостой шорвог ус буюу нэг шанага усанд 10-20 гр саван уусгаж түүнд 2-3 хоолны халбага шар тос хийж бүлээсгэсэн уусмалаар бургуй тавихад түгжирсэн зунгаг дорхноо гарна. Баас зунгаг нь гарахгүй байвал 2-3 удаа бургуй тавина. Олон ясны уулзвар дээр халуун жин тавина. Бургуй тавихдаа төлийн бөгсөн биеийг өндөрлөсөн байвал зохино.

ТӨЛ БҮТЭХ

×

Хээлтэгч мал төллөж чадахгүй удаашрах, хаг, салс, усаар хамар, ам нь бөглөгдөх зэргээс төл бүтэж үхэх явдал тохиолдоно.

Үүнээс сэргийлэхийн тулд Мал төллөж байгаа үед хээлтэй малыг дагаж хариулах, манах, хотондоо авч үлдэх зэргээр мал төллөх үед сайн ажиглаж байвал зохино. Хөгшин болон анх төллөж байгаа малыг төллүүлэхэд онцгой анхаарал тавих нь чухал.

Хурга, ишиг бүтвэл салс, хаг, уснаас ам хамрыг цэвэрлэх, амыг нь ангайлгах, ам чихрүү нь хүчтэй үлээх, үе мөчийг хөдөлгөх, цээжин биеийг алгадаж доргиох, илэх арга засал хийнэ.

Унага, тугал, ботго бүтвэл дээрх адил ам хамрын салс, усыг цэвэрлэх, чих, ам руу нь үлээх, хүйтэн ус биед нь цацаж цочрол үүсгэх, үе мөчийг хөдөлгөх, цээжин биеийг илэх зэрэг засал хийнэ. Бүтсэн төл амьсгал авч сэргэсний дараа амлуулах нь чухал.

ХОРДЛОГО

×

Голын хор, хайчин хор, бугна зэрэг хорт ургамал, таана, муудсан тариа тэжээлээс мал хордоно.

Хордсон мал ногооноор бөөлжинө, шилээ татна, цагаан хөөс савируулна. Нүд нь улайна, булчин бие нь татна, дөрвөн үе мөч нь чичирч салганана, гэдэс нь дүүрнэ,, явж чадахгүй. унаж босно.

Малд ногооны хордлого тохиолдох үед бэлчээрийг ойр ойрхон сольж, хорт ургамалгүй бэлчээр сонгодог заншилтай.

Эмчилгээ: Хордсон малд дор дурдсан аргуудыг бололцоогоо ашиглан хийнэ. Үүнд:

Ямар ч хордлогод бог малд давстай ус, цагаа, шар сүү өгөх, айраг, сүү 500 мл орчим өгч гүйлгэж чацга алдуулах нь ашигтай.

Зуны улиралд бог мал хордоход гүрээнээс 0,5 литр орчим цус авч, дотуур нь шар ус, айраг 0,5-1 литр өгч, хүйтэн усанд шумбуулах, гүзээнд илэлт хийнэ.

Зарим малчид гүрээнээс цус авахаас өөр сайн эмчилгээ байхгүй гэж үздэг.

Хордлого их хүндрээгүй бол хордсон малд үхрийн түүхий сүү өгч, самсааг ханана.

Ургамалд хордсон малын хаанаас ч хамаагүй цус авч, тараг өгнө.

Мөн ажигцэрэн ургамлын хатааж нунтагласан цэцэг, ишнээс 4 хуруу чимх авч нэг литр усанд буцалгаж үхэрт 500, бог малд 200 мл өгнө.

Мөн хордсон бог малд цагаан архи нэг хундага өгч болно.

Тарианд хордсон малын хоёр хааг ханаж, буцалгасан давстай ус, үхрийн түүхий сүү (3-5 литр) өгнө. Дараа нь чацга алдтал хөөнө.

Бог малын ногооны хордлого, гэдэс дүүрэхэд том хонинд нэг жижиг шаазан аяга аргалын үнсийг литр усаар зуурч тунгаагаад усыг өгч хорыг дарна. (Б.Шижээ)

Хорт ургамал, таанаар хордсон ямаа бахирна, гэдэс дүүрнэ, шүлс гоожуулна, ус тэжээлээс гарна, татаж саатна, улаанаар шээнэ, амьсгаадна.

-Шприцийн нарийн зүүгээр зөв талын сүвээний хавирганы араар хатгаж гүзээний хийг гаргана. Чих, хамар сэтлэх буюу гүрээнээс цус авна. Мөн айраг, давстай ус өгч болно. Хүйтэн усанд, хордсон ямааг дүрэхэд сайн.

-Хордсон малд шимийн архи өгөх буюу хордсон малыг усанд хэд хэд сайн дүрэхэд сэхдэг.

Дээр үед мал хорт ургамлаар, хордохоос сэргийлэхийн тулд гашуу хэмээх бэлдмэлийг зээргэнэ, хар хорс, шүдэн цагаан зэрэг тэр нутагт ургадаг хорт ургамал бүрээс авч, 10 литр усанд хийж хандлаад, хонинд ялангуяа төлөг, шүдлэн, хурга, ишгийг хорт ургамалтай бэлчээрт гаргахаас өмнө 100 гр орчмыг өгч сэргийлдэг байжээ. Гашууг тэр нутагт ургадаг хортой ургамлаас бэлтгэж байжээ. (Т.Тагтааням)

Хувийн цөөн хоньтой айл дээрх хандыг хониндоо өгч хорт ургамалтай бэлчээрт гаргахад хорддоггүй байсан бол олон хоньтой баян айл хониндоо дээрх хандыг бэлтгэж өгч чаддаггүй байснаас хонио олноор нь үхүүлдэг байжээ. (Ховд, Мөст, Р.Лхамсүрэн)

Хордсон үхэр, адуунд 3 литр орчим савантай ус (сүүтэй цай мэт болгож) цутгаж өгнө. Мөн усаар толгойг шавших, аарцны шар ус дотуур өгч чацга алдуулна. Адууны хэлний үзүүрийг огтлох, үхрийн гүрээнээс цус авах эмчилгээ хийнэ. (Ш.Бумба)

Адуу таанд хордож цусаар шээвэл хамрын самсааны судсыг хамгийн хойд талын сахал үсний ар дээр нарийн хутгаар нилээд лав ханана.

Тэжээлийн хордлоготой морины хошноого, умдаг хавдаж өтөх нь хялбар учир ийм эмгэгтэй мориог мөс хайлж байх үед голын усанд хагас цаг хэртэй уяхад засал авдаг. (Д.Сумъяа)

Таананд хордсон хонь, ямаа амьсгаадаж, түгшиж байвал тамхины бохь (байхгүй бол улаан тамхи) өгч самсааг сэтэлнэ. Цус гарахгүй бол толгойг тонгойлгоно. (Т.Ч.Гүүш)

ХУЖИРТ ТҮЛЭГДЭХ

х

Мал сүргийг эрдэс тэжээл өгөхгүй, хужирт оруулахгүй удаах, хужирт мараагүй бэлчээрт маллах, их хужирссан малыг гэнэт хужирт оруулснаас хужир их хэмжээгээр идэж хужирт түлэгдэнэ.

Мөн хужирт оруулсан малыг тэр даруй усалбал хужирт түлэгдэнэ. Ядарч доройтсон, эцэнхий өлөн мал хужирт түлэгдэх нь илүүтэй тохиолдоно. Бороо орсны дараа хурц нартай үед хужирласан малыг хужирт оруулбал түлэгдэх явдал ч гарна.

Шинж тэмдэг: Малын гэдэс дүүрч амнаас цагаан хөөс цахран хэвтэх, гөлийж зогсох, шингэн хар чацга алдах болно.

Эмчилгээ: Хужирт түлэгдсэн малд дараах эмчилгээ хийнэ.

Хорыг гаргахын тулд үхрийн түүхий сүү, (бусад малынх ч болно) цутгаж өгнө.

Мөн түүхий сүү, гурилын зутан, нүүрс, үнсний уусмал уулгаж болно.

Хужирт түлэгдэхээс сэргийлэх аргууд: Мал сүргийг тогтмол хужирлах, давс, хужир шүүг хороо хотондоо тавьж долоолгоно. Мал хужирлахдаа дараах журмыг баримтална.

Малаа хужирлахын өмнө усалж, идээшлүүлсэн байх.

Малаа амрааж, хужирт оруулж, хужирнаас гаргахдаа усалж болохгүйг анхаарах.

Их хужирссан, олон хоног сараар хужирт оруулаагүй буюу бор шороо, мараа долоож байсан малыг цөөн цагаар хужирт оруулж гаргах замаар хэд хэдэн дахин хужирлуулна.

Мал хужирт нэг ороод ханадаггүй учир 1-2 хоногоор хужиртай нутагт бууж, хэд хэд дахин хужирт оруулна.

ЯДАРЧ ДОРОЙТСОН МАЛ СУВИЛАХ, ТАРГАЛУУЛАХ АРГА

х

Турж эцсэн, өргүүлсэн болон тарга тэвээрэг авдаггүй малыг тэнхрүүлэх, таргалуулахын тулд дараах уламжлалт аргуудыг хэрэглэнэ.

Тарга хүч авалгүй нүд нь хөнхийж, үс нь өрвийж, толборч, халцарч буй адууны хоёр дөрөлхийг хоёр хастай нэг зэрэг хавар ногооноор ханана.

Таргалахгүй, хатингар болж, урд хоёр хөлөө гүйцэт гишгэхгүй болсон адуу болон мал тарга хүч авах үед тарга хүч авахгүй, хөхөрсөн адуу, тэмээ болон бусад малын дөрөлхийг ногооноор ханана.

Тарга, хүч авдаггүй тэмээнд хөх дэрсний хандыг уулгахад маш сайн.

Ядарч доройтсон малд чонын мах чанаад хандалж, шөлийг бодод 100-200 мл, богд 30-40 мл-ээр нэг удаа өгөхөд амархан тэнхэрнэ.

Бүх төрлийн мал, ялангуяа тэмээ, үхэрт дугуй булантай цай дөрөвний нэгийг хандлаад өгөхөд сэргэх нь түргэн.

Ядарч доройтсон малд 8 сарын 15-ны дотор түүж хатаасан царванг хандалж өгөхөд амархан засарна.

Тарга хүч муу хатиардсан тэмээнд зуны халуун өдөр эсгий юмуу аль болох зузаан зүйлээр нэмнэж, бозод 5 литр хүртэл, том тэмээнд 15-20 л, тайлагт 5 литр өгч хөлөргөж, хөлсийг сайн хатаасны дараа тавина. Энэ эмчилгээг 10-15 хоногийн дараа давтан хийнэ. Мөн тарваганы мах сайтар чанаж, мах, тос шөлийг өгч болно.

Тарга хүч авдаггүй, туранхай тэмээг ноос нь унаж ид ногоонд цадаж байгаа үед тарваганы тостой хорхогны шөл 3-4 литрийг, 2-3 өдөр өгч сайн хөлөргөж байгаад тавихад таргалж засарна.

Өргүүлж байгаа үхэр, адуунд хонины хагийг авч цэвэрлэж, чанаад шөлийг нь дангаар буюу хивэгтэй хольж өгвөл хурдан тэнхэрнэ.

Өргүүлсэн малд 1 кг агийг 10 литр усанд буцалгаж, 5 литр болгоод бог малд өдөрт 3 удаа жижиг аягаар, бодод 1 литрээр өдөрт 3 удаа 1-2 өдрийн завсартайгаар өгөхөд сэхнэ. (С.Цэрэнжаргал)

Мөн үхэрт хонины уураг сүү өдөрт нэг аяга, хэд хэд өгөхөд түргэн сэхнэ. (Д.Цэрэндэжид)

200 мл усанд 2,5 гр (цайны халбага) шагтав өвс хийж хандлаад өргүүлсэн үхэрт өгөхөд дороо тэнхэрдэг. (С.Батдорж)

Өргүүлж хэвтсэн үхэрт хонины намрын шар бууцыг буцалгаж 1 сахуу (3-5 литр)-г гурван өдөр дараалан өгөхөд тэнхэрч босно. (Д.Балдорж)"

Хэт туранхай адууг сайн хөлөргөөд 7-8 цаг уяад тавихад засрах нь түргэн байна.

Өргүүлсэн борлон, бяруунд адууны элэг чүдэнзний хайрцаг хиртэйг өдөрт 2 удаа өгнө. Мөн тарваганы тос хоолны халбагаар өдөрт 1-2 өгнө. Халгай, агь хандалж өгдөг. (Б.Цэгмид)

Морины шанааг ханахад тэр жилдээ сайн таргалах боловч дараагийн жил таргалахгүй, нүд, хамар, шанаагаа шөргөөж үс нь халцарна. Иймд тэр жилдээ идшинд хэрэглэх адууны шанааг ханаж болно. Идшинд хэрэглэх адуу.нд 300-500 гр элсэн чихрийг шимийн архинд найруулж 1 удаа өгнө. Унаж эдлэх моринд өгч болохгүй. Турж доройтсон малын сүүлний яс зөөлөрнө. Ийм малд яс шатааж нүдэж нунтаглаад давстай хольж яс, давсны зоодой бэлтгэж, мал ялангуяа төл малд долоолгож байвал янз бүрийн эрдэс махбодийн дутагдлыг нөхөх гар доорх арга учир өргөн хэрэглүүштэй туршлага юм.

ҮНЭЭ, ЭМ ХОНЬ ХЭЭЛ ХАЯХААС СЭРГИЙЛЭХ нь

х

Хээлтэгч мал хээл хаяхаас сэргийлэхийн тулд дараах арга засал хийнэ.

- Үнээ хээл хаях шинж тэмдэг илэрмэгц үнээний толгойг битүү хучиж, аргалын цог дээр ямааны дотор өөх тавьж хөлөртөл утна. Мөн тарваганы тосыг бог малд цөгцөөр, үнээнд жижиг шаазангаар өгөхийн зэрэгцээ үтрээний амсарт дээрх тос түрхэнэ.

- Хээл хаях гэж байгаа үнээнд (төлийн ус гараагүй үед) хонь, ямааны цагаан тос, эсвэл аарцыг хоолны халбагаар нэг удаа өгвөл сайн.

-Охин бөгсөнд нь давс хийнэ.

МОГОЙД ХАТГУУЛАХ

х

Хорт могойтой бэлчээрт идээшилж яваа малын толгой, хоншоор, хошуу, хөл, дэлэн хөхийг могой хатгаж хордуулах явдал тохиолдоно. Хэрэв могой малын судас буюу түүнд ойр хатгасан бол могойн хор түргэн зуур бүх биед хурдан тархаж хүндээр өвчлүүлнэ.

Малын толгойн хэсэгт могой хатгасан бол малын эрүү, толгой нэн их хавдаж, идээшлэхгүй зогсоно. Хэрэв хол үе мөчийг хатгасан бол хөл нь их хавдаж, доголно. Могой хатгасан хэсэгт хатуу, халуунгүй дарахад эмзэг хавдар үүсэх онцлогтой.

Тэр хэсэгт үсийг ярж сайтар ажиглавал ганц, хоёр цэгт зүүний сүвэгч мэт нарийн нүхээр дусал цус бултайсан, хатсан байхыг ажиглаж болно.

Эмчилгээ: Хавдрыг шар сүүгээр угааж, исгэлэн тараг, хоормог түрхэнэ. Мөн хатгуулсан малд шар сүү, тараг цутгаж өгнө.

-Могой хатгасан даруй тамхины бохь хавдрын гадуур түрх, хавдар харимагц улам дотогш түрхвэл сайн. (Өчүүхэн хар дом судар)

-Хөл нь хавдаж байгаа бол хавдрын дээгүүр сур олсоор боож, хавдрын доод талаас хагалж цус гаргаж болно.

-Хавдраас могойн хорыг хөхүүлэхийн тулд үхрийн нойтон баас, малын шинэ дэлүү, уушиг, нэхийн нойтон голоор хавдрыг ороож хорыг гадагш хөхүүлнэ. Мөн хавдрыг шар усаар байн байн шавших, хавдар дээр тараг, үхрийн нойтон баас, нялцгайвтар зуурсан гурил тавьж боож ч болно. Могойн хатгасан газарт сохор цох тавьж бооход хорыг сайн авна. (Ж.Дамиран)

БАЙГАЛИЙН ГЭНЭТИЙН АЮУЛААС ҮҮССЭН ӨВЧИН ЭМГЭГ АНАГААХ, СЭРГИЙЛЭХ АРГА

х

Гэнэтийн хүйтрэлт, хүйтэн цасан шуурга, бороотой үед мал осгох, бээрэх, хөлдөх явдал тохиолдоно. Хавар тохиолдох цасан шуурга, зуны хүйтэн борооноос мал сүргийг сэргийлэхэд онцгой анхаарах нь чухал.

Ж.Бараадийн мэдээлснээр намрын дунд сарын бүх өдрүүдийг сайтар ажиглаж цас орох тоо, хэдийд нь цас хүчтэй орсныг мэдэж авах хэрэгтэй. Энэ сард орсон цасны тоогоор хавар цас шуурга тавьдаг бөгөөд намрын хэдийд цас хүчтэй шуурч орсон бол мөн хаврын тэдийд цас хүчтэй шуурч орно. Хаврын энэ цасан шуурга 4-р сарын 2 дугаар арав хоногт голдуу тохиолдоно.

Тухайн орон нутгийн маргаашийн цаг агаар болон ойрын өдрүүдийн цаг агаарыг үхэр огдой сайн мэднэ. Үхэр огдой дуугарч байвал маргааш нь дулаан болно. Хэрэв дуугарахгүй байвал, заримдаа хэдэн өдрүүдэд дулаарахгүй бол маргааш буюу ойрын өдрүүдэд тэнгэр муудаж, шуурга тавьдаг.

Нутгийн цаг агаарыг тэмээ сайн мэднэ. Ойрын үед тэнгэр муудаж, яггүй шуурга болох бол тэмээ бөөгнөрч, салхи уруу харж хүзүүгээ газар тавьж сунгаж хэвтэнэ.

1986 онд Дорнодын бүсэнд тохиолдсон цасан шуурганы өмнө тэмээ ингэж хэвтэж байжээ. Бас хаврын цэцэг дэлбээгээ хумхиж доошоо унжвал хүйтэрч, шуурга тавихын тэмдэг болно. Хүчтэй цасан шуургатай үед малд өвс тэжээл өгөх, услах, арчлах бололцоогүй үе ч тохиолдоно.

Нүд нүүргүй шуургатай үед мал осгох, дарагдаж үхэхээс сэргийлэхийн тулд дараах арга хэрэглэнэ.

-Өвсийг үүрч явах төдийгөөр боогоод шуурга тавьж байгаа үед үүрч мал дотуураа явахад мал дагаж өвс зулгааж идэхээс гадна мал нэг газар бөөгнөрч дарагдаж үхэхээс сэргийлнэ.

-Нүд нүүргүй хүчтэй цас шуурга өнжин хонон үргэлжлэх үед малд гурил, хивэг зуурч бага багаар малын аманд хийж өгч байвал осгохоос сэргийлнэ.

МАЛ ОСГОХ

х

Өл хоолгүй, халхавч нөмөргүй байснаас зун, намрын хүйтэн бороо, хавар намрын цасан шуургатай үед цасанд дарагдах, осгож олноор үхэж хорогдох явдал бэлчээрийн мал аж ахуйд тохиолддог байгалийн нэг аюул юм.

Мал осгох явдлаас сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээ авна.

Үүнд:

-Мал сүргийг өл хоолтой байлгах, ялангуяа зуны хүйтэн борооноос хамгаалахын тулд ноосолсон хонийг бэлчээрлүүлэн идээшлүүлэх, голын усанд шумбуулж олчиржүүлэх нь чухал.

-Зун намрын улиралд бог малын сууриудыг хөнгөн маягийн нөмөр халхавчаар хангагдсан байвал зохино.

-Осгосон малыг битүү хучиж бүлээн цай цутгаж уулгана. Төл малд эхийнх нь бүлээн сүүг өгнө. Осгосон малыг шууд дулаан байранд оруулж болохгүй.

-Осгосон малд бамбай өвс(чимх хиртэй 200-300 мл усанд) буцалгаж хандлаад өгөхөд түргэн сэхнэ. (Б.Сэр-Од)

-Мөн зуны хүйтэн бороонд осгосон малыг газарт буюу халуун элсэнд булахад түргэн сэхнэ.

-Мөн осгосон малын ам уруу нь шээж ч сэхээдэг.

-Осгосон малын ам уруу нь цайны халбага хар чинжүү (хандлаад өгч болно) хийхэд хялбар сэхнэ. (Ш.Халидалдаа)

-Өвлийн улиралд цочмог хүйтрэлт болсон үед малын хөх, чих, сүүл, хөл нь хөлдсөн тохиолдолд малын хөлдсөн эрхтнийг бүрэн далд ортол харз ус, хүйтэн, мөстэй усанд дүрэх буюу хүйтэн усаар шавших, цасаар үрэх зэргээр гэсгээнэ.

Үүний дараа давирхай буюу зуурсан гурилаар хөлдсөн хэсгийг шавшиж хөхүүлэн хорыг авна. Хөвөн даавуунд шээс шингээж хөлдсөн хөлийг боох буюу хөлийг тарваганы тосонд дүрж гэсгээх арга ч хэрэглэдэг.

АЯНГАНД ЦОХИУЛАХ

×

Аянганд цохиулсан малыг тэр даруй нь нойтон шороогоор булах буюу усанд хийж биед нь хурсан цахилгааныг газар уруу дамжуулах хэрэгтэй. Ийнхүү булах, усанд хийхдээ толгойг ил байлгаж амьсгалах боломжтой байлгавал зохино.

Аянганд цохиулсан малд 1-2 чимх ганга өвс 1 аяга усанд буцалгаж, өдөрт 2-3 удаа өгөхөд сэхэх нь түргэн. (Г.Цэвээн)

Жилийн жилд аянга буудаг газраас зайдуу буух, тэр газраас дуу цахилгаантай өдрүүдэд малаа зайлуулах хэрэгтэй.

УСАНД УНАХ

×

Усанд унаж живсэн малыг тэр даруй яаралтай уснаас гаргаж, уушиг ходоодонд орсон усыг гаргах аргыг хэрэглэнэ.

Үүний тулд усанд унасан малыг уснаас хурдан гаргаж, хэлтгий газар толгойг газрын уруу харуулан хэвтүүлж цээжин бие, гэдсийг байн байн дарах, илэх, үе мөчийг хөдөлгөх үйлдэл хийж уушиг гэдэсний усыг гаргах арга хэрэглэнэ.

ГАЗРЫН ГҮЙДЭЛ ДАЙРАХ

×

Ямарч мал бэлчээрт явж байгаад гэнэт өнхөрч ойчин, дөрвөн хөлөө сарвагануулна. Унаж босно. Унаж явсан морь гэнэт таталдаж ойчиж тийчилнэ. Үүнийг газрын гүйдэл дайрах гэж нэрлэнэ.

Эмчилгээ: Унасан талын чих, хамар сэтлэх, шар эсгийгээр утах, шивэр буюу чулуу хагалж үнэртүүлэх зэргээр засал хийнэ.

Ийм засал хийхгүй бол дороо үхнэ. Мөн сүүлний үзүүр, чихний хоёр үзүүрээс цус гаргах, тамхиар утахад сайн.

ГАЛД ТҮЛЭГДЭХ

х

Бэлчээрийн түймэр, байр, хот хороо шатах зэргээс мал сүргийг хамгаалж чадаагүйгээс мал түлэгдэж, үхэж хорогдох явдал бэлчээрийн мал аж ахуйд тохиолддог гэнэтийн аюул юм. Гал түймрээс болж мал түлэгдсэн хир хэмжээ, хүнд хөнгөн янз бүр байх бөгөөд түүнээс шалтгаалан түлэгдсэн малд үзүүлэх тусламжийн арга хэрэгсэл өөр өөр байна. Тухайлбал:

-Арьс нь бамбайж, улайсан байвал аргалын үнсийг усанд шингэн найруулж, түлэгдсэн хэсгийг шавшиж, дараа нь цөцгийн тос түрхэнэ. Энэ эмчилгээг өдөр бүр хийнэ.

-Түлэгдсэн арьс нь цэврүүтээд шүүс гоожих, хагарч идээлэх байдалд орсон бол үнсний усаар угааж шавшин дараа нь үнс, цөцгийн тосны зуурмагаар түлэгдсэн хэсгийг шавж цэвэр даавуу марлиар даруулан бооно.

-Малын арьсны түлэнхийд нохойн цус түрхэх хэрэгтэй. (Д.Тэрбиш)

-Түлэгдсэн хэсэг нь гүнзгий гэмтэж, эд эс нь үхэжсэн бол тэр хэсэгт нь тахианы түүхий өндөг түрхэж, хуурай, шинэ үнс тавьж, бооно. Хүндээр түлэгдсэн тохиолдолд мал эмнэлгийн мэргэжилтний туслалцааг авбал зохино.

МАЛ ШИВЭЭТЭХ

х

Ихэвчлэн тал хээрийн бүсэнд шивээт хялгана, нохой- шивээ их ургадаг бөгөөд шивээтэй бэлчээрт хариулж байсан мал шивээтэх нь их.

Говьд эрт бороо орж, дараа нь гандвал шивээ их ургаж хатсанаас шалтгаалан мал шивээтнэ. Шивээ ихтэй өвсөөр тэжээсэн мал бас шивээтнэ. Хонь, ямаа, тэмээ шивээтэх нь их байдаг.

Шивээтсэн малд тохиолдох шинж тэмдэг гэвэл шивээний үр (зүү) малын үс ноосонд шивж тогтоод улмаар арьс мах уруу ярган орж биеийг загатнуулснаас мал биеэ шөргөөж үс ноос бүрзийж унана.

Малын ам, хамар, эрүү, хэл, тагнайд шивээний үр шигдэн орсноос үрэвсэл үүсэж идээлэх учраас хавдаж, шархлах нь их байна.

Үүнээс болж мал өвс тэжээлээс гарч тарга хүчээ алдаж, зогсоно. Шивээтсэн малын турууны салаа, шилбэнд шивээний үр шигдэж үрэвсүүлснээс доголно. Тэмээний уланд шивээний үр яргаж орсноос тэмээ дэвсэлж, ул тавгаа элээж цоолно. .Малын арьс болон булчинд хэдэн зуун шивээ яргаж орсон байдаг.

Мал шивээтэхээс сэргийлэхийн тулд хагдарсан шивээт хялгана ихтэй бэлчээрт мал бэлчээхгүй байвал зохино.

Малын биед наалдсан, биед нь яргасан шивээг . байнга түүж арилгах хэрэгтэй. Шивээт хялгана цэцэглэж байгаа үед нь уг бэлчээрээр олон адууг тууж өнгөрүүлбэл хялганы цэцэг унаж үр тогтохгүй болж мал шивээтэх нь бага болно.

Мөн шивээт хялгана хагдарсан үед нь тэр бэлчээрээр адуу, үхэр тууж хөлөөр нь шивээг унагах арга хэрэглэж болно. Их шивээтэй өвсийг хэрчих, дэвтээх зэргээр боловсруулж ядарч доройтсон мал төлд өгөх нь зүйтэй.

ХАЧИГТАХ

х

Бэлчээрийн хачиг хаврын тарчиг цагт малын тарга хүчээ алдаж, эцээж тураах, элдэв халдварт өвчин халдах, ноос унагаах, арьс гэмтээх зэргээр мал аж ахуйд асар их хор хөнөөл учруулна.

Судалгаанаас үзэхэд манай орны малд 10 гаруй зүйлийн хачиг шимэгчилдэг бөгөөд мал хавар 3-5 саруудад голдуу хачигт баригдцаг.

Урьдчилан сэргийлэх, эмчлэх аргууд:

Хачиг их унах үед мал сүргийг хачиг их унадаг бэлчээр, тухайлбал дэрс, бут, сөөг ихтэй нам доор хоолой, салхины нөөлгө багатай бэлчээрт аль болохоор бэлчээхгүй байх нь хэрэгтэй. Хачиг их унах хугацаанд хуурай, өвс хагдаар намхан, гүвээ, дэнж дагуулан алсын салхи тоссон бэлчээрт салхи сөргөөн бэлчээхэд мал хачигтах нь бага байна. (Мө.Даш)

Мал ялангуяа өсвөр мал ядарч доройтсон малын хүзүү, нуруу, дал мөрний үсийг ярж хачиг хувалзыг түүж хаях, малын биеийн их хачигтддаг хэсэгт адуу, тарваганы тос, тостой хөө, арц, хар шаваны нунтаг цацаж эмчилгээ сэргийлэлт хийнэ. Малын биеийн их хачигтддаг хэсэгт креолины уусмалаар шавших дуст цацах зэргээр эмчлэх, сэргийлэх нь илүү үр дүнтэй болно.

МАЛ ШИРХТЭХ

х

Ширх бол малын тайван байдлыг алдагдуулах, тарга хүч авах, тогтоход сөрөг нөлөө үзүүлдэг. Үс ноос гэмтээх учраас түүнийг устгах талаар дараах уламжлалт сэргийлэх, эмчлэх аргууд хэрэглэнэ.

Ноос авсны дараа угаалга хийх, усанд шумбуулах намар аль болох сэрүүн газарт бэлчээрлүүлэх зэргээр ширхээс сэргийлэх арга хэрэглэнэ. Ширхтсэн малд арц, мойл, аргалын үнс, улаан тамхи, хар шаваг, дагш, цагаан ортууз, зээргэнэ өвсийг нунтаглаж малын биед цацаж түрхэх буюу дээрх ургамлуудаас ханд бэлтгэж, малын биеийн ширхтсэн хэсэгт шавших

эмчилгээ хийдэг байна. (Мө.Даш, Б.Бямба) Аргалын хөх үнсийг ширх хүрд ассан хэсэгт түрхэхэд сайн.

Малын ширхтсэн хэсэгт тарваганы бүлээн тос түрхэх, мөн улиас модны үнснээс ширхтсэн газарт цацаж түрхдэг. Мал ширхтэхээс сэргийлэхийн тулд хотондоо. 3-4 газарт аргалын эвэр шатааж утлага хийдэг байна.

Морин шарилжийг боож хурга ишигний байр, зэлэнд өлгөх, эсвэл нунтаглаж хэвтэр дээр цацах замаар ширхнээс сэргийлж болно. (Ц.Адъяа)

Түүнчлэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын Дотор шанд гэдэг газрын бор шороо ширхийг арилгах үйлчилгээтэй гэж Ц.Адъяа мэдээлж байна.

Морин шарилжийг нунтаглаж малын бие дээр цацахад ширх халддаггүй гэдэг. Адууны өөх тосыг хавтгай мод, панер дээр түрхэж хотонд тавихад түүн дээр ширх үй олноор цуглах бөгөөд түүнийг цуглуулж устгаж байвал мал ширхтэх нь бага байна.

Мөн бог малын шилбэнд адуу, тарваганы тос түрхэхэд түүнд ширх хүрд холд нь цуглардаг учир мал өөрөө маажиж арилгадаг. Нэг атга дүнсэн тамхийг нэг литр усанд чанаж хандлаад малыг шавшихад ширх арилдаг. Улиас модыг битүү түлж, үнсийг нунтаглаж үхрийн ширхэнд түрхэхэд ширх арилна. (Л.Тэхээш)

Лууль, царванг 1:10 харьцаатай усанд хандалж (2-3 хоног усанд хийж байлгаад хандалж болно) ширх хачиг хувалзанд баригдсан малыг эмчлэх, сэргийлэх зорилгоор угаана. (Ш.Халидолдаа)

Хөх салхитай өдөр сайн хөлөргөөд тавихад адууны ширх арилна. (Ц.Пүрэвзав)

ШУМУУЛ, ХӨХ ТҮРҮҮ, ДЭЛЭНЧЭЭС СЭРГИЙЛЭХ

х

Зун намрын улиралд шумуул, хөх түрүү, дэлэич зэрэг цус сорогч ялаа шумуул гарч малын цус сорох, тайван идээшүүлэхгүй оодогнуулах, салхи сөрж гүйлгэх зэргээр малын тарга хүч авах, сүү шимд муугаар нөлөөлнө.

Ялаа шумуулаас мал сүргийг сэргийлэхийн тулд дараах аргуудыг хэрэглэнэ.

-Хөх түрүү хурц нартай өдөр, үдийн үед халуунд нисэх нь идэвхжиж, малын цус сорж тайван байдлыг алдагдуулна. Иймд энэ үеэр малыг уул толгод, гүвээний хяр орой, дэнж газарт бэлчээх зогсоох хэрэгтэй.

-Шумуул өглөө, орой салхигүй бүгчим үед нисэх нь идэвхжиж малд үй олноор сууж шимэгчилнэ. Мөн гол горхи, нуур цөөрмийн нуга, намагтай газарт, бут сөөг ихтэй нутагт илүү их үржинэ.

Иймд өглөө оройн бүгчим салхигүй үед гол горхи, нуур цөөрмөөс малаа зайдуу бэлчээх хэрэгтэй.

-Малын хот хороо, зогсоол, унага тугалын зэлний эргэн тойронд май гавьж малыг ялаа шумуулаас сэргийлдэг байна.

ХАМУУ ӨВЧИН

×

Хамуутай малыг эмчилж байсан ардын уламжлалт туйлын сонирхолтой аргууд олон байсан бөгөөд түүнийг судалж шинжлэх ухааны үндэслэл өгөх явдал эрдэмтэн мэргэжилтнүүдийн нэг зорилт юм.

Хэдийгээр хамууг анагаахад орчин үеийн өндөр үйлчилгээтэй эм хэрэглэж байгаа хэдий боловч малын хамууг эмчлэх уламжлалт аргыг хэрэглэхийг үгүйсгэх үндэсгүй юм. Ардын уламжлалт аргуудаас дурдвал:

Ээрэм шарилжны нэг хоолны халбага үрийг 2 литр усанд хийж, нэг литр болтол буцалгаж, ширгээж хандлаад хамуутай хонинд жижиг халбага цутган өгөх.

Бог мал, адууны хамууг хужиртай усаар шавшаад хамуурсан хэсэгт адуу, тарваганы тос түрхэх.

Адуу, тарвага, мануулын халуун тосыг малын толгойд гарсан хуурай хамуутай хэсэгт түрхэх.

Таван килограмм яргуйг 100 литр усанд хийж нэг цаг хиртэй буцалгаж бэлтгэсэн ногоон өнгөтэй, өтгөвтөр хандаар хамуутай малыг угаах.

Хар чавганы хандаар хамуутай малыг шавших, угаах.

Хонь, ямааны хамууг ганга өвс усанд буцалгаж хандлаад шавших.

Малын хамууг үнсний шүлтээр угаах.

усны үйс нэрээд гарсан хар тосыг улаан тамхины хандтай холиод- малын хамуу, ширх, хүрд ассан газар шавших зэрэг аргуудыг хэрэглэдэг байна.

Адууны хамууг зэсийн цэнхрийн уусмал, яснаас нэрж гаргасан тосыг хар модны нүүрстэй хольж түрхэж эмчлэхийн зэрэгцээ дараах эмчилгээг үе шатлан хийдэг.

Тухайлбал:

Хамуутай адууг сайн хөлөргөж 1 хоног (өдөр шөнө) сойно. 7 хоногт энэ эмчилгээг 3 удаа хийнэ. Хэрэв засал авахгүй бол хаа, сүүлний үзүүрээс цус авна.

ХАЛУУРСАН МАЛЫГ ЭМЧЛЭХ АРГУУД

х

Халуурсан тэмээ, адууны хар нүдэн дотор хүний нүүрний тал харагдах учир халуурсан эсэхийг мэдэхэд хялбар юм. (Н.Бадарчин)

Ямар нэг шалтгаанаар халуурсан малд дараах эмчилгээг хийнэ.

-Газар үс өвсийг хайчилж нунтаглаад түүнээс чүдэнзний хайрцагний 3-ны 1 хиртэйг авч литр усанд буцалгаж, хандлаад хөргөж, бог малд хагас литр өдөрт нэг удаа, хүнд бол 2 удаа өгнө. (Б.Цэгмид)

-Могойн хальс халуурсан малд гойд сайн. Могойн хальс нэг чимх хиртэйг литр усанд буцалгаж богт 500 мл, бодод 1 литр орчмыг өгнө.

-Нэг аяга арц буцалгаж цэв хүйтнээр өгнө.

-2 литр усанд хоолны нэг халбага хойлогны нүдсэн бо.рц мах хийж буцалгаад шөлийг өгнө.

-Халуунтай тэмээнд гунжин өвс, адуунд цулбуур. өвс хандалж (хар цай мэт) халуунтай малд өгөхөд этгээд сайн. Ихдэснээс гэм болохгүй. Мөн зээрний ундааны ханд өдөрт 3 удаа халуун буутал өгнө. Тэмээ их хөлрөх учир салхигүй тогтуун өдөр өгнө. (Ц.Лувсандорж)

-Нэг атга таван салаа буюу ганга өвс 2-3 литр усанд хандалж ботгонд 250 мл-ээр өдөрт 3 удаа өгнө.

-Ингэ хээл хаяж халуурвал гишүүний 1 кг үндсийг 5 литр усанд хандалж өгнө. Үүнийг үхэр хонины халуунд ч өгнө. (Д.Балдорж)

ХАНАХ ЗАСЛЫН ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

х

ХАНАХ ЗАСАЛ ХИЙХ ЁС ГОРИМ: Ханах засалд цаг улирлын байдал, нар хурын тэнцэл, өвс ногооны шим, малын тарга хүч, өвчний гүйх мөр, цул сав эрхтний холбоо, ханах судасны байршил, ханах өдөр буюу сүнсний орших орон, цус шинжлэх, өвчнийг боловсруулах, хануурын хэмжээ, цус тогтоох зэрэг олон ойлголтууд багтана.

Малд тарга тэвээрэг авахуулах, өвчний муу цусыг гадагшлуулах, тэжээлийн хорыг арилгах зорилгоор зуны тэргүүн сараас зуны дунд (5-7) сар хүртэл дөрөөлөх, гүрээ, чамархай, хаа, самсай, тагнай зэргийг хатгаж ханана.

Цээжиндээ буюу хөлдөө цустай болсон үед ороо хар, улаан суга, хаа болон шөрмөсөн сиймхий, бэрэвхийн сиймхий, туурайн магнай, туурайн хана, ар жолоо, гахай сөхөх, өсгий сэтлэх зэрэг хатгааг эмгэгийн байдалд нь тохируулан хийх бөгөөд дээрх хатгааг намрын дунд (10-11) сард газар товууцах үеэр хийвэл сайн байдаг.

Хордлого болон бусад эмгэгийн үед ханах засал эмчилгээг хийхдээ цаг улирал, өвчний байдал, тарга тэвээргийг харгалзан өвчин хүндрэх, бусад өвчинтэй хавсрахаас урьтаж хийх хэрэгтэй. Эс чадваас өвчнийг түргэн боловсруулах харшилсан болон хурмал өвчнийг ялгах, өвчний цусыг судсанд ирүүлэх, тан өгч өвчнийг бүрэн боловсруулж ханана.

БОЛОВСРУУЛАХ ТАН: Боловсруулах тан нь амтлаг, исгэлэн, давслаг, гашуун, халуун, эхүүн зэрэг эмийн зургаан зүйл амт төгөлдөр, махбодыг тэгшитгэн хорыг тайлах, нянг устгах, өвдөхийг зогсоох чадал бүрдсэн, цусны халууныг арилгах, илчийг үүсгэх, хурмал болон харшилсан өвчнийг боловсруулах хүчин төгс, хий, шар, бадганын тэгш бус билэг чанарыг даран чадах тэгш чанар цогцолсон, эмийн эрдэм, нууц увидас бүрдсэн байна. Үүнд: мана, лидэр, ар үр, бар үр, жүр үрийн тангаас гадна бургасны хальс, дол, тарвага, чонын цөс, баавгайн доньт зэргийг голлон хэрэглэнэ.

Хэрвээ өвчнийг боловсруулахгүйгээр ханавал халуун нь арилахгүйн гадна хий түрж өвчний урхаг хоцорно. Өвчний цусыг ялгаж судсанд ирүүлэхгүйгээр ханавал тамирын цусыг алдуулахыг анхаарах ёстой.

ЦУС ШИНЖЛЭХ: Цус нь шим тэжээлээр төгөлдөр, халуун, хөнгөн, шингэн, хурц билэг чанартай, өнгийг тодруулах, махбодыг шимжүүлэх үйлдэлтэй шингэн юм. Цус нь идэш тэжээлийн охь тунгалгаар тасралтгүй төлжин боловсорч хар судлаар дамжин бүх биед тархдаг. Ингэснээр биеийг шимжүүлэх эрүүл байдлыг хангах бодисын эх суурь болдог. Цусны биед үзүүлэх нөлөө болон өвчний хувиралтаас гарч илрэх шинж тэмдгийг нь үндэслэн түүний билэг чанарыг тодорхойлно.

Ханахад гарч буй цус нь тамирынх бол шунх мэт ягаан өнгөтэй шингэн, харин өвчнийх бол хар хүрэн өнгөтэй, эвгүй өвөрмөц үнэртэй, өтгөн байна. Үүнийг гурван хэмийн онолоор авч үзвэл хийн цус-харавтар, ширүүн, улаан хөөстэй, шарын цус-шар, шингэн, өмхий үнэртэй, бадганы цус-цайвар улаан, өтгөн, зөөлөн байдаг.

ХАНАХ СУДАС: Улаан буюу тараагуур судас нь зүрхнээс бүх бие рүү хий, шимжүүлэх тунгалаг, цусыг тарааж байдаг цусны судас юм. Хөх буюу хураагуур судас нь бүх биенээс хий, цөв, цусыг хурааж зүрх үрүү цутгаж байдаг цусны судас болно. Энэ судас нь хануур хийх судас юм. Хос судсыг оруулбал адуунд 120-иод орчим судас байх бөгөөд тэдгээрийг байршлаар нь ангилбал:

Толгой, хүзүүний хэсэгт 33, их биед 23, үе мөчинд 62 хос ханах судас байна. Үүнээс судасны торлог сүлжээ хатгах цэг 7, битүү хатгах (цусан гагнаа үүсгэх) цэг 5, нэвт хатгах цэг 3, тодорхой нэр бүхий судас 35 байдаг (Б.Шаравдоржийхоор).

ХАНАХ АРГА: Судасны өнгөц гүний байрлал, нарийн бүдүүний хэмжээнээс хамаарч хануурын урт, өргөнийг маш нарийн тохируулах шаардлагатай. Судсыг ханах талаар олон заалт бий.

Үүнд:

Голд нь ханах: Судасны хоёр захын яг гол дунд судасны дагуу ханах бөгөөд энэ аргаар том судсуудыг ханана. Үүнд өргөн сумч хэрэглэнэ.

Хавиргалан ханах: Судасны хоёр хажуугийн аль тохиромжтой талд хатгаж цус гаргана. Дунд хануур хэрэглэнэ.

Хөндлөн ханах: Энэ хатгааг маш нарийн судаснуудад хийх бөгөөд энэ хатгаанд судас хөндлөн хатгагдана.

Хоёрдож ханах: Энэ хатгаагаар эхлээд арьсыг цоолж дараа нь судсыг ханах арга. Энэ аргаар оньсон дээрх болон ясан дээрх судсыг ханадаг. Том судсыг ханахдаа судасны цаад ханыг гэмтээх, нэвт хатгахаас болгоомжлох шаардлагатай.

ЦУС ГАРГАХ ХЭМЖЭЭ: Цус гаргахаасаа хий, уурыг гаргах нь илүү тустай тул арьсны сүв нь судасны сүвнээсээ том байх нь тохиромжтой. Өвчний цусыг гаргахдаа ухаа ягаан хөөстэй тамирын цусыг гармагц даруй зогсоох нь ёстой. Хэрвээ тамир нь барагдаад хий хавсарсан бол муу цус мөн боловч зогсоох хэрэгтэй. Бүх биед болон үе мөчнөөс цус дэлгэрсэн, хямарсан үед цусыг баахан илүү гаргаж цусны хүчийг бууруулбал зохино.

ЦУС ТОГТООХ АРГУУД: Ханах судасны байршлаас хамаарч янз бүрийн арга хэрэглэнэ.

Үүнд: 1. Хөдөлгөж явуулах, 2. Халуун төмрөөр хайрах, 3. Даруулж боох, 4. Хүйтэн жин тавих, 5. Цус тогтоох бүлэгнүүлэх төрлийн эм хэрэглэнэ.

ХАНАХ ЗАСАЛ ХИЙХЭД АНХААРАХ ЗҮЙЛҮҮД: 1. Бороо хуртай болон цаг агаарын таагүй нөхцөлд, 2. Хээлтэй мал буюу нялх төлд, 3. Чацга алдсан буюу шингэн дутагдсан малд, 4. Ханах заслын дараа малыг уяж хонох, унаж эдлэх, усанд зогсоохыг тус тус хориглоно.

Мөн зурхайн сударт ханах засал хийхийг цээрлэх өдрийг заасан байдаг. Үүнийг сийрүүлбэл: Хаврын гурван сарын гахай, хулгана, зуны гурван сарын бар, туулай, намрын гурван сарын могой, морь, өвлийн гурван сарын бич тахиа өдрүүдэд ханах болон имнэх, агтлахыг цээрлэ гэсэн байна.

ХАНУУРЫН ХУТГА: Ханах засалд хэрэглэгдэх багажийг хануур буюу сумч гэж нэрлэдэг. Хануур нь зориулалтаараа олон янз байх боловч хийцийн хувьд алт, мөнгө, ган, зэс, яс, хулс зэргээр хийгдсэн зэв, ташуу, тал саран хэлбэр бүхий иртэй байна.

Уламжлалт хануурын энэ бүх онцлогийг тусгасан бидний зохион бүтээсэн

"Хануурын цомог" нь 3 төрлийн хануураас бүрдэх бөгөөд зориулалтын хувьд бүхий л шаардлагыг хангахаар хийгдсэн болно.

Том хануур 9-10 мм өргөн, 2-3 мм зузаан, 150-200 мм урттай. Хоёр талдаа ирлэгдсэн. Цүүцэн иртэй талаар нь гүрээ, дөрөөлөх, хаа, хас зэрэг том судсыг ханана. Тал саран иртэй талаар мал засах болон мэс заслын ажилбар хийнэ.

Дунд хануур 7-8 мм өргөн, 1, 5-2 мм зузаан, 100-150 мм урт байна. Нэг тал нь ташуу нөгөө тал нь дугуй иртэй. Ташуу иртэй талаар бод малын мөчний, бог малын том судсыг ханана. Дугуй иртэй сүвэгчтэй талаар сүвэгчит хануур хийнэ.




Жижиг хануур 4-5 мм өргөн, 1-1,5 мм зузаан, 100-150 мм урт байна. Хоёр талдаа зэв болон ташуу иртэй. Бод, бог малын судсыг ханах хатгахад тохиромжтой.


СҮНС ОРШИХУЙ: Сүнс нь адуу, малын биеийн эд эрхтнийг дамжин оршино. Сүнс байрлах эл өдөр тухайн эрхтэнд аливаа засал, мэс хүргэхийг цээлэнэ.

Шинийн нэгэнд тавагт, шинийн хоёронд сагагт, шинийн гурванд шилбэнд, шинийн дөрвөнд борвинд, шинийн таванд тойгонд, шинийн зургаанд сүүжний нүхэнд, шинийн долоонд олон ясанд, шинийн найманд бөөрөнд, шинийн есөнд улаан суганд, шинийн арванд урд хөлийн тавагт, шинийн арван нэгэнд сагагт, шинийн арван хоёронд шилбэнд, шинийн арван гурванд өвдөгт, шинийн арван дөрвөнд мөрөнд, шинийн арван таванд бүх биед, хуучид арван зургаанд хаанд, хуучид арван долоонд хүзүүнд, хуучид арван найманд дэлд, хуучид арван есөнд аман хүзүүнд, хуучид хоринд хоншоорт, хуучид хорин нэгэнд шүдэнд, хуучид хорин хоёронд тагнайд, хуучид хорин гурванд хэлэнд, хуучид хорин дөрвөнд магнайд, хуучид хорин таванд өвчүүнд, хуучид хорин зургаанд аюулхайд, хуучид хорин долоонд бэлгэст, хуучид хорин найманд сүүлэнд, хуучид хорин есөнд нуруунд, хуучид гучинд бүх биед оршино.


АГТЛАХ, ИМНЭХ, ХАНАХ ӨДРҮҮД: Бар сарын үхэр, туулай сарын хонь бар, луу сарын бар туулай, могой сарын бич луу, морь сарын туулай могой, хонь сарын тахиа морь, бич сарын луу хонь, тахиа сарын тахиа бич, нохой сарын могой тахиа, гахай сарын гахай нохой, хулгана сарын морь гахай, үхэр сарын хулгана өдрүүд ээлтэй сайн.

ТОЛГОЙ ХҮЗҮҮНИЙ ХЭСЭГТ ХАНУУР
ЗАСАЛ ҮЙЛДЭХ ЦЭГҮҮД





3-р зураг ИХ БИЕИЙН ХЭСЭГТ ХАНУУР ҮЙЛДЭХ ЦЭГҮҮД



4-р зураг ХӨЛ ҮЕ МӨЧНИЙ ХЭСЭГТ ХАНУУР
ҮЙЛДЭХ ЦЭГҮҮД

ЦЭЭЖЭЭ АВАХ

х

Бага насны адуу, уналга эдэлгээний адуу, тэмээ, шар ихэвчлэн доголох шинжээр илэрдэг эмгэг юм.

Шалтгаан: Морио хүчтэй давирч явах, богино дөрөөтэй гутлаар хөх махыг байн байн хүчтэй нидэрч давирах, хүнд биетэй хүн жижиг морь унаж газрын уруу ширүүн давхих, давхиж яваад гэнэт эвгүй, огцом эргүүлж зогсоох, хүнд ачаатай тэрэгтэй морь, шарыг газрын уруу ширүүн оруулах, бага насны адууг хүүхэд, залуучууд буруу эдлэн, гуядан давхиулах зэрэг олон шалтгаанаас цээжээ авах гэм сууна.

Тэмээнд, уяа сойлго алдах, тарган тэмээг уяж, сойлгүй буруу эдэлсэнээс цээжин бие бяцарч гэм суудаг. Үүнийг асгатах гэнэ. Дал богино хавирга хоёрын хоорондох сиймхийнд цус хуралдсанаас, эсвэл адгийн хавирганы бүлх булчирхайн дунд байдаг судас бүдүүрсэнээс адууны цээжээ авах эмгэг тусдаг, тэмээний асга суух нь далангийн булчин бяцарсанаас шалтгаалдаг хэмээн ардууд үздэг. Адуу цээжээ авах эмгэгийг зарим газар богино хавирга чинэх гэж нэрлэдэг.

Шинж тэмдэг: Цээжээ авах гэм суусан адуу урд хоёр хөлөө юмуу аль нэгийг нь гүйцэд самарч, сугаа сайн тэнийлгэж чадахгүй, хөлөө дутуу богино, хүчгүй тавьж гишгэнэ. Дөрөөнд хүчтэй давирагдсан хөх мах хавдах, няцрах заримдаа булчин нь хатингартана. Давхиж, хатирч чадахгүй тул ихэвчлэн цогих ба урд хоёр хөлөө ойр ойрхон гишгэнэ. Биеэ дааж ядах байдалтай эмзэглэн бүдчинэ. Бяцарсан хөх мах нь дарахад эмзэг, овойж хавдсан ба уяж байгаад хоолоо оргож хүчтэй доголон цээжээ түрэх байдалтай явна. Хэвтэж байгаад босохдоо бүр явж чадахгүй балцагнан явах ба зогсож байхдаа урд хоолоо хумсалж гишгэх зэрэг онцлог шинж илэрнэ. Асгатсан тэмээ, урд хоёр хоолоо зэрэг гишгэж, хөлөө урд хойно тавьж, тэмтчин явна.

Таних нь: Адуу малын доголох гэм аль хээгтээ байгааг ялган үзэж, цээжээ авах гэм суусан эсэхийг тогтооно. Аль хэсэгт өвчний гэм байгааг тогтооход дараах байдлаар шалгана. Доголохдоо толгойгоо өргөвөл өвчин нь далны хэсэгт буюу дээгүүр догол, доголохдоо толгойгоо хазайлгаж байвал өвчин нь богтсонд байгаа, доголохдоо толгойгоо бөхийлгөвөл өвчин нь сагаг орчимд, урд хөлөө хөдөлгөхөд эмзэглэвэл өвчин нь атгаалд, өлмийгөөрөө гишгэвэл өвчин нь шилбэний ясанд буй, уруу газар буухаасаа халширвал өвчин нь цээжин биед, хатуу газар явахаас халширвал улдсан тэмдэг болно.

Цээжээ чухам хаагуураа авсаныг буюу өвчний голомт байгаа газрыг олохын тулд далны зузаан махны тушаа байрладаг цувраа гурван хонхорт ээлжлэн дарж үзнэ. Дээд талын хонхорыг далны хуудасных, дунд талын хонхорыг бүдүүн хөх махны /цагаан хуянгийн/ гурав дахь хонхорыг нарийн хөх махных хэмээн нэрлэнэ. Шалгахдаа, доод талд орших хөх махны хонхорт долоовор хуруугаа тавьж, дунд хуруугаар дээш нь хэмжих байдлаар дунд, дээд хонхорыг олж дарна. Эгэмнээс хойш мухар сөөм, дал богтосны үеэс дээш мөн мухар сөөм тавьж үзэхэд эрхий ором хонхор таарах нь хөх махны хонхор юм.

Анагаан засах нь: Цээжээ аваад удаагүй буюу хөлөө зэрэг гишгэлж тушаатай мэт доголсон үед *эгэмний судас буюу ороо харыг* хатгана. Их зовиуртай доголж, хөлөө сойж хумсалж гишгэж байвал *хөөсөн хааг* авна. Хөөсөн хааг хатгах хэмжээг адуу бүрд тохируулах арга бий. Үүнд: Хөх мах нь зузаан бол гарын 4 хурууны угийн өргөнөөр, дунд зэрэг бол үзүүр үеийн өргөнөөр, дааганыхыг 4 хурууны өндөгний өргөнөөр хэмжээлж хоёр талд хатгана. Ороо харыг хатгасан үед хэд хоног хүйтэн усаар хөх мах тушаа үсийг сөргүүлэн шавшаад уяж хононо. Дээрх заасан гурван хонхорыг тэмтэрч үзээд аль эмзэглэлтэй байгааг нь олж хатгаж болох ба далны хуудасны хонхорт 2,0-2,5 см, бүдүүн хөх махны хонхорт 4 хуруу, нарийн хөхмахны хонхорт 3 хуруу гүн хатгана.

Цээжиндээ цустай болсоноос балбаж доголох буюу богино “хавирга чинэх” үед улаан суга хатгана. Энд богино хавирга дамнасан хураагуур судас */V.axilaris/-ийг* хатгаж байгаа хэрэг юм. Ардууд “суга гижигдэх” хэмээн нэрлэнэ.

Улаан суга хатгах: Цус авах талын хөлийг урагш татаж гишгүүлээд, дал хавирга хоёрын завсраар мухар сөөм хатгана. Асгатсан тэмээг дал хавирганы завсар, далны хуянг урдаас төө илүү гүн хатгана. Мөн асга суусан талын хаа юмуу тавхайн салаа хонхорт 1,5 см орчим гүн хатгана.

Дээрх хатгаануудыг хийсний дараа 7-14 хонуулаад “цусыг тэнцүүлэх зорилгоор “хойш татах” заслыг сүүлний гол, хас, сүүлний самсаа зэрэгийн аль нэг цэгт хийнэ.

Сүүлний самсаа: Нурууны хоёр талаар гол мах дагасан хоёр судас нь сүүлний доод гадаргуугийн хоёр хажуугаар сүүлний үзүүр хэсэгт нэгддэг судас (*V.cossusea lateralis et medialis*) бөгөөд сүүлний угаас доош 3-4-р үед дотор гадаргуугийн хоёр хажууд хатгах ба боолт тавьж тодруулж хатгах нь дээр. Боолтныхоо доод талд хуруу зайтай хэсэгт цэгээ олно. Цус бага хэмжээтэй гарна. Уур гаргахад болно.

ЦУС БУУХ

х

Цусны эргэлтийн хэсэг газрын хямрал буюу хураагуур судасны цус тогтонгишилтыг “цус буух” хэмээн нэрлэнэ. Цусны эргэлтийн хэсэг газрын хямрал гэдэг нь бүх бие махбодийн цусны ерөнхий хэмжээ хэвийн тогтмол байхад эд юмуу эрхтэний аль нэг хэсэгт цусны хэмжээ өөрчлөгдөхийг хэлнэ. Цус буух эмгэгт “богино хавирга чилэх” буюу цээжиндээ цустай болох, сиймхий буюу шилбэ, сагаганд цус буух, голхио самрах, ясан, шөрмөсөн, цусан бороо суух, улдах, гахайдах, тэмээний тавагтах зэрэг олон эмгэг өвчин хамаарна.

Цус буух гэмийг байршил бие бүтцийн үүднээс а. Том хураагуур судасны цусны эргэлт хямрах эмгэгүүд (цээжинд цус буух, цээжиндээ цустай болох үүнийг зарим газар “богино хавирга чилэх” гэж нэрлэдэг).

б. Дунд хэмжээний хураагуур судасны цусны эргэлт хямрах (сиймхийд цус буух, голхио самрах, бороолох).

в. Жижиг хураагуур судас түүний торон сүлжээний цусны эргэлт хямрах (улдах, гахайтах, тавагтах г.м) хэмээн ангилж болно.

Шалтгаан: Морь, малыг хайр гамгүй эдлэн, хатуу чулуулаг хөрстэй газар хүчлэн давхиулах, явуулах, хөлорсон морины эмээлийг гэнэт хүйтэн болон халуунд хуулж хаях, давхиж яваад гэнэт тулгуурдан зогсоох, хөдөлгөөнгүй уях, хөлстэй морийг халуун бууцанд уях, удан хугацаанд чөдөртэй байлган, дэвхцүүлж хөлийн нь халаах зэрэг олон шалтгааны улмаас цус буух эмгэг тусна. Ихэвчлэн урд хөлд цус буух боловч, чөдөртэй морь адуу дагаж дэвхцэхлээр хойт хөлд цус буудаг.

Тэмээг алс замд хүнд ачаатай зүтгүүлж, аяншуулах, ачаа нь хүнддэх, хол явсаны дараа амрааж идээшлүүлэхгүй уяж хэвтүүлсэнээс хөлийн тавагт цус бууна.

Эмээлийг хэтэрхий урд тохсоны улмаас далны мөгөөрс мундаа хоёрын завсарт нухлагдсанаас болон хүчтэй давирч огцом ухасхийн зогтусах зэргээс болж бага насны адууны цээжин биед цус бууна.

Уралдааны болон уургын морины хойт хөлийн туурайн ирмэг, урд хөлийн шилбэний арыг үргэлжлэн хүчтэй цохисноос “голхио самрах”, “голхио цохих” гэж нэрлэдэг эмгэг үүснэ. Хөлд цус буух, голхио самрах үед даруй эмчлэхгүй бол уг эмгэг архагшин бороо болж хүндэрнэ.

Дээрх шалтгаануудын улмаас адуу, малын уушиг тэлэгдэх, түүнчлэн зүрхний баруун ховдолын үйл хямарч, зүрх лүү цус урсах нь удаашран том болон дунд хэмжээний хураагуур судсуудад, биеийн доод хэсэгт голлон цус тогтонгишилт үүсдэг ажээ.

Шинж тэмдэг: Хөлд цус буусан адуу, мал хатуу газар гишгэхдээ эмзэглэн доголох, толгойгоо дохиж доголох, зогсож байхдаа хөлөө байн байн сойж өргөн удаан зогсож чадахгүй хэвтэж босох шинж тэмдэг үзүүлэх ба биеийг нь халтал унаж эдлэхэд доголох нь намдаж байвал хөлд цус буусны шинж мөн.

Харахад туурайн хана, сагаг, бэрэвхийн үеэр хавдсан, барьж үзэхэд эмзэг халуун, хүндэрсэн үедээ бороолж хүйтэн болсон байна. Хойт хөлд цус буусан үед бөгсөө чирэх мэт доголно.

Тэмээний таваг өвчилж ул нь цусархаг болсон бол алцагнан доголно. Адуу ойр ойрхон гишгэж, жоорогنون явбал цээжиндээ цустай болсоны шинж байдаг.

Бороог үүссэн байдал, байрлал зүйн талаар нь гурав ялган үздэг.

а. Цусан бороо-шөрмөсний сиймхийд цус бууж удаж архагшсан хэлбэр юм. Өөрөөр хэлбэл шөрмөсний сиймхий орчимд түүний хөндий зайд цус тогтонгошин хурсанаас эмгэг голомт буй болсон хэлбэр юм.

б. Шөрмөсөн бороо-Шөрмөсний дугтуй гэмтэж, шөрмөсний хөндийд цус, шар ус, шингэн хурж эмгэг үүсгэнэ.

в. Ясан бороо-дээрх хоёр бороог эмчлэлгүй архагшуулсанаас, хурсан цус шингэн, шилбэний ястай барьцалдан хатуурсан хэлбэр юм.

Таних нь: Цээжиндээ цустай болсон адуу, малыг дээрх шинж тэмдэгүүдээр ялган танихын зэрэгцээ, далны мөгөөрсний дунд ба доод хонхорт дарахад ямар нэгэн доголох гэмээс ялган тавина. Хөлийн доод хэсгийн доголыг барьж үзэх, харах, зэрэгцүүлэн жиших байдлаар үзэхэд танигдана. Мөн унаж үзэх, явуулах аргаар хаагуураа доголж байгааг мэднэ.

Анагаан засах нь: Цээжиндээ цустай болсон адуу малыг суга гижигдэх, ороо харыг хатгах засал хийнэ. 2-3 хонуулаад гүрээ, чамархайн аль нэгийг аваад 14-21 хоносны эцэст хас, сүүлний самсаа, гол, үзүүрийн аль нэгийг хатгана. Хөлд цус буугаад архагшин бороолсон бол хатуурсан хэсэгт гүүний айраг, нитэг, саам, бүлээн сэвс, шээсээр дэвтээлэг хийж 5-7 хоног эмчлэнэ. Үүний дараа бэрэвхийн сиймхий, туурайн хана, туургыг хатгана.

Бэрэвхийн сиймхий хатгах: Бэрэвхийн сиймхийг сохор сиймхий, эрхийвч, хангирцаган сиймхий, харцагны сиймхий, сиймхий буулт, уран сиймхий, жолооны сиймхий, сагагны сиймхий, шивэнхийн сиймхий, шивэнхий, хулгайч шандас, сагагны хий хатгах, далны хар хуянгийн үзүүр хэмээн нэрлэдэг.

Бэрэвхийн дээд, урд хураагуур (*Ramus dorsalis plangis primae*) судас бөгөөд, шилбэний араас өнгөц гадна, дотно хураагуураас салаална. Уг судсыг сагагны гадна, дотно хажууд байрлах сиймхийд хурууны нарийн үзүүрийн хэмжээтэй гүн хатгана. Сиймхийг бас туурай хавчийж хомойх, салбарах өнгө зүсээ алдахад хатгана.

Туурга хатгах: Энэ цэгийг туурайн хана, туурайн сиймхий, туурайн хажуу хана, туурайн шанаа, туурайн зах гэж нэрлэнэ. Туурайн хажуу хананаас дээш өгсөж, бэрэвхийн сиймхийд нийлэх (*V.digitalis lateralis*) хурууны гадна, дотно хураагуурын төгсгөл судас юм. Туургыг арьс, туурай хоёрын заагт туурайн гадна дотно хажууд тэмтрэн үзэхэд үл мэдэг хонхор таарах ба түүнд 0,5-1,0 см гүн, доош жишүү хатгана. Голхио самарсаны улмаас хүндэрч бороо суусан байвал. шөрмөсөн сиймхийг хатгаад 3-7 хонуулаад хаа, гүрээг хатган засна. Дараа нь хойш татах хэрэгтэй.

Шөрмөсөн сиймхий хатгах: Энэ цэгийг, шөрмөсөн хөндий, жолоо, шилбэний сиймхий, шөрмөсөн хий, лагцны сиймхий, ягнаг, чөдөрлөхийн сиймхий, хулгайч найман шандас хэмээн нэрлэдэг. Энэ судас нь шилбэний ясны ар дахь нимгэн хавтгай шөрмөс, түүний гадна буй том хөндий шөрмөс хоёрын завсарт байрлах, шилбэний арын өнгөц гадна дотно хураагуур (*V.metacarpea volaris lat et medialis*) юм. Шөрмөсөн сиймхийг хоёр янзаар хатгана. Үүнд:

а. Сиймхий дан хатгах: Сагагны үеийн доохно чигт гадна хажуугаар тэмтрэхэд мэдрэгдэх сиймхийд болон дотно талд адил байрлах сиймхий зайд 1-2 см гүн хатгаж цус гаргана. Хар хүрэн цус хүчтэй гарч байвал хатгалт зөв болсон гэж үзнэ. Энэ хатгааг “мухар сиймхий авах” ч гэдэг.

б. Давхар сиймхий хатгах: Сагагны үеэс дээш 2-3 хуруу зайд яс; булчингийн зайгаар барилан үзэхэд таарах сиймхийг олоод, зүүн гарын эрхий ба долоовор хуруугаараа гүн ба өнгөц нугалагч шөрмөсийг гадагш заагдах маягтай, шилбэний хоёр талаас хүчтэй барихад хоёр хурууны өндөг нийлэх цэгт 2-3 хуруу гүн хатгах ба хутганы ирийг өөд нь харуулж барьсан нь дээр байдаг. Энэ хатгааг зарим газар “өндөр сиймхий хатгах” гэж нэрлэдэг.

Бороолсон хэсгийг зөөлөрсөний дараа сиймхийг хатгаад туурайн магнай, хааг “цус тэнцүүлэх” зорилгоор хатгана.

Сиймхий болон тавганд цус буусан бол гахай сөхөх засал хийгээд 3-7 хонуулаад хааг авна. Гахай сөхөхөд ясан туурайнаас гахай руу орсон улны хураагуурын торон сүлжээг ханаж буй хэрэг юм. Мөн тавгандаа цустай болсон адуу, малын өсгийн ар гол (гол сэтлэх), сагагны хонхор (ар жолоо, ар цөнхөө)-ыг хатгана.

Өсгийн ар гол хатгах: Энэ нь өсгийн ар заадлаар дээшээ өгсөн харагдах өсгийн хураагуурын торон сүлжээ (Rete venosum) бөгөөд ар заадалд нь нарийн хуруу гүн хатгана. Зарим үед өсгийн ар хажууг заазуур, том хутга тавьж байгаад сэт цохиж цус гаргана.

Сагагны хонхор хатгах: Энэ нь титмийн арын хураагуур (Ramus, rete volaris phalanges secudae) судас бөгөөд сагагны ар хонхорт 1-2 хуруу гүн хатгана.

“Сударт” тавагны цус буухад ууц тэмнэж буух судас хавдах бөгөөд давстай хар цайгаар шавшиж 3 хоног цус авна. Богино ууц, сүүлнээс 3-4 үе завсар дахь 2 хар судсыг төмөр таягаар эрээд илт болох цагт хана” хэмээн бичсэн нь ул, тавганд цус буусаныг ханаж хатгаж эмчлэхдээ цус тэнцүүлэх засал хийхийн чухалыг заасан хэрэг юм. Дээрх хатгах цэг нь самсааны судас юм.

Байнга доголж байвч, унаж давхихад доголохоо больж амрааж байгаад мордоход их доголдог гэмтэй морины хойт хөлийн тавагны сиймхийг хатгана.

Тавагны сиймхий хатгах: Өсгийн зөрүүлэг, өсгий хатгах, өсгийн сиймхий, өсгийдөх, туурайн товгорын судас, нуугдавчийн судас хэмээн нэрлэдэг энэ судас нь өсгийн ар товгорыг дамжин дээшээ өгсөн харагдах зөөлөвчийн хураагуур (V.pulvinages toricae) бөгөөд шилбэний арын өнгөц гадна, гүн дотно хураагуур судсууд холбогдож энэ хэсэгт хураагуур судасны нум үүсгэнэ. Туурайн арын хоёр товгор дээр буюу сиймхийд нь ясан туурай өөхөн таваг хоёрын завсар ташуу байдлаар 15-20 мм юмуу хуруу гүн хатгана.

Тарган морийг уяж сойлгүй ширүүн унаж эдэлсэний уршигаар няцарч доголох сагагны арьс улайн зулгарах, ханзрах үед догол нь доогуур байвал туурга, дээгүүр маягтай доголбол хүзүү сээрэн сиймхийг тус тус хатгана.

Сээр хүзүүний сиймхий хатгах: Сээрэн сиймхий, онжрого, унжуурга хэмээн нэрлэдэг хүзүүний хөндлөн хураагуур (V.transversa colli) судас бөгөөд, сээр хүзүүний дээд хэсгээр салаалж гол судсанд очно. Энэ цэгийг, хүзүүний нугалам богино сээр хоёрын заагт, шилний доод заагаар дэлний угаас 3-4 хуруу доор зайд тэмтрэгдэх хонхорт нэвт хатгана.

Гүймэл цустай адуу урагш хойшоо сажлан доголж, унаж эдлээгүй үед бол огт доголохгүй байдаг. Ийм адууны зөв талын ороо хар (богтосны)-ыг буруу талын хастай хатгаад 3-4 хонуулаад нөгөө талын богтосны ороо харыг хастай хатгана. Эсвэл сүүлний гол, сүүлний үзүүр, самсааны аль нэгийг авна.

Богтосны ороо хар хатгах: Богинын хар хэмээн нэрлэдэг энэ цэг нь залааны ясан дээгүүр гарч ирэн суганы ерөнхий хураагуурт нийлдэг богтосны хураагуур судас (V.radialis)-ыг хатгаж байгаа бөгөөд адууны хаан талны дээд гадаргуугийн

орчимд, залаа ясны дээхэн талд эрхийгээр нухлан дархад мэдрэгдэх эрхий дарам хонхорыг олж 2 хуруу гүн биетэй эгц хатгана.

Тэмээний хөлд цус буувал тэр хөлийн тавагийг давстай хар цайгаар боож хэд хонуулсаны дараа тавагийг хатгана.

Таваг хатгах: Алтан хумснаас хойш гадна талд 4 хуруу зайд, эрхий хурууны өндөг ором хонхор сиймхийд, мах өөхөн тавагны завсар зайгаар хөлөө өргөхөд нь нарийн хутгаар 2-3 хуруу гүн хатгана. Эсвэл салааны дээд судсыг, салаанаас 1-2 хуруу дээр зайд олж хатгана.

Анхаарах зүйл: Шөрмөсөн сиймхийг хатгахдаа шөрмөс гэмтээхээс болгоомжлон дадлагатай хүн хатгавал зохино. Хөлийн доод хэсгийн судас хатгасан үед ус шаварт норгохоос болгоомжлох ба 3-6 сар гам хийж, ширүүн унаж эдлэхээс зайлсхийх хэрэгтэй. Гахайг хатгахдаа намар орой газар хөлдөх үед хатга. Аль нэгэн бороо үүссэн байвал дэвтээлэг хийж зөөлөрсөн үед нь хатгах нь зөв. Ямар ч судсыг хатгалаа гэсэн “цусыг тэнцүүлэх хатгаа” буюу “урагш”, “хойш”, “дээш доош татах” засал хийх хэрэгтэй

ДОГОЛТОХ

х

Адуу малын ул, тавхай, туурайн салаа, зах орчимоор шарх шалбархай үрэвслийн улмаас халдвар орж, идээлэн явж үл чадах эмгэгүүдийг доголтох гэнэ.

Шалтгаан: Адуу, малыг намаг, өмхий шавар, тогтонги усанд удаан зогсоох, шүүдэр, хар чийг халах үеэр болон сахлаг, бүдүүн өвс, шар өнгөтэй шарилжтай газраар бэлчээрлүүлэх мөн шавхайтай хашаанд удаан хугацаагаар хаших зэрэг олон төрлийн шалтгаанаас доголтох эмгэг тусна. Мөн өвчтэй эрүүл малыг хамт байлгаснаас халдаж, тэмээний хөлийг боож тавхай, нар өөд харуулж удаан хэвтүүлснээс таваг нь халж цус хурсанаас доголтоно. Сударт “зуны цагт хур их буух үед өвс ногооны өлөн чийгний гэмээр хонины хөл өвчлөх догол тусдаг” хэмээсэн байна.

Шинж тэмдэг: Адуу малын хөлний гярх, сагаг, бэрэвхий, туурайн орчмоор халуун хаван үүсч хэд хоносны дараа жижиг цэврүү үүсч улмаар яр, шарх болон өргөжиж шархны захын арьс мах үхжинэ. Өвчин олон малд дамжин халдварлана. Өвчтэй мал халууран хэвтэмтгий болж доголно.

Тэмээний байврагын яр нь тавхайн дээд талын арьсан дээр тойрсон маягтай шар ногоон толгойтой байснаа улмаар өвчин хүндрэн эвэр тавхай нь хавдаж, эвэр тавхай, арьсны завсарт идээ бээр хуримтлагдан идэгдэж, эвэр үл хуурч унан цус идээ гоожно. Зарим тэмээний хар ул хуурч гутлын ул ханзарсан мэт чирж явна.

Бог малын туурайн хоорондох арьс улайж эмзэглэн халуурч доголоод улмаар салаа нь яршина. Туур нь мултарч унах буюу нүүнэ.

Таних нь: Халдварлах байдал халуурал, яр арх үүсэх, идээ бээр болж хүндрэх зэрэг шинж тэмдгийг арчилгаа маллагаа, цаг улирлын байдалтай уялдуулан оношлоно. Бэртэл гэмтлийн улмаас үүссэн үе мөчний гэм, доголохоос ялган таних нь чухал юм.

Анагаан засах нь: Адууны догол буюу сөдрөгийг ханаж эмчлэхдээ туурайн магнай, хааны судас, өсгийн зөрүүлэг ороо ар, сагагны ар хонхор, хас, сүүлний самсаа, гол үзүүрийг зохих зааврын дагуу завсарлагатай хатгана.

Тэмээний догол буюу байврагыг ханаж эмчлэхдээ алтан хумс, ул хатгах, хас, тавхайн салаан дээр цэг, хаа, хасыг хатгах горимоор хатгаж засна.

Бог малын догол буюу балцрууг ханаж эмчлэхдээ, салаан дээд юм уу хажуугийн судсыг эсвэл туурайн өмнө талаас тайрч ул дагуу 0.5-1.0 см хатгах мөн сагагны хонхрыг хатгаж засна.

Сударт өвс ногоо эс идэх ба хэвтсэнээс хөлийн туурайн ар тал давхралсны дээр торойх усны доорх судсыг ханаж цус авбал тустай... хэмээн бичсэн байгаагаас үзвэл туурайн ар нуугдавч буюу ар товгорын судсыг хатгаж засч болох юм. Хашир сайн малчидын арга туршлага ч үүнийг гэрчилж байна.

Анхаарах зүйл: Ханаж хатгахын урьд шарх, идээг цэвэрлэх, угаах ариутгах эмчилгээ хийнэ. Мөн ханах хутга, багажийг сайн ариутган халдвар тархахаас сэргийлнэ. Эмчилж байгаа малыг 3-2 хоног сойж өлсгөлөн байлгах хэрэгтэй. Эрүүл сүргээс ялган, бэлчээрт гаргахгүй хэд хонуулбал зохино. Энэ тухай сударт сөдрөг өвчин ус үл хэрэглэн, архины охиор эсгий дэвтээж боогоод өлсгөхөд хэзээний угшмал өвчинд ч тустай... гэсэн нь огт хоосон зүйл биш ажээ.

БАГТРАХ

х

Амьсгалын зам тухайлбал, уушгинд цус ихдэлт болж зүрхний үйл ажиллагаа хүндэрч, амьсгал зүрх судасны үйл ажиллагаа хямрах эмгэг юм.

Шалтгаан: Хурдан морийг уяа сойлго тохируулалгүй дутуу буруу хөлсөлж өлөн эсвэл цатгалан уралдуулснаас морь багтрана. Энэ эмгэгийг, “цусан хэлбээ”, “өлөн хэлбээ”, “өлөн таараг”, “тарган бөглөө” хэмээн нэрлэдэг. Намар цагийн тарган морийг хол газар амраалгүй давхиулах, ширүүн хүчтэй хөөж элдэх үед багтрах тохиолдол бий. Тарган морийг ширүүн унаж эдэлснээс тусах эмгэгийг “цусан бөглөө” гэнэ. Хурдлуулах морийг уяж байх үед арьс булчин агшиж чангарсан боловч умс гүйцэд агшаагүй, хуучин баас гүйцэд гараагүй, шинээр үүссэн баас сэвсгэр, нягт хомоол болж чадаагүй, бүдүүн ширхэгтэй, исэлт ихтэй байдгаас шалтгаалан умсанд хий хуримтлагдсанаас давхих үед умс байршилаа өөрчилж түүний мухар үзүүр аарцагны яс руу түрж орохыг “өлөн таараг” гэж нэрлэнэ. Мөн идэш тэжээл нь багадсан адууны сул цус багтахаа болисоноос “өлөн дэлүү” тусдаг гэлцдэг.

Шинж тэмдэг: Уралдааны замд болон адуу мал ширүүн хөөж элдэх, ширүүн хөөгдөх үед болон тарган мориор огцом давхиснаас морины хүч суларч, хар хөлс асгаран ташуурдан хөөвч явж чадахаа болино багтарч зарим нь унадаг. Багтарсан морины ам, хамраас хөөс гарч, амаа ангайлган гэнэт унаж хөдөлгөөнгүй хэвтэх бөгөөд булчин мах нь чичрэх, таталдах, хамрын самсаа нь хавчийж амьсгал нь мэдэгдэхгүй шахам болно. Түүнчлэн ам хамраас цус гоожих, амь тэмцэх, шүд зуурах, нүд нь гөлийх шинж тэмдэг илэрдэг боловч танихад хялбар байна.

Таних арга: Дээр өгүүлсэн шинж тэмдгийг ажиглан багтарч байгааг тогтоох боловч уналга эдэлгээний цочирдолт зэргээс шалтгаалан гүентэх эмгэг тусдагийг харгалзах нь зүйтэй. Гэдэргээ харан хөрвөөж, хөлөө дээрээ гаргах юм уу хушуугаараа газар зурж малтаад байгаа адуу гүентсэн байдаг. Тарган болон хэт туранхай адуу гүентдэг. Адууны хамрын дотор талд 1-2 см орчим мөгөөрс урган хамрын нүхийг бөглөж үхүүлэх эмгэгийг гүентэх гэдэг.

Гүентсэн адууг эмчлэх: Адууны хамрын нүхний ёроолд эвэр угалз шиг тогтсон мөгөөрсийг хагалж зүү, тэвнээр сүвлэн татаж байгаад үзүүрийг нь огтлон хаяад шарханд ариутгагч эм цацна. Энэ үед адууг цорводон сайн бэхэлсэн байх ба маш хурц хутгаар зүсэх хэрэгтэй байдаг.

Адууны нүдний дотор талын өнцгөөс хар захтай мөгөөрсөн хальс гарч нүдийг халхлан үхүүлдэг эмгэгийг налхитах буюу “нүдний гүен” гэдэг. Ингэсэн адууг цохдох, юмуу нүдийг бүрхсэн мөгөөрслөг хальсыг зүү, тэвнээр татан барьж байгаад огтлож хаяна. “Цохдох” гэдэг нь налхитсан нүдний дээд талд арьсыг гурвалжин огтолж авахыг хэлнэ. Мөн тагнай, хамрын сиймхий хатгаж эмчилж болно.

Умсны гүен хатгах: Баруун өлөнгийн хонхорд, ташаан толгой, сүүлчийн хавиргыг холбосон шугамын голд, аймхай мөгөөрсийг чиглүүлэн үсний эргүүлгэнд хатгана.

Анагаан засах нь: Адуу малын багтрах эмгэгийн үед ханаж хатгаж эмчлэхдээ дорно дахины арга билгийг тэнцүүлэх зарчим буюу урагш хойш татах зарчмыг баримтлан дараах цэгүүдэд үйлдэх ба өвчний явц, хүнд хөнгөний байдал, тарга тэвээрэг, шалтгааныг харгалзан эмчилгээний горимыг тогтоохдоо эхлээд заавал урагш татаж, авируулан хатгахаар тооцно.

Дээд уруулын дотор талын судас хатгах: Дээд уруулын дотор талын хураагуур судас (V.labialis superior) нь оочны хураагууртай нийлэн хацрын ерөнхий хураагуурт очдог бөгөөд судас, мэдрэлийн торон сүлжээ орчимд нь байрлана. Уг суудас нь салст бүрхүүлэн доор гэрэлтэн харагдах нарийн хураагуур юм. Энэ судсыг, адууны дээд уруулыг дээш сөхөөд, уруулын голд орших салст таславчийн зүүн баруун талд харагдах эгнээ маягтай судсуудаас буруу талын араасаа хоёр дахийг нарийн шовх үзүүртэй хутгаар хагас см орчим гүн хатгана. Энэ судсыг ардууд “нарийсгалын судас” гэдэг. Гол салст таславчийн зүүн баруун талд дөрөв, дөрвөн эгнэсэн судас байрлах ба адуу малыг амьсгал хураахын өмнөх үед нууцлан хатгаж сэхээдэг “нууцын судас” байдаг ажээ.

Мөн багтарсан адууны хамрын сиймхийг аваад хаа, хасны судсыг 3-7 хоноод хатгах, тагнайн судас ханаад мөн хас авах, тагнай хатгаад ороо хар авах, хамрын судас аваад сүүлний гол хатгах, тагнай хатгаад борвины сиймхий авах, гөхөл сөхөөд борвины сиймхий хатгах, сүүлний гол, үзүүр авах заслуудаас аль нэгийг сонгон үйлдэнэ. Мөн багтарсан морийг, өвчүүний бүдэрхийн харалдаа “арьсыг нь таван см хиртэй өм огтлох юм уу босоо зүсч арьсыг нь сэртийлгэн “агаар өгч” эмчилдэг. Багтарсан морь явж чаахгүй хойт борвиороо нугарч доголбол цээж сугыг хүйтэн усаар шавшиж хоёр

товчлуурыг хатгана. Уясан морь өлдсөний улмаас унавал үхрийн шингэн чацга өгч хэл, гүрээг хатгана.

Хамрын дээд хажуугийн судас хатгах:Энэ нь нүдний доод хураагууртай нийлдэг хацрын өнгөц хураагуурын өмнөх судас (V.dorsalis nasi) юм. Уг судвыг ханахдаа ухархайн доод талд, хянган яснаас 2 хуруу хажууд, хамрын цулцангаас 3 хуруу дээр, ил үзэгдэх судсыг хуруу орчим гүн хатгаж цус гаргана.

Гөхөл сөхөх хатгааг хийх:Энэ цэгийг судлаачид нүдний дээд хураагуурын торон сүлжээ, гөхлийн доор магнай голд байгаа судас хэмээн тэмдэглэсэн бол профессор С.Андрей нар мэдрэлийн судал (Lenia medialis ossea prontalis)-д хийж буй хатгах ажилбар гэсэн байна. Адуу бахардах агшинд магнайн арьсыг гөхлийн дор тушаа арьсыг ярах юм уу гөхлөөс 4 хуруу доор арьсыг ярж хутгаар гөхөл тийш сөхөж өгнө.

Анхаарах зүйл: Морь бахардан унах гэсэн тохиолдолд, аль хатгаж болох судсыг эхлэн хатгаж цусны “уурыг” гаргахыг хичээх нь зүйтэй. Хатгалтыг хийхдээ аль болохоор уушиг-зүрхэнд ойр юм уу жижиг судсыг томруу нь авируулан атгах нь дээр. Идшинд хээглэх адуунд хатгадаг цэгийг хурдан моринд хатгахгүйг хичээ. Гэнэт их цус гаргавал адууны цаашдын уралдааны явц болон аминд нь халтай байдгийг анхаарахад илүүдэхгүй юм.

САХУУТАХ

х

Бага насны адуунд ханиад хэлбэртэй тусдаг халдварт өвчин.

Шалтгаан: Унагыг халуун наранд удаан уяж наршуулах, цангаах, зэл хэвтрийг сэлгэж зөөлгүй хэт давтуулах, өвчтэй унага, даагыг ялгаж эмчлэхгүй эрүүл адуутай хамт байлгах, унага даагыг ээлжлэн сольж бариагүйгээс уягдаагүй унага даага сахуурдаг.

Шинж тэмдэг: Зун, намрын цагт бага насны адуу, зэлний унаганы эрүүн доорхи булчирхай хавдаж томрон, идээ буглаа үүсч хамраас, эхлээд цагаан нус сүүлдээ ногоон, өтгөн шар өнгийн нус гоожин халуурч хэвтэнэ. Хавдарт нь толгой үүсч гадагшаа юмуу дотогшоо хагарч чидээ бээр гоожих ба унага, даага ханиан шуухитнан, эхээ хөхөхгүй, идээшлэхгүй байснаас турж эцнэ. Эмчлэлгүй байснаас бүх бага насны адуунд халдварлах шинж тэмдэг илрэнэ. Энэ өвчний шинжийн талаар хоёр дагинын сударт: морь сахуурваас хүзүүний орчим ба багалзуурын булчирхай дор гарна... хэмээсэн нь дээрх өвчний голлох шинж тэмдэг нь булчирхай хавдах болохыг хэлж байна.

Анагаан засах нь: Дараах жороор ханаж хатгах заслыг зааврын дагуу хийнэ. Тагнай хатгаад сүүлний үзүүр авах, шанаа хатгаад сүүлний үзүүр юм уу гол авах, хамрын сиймхий хатгаад хас, сүүлний үзүүр авах. чамархай хатгаад сүүлний гол, үзүүр авах. хэлний доод судас хатгаад гүрээ, сүүлний үзүүр авах мэт болно.

Шанааны судас хатгах: Ардууд эрүүний ороо хар, түүшин, талхи хатгах хэмээн нэрлэдэг энэ цэг нь нүүрний онгоц хураагуур судас (V.superficialis) бөгөөд, хамар, нүдний хураагуураас салаалж хацрын ерөнхий хураагуурт нэгдэнэ. Ханахдаа, доод

эрүүний онь орчимд тэмтрэн судсаа олж, шанааны том булчингийн урд өнцөгт хуруу гүн хатгана.

Сахуурсан адууг анагаан засахаа гарын доор хэрэглэж болох ардын аргууд тухайлбал, уураглаж огцом татах, нэрмэл архи, дарь өгөх, хонины нэхий, шар эсгий норгож хөхүүлэх зэрэг олон заслыг хийж болох юм.

Анхаарах зүйл: Ханах заслыг заавал цээжин биед 1-2 судас хатгаж эхлээд дараа нь хойш татах хэрэгтэй. Сахуугийн хорыг гүйцэд гаргах, цусыг цээжин биед бөглөрүүлэхгүйг хичээвэл зохино. Заслын үед ариутгал цэвэрлэгээг сайн хийж, халдвараас онцгой сэргийл. Ханах засал үйлдэх дээрх жорыг өвчний явц байдал, малын нас, цаг улиралтай нягт уялдуулан тооцож сонгон авбал дээр.

ХАНИАДРАХ

×

Ихэвчлэн хаврын цагт, бага насны адуу, тэмээ, гүүнд тусдаг амьсгалын замын халдварт өвчинг энэ эмгэгт хамааруулан шар байрагтах, нарийслага, гөлзөнгө, байрага, тагшаа ханиад, халуун ханиад, шүлдэн гэх мэтээр газар бүр харилцан адилгүй нэрлэж байна. Тэмээнд туссанг зарим газар “цэцэг” гэдэг ажээ.

Шалтгаан: Туранхай адуу малыг эрт хөөвөрлөх, хяргах, ноосолсноос хүйтэн салхи шуурганд нэрвэгдэж ханиадрах эмгэг тусна. Түүнчлэн ядарсан, хөлөрсөн малыг гэнэт хүйтэн усаар услах, арчилгаа тордолт муу байх, тарган тэмээг усаар гачигдуулах, хавар хэт ядраах зэрэг арчилгаа маллагааны олон дутагдлаас шалтгаалан ханиадаар өвчилнө. Мөн өвчтэй малын тоног хэрэгслэл, хэвтэр бууц болон өвчтэй малаар дамжин халдварлана.

Шинж тэмдэг: Адууны ханиад буюу ханиадрахыг ардууд илрэх шинж тэмдэг, өвчний голомтын байршил зүйгээр нь “голоороо туссан”, “уушигаар туссан” хэмээн ангилж үздэг. Ханиад голоороо тусахад, адуу цээжний гүнээс цаанаасаа бөгшиж, гүдэс гүдэсхийн голоороо ханиалгаж идээшлэхгүй бээцийн бөхийж зогсоно. Ижлээ гүйцэхгүй ядарч, гэдсээ татан бөгсөн бие нь ороолдон гуйвж, тагнай хавдан шүдний дээд ирмэгээс бараг давах ба хөлөө солбин гишгэлнэ. Хэл нь хув хуурай болно. Өвчин даамжирвал тэр жилдээ болон дараа жилд тарга тэвээрэг авахгүй гурина болдог. Хойш урагшаа ээлжлэн сурмаг доголох шинжтэй байна.

Уушиг барьж ханиад туссан адуу, мал хоёр чихээ унжуулан толгойгоо гудайлган хий гөлийж зогсох ба ханиаж хахаж цацан идээшлэхгүй, хамар нармай хүйтэн болно. Өнгө зүс алдан унахад учиргүй их амьсгаадна. Эрүүн доорхи булчирхай нь томрох ба хамрын нүхээр хуруугаа хийж үзэхэд хүйтэн хий үлээж, хамрын мөгөөрөс цэв хүйтэн болсон байна. Хамраас идээрхэг ногоон шингэн нус гоожиж, хүндрэх үед өтгөрч нүд нь нуухтан өвдөх ба хэвтэмтгий, ядрангуй болно.

Тэмээний ханиадыг илрэх шинж тэмдгээр нь гурав ангилан үзнэ. “Бөгших ханиад” туссан тэмээ хэвтэмтгий болж үе мөч нь өвчлөн, бөгшиж сул гүн ханиана. “Тарганы буюу хөнгөн цацлага” ханиад туссан тэмээ, өнгөц богино ханиан, амархан ядарч эхлэнэ. “Халуунтай ханиад” туссан тэмээ гэдсээ татан, өвс усанд дургүй болж, хэвтэх

ба дөрвөн мөч нь халуун болж халуурна мөн олноороо халдварлан ханиах бөгөөд хээлтэй ингэ зулбах, олон хоногоор хэвтэх, ингэний сааль татрах, ботгоо цатгахгүй болох сул дорой ботго гаргах шинж тэмдэг илрэнэ. Мөн ам суга цавинаас нь эвгүй үнэр гарна.

Уушиг, цээжний үрэвсэл, гэмийн улмаас бага насны адуу, гүү ханиах, ядрах шинжээр өвчлөхийг ардууд “гүлдэн” гэж нэрлэдэг. Гүлдэнг хүндрэхэд адууны үс нь зоо нуруунаасаа эхлэн бүрзийж хугаран, гэдсээ татаж огцом турж эцнэ.

Таних арга: Адуу, тэмээ олноороо өвчлөн халдварлах байдал, илрэх шинж тэмдгээр ялгаварлан оношлоно. Адууны сахуу, ям өвчнөөс өвчний тархалт шинж, байрлалаараа онц ялгагдана.

Анагаан засах нь: Ханаж, хатгах заслыг хийхдээ уг өвчний илрэх шинж тэмдэг, явц, малын тарга хүч, цаашид ашиглах ирээдүйг нь харгалзан тогтоосны эцэст эхлээд урагш татаж засаад эцэст нь хойш татан урхагийг арилгах хувилбарыг сонгоно. Эмчилгээ заслын хувилбаруудыг дурдвал:

Хамрыг буйллан, тагнай ханасны дараа хэд хоноод хасны судас хатгах, хамар буйллаад, дөрөө, умдагны задархайн аль нэгийг ханаад, сүүлний самсаа, үзүүрийн аль нэгийг авах, тагнайн судас хатгаад, гүрээнээс бага цус аваад завсарласны дараа хасыг хатгах, хэлний доод судас, гүрээг ээлжлэн хатгаад, хэд хонуулаад дороо, сүүлний самсаа авах, эрүүний ороо хар, хааг хатгаад хэд хонуулаад хас, сүүлний гол юм уу борвины сиймхий, шагайтын оромог авах, хааны судсыг хатгаад гүрээ авч завсарлаад дээрдэхээр нь сүүлний гол, хойш татах, хоёр гүрээг ээлжлэн ханаад сүүлд нь хоёр хасыг сөөлжүүлэн хатгах, тагнай хатгаад 2-3 хонуулаад хоёр гүрээ, чамархайн аль нэгийг аваад тэнхрэхлээр нь хойш татах, лидэрийн усан ханд, нойтон бургасны хальсны ханд юмуу хүүхдийн шээс өгч хэд хонуулаад хамар буйллан гүрээ авч хойш татах, дээд уруулын доторхи босоо судсыг хатгаад 3-4 хоноод чамархай, нарийн гүрээ, эрүүний ороо харын аль нэгийг хоёр талд хатгаад хойш татах гэсэн олон арга байна. Гүлдэн буюу нарийсах өвчнийг эмчлэхдээ, үхрийн махны шөл, тарвагны шөл 2-3 хоног өгч урьдал засал тордолт хийсний дараа сээр-хүзүүний сиймхийг хатгаад хойш татаж тэгшитгэнэ.

Тэмээний ханиадын үед гүрээний нарийн үзүүрийг хатгах ба удаан хугацаанд хэвтсэний урхагаас хөлд цус буусан үед тавхайн сиймхийг хатгана. Мөн чамархайг хатгасны эцэст тэнхрэх янз илрэхлээр хойш татна.

Анхаарах зүйл: Хатгалтын багаж, бусад зүйлийн ариутгалыг сайн хийж халдвараас сэргийлэх хэрэгтэй. Ханаж, хатгах эмчилгээний жор, хэм хэмжээг сайн сонгон тохируулж, аядуу зөөлөн аажим засах ёстойг анхаарах нь зүйтэй.

ДЭЛҮҮТЭХ

х

Энэ нь тэжээл боловсруулах эрхгэн системийн хямралын хам шинж бүхий цочмог явцтай эмгэг юм. Уг өвчний тухай дэд профессор С.Андрей өгүүлэхдээ: “Адуу, малын ходоод гэдэсний хэд хэдэн өвчний хам шинжийг малчид дэлүүтэх хэмээн нэрлэдэг” гэж

тодорхойлсон байна. Энд ижил төсөөтэй шинж бүхий хөрвөөх, цардаих, зайлагдах, чихэлдэх, цанхдах, таарах, түүдэгтэх, цуртах зэрэг ходоод гэдэсний цочмог хатгалтаар илрэх шинжтэй эмгэгүүд хамаарна.

Шалтгаан: Эрдэс тэжээлээр дутагдсан мал үндэс малтаж идэх, шавар, шороо долоох, бууц элс шороотой юмуу шорвог ус уух, мөн түүнчлэн халуун хүйтэн хямран гэнэт даарах, халах, уяа эдэлгээний буруу байдлаас шалтгаалан дэлүүтэх эмгэг тусна. Ялзарч муудсан тэжээл, дарш идэх, гэнэт хүйтэн ус уух, адууг өл хоолгүй хол газар давхиулсан зэрэг олон гэнэтийн цочмог шалтгаанууд нөлөөлнө.

Хөрвөөх нь умсны ёроолд элс, шороо хуримтлагдсанаас буюу уясан морины хур баасыг гүйцэд аваагүйгээс тусна.

Зайлагдах /чихэлдэх/ нь уяж буй морины умсыг гүйцэд агшаалгүй давхилд оруулснаас умсны байршил өөрлөгдөх, түүний улмаас аарцаг буюу өрц рүү түрэгдэхийг хэлнэ.

Цанхдах-оломыг буруу татаж, даамжруулснаас оломны цанх үүснэ.

Таарах-цас багатай өвөл, хаврын хүйтэнд элс, шороотой цас идэх, ялзарч хөгцөрсөн хөлдүү өвс, шороо цантай хужир идэх зэргээс шалтгаалан тусна.

Түүдэгтэх-хурга, ишиг шинэ ногоо, ургамалд хордох, мөн ходоодны “бөөмтөх” өвчний үед түүдэгтэх эмгэг илрэнэ.

Шинж тэмдэг: Дэлүүтсэн адуу идээшлэхгүй зогсох, хэвтэж хөрвөөх, гэдсээ үнэрлэх, нүдээ цавчлах, гэдсээ хайрах, эргэж харах, биеэ маажих, хазах, нохой мэт оцойн суух зэрэг шинж тэмдэг үзүүлнэ. Зарим үед адуу дөрвөн хөлөө дээш гарган хумин нуруугаараа хэвтэнэ.

Үхэр-тогтворгүйтэн, бөөрний хавь газраа үнэрлэх, гэдсээ тийрэх, газар дэвслэх, заримдаа чацга алдана. Гэдэс, гүзээ дүүрнэ. Нимгэн цавины дотор талаар урагш нь илэхэд мушгиралдсан судсууд гүрийж харагдана.

Тугал дэлүүтэхүйн шинжийг зарим газар “булчирхайтах” гэдэг.

Хөрвөөх гэмийн голлох шинж тэмдэг нь ихэнхдээ нэг талаараа хэвтэж тийчлэх бөгөөд энэ тухай сударт “гэдсээр түрүүлгэн хөрвөөх гэмийг “хөрвөөх өвчин” гэнэ хэмээсэн байна.

Цардайсан-үед гэдэс хийгээр дүүрснээс, тогтворгүй болж, улмаар ходоод умс хагарах аюулд хүрнэ.

Зайлагдах- эмгэгийн үед нуруугаараа хэвтэн өөдөө харан дөрвөн мөчөө хумих, гэдсээ цохих, оцойн суух шинж илрэнэ.

Хойшоо чихлэнгийн үед хошногоны амсар түмбэгэр, урагшаа чихлэнгийн үед их хонхор байна.

Цанхдалт даамжрахад бөгсөн тал нь мэдээгүй мэт болж савж унах, оцойн суух мэт шинж үзүүлнэ.

Гэдэс нь чихэлдсэн үхэр-богсоороо ухрах, сүүлээ шарвах, урд хоёр хөлөө цахалж толгойгоо гудайлган зогсоно. Суниах, дүлэх боловч баас гардаггүй, босохдоо нуруугаа хотойлгон суниана.

Түүдэгтсэн хурга, ишиг уухилах, амнаас хөөс цахран нуруу хотойлгон суниах, гэдэс дүүрэх, савж унах, бөгсөө чирэх, огцом түргэн үсэрч цойлох шинжтэй байдаг.

Таних нь: Ходоод гэдэсний эмгэгийн илрэх ерөнхий шинж тэмдгийг ажиглан оношлох бөгөөд ямар нэгэн хатгаа заслын дараа урьд илэрч байсан эмгэгүүд түргэн зуурт арилдгаараа онцлогтой юм.

Анагаан засах нь: Дэлүүтэхүйн хам шинжтэй эмгэг өвчнүүдийг дэлүү хатгах заслаар ихэвчлэн эмчилнэ.

Адууны дэлүү хатгах: Адууг босоо байдалд цоровдон, чөдөрлөж бат бөх бэхлэсний дараа зөв талын сүвээний сүүлчийн хавирганаас урагш тоолон 3 ба 4 дэх хавирганы завсарт, харцагны нугламаас доош мухар сөөмлөөд юмуу гарын алгаа дээш харуулан, нурууны голоос доош хөмрөн хэмжихэд эрхий ба долоовор хурууны завсарт тохиох цэгт шөвөг юмуу нарийн хутгаар 3-4 хуруу гүн урагш доош чиглүүлж огцом хатгана. Зөв хатгасан бол шөвөг зөөлөн савлан хөдлөх бөгөөд хэсэг хугацаанд шөвгөө байлгана. Энд цус бүтээх болон бусад олон чухал үүрэгтэй эрхтэн дэлүүг хатгаж биед цочрол өгч буй хэрэг юм.

Дэлүүтсэн үхрийн дэлүүний судас хатгаж засна. Энэ нь хэвлийн өнгөц хураагуур судас бөгөөд умдагны гадны хураагуураас эх авч хэвлийн арьсан дор урагшлан цээжний гадна ба дотно хураагууртай нийлнэ.

Тугалын дэлүү хатгах: Босоо байдалд тугалаа сайн бариулж байгаад, зөв талын сүвээний хавирганы араасаа 3 дахийн урдуур, нурууны голоос алга дарам газарт хоёр хуруу орчим урттай шөвгөөр жаахан урагш доош чиглүүлэн огцом хатгана /зүү, тэвнээр/. Дэлүүтэхүйн хам шинж, тэмдэгтэй малд дараах ханаж хатгах заслуудыг зохих зааврын дагуу хийнэ. Энэ өвчний явц, хүнд хөнгөний байдал, малын төрөл, нас, тарга хүч зэргийг харгалзан хувилбарыг сонгон хийх болно. Чих цуулаад 1-2 хонуулаад сүүлний үзүүр хатгах /шууд сүүл хатгаж болно/ хамар буйллаад сүүлний үзүүр хатгах, цорвоны гол хатгаад сүүлний самсаа авах, тагнай хатгаад нэг хоёр хоноод хас, сүүл гол авах, гүрээний судас ханаад сүүлний үзүүр, хас авах, өлөн таарагын үед тагнай ханаж цусыг нь залгиулан хойш татах, мөн хэлний доод судас ханаж цусыг залгиулан хойш татах, гүрээний судас хатгаад сүүлний гол, өлөн задархай авна. “Урьдал тордолтыг” эмийн ургамлаар юмуу бусад эмт бодисоор хийж байгаад дөрөө хатгана. Чихэлэнгийн үед чацархайн хураагуур судсыг хатгах засал хийж анагаана.

Чацархайн хураагуур судас хатгах: Чихэлдсэн адуу, малыг хажуу талаар нь унагаж бэхлээд, зөв талын өлөнгийн хонхорын тушаа, ташаан толгойноос урагш, сүвээний эцсийн хавиганы ард дэлүүнээс жаахан доор арьсыг биеийн дагуу нэг сөөм хэмжээтэй арьс, булчин, цорой хальсыг хагалахад умс, гэдэс түрж гарч ирнэ. Умс, гэдсийг цааш түлхэн үзэхэд гэдэс зангирч сэмжний хураагуур судас томорсон байна. Энэ үед томорсон судасны нэг ханыг хатгуурын хутгаар аядуу зүсч 1-1.5 л орчим цус авна. Арьсны болон булчингийн нүхийг багасган онгорхой орхиход нүхээр цус, шингэн шүүрч байгаад аяндаа эдгэрнэ.

Үхрийн чихлэнг анагаан засах:Хонхорцог бөөрний харалдаа нурууны далбага ясны, араасаа 2 дахь үеийн доош 3 хуруу зайд сөөм хэртэй, арьс булчин махыг зүсэн, хоёр хуруугаа оруулж аарцаг ясны дагуу илэн үзэхэд бүдүүрч, хатуурсан судас таарах ба түүнд гэдэс тохон ороолдсон байдаг. Тэр судсыг хоёр талаас нь боож дундуур нь огтолж цус аваад орхино.

Адууны умсны үзүүрт хий тогтоход дэлүүтэй төсөөтэй шинж үзүүлэх ба энэ үед мухар умсны оройг буруу талд, цавины эргүүлгэний голд 2-3 хуруу гүн хатгаж засна. Түүдэгтэх эмгэгийн үед чихийг имнээд сүүлний үзүүрийг хазах юмуу хутгаар зүсч цус гаргана.

Анхаарах зүйл: Дэлүүтсэн адуу, малыг хатгаад ганц нэг хоног өлөндүү байлган услаж байх хэрэгтэй. Чацархайн судас хатгах нь тарган малд нэлээд төвөгтэй байдгийг анхаарах нь зүйтэй. Хатгах хутганы хэмжээг нягт тохируулна.

ЖИЛБЭНТЭХ

х

Арчилгаа маллагааны таагүй нөхцөл болон уналга, эдэлгээний, уяа сойлгын хэм алдагдаж тусдаг эмгэг нь жилбэнтэх юм.

Шалтгаан: Жилбэнтэх гэмийг үүсэх шалтгаанаар нь хийн, тосон, наран, ташууран, усан, цусан жилбэн хэмээн ангилж үздэг. Мөн сударт “гадар, дотор жилбэн” гэж ялгасан байдаг. Усан жилбэн гол төлөв хаврын улиралд, хөлстэй байхад нь морийг услах, цасны шар ус уулгахад, хийн жилбэн адууны биеийн хөлсийг хатаагүй байхад эмээлийг нь хуулж салхинд цохиулснаас үүснэ. Тосон жилбэн нь намрын тарган цатгалан морийг уяа сойлго оруулалгүй ширүүн унаж эдэлж гэм суулгаснаас тусах ба эдэлгээ уналга хэтэрвэл ташууран жилбэн болно. Зун намрын хурц наранд, уяж сойлгүй ширүүн дориун эдэлж гам алдагдсанаас наран жилбэн тусдаг.

Шинж тэмдэг: Жилбэнтсэн мал ерөнхийдөө тамир тэнхээ суларч, өвс тэжээлдээ дурамжхан болж, өвчинд нэрвэгдэмтгий байж заримдаа ил үзэгдэх шарх, гэмтэлгүй атлаа өнгө зүс алдан хамар амнаас идээ бээртэй нус гоожих зэрэг шинж тэмдэг ажиглагдана. Мөн энэ үед адуу мал гэдсээ татан, өнгө зүс алдаж, мундаа, ташаан толгой бөөр, хондлой, хонго, сугаар идээ бээр нэвчин гоождог. Намар цагт эдэлгээний жилбэн олсон адуу дараа жилийн нялх ногоо идэхлээр гэнэт сульдаж, гэдэслэхгүй, шар үстэйгээ хатаж, эцэж туран цоорч нэвчинэ. Хаврын жилбэнгийн урхагаар, намар цагийн уналга, эдэлгээ даалгүй хавдаж цоорох, өвөлжин нэвчих ч бий, Усан жилбэнгийн үед гэм нь түргэн илэрч, амьсгаадах, нүд нь гөлрөх, солбин доголон, хөлний үе хавдах, толгойгоо унжуулан савалж явах зэрэг шинж үзүүлнэ. Тосон жилбэнгийн үед цавь, суганы үс өвлийн цагт халцарч, хавар илрэх ба тэмээний тагнай цагаан цайвар өнгөтэй болж тагнайн гол нь хотойн хатуурч хавдана. Сүүлний дотор талыг эмэрч үзэхэд ясны үеийг тэмтрэн тоолж болохуйцаар сүүлний арьс нимгэрч, үе суларсан байна. Хоргол нь гялгар бүрээстэй болно.

Хийн жилбэнтэй тэмээний ам нь өмхийрч тагнай нь хүрэн буюу хөхөрч суларсан байна. Цусан жилбэн туссан тэмээг эгц зогсоогоод урдаас нь харахад нэг талын гэдэс нь татагдаж дээшээ сойгдсон байдалтай харагдана. Наран жилбэнг тэмээнд “гуйванга” гэдэг. Энэ үед өвчилсөн

тэмээний үс нь тачир хилэн мэт болж, үсэн доор хэсэг, хэсэг өөр өөр өнгийн үс ургаж цоохортсон байна.

Таних нь: Өвчний илрэх эмнэлзүйн шинж тэмдгийг цаг улирлын байдалтай уялдуулан оношлоно.

Анагаан засах нь: Жилбэнтсэн малыг юуны урьд лидэрийн усан ханд, баавгайн доньт, чонын цөс, тарваганы тос, шөл, адууны шөл, тарваганы цөс, бургасны дол зэрэг эмт бодисоор “урьдал засал” хийсний эцэст урхагийг арилгах үүднээс ханаж, хатгаж эмчлэх хэрэгтэй юм. Усан жилбэнтэй адууг урьдал засал тордолт хийсний дараа хаа, ороо хар, дөрөөг хатгасны дараа хэд хонуулаад хойш татан сүүлний гол, самсаа, үзүүрийн аль нэгийг авна. Наран жилбэнд дээд уруулын доторхи судасны буруу талын араас 3 дахь судсыг, гүрээний судастай хатгаад ганц, нэг хоноод хас, сүүлний гол, борвины сиймхий, шаантны ороолт зэрэг судаснуудыг уялдуулан хатгана. Эсвэл шанаа, чамархай, хамрын самсааны нэг, хоёрыг ханаад хэд хонуулаад хойш татан дөрөө, дэлэн, хас мэтийн судасны аль нэг, хоёрыг авна. Тосон жилбэнгийн үед, шөрмөсөн сиймхий, олмооргүй бол туурга, туурайн товгор, зэтэрийн магнай зэргийн нэг хоёрыг хатгаад ганц нэг хонуулаад хойш татан хас, сүүлний самсаа, сүүлнийголын аль нэгийг авна. Бас эхлээд хааг хатгасан ч болно. Цусан жилбэн туссан тэмээний, тагнайг соёоны дотор талд хатгаад, голд тогтсон цусыг гаргахын тулд хойт бөхний орой руу /гол руу/ төө, сөөм буюу төө 4 руруу урт хөндий шөвгөөр хатгаж засна.

Анхаарах нь: Жилбэнг эмчлэхдээ, эхлээд цоорч гоожсон зүйлийг ариутгагч уусмалаар, эмээр цэвэрлэн эмчлэхийн сацуу хатгаж, ханах хэрэгтэй. Хатгасан малыг 3-6 сар эдэлгээнээс чөлөөлж, сайн арчилж тордох нь зүйтэй. Ханах арга боловсруулахдаа жилбэнгийн явцыг сайн харгалзан уйгагүй засахаар тооцох хэрэгтэй. Цус боловсруулах тангийн зүйлээр урьдчилан 7-10 хоног урьдал засал тордолт хийж цусыг нь шингэрүүлж эцэст нь ханах ба цусны өнгө буюу ханах цаг үе болсон эсэхийг гүрээнээс бага зэрэг цус авч үзэж шийдэх хэрэгтэй юм.

ХОРДЛОГО БОЛОН БУСАД ӨВЧИН ЭМГЭГҮҮД

×

Элдэв зүйлд хордох: Адуу мал бэлчээрийн өвс, ургамал, хүнсний ногоо, эрдэс болон хүчит тэжээл, амьтны гаралтай зүйл, бусад исэж ялзарсан зүйлд хордох нь элбэг байдаг. Ургамлын хордлогыг, хордуулж буй ургамлын төрөл нэрээр нь таанатах, баглууртах, зээргэнэтэх, халгайтах, буюу цүнгэрэг, цовхроготох гэхчилэн нэрлэдэг.

Шалтгаан: Ядарч доройтсон юмуу өлөн малыг хөгцөрч муудсан өвс, тэжээлээр тэжээх, өөр орон нутгаас авчирсан болон ядарч турсан мал, өсвөр насны мал, бэлчээрийн ургамалд шилэлт сонголт хийж идэж чадахгүй учраас, хорт ургамал идэж хорддог. Тэжээл бэлтгэх үед хорт ургамал холилдсоноос болон хужир, давсаар дутагдуулж байгаад гэнэт өгөх зэргээс шалтгаалан мал амьтан хордоно.

Шинж тэмдэг: Хордсон мал, амьтны амьсгалын тоо, судасны лугшилт түргэсч, тогтворгүйтэн гэдэс, гүзээ дүүрэх, амнаас нь хөөс, шүлс савиран гоожих, босч хэвтэх, дөрвөн мөч нь таталдан савж унах, салгалах, нүдний хүүхэн хараа өөрчлөгдөх зэрэг шинж илэрнэ. Мөн

түүнчлэн зүрх судасны систем, төв мэдрэлийн систем болон ходоод гэдэсний үйл ажиллагаа хямрах шинж илэрнэ.

Таних нь: Малд илрэх цочмог шинж тэмдэг болон цаг улиралын байдал, арчилгаа маллагаа, тэжээлэгийн нөхцөл, тэжээл бэлчээрийн байдлыг шалган үзэж өвчний оношийг тогтооно. Энд ямар нэгэн халдварт өвчний байдалтай уялдуулан шалгах шаардлагатай тул эмч үзэж тогтооно.

Анагаан засах нь: Ямар нэгэн зүйлд хордсныг тогтоосны дараа эхлээд монгол архи, исгэлэн аарц, цагаа, цагаан гурлын жонхуу, шорвог давстай ус, шар сүү, эмийн зүйл өгч тусласны эцэст ханаж, хатгах засал хийнэ. Заслыг чухам ямар эрхтэн системийн эмгэг хордлого болсонг харгалзан үйлдэнэ. Зүрх судасны эрхтэн системийн хямрал хордлогын үед бол хамрын самсаа, гүрээ, талхи, ороо хар, дөрөө, дэлүүний судасны аль нэгийг юмуу хосолж хатгаад, өвчин аядал 1-2 хонуулаад хойш татан сүүлний гол, үзүүр самсаа, хасны аль нэгийг хатгаж цус авна.

Мэдрэлийн системийн хямралтай хордлого буюу үйл ажиллагааны эмгэг хямралын шинжтэй хордлогын үед хамрын самсаа, хэлний доод судас, тагнай, туурайн магнай, туурга, сиймхий хатгаад 2-3 хонуулаад хойш татах ба эхний хатгаанд 1-2 судас авч, хөлний цусыг дээш татан эцэст нь хойш татна.

Сүүн жилбэн буюу гүү сүүндээ хордох эмгэгийн үед эхлээд гүрээ, хамрын самсаа, хааг хатгаад нэг хоёр хоноод хас, шагайтын ороомог, борвины сиймхий, сүүлний самсааны аль нэг, хоёрыг хатгаж засна. Хачгийн хордлогын үед бол, хоёр гүрээнээс ахиухан цус аваад юмуу хаа, ороо харыг авч хэд хоноод сүүлний үзүүр, гол самсаа, хасыг авна. Мөн хаа, тагнайн аль нэгийг хатгаад хас, хойш татах засал хийнэ.

Анхаарах зүйл: Бог малыг ургамлын хордлогоос сэргийлж нялх ногоо гарах үед “хамрын сиймхий” хатгаж засдаг арга бий. Хордсон мал удаан хэвтсэнээс 4 хөлд нь цус буух тул заавал хөлийн судсыг хатгаад дээш авируулан, эцэст нь хойш татах нь зүйтэй. Сударт: “ер нь юмыг яаж мэдэх вэ, өвсний сөл хар ногоорон хатахын цагт улаан шаргалтах хүртэл өндөр аль буюу мухар сөөм, үзүүр сөөм дүүрэн тийн олонт ургахад зүүн тийш нь эргүүлэн налуулж орхи” гэсэн байгаа нь бэлчээрийн хорт ургамлаас сэргийлж, малд идүүлэхгүй байх талаар дурдсанг анхаарахад илүүдэхгүй юм.

ДЭЛЭНГИЙН ӨВЧИН

×

Малын маллагааны тохиромжгүй байдал, зарим халдварт өвчний үед гүү, үнээ, бог малын дэлэн өвчлөхийг “дэлэн айх” гэдэг.

Шалтгаан: Малын дэлэн элдэв зүйлд цохигдон гэмтэх, хүйтэнд хайрагдах, арчлах тордолт муугаас дэлэнд яр, шарх гарах тэр нь халдвар орж үрэвсэх, хэвтрийн ариун цэвэр муугаас

дэлэн бохирлогдон шархлах, механик саалтууртай газар технологи зөрчигдөн хэт соруулах зэрэг олон шалтгаануудаас уг эмгэг тусна.

Шинж тэмдэг: Дэлэн хавдаж, үнээ мал халуурч явахдаа хөндүүрлэн эмзэглэнэ. Өвс тэжээлд дургүй тугалаа хөхүүлэхгүй тийрнэ. Яр шарх гарна.

Анагаан засах нь: Эхлээд тусч эхлэмэгц даруй үзэж мэдээд, айраг, тараг цагаа түрхэх, хүйтэн жин тавих, дотуур мөөг өгөх, цөцгийн тос түрхэх, эм бэлдмэл хэрэглэх эмчилгээг хийж хамтад нь хатгаж засна. Энд дэлэнгийн урд судсыг дэлэнгээс урагш мухар сөөм зайд ханах юмуу сүүний худагт хатгана. Чухам дэлэнгийн аль хэлтэр нь өвчилснөөс хамааран дэлэнгийн урд судсыг тэр талд нь эхлэн хатгах мөн арын хэлтэр өвчилсөн бол хойт судсыг өвчтэй талд эхлэн хатгана. Хавдартай үед дэлэнгийн судас хатгахад хэцүү байдаг, тийм байвал тэр талын судсыг хатгаад дараа нь дэлэнгийн судас хатгасан ч болно. Ингэсний дараа амьсгал, зүрх судасны үйлийг тэтгэх үүднээс хаа гүрээ, хэлний доод судасны нэгийг авч хэд хоногоос хойш татна.

Анхаарах зүйл: Өвчтэй хэсэгт хамгийн ойр цэгт хатгалтыг эхэлж үйлдэхийг бодох хэрэгтэй. Дэлэнгийн судас хатгасны дараа сүү нэлээд багасч болно. Хэрэв та зөв хатгасан бол сүү нь урьдахаасаа ихсэх ба буруу бол сүүгүй болно. Их сүүтэй гүүг ширгээлгүй хэтэрхий цочир унаж эдэлбэл сүүндээ хордож, бөгсөө даахгүй болж, бөгсөөрөө суун хойт хөл нь мэдээ муутай болдог. Дэлэн хавдана. Энэ үед хасыг хоёр талд нь хатгаж нэг хоёр хонуулаад дэлэнгийн урд, юмуу хойт судсыг авна. Эцэст нь урагш татаад хаа, сиймхий, дөрөө авч тэнцүүлнэ. Гүүг унаж эдлэх бол хаснаас бага цус гаргаж сүүн жилбэн тусахаас сэргийлж унах арга бий.